



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ТӨВ

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

(СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА)



DDC
328015
Б-53

«Судалгаа, мэдээлэл, лавлагаа» -ны эмхэтгэлийг УИХ -ын
Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах
төвөөс эрхлэн гаргав.

Редактор: Ц. Норовдондог (Ph.D)

Техник редактор: Г. Чулуун

Хэвлэлийн эх бэлтгэсэн: О. Нарантуяа

ISBN 978-99929-895-6-4

ГАРЧИГ

Өмнөх үг 7

Нэг. **УИХ -ын 2009 оны хаврын чуулганы хугацаанд гүйцэтгэсэн тойм судалгаа, мэдээлэл, лавлагаа**

Бүлэг 1. Эдийн засаг, санхүүгийн салбарын бодлогын асуудлаар

Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн өнөөгийн байдал, хямралын шалтгаан, нөлөөллийг тогтоох, хямралаас гарах арга замыг тодорхойлох нь <i>Ц. Норовдондог (Ph.D), макро эдийн засгийн багийн судлаачид</i>	10
Стратегийн ач холбогдолтой салбаруудад гадаадын хөрөнгө оруулагчдад хувьцаа эзэмшүүлэхэд тавих хязгаарлалт, холбогдох эрх зүйн зохицуулалт <i>Ц. Норовдондог (Ph.D), Д. Ариунаа (MSc)</i>	38
Эдийн засаг, санхүүгийн хямралтай холбогдуулан төсвийн талаар зарим орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Засгийн Газраас УИХ -д өргөн барьсан төсвийн тодотгол, түүнтэй холбогдуулан зарим ТББ-ын гаргасан санал, зөвлөмжийн талаархи мэдээлэл <i>Д. Ариунаа (MSc), Г. Билгээ, Ц. Батдорж, Ц. Элбэгзаяа, А. Пагма</i>	44
Төсвийн орлогыг нэмэгдүүлж, зарлагыг бууруулах талаар баримталж болохуйц олон улсын стандарт туршлага <i>Д. Ариунаа (MSc)</i>	61
2009 оны төсвийн тодотголтой холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулахаар УИХ-д өргөн барьсан хуулиудын харьцуулалт <i>Макро эдийн засгийн багийн судлаачид</i>	66
Дэлхийн зарим орнуудын төв банкны хүү <i>Д. Ариунаа (MSc)</i>	70

Бүлэг 2. Уул уурхай ашигт малтмалын салбарын бодлогын асуудлаар

Монгол Улсын нефть бүтээгдэхүүний импорт, хилийн болон зах зээлийн, жижиглэнгийн үнийн талаархи харьцуулалт” (Шударга бус өрсөлдөөний аспект)	76
<i>Ц. Батдорж</i>		
Бичил уурхай болон гар аргаар ашигт малтмал олборлох асуудлыг зохицуулах эрх зүйн орчин, бусад орнуудын туршлага	83
<i>Д. Мягмарцэрэн, Ч. Базар (Ph.D), Г. Чулуун, О. Дорждагва, Ц. Болормаа</i>		
Алт хөтөлбөрийн хэрэгжилтээс үүссэн сөрөг үр дагаварууд	108
<i>Д. Мягмарцэрэн</i>		
Дархан цаазат Богдхан уулан дах газар ашиглалтын өнөөгийн байдал, гарч буй зөрчил	110
<i>Ч. Базар (Ph.D)</i>		

Бүлэг 3. Эрх зүй, төрийн байгуулалт гадаад бодлогын асуудлаар

Гадаадын зарим орны төрөөс олгодог одон, медаль, цолны талаархи тойм судалгаа	122
<i>(Ш. Хишигсүрэн)</i>		
Авилга, төрийн албаны хүнд суртал, төрийн албан хаагчийн ашиг сонирхолын зөрчлийн асуудлаар Монгол Улсад 2005 - 2009 онуудад хийгдсэн судалгааны тойм	128
<i>У. Мөнхбат, Ш. Хишигсүрэн, К. Пүрэвсүрэн</i>		
Төрийн албан тушаалд тавих шаардлага, болзолын тухай	169
<i>У. Мөнхбат</i>		
Төрийн байгууллагад 2005 - 2009 оны хооронд шинээр буй болгосон орон тоо, тэдгээрийн чиг үүргийн талаархи мэдээлэл лавлагаа	189
<i>К. Пүрэвсүрэн</i>		
Төрийн сангийн зээлээр өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын талаархи мэдээлэл	193
<i>К. Пүрэвсүрэн</i>		

Бүлэг 4. Парламентын Тамгын газар болон судалгааны төвүүдийн талаархи мэдээлэл

УИХ -ын судалгаа, шинжилгээний нэгжийн түүхчилсэн танилцуулга	200
<i>Ц. Норовдондог (Ph.D), О. Нарантуяа</i>	
Гадаадын Парламентийн судалгааны нэгжүүдийн талаархи мэдээлэл	207
<i>Ю. Эрдэнэтуяа ((Ph.D),) болон бусад судлаачид</i>	

Хоёр Хавсралт

• Улсын Их Хурлын 2009 оны хаврын чуулганы хугацаанд гүйцэтгэсэн бусад судалгааны жагсаалт (Боть - 1 -д орсон)	221
--	-----



ӨМНӨХ ҮГ

УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв нь УИХ-ын ээлжит чуулганы хугацаанд УИХ-ын гишүүд болон Байнгын хороодын захиалгаар бодлогын болон харьцуулсан судалгааны ажлуудыг гүйцэтгэхээс гадна хууль тогтоомжийн төсөл боловсруулах, УИХ-д өргөн баригдсан хуулийн төслийг Байнгын хороод болон УИХ-ын чуулганаар хэлэлцэх явцад гишүүдийг мэдээлэл, лавлагаагаар хангах үүрэгтэй.

Мөн тус төв нь дэлхийн эдийн засаг, Монгол улсын нийгэм эдийн засгийн байдлын талаар УИХ-ын гишүүдэд шуурхай мэдээлэл хүргэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц байдал, эрх зүйн зохицуулалт шаардагдаж буй нийгэмд тулгамдсан асуудлуудын талаархи олон нийтийн санаа бодол, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллага, нэр хүнд бүхий олон улсын судалгааны байгууллагуудын судалгааны тайлан, зөвлөмжүүдийг харьцуулан судалж тойм мэдээлэл бэлтгэн хууль тогтоох засаглалд дамжуулан хүргэх “гүүр” болдогоороо онцлогтой.

УИХ-ын 2009 оны хаврын чуулганы хугацаанд тус төв нь УИХ-ын гишүүдийн захиалгаар 20, Байнгын хороодын захиалгаар 7, төвийн санаачлагаар 14 судалгааны ажлыг гүйцэтгэснээс бодлогын судалгаа 8, харьцуулсан судалгаа 11, тойм судалгаа 9, мэдээлэл лавлагаа 11, контент анализ 1 –ийг тус тус гүйцэтгэсэн байна.

Эрхэм гишүүд та бүхний гар дээр УИХ-ын Тамгын газрын судалгаа шинжилгээ олон нийттэй харилцах төвийн 2009 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд гүйцэтгэсэн зарим лавлагаа, мэдээлэл, тойм судалгаануудыг түүвэрлэн “Бодлогын судалгаа, шинжилгээ” эмхэтгэлийн 2 дугаар боть болгон хүргэж байгаадаа баяртай байна.

Уг эмхэтгэлд тухайлсан асуудлаар УИХ-ын гишүүдийн хүсэлтээр гаргаж өгсөн мэдээлэл, лавлагаануудыг түүвэрлэн оруулсан тул цаг хугацааны хувьд мэдээллийн ач холбогдол багатай байж болох ч бодлого боловсруулах шийдвэр гаргах явцад ашиглагдах системтэй цэгцтэй мэдээлэл болох учраас энэхүү эмхэтгэлийг олон нийтийн хэрэгцээнд бус зөвхөн УИХ-ын гишүүдийн ажлын хэрэгцээнд зориулан гаргалаа.

Бид цаашдаа УИХ-ын ээлжит чуулган бүрийн төгсгөлд нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдол бүхий томоохон судалгааны ажлууд, мэдээлэл, лавлагаануудыг эмхэтгэн цуврал хэлбэрээр эмхэтгэн хүргэх бөгөөд эрхэм төрийн түшээд, уншигчид та бүхний санал зөвлөмж, итгэл дэмжлэг, хамтын ажиллагаа туйлын чухал тул санал бодлоо харамгүй хуваалцана уу.

* * *

Ц. Норовдондог

(УИХ-ын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төвийн дарга, Ph.D)

1

БҮЛЭГ

ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДАЛ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЯМРАЛЫН ШАЛТГААН, НӨЛӨӨЛӨЛ, ДАВАН ТУУЛАХ АРГА ЗАМ

*Ц. Норовдондог - Судалгааны багийн ахлагч,
Макро эдийн засгийн судалгааны багийн судлаачид*

СУДАЛГААНЫ СЭДВИЙН АГУУЛГА

Нэг. Монгол улсын эдийн засаг санхүүгийн хямралын гадаад орчны нөлөө (Тойм мэдээлэл)

- 1.1 Дэлхийн эдийн засаг санхүүгийн хямралын уг сурвалж, учир шалтгаан, үйл явц, өрнөл, цаашдын хандлага
- 1.2 Эдийн засаг, санхүүгийн хямралыг даван туулах талаар бусад орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн
- 1.3 Дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралын Монгол улсад үзүүлж буй нөлөөлөл
- 1.4 Дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралын сургамж
- 1.5 Санхүүгийн хямралын асуудлаархи зарим олон улсын байгууллагын зөвлөмж

Хоёр. Монгол улсын эдийн засаг, санхүүгийн дотоод орчин, төлөв байдал, цаашдын хандлага (лавлагаа, мэдээлэл)

- 1.1 Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, эдийн засгийн ерөнхий төлөв байдал
- 1.2 Төрийн санхүү, төсвийн орлого, зарлагын байдал
- 1.3 Гадаад худалдааны төлбөрийн тэнцэл, Засгийн газрын өрийн байдал
- 1.4 Төрийн мөнгөний бодлогын хэрэгжилт, банк санхүүгийн системийн өнөөгийн байдал, авсан арга хэмжээ үр дүн
- 1.5 Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, бараа таваарын үнийн өсөлтийн шинжилгээ, инфляцийг бууруулах талаар Төв банкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн
- 1.6 Валютын зах зээлийн өнөөгийн байдал, төгрөгийн ханшийг тогтворжуулах талаар
- 1.7 Санхүүгийн хямралтай холбогдуулан төр засгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн

Гурав. Дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралын Монгол улсад үзүүлэх нөлөөллийг багасгах, хямралыг даван туулах чиглэлээр төр засгаас баримтлах бодлого, хэрэгжүүлж болохуйц арга хэмжээний санал, ЗӨВЛӨМЖ

- 1.1 Макро эдийн засгийг тогтворжуулах, эдийн засгийн бүтцийг сайжруулах чиглэлээр
- 1.2 Төрийн санхүү, төсвийн удирдлагыг боловсронгуй болгох чиглэлээр
- 1.3 Төрийн мөнгөний бодлого, банкны системийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр
- 1.4 Санхүүгийн зах зээлийг төлөвшүүлэн хөгжүүлэх, санхүүгийн зах зээлийн шинэлэг хэрэгслүүдийг ашиглан хөрөнгө төвлөрүүлэх чиглэлээр
- 1.5 Гадаад худалдааны төлбөрийн тэнцлийг сайжруулах, валютын зах зээлийг тогтворжуулах, улсын алтны болон валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр
- 1.6 Хэрэглээний үнэ, инфляцийг бууруулах чиглэлээр
- 1.7 Нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах чиглэлээр
- 1.8 Гадаад харилцааг эдийн засагжуулах, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр

Ашигласан материалын жагсаалт



Жич:

- УИХ-ын Тамгын газрын СШОНХ төв нь шинэ тутам байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлж байгаа учраас судалгаанд шаардагдах мэдээлэл, нарийвчилсан судалгааны статистик тоо баримтуудыг олж цуглуулахад цаг хугацааны хувьд хүндрэлтэй байлаа.
- Судалгаанд Үндэсний Статистикийн хороо, Монгол банк, Сангийн Яам болон бусад холбогдох байгууллагуудын 2008 оны статистикийн тайлан, мөн 2009 оны 01 сарын 22 - 23 -ны өдрүүдэд МАХН -ын Удирдах зөвлөлөөс санаачлан Төрийн ордонд зохион байгуулсан “Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал ба Монгол Улс” сэдэвт зөвлөлдөх уулзалтын яцад хэлэлцүүлсэн илтгэлүүд, хэвлэл мэдээлэлийн эх сурвалжууд, эрдэмтэн судлаачдын санал дүгнэлтүүд, олон улсын байгууллагуудын зөвлөмжийг тусгасан болно.

Нэг. Монгол улсын эдийн засаг, санхүүгийн хямралын гадаад орчны нөлөө (Тойм мэдээлэл)

1.1 Дэлхийн эдийн засаг санхүүгийн хямралын уг сурвалж, учир шалтгаан, үйл явц, өрнөл, цаашдын хандлага

2007 оны намраас АНУ-ын орон сууцны барьцаат зах зээлийн хямралаас үүдэлтэй санхүүгийн хямрал бүх дэлхийг хамарлаа. 1995-2000 онуудад АНУ жилд дунджаар 180-190 тэрбум ам.долларын орон сууцны барьцаат зээл гаргадаг байсан бол 2000-2007 онуудад 500 тэрбум хүртэл өсгөсөн нь зах зээл дээр орон сууцны илүүдлийг бий болгосон. Үүний уршгаар, зах зээл дээр орон сууцны үнэ 1-1.5 жилийн дотор 25-30% унаснаас хямрал эхэлсэн гэж үзэж байна. Зээлийн баталгаа болж байсан орон сууцны бодит үнэ зах зээлийн үнэлгээнээс ихээхэн доогуур болж, үнийн хиймэл хөөс үүссэн байжээ.

АНУ-ын ипотекийн зах зээл дээр сүүлийн жилүүдэд зээлийг орон сууцны бүтэн үнэнд нь тулгаж хавтгайруулан өгдөг практиктай болсон, орон сууцны баталгаатай үнэт цаасыг зуучлан борлуулагчид ашиг олохын тулд ухуулга сурталчилгаа хийх замаар орон сууцны баталгаатай үнэт цаасны үнэ ханшийг өсгөх, санхүүгийн мэдээллээ ил тод тайлагнах, мэдээлэх журам хангалтгүй, эрсдэлийн менежмент сул байсан ба хөрөнгийн үнэлгээний компаниуд ч үүнд тодорхой хэмжээгээр хариуцлагагүй хандаж байсан байна. Мөн иргэдийн зүгээс банк санхүүгийн байгууллагууддаа ихээхэн итгэл өгч байжээ. Гэтэл олон зуун тэрбум ам долларын хөрөнгөтэй гэгдэж байсан банк санхүүгийн томоохон компаниуд дампуурч, үүнийг дагаад эдийн засгийн бодит салбарын хямрал үргэлжилж байна. Ялангуяа эрдэс түүхий эд үйлдвэрлэгч, экспортлогч компаниудад энэхүү хямрал хүндээр тусч байгаа ба 2008 оны 9-р сараас эхлэн АНУ-ын болон бусад орнуудын хөрөнгийн зах зээл дээр үнэт цаасны үнэ огцом унаж эхэлсэн одоо ч үргэлжилж байна. Үүнээс үүдэн дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, хямрал дэлхийн улс орнуудад харилцан нөлөөлж улам бүр глобал шинжтэй болж байна.

Дэлхийн зах зээл дээр эрдэс, түүхий эд, бүтээгдэхүүний үнэ ихээхэн хэмжээгээр буурах боллоо. Газрын тос, зэсийн үнэ сүүлийн жилүүдэд байгаагүйгээр унаж, хүнсний бүтээгдэхүүний үнэ буурав. Инфляцид нөлөөлдөг гол бараа бүтээгдэхүүний үнэ дэлхийн эдийн засгийн удаашралтаас шалтгаалан тодорхой хэмжээгээр буурч байгаач зарим улс орнуудын хувьд инфляцийн түвшин харьцангуй өндөр хэвээр байна. Судалгаанаас үзэхэд, энэхүү хямралд дэлхийн хөгжингүй улс орнуудын 3-4 % нь өртөөд байгаа ба үлдсэн 1-4 % нь гол төлөв буурай хөгжилтэй, эсвэл хөгжиж буй орнууд байна. Хямралд өртсөн орнуудын нийтлэг шинж нь өндөр хөгжсөн, санхүү эдийн засгийн болон гадаад харилцаа сайтай, олон улсын худалдааг идэвхтэй өрнүүлдэг орнууд байна.

Манай орны хувьд бусад орнуудын нэгэн адилаар энэхүү хямралд татагдан орсон ба



хямрал манай оронд шууд болон шууд бус замаар нөлөөлж байна. Глобаль шинжтэй энэ хямрал нь аль хир гүнзгийрэх, дэлхийн эдийн засгийн зогсонги байдал хэзээ арилахыг таамаглаж хэлэхэд хэцүү байна.

1.2. Дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралын Монгол улсад үзүүлж буй нөлөөлөл

- Монголын экспортын бүтээгдэхүүний (зэс, жонш г.м) дэлхийн зах зээлийн үнэ унаж байгаа нь манай эдийн засагт тааламжгүй нөлөө үзүүлж төсвийн бүрдүүлэлт хомсдох, хөрөнгө оруулалт багасах нөхцөлийг бий болгож байна.
- Төгрөгийн худалдан авах чадвар буурч, гадаад валюттай харьцах ханш унаж, гадаадаас орж ирэх валютын урсгал багасч байна
- Импортоор орж ирэх барааны үнэ нэмэгдсэнээс болж борлуулалт нь багасах, хүн амын бараа үйлчилгээний худалдан авах чадвар буурах, хэрэглээ хумигдах хандлага гарлаа. Энэ нь худалдааны бизнест сөргөөр нөлөөлж байна.
- Мөнгөний хатуу бодлого явуулсанаас арилжааны банкууд зээл олгохоо больж, урьд олгосон зээлийн эргэж төлөгдөх магадлал нь багассан, мөнгөний хомсдол бий болж эдийн засгийн бодит салбарт царцанги байдал үүсч орон тооны цомхотгол хийх болсоноор ажилгүйдэл өсч, ядуурал улам гүнзгийрэх шинжтэй боллоо.
- Одоогоор мэдрэгдэж буй зүйл бол манай дотоодын зах зээлд эдийн засгийн 30 гаруй хувийг эзэлдэг ноолуур, арьс шир зэрэг малын гаралтай түүхий эдийн үнэ 4-8% буурлаа. Энэ хэмжээгээр малчдын орлого буурч, худалдан авах чадвар нь доройтож байна
- Зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр бараг 3 дахин буурсан, түүнчлэн нүүрс, төмөр, цайр, жонш зэрэг манай экспортын бүтээгдэхүүний үнэ огцом буурч, ашиг орлого нь багасч байна.
- Манай улсын гадаад худалдааны болон төлбөрийн балансад хүндрэл учирч байна. Үүний зарим хэсгийг нефть бүтээгдэхүүний үнийн бууралтаар нөхөх боловч манай нийт экспортын барааны үнийн бууралтын зөрүүгээр алдагдалтай байхаар байна.

2008 оны 11-р сарын 15, 16 -ны өдрүүдэд Вашингтонд болсон тэргүүлэх 20 орны дээд хэмжээний уулзалтаас гаргасан тунхаглалд өнөөгийн хямрал хөгжиж буй орнууд, ялангуяа эмзэг эдийн засагтай орнуудад илүү нөлөө үзүүлнэ гэж дүгнээд ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын болон бүс нутгийн хөгжлийн банк санхүүгийн байгууллагууд, донор орнууд, тэдгээрийн хөгжлийн сан, байгууллагуудын зүгээс олгох хөрөнгө, хүчин чармайлтыг нэмэгдүүлэхийг уриалжээ. Мөн НҮБ-ийн 2002 оны Мексикийн Монтеррегийн хөгжлийг санхүүжүүлэх бага хурлын шийдвэр чухал ач холбогдолтой хэвээр байгааг тэмдэглэж, НҮБ-ийн индэрээс баталсан Мянганы хөгжлийн Зорилтуудыг хэрэгжүүлэхэд туслах амлалтуудаа хэрэгжүүлэхийг хөгжингүй орнуудад сануулсан байна.

1.3 Эдийн засаг, санхүүгийн хямралыг даван туулах талаар бусад орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн

Улс орнуудын хямралыг даван туулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ нь мөнгө хийгээд банкинд итгэх итгэлийг бэхжүүлэх, санхүүгийн зах зээлийг тогтворжуулах, иргэдийн хадгаламжийг эрсдэлээс хамгаалах, улс хоорондын харилцан итгэлцэл, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, эдийн засгийг дэмжихэд чиглэгдэж байна. Байдал нэгэнт хяналтаас гарч болзошгүй болсон 2008 оны 9 сараас АНУ, Британи зэрэг орнууд банк санхүүгийнхээ системийг аврахад зориулан олон зуун тэрбум доллар зарцуулах арга хэмжээ авч хэрэгжүүлж эхлээд байна. Мөн дэлхийн хөгжингүй орнууд, Их долоогийн орнууд (АНУ, Япон, Герман, Франц, Англи, Канад, Итали)-ын төр засгийн тэргүүн, банк санхүүгийн удирдлагууд өнгөрсөн оны 9, 10 сард уулзаж хямралыг зогсоох талаар олныг

тайвшруулсан арга хэмжээ авч эхэлсэн

Мөн нөлөө бүхий 20 орны тэргүүнүүд ОУВС, Дэлхийн банк, НҮБ, Европын холбоотой хамтран 2008 оны 11 сарын 16,17 нд дээд хэмжээний уулзалт хийж хямралас гарах, цаашид хэрхэн сэргийлэх талаар тунхаглал гаргасан байна. Явц байдлыг 2009 оны 1-р улиралд авч хэлэлцэхээр болжээ. Эдийн засгийн хямралыг даван туулах талаар дэлхийн улс орнуудын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний эхний хэсэг нь зээлийн хямралыг зогсоож, банкны системг аварч, итгэлийг бэхжүүлэхэд чиглэгдэж байна.

Британийн авсан багц арга хэмжээ бусдад үлгэр, загвар болж байгаа тул түүний 5 багц гол агуулгыг дурьдвал:

- ЗГ-ын хөрөнгийн багцаас томоохон 8 банкинд дэмжлэг үзүүлэхээр тогтож, цаашид томоохон бизнес үйл ажиллага явуулдаг аль ч банк хамрагдаж болохыг зөвшөөрсөн
- ЗГ нь 50 хүртэл тэрбум фунт стерлингийн хөрөнгө оруулалтыг арилжааны банкинд хийх, ингэхдээ тухайн банкуудын хувьцааг худалдаж авах замаар бодитой хөрөнгө оруулалт хийсэн
- Хадгаламж эзэмшигчдийн мөнгөний төрийн баталгааг 50,0 хүртэл мянган фунт болгон нэмэгдүүлсэн. Герман зэрэг орнууд иргэдийн хадгаламжиндаа бүхэлд нь баталгаа гаргахаа амлаж байна
- 250 тэрбум фунтийг богино болон дунд хугацаатай зээлийн баталгаа гаргаж, банкуудын өрийг санхүүжүүлэхэд туслах амлалт өгсөн
- Тусгай нөхцөлтэйгээр арилжааны банкуудын үнэт цаасыг Засгийн газрын бондоор солиход зориулж 100 ба түүнээс дээш тэрбум фунтийг бэлэн байлгах аар амалсан

Дэлхийн улс орнуудын дараагийн шатанд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь эдийн засгийг хөхүүлэн дэмжихэд чиглэгдэж байна.

- Дэлхийн зээлийн хямрал нь эдийн засгийн хямралд хүргэж байгаа тул эдийн засгийн өсөлтийн уналтыг саармагжуулах, зогсоох үүднээс Өрнөдийн орнуудын ихэнх нь зээлийн суурь хүү хийгээд валютын ханшийг бууруулах арга хэмжээ авч эхэллээ.
- Дээрхи арга хэмжээнүүд хүссэн үр дүнд хүргэхгүй байгаа тул дотоод үйлдвэрлэл, хэрэглээг дэмжсэн бодлогыг ихэнх орнууд авч эхэллээ. Тухайн орны эдийн засагт голлох нөлөөтэй салбар, томоохон үйлдвэрлэгчиддээ олон зуун тэрбум ам.доллар зарцуулах амлалт өгч хэрэгжүүлж эхлээд байна.
- Зарим орнууд татварын хувь хэмжээг бууруулах, татварын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ ч авч байна

ОУВС-аас хийсэн дэлхийн эдийн засагт голлох үүрэгтэй орнуудын хөгжлийн өсөлтийн прогнозоос харахад АНУ, Еврогийн бүсийн орнууд, Британи, Хятад, ОХУ, Энэтхэг зэрэг ихэнх орнуудад эдийн засгийн өсөлт буурах хандлагатай байна. Тухайлбал, хөрш 2 орон Хятадын үзүүлэлт 0.5%-иар, ОХУ-1.8%-иар тус тус буурах хандлагатай байна. /Дэлхийн зарим улс орны хямралын үед авч байгаа арга хэмжээг хавсралт 2-оор үзүүлэв/

1.4. Дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралын сургамж

- Эдийн засаг нийгмийн амьдралд чухал нөлөөтэй банк санхүүгийн байгууллагуудыг дампууруулах нь ихээхэн холын үр дагавартай болохыг энэ удаагийн хямрал харуулж байна
- Зээлийн баталгаанд голчлон хэрэглэгддэг үл хөдлөх хөрөнгийн хувьцааны үнэ бодит өртгөөс ихээхэн доогуур болж хөрөнгө оруулагчдыг алдагдалд оруулж байна.
- Жижиг улс гүрэн өөрийн гадаад валютын нөөц, чадавхиас хэтэрсэн банкны зээл,

ялангуяа арилжааны зээл авах нь улс орныг сүйрүүлж болох талтайг хямралд өртсөн зарим орны жишээ харуулж байна. Эдийн засаг, санхүүгийн байдал хүндрэх үед гадаадын банк, хувийн хөрөнгө оруулагчид тухайн орноос хөрөнгөө татаж эхлэх нь олонтой. Ийм байдал Азийн санхүүгийн хямралын үед ихээхэн ажиглагдаж байжээ.

- Малын гаралтай түүхий эдийг худалдан авагч ганцхан зах зээлтэй манай орны хувьд байдал хүндээр тусч буйд нухацтай дүгнэлт хийх шаардлагатай боллоо. Түүхий эд боловсруулах дотоодын үйлдвэрлэл байхгүй, гуравдагч зах зээлд борлуулах боломжгүй үед түүхий эдийг эдийн засгийн үр ашигтай эргэлтэнд оруулах арга замыг олохыг шаардсан нэгэн сургамж болж байна.
- Зах зээлийн эдийн засгийн мөчлөгт циклийн хүнд үед түүхий эдийн үнэ унадаг, оргил үед өсдөг гэдгийг бодолцож үнийн савалгаанд өртөхгүй байх арга хэмжээ авах, ингэхдээ гадаад, дотоод нөхцөл, хүчин зүйлийг бодолцох шаардлага байна. Ганцхан уул уурхайн салбарт найдлага тавьж, бусад салбар секторыг орхигдуулж болохгүйг энэ нь харуулж байна.
- Эдийн засгийн хүндрэлийн үед ажлаас халах, ажлын байрыг цомхотгох шаардлага зайлшгүй гардаг ба энэ нь тухайн үйлдвэрлэлийг дампуурахаас сэргийлэх нэг арга хэмжээ гэдгийг нийгэм ойлгож хүлээж авах бэлтгэлтэй байх ёстойг сануулж байна. Иймээс ажилгүйдлийн тэтгэмж, даатгалын тогтолцоог эргэн харахыг сануулж байна.
- Төрөөс банкуудыг дэмжих талаар авч буй арга хэмжээ нь эцсийн дүндээ татвар төлөгчид, харилцагчдынх нь төлөө авч буй арга хэмжээ гэдгийг ойлгуулж, ингэхдээ алдаа гаргасан бүх хүмүүст хариуцлага тооцох хариуцлагын тогтолцоог сайжруулах хэрэгтэйг сургамж харуулж байна.

1.5. Санхүүгийн хямралын асуудлаархи зарим Олон улсын байгууллагын санал, зөвлөмж

2009 оны 01 –р сард төрийн ордонд болсон семинар дээр Дэлхийн банкны Суурин төлөөлөгч Аршид Саед, ОУВС-гийн Суурин төлөөлөгч Бэнг Гюн Жанг нар тавьсан илтгэлдээ дараахь санал, зөвлөмжийг хэлсэн болно.

Дэлхийн банкны зүгээс

Хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгоход анхаарах. Энэ хүрээнд:

- Өсөлтөнд саад болж буй саад тогторыг арилгаснаар эдийн засгийн өсөлтийг хангаж, өсөлтийн эх сурвалжийг төрөлжүүлэх
- Боловсрол ба хүний нөөцөд хийх хөрөнгө оруулалтыг дэмжих
- Дэд бүтцийг сайжруулах
- Санхүүгийн тогтолцоог шинэчлэх
- Одоо ажиллаж буй үйлдвэрлэл дэх инновацийг дэмжих
- Хууль эрх зүйн орчин болон төрийн үйлчилгээг сайжруулах

Ядуу болон эмзэг бүлгийн иргэдийг хамгаалах шаардлагатай. Энэ хүрээнд:

- Эмзэг байдлаас ядуу иргэдийг хамгаалах
- Эв нэгдэлтэй нийгмийн төлөө нийгмийн нэгдэл нягтралыг бий болгох

Дэлхийн Банк цаашдаа

- Нийгмийн халамжийн хөтөлбөрийн чанарыг сайжруулах
- Өсөлтийн дүн шинжилгээ
- Худалдааг хөнгөвчлөх ажлын хөтөлбөр



- Банкуудад санхүүгийн салбарын дэмжлэг үзүүлэх
- ОУВС-гийн хөтөлбөрийг дэмжин оролцох
- Бүтцийн өөрчлөлт болон өөрчлөлт хийх чадавхид дэмжлэг үзүүлэхэд бэлэн гэжээ.

Олон улсын валютын сан

- Дэлхийн олон орны банк гаднаас маш их хэмжээний зээл татаад дотооддоо тэр хэмжээгээр зээл олгосноос маш их хүнд байдалд байна. Харин Монголын арилжааны банкууд гаднаас зээлийн хараат болоогүй нь сайн хэрэг. Гэхдээ сүүлийн жилүүдэд маш их зээл олгосон нь одоо хүндрэлд оруулж байна. Зээл харилцах хадгаламжийн хэмжээ 2004 онд 90%, 2007 онд 100%, 2008 онд 140 % болж өссөн. Нийт зээл, харилцах хадгаламж 140 % -иас давсан нь зээл олгох боломжийг хаасан.
- Өнөөдөр дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ бага хэвээр байна. Цаашид энэ түвшинд байна гэж үзвэл Монгол улс төсвийн тодотголоо даруй хийх хэрэгтэй.
- Эдийн засаг хүндхэн байгаа үед Засгийн газар, УИХ донор байгууллагуудаас зээл, тусламж авах хэрэгтэй. Үүний тулд дараах зүйлийг анхаарах хэрэгтэй байна. Үүнд:
 1. Засгийн газар, УИХ, дотоодынхоо нөхцөл байдлыг засах хэрэгтэй. Өсөлт байсан үед хуримтлал бий болгоогүй зардлын талдаа илүү анхаарсан нь өнөөдөр хүндрэл бий болгож байна.
 2. Нийгмийн халамжийг тооцоо судалгаагүй хавтгайруулсан бодлого барьсан нь нөөц бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлсөн
 3. Төсвийн үрэлгэн зардлаа хэт их нэмэгдүүлсэн.

ОУВС цаашид Монгол улсын Засгийн газартай хамтран ажиллахад бодлогын хувьд дараах нөхцөлийг тавина.

- Эдийн засгийн буй болгосон тэнцвэрт бус байдлыг арилгах
- Эдийн засгийг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх бодлого явуулахыг шаардана гэжээ.

Хоёр. Монгол улсын эдийн засаг, санхүүгийн дотоод орчин, төлөв байдал, цаашдын хандлага

2.1 Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, эдийн засгийн ерөнхий төлөв, байдал

Өнөөдөр Монгол улсын санхүү, эдийн засаг хүндхэн байдалд орж 2008 онд эдийн засгийн өсөлт саарч /ДНБ-ний өсөлт 10.1% байхаар төлөвлөснөөс 8.9 орчим хувь болж буурч 6% байхаар ногдож байхаар тооцож байсан инфляци 22.1% болон өсч 2007 онтой харьцуулахад 28.0% болсон нь сүүлийн 10 жилд байгаагүй өндөр үзүүлэлт юм. Үүнээс гадна манай улсын валютын нөөц 2007 оны 6 сард байсан нэг тэрбум доллараас 606.2 сая ам.доллар болтол буурсан хийгээд гадаад худалдааны алдагдал 1.1 тэрбум доллар хүрсэн байна. Юаны төгрөгтэй харьцах ханш 200 давж, долларынх 1400 дөхөж төгрөгийн ханшгүйдэл хүчтэй явагдаж байна. Энэ хямрал манай орны эдийн засгийн аль ч секторт сөргөөр нөлөөлөх байдал ажиглагдаж тухайлбал уул уурхайн салбарын өсөлтийн хурдац 2008 онд нэлээд саарсан байдал харагдаж байгаа нь алт олборлолт 2007 оныхоос 2.3 тн, цайрын баяжмал 167.0 тн-оор тус тус буурсны дээр хөнгөн үйлдвэрийн салбарт ч бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурах хандлага гарч байна.

Нийт салбаруудаар дүгнэж хэлэхэд хүн амын худалдан авах чадвар эрс буурч үнийн хэт өсөлт, мөнгө зээлийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалж эрэлт олигтой нэмэгдэхгүй, зарим тохиолдолд буурсан байгаагаас зарим салбарын өсөлт саарах, зарим тохиолдолд огцом унах хандлага байна. Салбарын байдалд дэлхийн санхүү эдийн засгийн хямралтай

холбоогүйгээр салбарын дотоод үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, өр төлбөр, санхүүжилттэй холбоотой бэрхшээлүүд тулгарч байна. Нийт салбарын дотор 10-аас дээш пунктээр буурсан үзүүлэлтүүдтэй, улирлын бөгөөд дотоодын хямралын шинж тэмдэгүүд эрт илэрч байгаа барилга, уул уурхай, тээвэр /төмөр зам/, мал аж ахуй эрчим хүчний салбарууд байна.

Барилгын салбарт 2008 онд бууралт гарсан нь дэлхийн санхүү эдийн засгийн хямралаас шалтгаалж гэхээс илүүтэй арилжааны банкны зээл олголт түүний зориулалттай илүү холбоотой байсан гэж үзэж болно. Инфляцийн өндөр өсөлтийг хязгаарлах зорилгоор 2008 оны эхээс мөнгөний хатуу бодлого явуулж, арилжааны банкнаас олгох зээлийн эх үүсвэрийг хязгаарлах, зээлийн хүүг өсгөх арга хэмжээг авсан нь зээлээр үйл ажиллагаа явуулдаг орон сууцны салбарт санхүүжилтийн бэрхшээл учруулсан юм. Өнөөгийн байдлаар барилгын хувийн компаниудад 200 орчим орон сууцны дутуу баригдсан барилга байгаа бөгөөд тэдгээрийг дуусгахад тодорхой хэмжээний санхүүгийн эх үүсвэр дутагдаж байна.

Тээврийн салбарт огцом уналт гарсан бөгөөд тэр дотроо төмөр зам илүү анхаарал татаж байна. Хөрш орнуудын үйлдвэр худалдаа буурч байгаатай холбоотойгоор транзит тээврийн ачаа барааны хэмжээ, бусад тээвэрлэлтийн хэмжээ 70-80% буурч, УБТЗ 10000 ажилчдыг эхний ээлжинд богиносгосон ажлын өдөрт шилжүүлэх, санхүүгийн байдал сайжрахгүй тохиолдолд цомхотголд оруулах ч магадлалтай байна. Түлш эрчим хүчний салбарт өр төлбөр, их хэмжээний алдагдал үүссэн бөгөөд үүнийг арилгахад ихээхэн хэмжээний эргэлтийн хөрөнгө шаардлагатай нь тодорхой.

Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн үнийн бууралтаас шалтгаалж, малчдын орлого буурч арилжааны банкнаас авсан зээлийг төлж чадахгүйд хүрч, тэдний амжиргаанд нь сөргөөр нөлөөлж байна. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэ дэлхийн санхүүгийн хямралтай шууд бус байдлаар холбоотой байгаа юм. Хямралаас болоод аж үйлдвэрийн барааны эрэлт өндөр хөгжилтэй орнуудад буурсан нь түүхий эд экспортолдог манай орны хувьд хөрш Хятад улсын түүхий эдийн эрэлт огцом буурсны шалтгаан болсон гэж үзэж байна. Үүнээс гадна ноолуур, бусад мал аж ахуйн гаралтай түүхий эдийн үнэ, байгаль цаг уурын байдал манай дотоодын эрэлт буурснаас хамаарч үнэ буурсан нь малчдын амьдралд сөргөөр нөлөөлөх боллоо.

2.2 Төрийн санхүү, төсвийн орлого зарлагын байдал

Үзүүлэлтүүд	2006	2007	2008	2008\2007 (%)
ДНБ, оны үнээр, тэрбум төг	3715,0	4599,5	6130,3	133,3
Нэгдсэн төсвийн нийт орлого, оны үнээр, тэрбум төг	1360,4	1880,5	2156,4	114,7
Нэгдсэн төсвийн нийт зарлага, оны үнээр, тэрбум төг	1237,0	1747,3	2462,0	140,9
Нэгдсэн төсвийн урсгал орлого, оны үнээр, тэрбум төг	1354,1	1856,0	2136,1	115,1
Нэгдсэн төсвийн урсгал зарлага, оны үнээр, тэрбум төг	982,3	1367,7	1749,5	127,9
Хөрөнгийн зардал		299,5	624,9	

Нэгдсэн төсвийн нийт тэнцэл, тэмбум төг	123.4	-133.2	-305,7	
Нэгдсэн төсвийн урсгал тэнцэл, тэрбум төг	371.7	488.3	386.6	79.2
ДНБ-д төсвийн нийт орлогын эзлэх %	36.6	40.8	35.2	0.8
ДНБ-д төсвийн нийт зарлагын эзлэх %	33.3	40.0	65.5	1.64
ДНБ-ний жил бүрийн өсөлт,%	-	123.8	133.3	1.07
Нэгдсэн төсвийн нийт зарлагын жил бүрийн өсөлт,%	-	141.2	140.9	0.99
Урсгал зардлын жил бүрийн өсөлт, %	-	139.2	127.2	0.91

Эх сурвалж: Статистикийн бюллетень, 2008оны урьдчилсан гүйцэтгэл

Судалгаанаас үзэхэд, 2008 оныг 2007 онтой харьцуулахад ДНБ оны үнээр 133,3 %-иар өссөн байхад төсвийн нийт зарлага оны үнээр 140,9% -иар өсч ДНБ-ний өсөлтөөс давжээ. Үүнээс үзэхэд төсвийн нийт зардал эдийн засгийн хөгжлийн түвшинтэйгээ харьцуулахад өндөр байгаа нь харагдаж байна. 2007 онд энэ үзүүлэлт 40%-тай байсан бол 2008 онд 65.5 % болж бусад орнуудын дундаж болон улсын хэмжээний нөөц боломжоос хэтэрсэн үзүүлэлттэй байна гэдгийг анхаарууштай. (“Дэлхийн хөгжлийн үзүүлэлт-2007” эмхэтгэлээс үзэхэд, энэхүү үзүүлэлт 2005 онд ОХУ-д -20%, БНХАУ-д-11.1%, Арменийн-18.1%, Таджикастанд-13.7% байжээ) Судалгаанаас үзэхэд, 2000 оноос хойш манай улсын төсвийн зарлагын өсөлт ДНБ-ний өсөлтөөс байнга давж байжээ.

Манай орны хувьд шилжилтийн эдийн засгийн онцлог, төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагаас шалтгаалан хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэх бодитой шалтгаан байгаа хэдий ч төсвийн орлого нэмэгдэхийн хирээр төсвийн урсгал зардал дагаад үндэслэлгүйгээр нэмэгдэж ирсэнийг бодолцох шаардлагатай болжээ. Засгийн газрын зардлыг багасгаж, төсвийн урсгал зардлын өсөлтийг хязгаарлах шаардлагатай байна. Тухайлбал, 2008оны төсвийн нийт зарлагын 71% нь төсвийн урсгал зарлага байна. Үлдсэн 29% нь хөрөнгийн зардал буюу эргэж төлөгдөх цэвэр зээл байгаагаас үзэхэд цаашид төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үргүй зардлыг багасгах шаардлага бий болсон байна.

2008 оны нэгдсэн төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 386.6 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 305.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн ДНБ-ны 35.2%, Нийт зарлага, эргэж төлөгдөх зээл ДНБ-ны 40.2%, төсвийн нийт алдагдал ДНБ-ний 5% -ийг тус тус эзэлж байна. Өнгөрсөн онуудад төсөв ашигтай гарч байсан нь төсвийн орлогыг дутуу төлөвлөж байсан, мөн хөрөнгө оруулалтын зардлыг “хэмнэсэн”-тэй холбоотой гэдгийг ШУА-ийн харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн 2007 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн мэргэжлийн шинжилгээний тайланд тусгасан байна. Уг тайланд “Монгол улсын төсвийн тэнцэл сүүлийн 3 жилд ашигтай гарч байгаа нь сайшаалтай ч энэхүү “ ашигтай” байдал нь төсвийн болоод нийт эдийн засгийн тогтворгүй байдал руу аажмаар аваачих аюул дагуулж байх магадлалтай.

Сүүлийн 2 жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд манай улсын төсвийн орлого дэлхийн эрдэс баялгийн буюу алт, зэсийн үнийн өсөлтөөс шалтгаалсан “хэврэг” өсөлт байна. Энэ хэмжээгээр төсвийн үргүй зардал нэмэгдэж, улс орны эдийн

засаг экспорт, уул уурхайн салбараас хэт хамаарсан, эрдэс баялгийн үнийн хэлбэлзэлд өртөмтгий хэт мэдрэмтгий, эмзэг эдийн засгийн ттогтолцоог бий болгож байна” хэмээн урьдчилан анхааруулж байжээ.

Монгол улсын төсөв хэт халамжийн шинж чанартай болсон улс төрийн шалтгаан, амлалтын шинж шинж чанартай халамжийн зардлуудын талаар ч мөн анхааруулж, нийгмийн халамжийн зардлууд нь эргэлтэнд байгаа бэлэн мөнгөний хэмжээг нэмэгдүүлж, ингэснээр эрэлтийг нэмэгдүүлж инфляцийг хөөрөгдөх нэг эх сурвалж болж байна гэдгийг ч мөн дурьдсан байна.

2.3 Гадаад худалдааны төлбөрийн тэнцэл, ЗГ-ын өрийн байдал

Үзүүлэлтүүд	2006	2007	2008	2008\2007
Экспорт, сая ам. Доллар	1542,8	1949.2	2539.3	130.3
Импорт, сая ам,доллар	1485.6	2170.1	3615.8	166.6
Эргэж төлөгдөх цэвэр зээл		80.1	87.6	
- Гадаад зээлээр санхүүжих төсөл		72.7	68.9	
- Эргэж төлөгдөх цэвэр зээл		7.4	18.7	
Гадаад худалдааны тэнцэл, сая ам, доллар	57.2	-220.9	-1076.5	
Гадаад валютын цэвэр албан нөөц	687.3	1103.2	606.3	
- импортын 7 хоногоор	24.1	28.3	8.7	
Валютын зах зээлийн ханш, тухайн үеийн эцэст, 1 ам, доллар= төгрөг	1165.0	1169.97	1267.51	108.3
Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр		-133.2	-305.7	
Гадаад цэвэр		46.7	43.0	
Ашиглах төслийн зээл		96.0	88.8	
Ашиглах санхүүгийн зээл		-	-	
Зээлийн үндсэн өрийн төлбөр		-49.2	-45.8	
Дотоод цэвэр		-179.9	262.6	
Өмч хувьчлалын орлого		17.9	7.3	
Урт хугацаат бонд		-	-20.3	
Монгол банкны үндсэн өрийн төлбөр		-11.5	-	
ОУВС, цэвэр		-7.6	-5.9	
Банкны системээс		-178.8	281.5	

Эх сурвалж: Статистикийн бюллетень, 2008

2008 оныг 2007 онтой харьцуулахад урьдчилсан гүйцэтгэлээр экспорт 130.3%, импорт 166.6%-ийн гүйцэтгэлтэй байна. Гадаад худалдааны төлбөрийн тэнцэл 1076.5 сая ам.долларын алдагдалтай гарч, 2007 оныхоос алдагдал 855.6 сая ам доллар буюу 4.9 дахин өссөн байна. 2008 оны гүйцэтгэлээр манай улсын экспортын голлох нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ ханш оны 2-р хагасаас унаж эхэлжээ. Зэсийн үнэ 2008 оны 5-р сард 1тонн зэсийн баяжмалын экспортын дундаж үнэ 1.696 ам долларт хүрсэн нь хамгийн

өндөр үзүүлэлт байсан бөгөөд 6 сараас аажмаар буурсаар 1 тонн зэсийн баяжмалын үнэ 12 с ард 721 ам доллар болж өмнөх оны мөн үеийнхтэй харцуулахад 309 ам доллараар буюу 30 хувиар буурчээ.

Алт болон самнасан ноолуурын экспортын үнэ 7-р сараас эхлэн буурсан үзүүлэлттэй байсан ба алтны үнэ 12 сард өссөн үзүүлэлттэй гарсан бол ноолуурын экспорт буурсан үзүүлэлттэй гарчээ¹. 2008 оны гүйцэтгэлээр 3795 нэр төрлийн барааг импортоор оруулж ирсэн нь 2007 онытой харцуулахад 157 нэр төрлөөр өсчээ². Импорт өмнөх оныхоос 66.6 хувь буюу 1.455.7 сая ам. доллараар өссөний 64.2 хувь буюу 928.8 сая ам. доллар нь үнийн өсөлт, 35.8 хувь буюу 516.9 сая ам. доллар нь биет хэмжээний өсөлт байна. Импортоор нийлүүлэгдсэн барааны 84.3 хувийг валютын төлбөртэй худалдаа, 7.2 хувийг гадаадын хөрөнгө оруулалтын бараа, 1.7 хувийг тусламжийн бараа, 0.7 хувийг зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа, 0.2 хувийг хувийн захиалагчийн материал эзэлж байна.

Экспорт, импортын бараа гүйлгээний нийт эргэлт, хүлээгдэж байгаа төлбөр, татвар хураалт буурсантай холбоотойгоор төсвийн орлого бүрдүүлэлт буурсан байна. Тухайлбал, импортын барааны нэмэгдсэн өртгийн татвар 50.1 тэрбум төгрөгөөр, онцгой албан татвараас автобензин, дизель түлшний албан татвар 7.4 тэрбум төгрөгөөр, импортын архи, тамхи, пивоны албан ОАТ-589.1 сая төгрөгөөр тасарсан зэрэг үзүүлэлт байна. Нийтдээ гадаад худалдааны орлого урьдчилсан гүйцэтгэлээр 150.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байсан ба төлөвлөснөөс 5.4% буюу 8.6 тэрбум төгрөгөөр тасарсан байна. (импортын барааны гаалийн татвар- 142.0 тэрбум төг, экспортын барааны гаалийн татвар- 8.8 тэрбум төгрөг оржээ)

Манай улсын нийт импортын өсөлтийн хурд оны эхний хагастай харьцуулахад эрс буурсан нь гаалийн орлого тасрахад гол нөлөө үзүүлсэн. Оны эхний хагаст нийт импортын өсөлт өмнөх онтой харьцуулахад 60 гаруй хувьтай байсан бол оны сүүлийн саруудад 47% орчим болж буурсан байна. Түүнчлэн зарим барааны татварыг тэглэсэн, хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлсэн зэрэг нь төсвийн орлого бууралтанд нөлөөлсөн гэж холбогдох байгууллагууд дүгнэж байна

Судалгаанаас үзэхэд, төсвийн нийт орлогын ихэнх хувийг гадаад худалдааны татварын орлого- 150,8 сая, Онцгой албан татвар- 178.4, НӨАТ-355,0, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар- 388.7 болон уул уурхайн салбарын аж ахуйн нэгжийн албан татвар (ТЕГ-ын мэдээллээр 2007 оны байдлаар нэгдсэн төсвийн нийт орлогын 38.0%-д хүрсэн) зэрэг татварууд эзэлж байна гэсэн тоон үзүүлэлтүүд байна. Эндээс харахад манай орны төсөв уул уурхайн салбараас ихээхэн хараат, тэр тусмаа 2006 оноос хэрэгжиж эхэлсэн зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвартай холбоотойгоор экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох алт, зэсийн дэлхийн зах зээлийн үнээс ихээхэн хамааралтай төсөв болж хувирчээ.

Дэлхийн зах зээлийн үнэ ханш, байгаль цаг уураас шууд хамааралтай хөдөө аж ахуй, уул уурхайн салбар давамгайлсан бүтэцтэй манай орны эдийн засгийн бүтцийг сайжруулж, гадаад хүчин зүйлээс хамааралтай эрсдэлийг багасгах явдал өнөөгийн хөгжлийн тулгамдсан асуудлуудын нэг болж байна. ЗГ-ын гадаад өрийн тухайд, Монгол улсын Засгийн газар 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад орнуудаас зээлээр 86 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг авч ашиглахаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 68.9 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг төслийн зээлийн хэлбэрээр авч ашигласан гүйцэтгэлтэй байна.

¹ Статистикийн хороо “Монгол улсын эдийн засаг, нийгмийн байдлын тухай танилцуулга 59 дахь тал

² Статистикийн хороо “Монгол улсын эдийн засаг, нийгмийн байдлын тухай танилцуулга 60 дахь тал

2.4 Төрийн мөнгөний бодлогын хэрэгжилт, банк санхүүгийн системийн өнөөгийн байдал, авсан арга хэмжээ, үр дүн

Үзүүлэлтүүд	2006	2007	2008	2008\2007
ДНБ, оны үнээр тэрбум төг	3715.0	4599.5	6130.3	133.3
ДНБ, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг	3017.4	3325.9	3620.5	108.9
Мөнгө М2, 2008 оны 12 сарын эцэст, тэрбум төг	1536.5	2401.1	2341.4	97.5
Мөнгө М1, 2008 оны 12 сарын эцэст, тэрбум төг	331.9	590.5	660.6	111.9
Мөнгө Мо, 2008 оны 12 сарын эцэст, тэрбум төгрөг	381.8	535.0	633.2	
Банкнаас гадуурхи мөнгө, тэрбум төг	185.1	283.3	328.7	
Төгрөгийн харилцах, тэрбум төг	146.8	307.1	331.9	
Бараг мөнгө, тэрбум төг	1204.6	1810.8	1680.8	
Нийт хадгаламж, тэрбум төг	995.4	1489.7	1396.9	
Төгрөгийн хадгаламж, тэрбум төг	692.5	1113.7	944.1	
Валютын хадгаламж,	302.9	376.0	452.8	
Валютын харилцах	209.2	321.1	284.0	
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, жилийн эцэст, %	6.0	15.1	22.1	

Эх сурвалж: Монгол банкны мэдээ, мөнгөний үзүүлэлтийн тойм, 2008 оны 12 сар

2008 оныг 2007 онтой харьцуулахад, мөнгөний нийлүүлэлт М2-ийн хэмжээ өмнөх оноос 59.7 тэрбум төгрөгөөр, нийт хадгаламж- 92.8 тэрбум төгрөгөөр, валютын харилцах-39.1 тэрбум төгрөгөөр, төгрөгийн хадгаламж 24.1 тэрбум төгрөгөөр тус тус буурч, харин төгрөгийн харилцах болон валютын хадгаламж өссөн байна. Мөн банкнаас гадуурхи мөнгө 45.4 тэрбум төгрөгөөр өсчээ.

Төв банкнаас явуулж буй мөнгөний бодлого нь мөнгөний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр дамжуулан мөнгөний зах зээлийг тэнцвэртэй байлгахад чиглэгдэж байдаг. Мөнгөний зах зээлийн тэнцвэргүйгээр макро эдийн засгийн тэнцвэржилт гэж байхгүй. Онолын хувьд, мөнгөний нийлмэл эрэлт нь үндсэндээ ҮНБ-ний нэрлэсэн өртөгтэй тэнцүү байх ба, мөнгөний нийлмэл нийлүүлэлт нь мөнгөний массын нийт хэмжээгээр тодорхойлогддог. Судалгаанаас үзэхэд, Сүүлийн жилүүдэд мөнгөний нийлүүлэлт М2-ийн өсөлт нь ДНБ-ний өсөлтөөс харьцангуй бага байсан байна. Зарим судлаачид Төв банкнаас мөнгөний бодлогын хүүг шат дараатайгаар өсгөж 2008 оны 9 сар гэхэд 10.25 % болгосон, арилжааны банкуудын зээл олголтыг хязгаарлах зэргээр мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлж мөнгө зээлийн агрегатуудын өсөлтийг сааруулсан, инфляцийг дарангуйлах мөнгөний хатуу бодлогыг түлхүү явуулсан нь эдийн засгийн өсөлтийг саармагжуулсан гэсэн дүгнэлтийг хийж байна. Энэ нь үндэслэлтэй гэдэг нь дээрхи тоо баримтаас харагдаж байна.

Онолын хувьд мөнгөний зах зээлийн тэнцвэрийн талаархи монетаризм буюу” зоосны “ онол, мөн кейнсийн онол гэсэн онолын 2 урсгал зонхилох боловч төв банк мөнгөний ямар бодлого явуулах нь тухайн орны эдийн засаг , нийгэм, улс төрийн байдал, зах зээлийн мөчлөгт хэлбэлзлийн ямар шатны нөхцөлд бодлого боловсруулж байгаагаас ихээхэн шалтгаалдаг байна.

Төв банкны явуулж ирсэн бодлогоос үзэхэд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нь зөвхөн инфляцийг өдөөх гол хүчин зүйл болно гэсэн монетарист үзэлд тулгуурласан харагдаж байна. Гэтэл кейнсчүүд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нь богино хугацаанд үр ашгаа өгдөг, учир нь цалин хөлсний болон үнийн өсөлт уян хатан биш учраас мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлмэгц инфляци нэмэгдэхгүй, харин урт хугацаандаа инфляцийг өдөөнө гэж үздэг байна. Эдийн засгийг хямралт байдлаас гаргаж идэвхжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах зэрэг бодлогын чанартай арга хэмжээнүүдийг шийдвэрлэхийн тулд цаашид мөнгө зээлийн болон төрийн сангийн бодлогыг илүү боловсронгуй, уян хатан болгох, уялдаа холбоог сайжруулах шаардлагатай нь харагдаж байна.

Цаашид, ихэнх орны төрийн эрх барих дээд байгууллага нь шинэ санхүүгийн жилийн мөнгөний массын өсөлтийн дээд, доод хязгаарыг тогтоон өгч хэрэгжүүлэх үүргийг төв банкиндаа олгодог жишгийн дагуу Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд энэ асуудлыг тусгаж, мөнгө зээлийн бодлогыг уян хатан оновчтой болгох нь ялангуяа санхүүгийн хямралын энэ цаг үед чухал ач холбогдолтой арга хэмжээ болох болов уу.

2.5 Үйлдвэрлэл үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, инфляцийг бууруулах талаар авсан арга хэмжээ, үр дүн

	2006	2007	2008	2008]2007
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, жилийн эцэст , %-иар	6.0	15.1	22.1	
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг	1555.9	1716.9	1764.6	102.8
Нийт малын тоо, оны эцэст, сая толгой	43.8	40.3	43.3	107.5
Хураасан ургац, мянган тонн	138.6	114.8	212.9	185.5
Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа, сая тонн	24.0	23.3	23.9	102.5
Бүх төрлийн тээврээр тээсэн зорчигчид, сая хүн	195.4	209.9	231.6	110.3
Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр, тэрбум төгрөг	266.8	389.4	440.3	113.1

Эх сурвалж: Статистикийн бюллетень, 2008 оны 12 сар

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2008 оны жилийн эцэст 2007 оны жилийн эцсийнхээс 22.1 хувиар өсжээ. Хэрэглээний үний өсөлт нь Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн үндсэн чиглэлд дэвшүүлсэн хэрэглээний үний индексийг 6.0 хувьд

байлгахаар тавьсан зорилтоос 3.7 дахин өндөр байна. Түүнчлэн хэрэглээний үнийн улсын индексийн жилийн дундаж түвшин 2008 онд 28.0 хувь байгаа нь сүүлийн 10 жилд гараагүй өндөр үзүүлэлт юм.

Судалгаанаас үзэхэд, өрхийн хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг хүнсний барааны бүлгийн үнийн дүн 24.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 22.6 хувь, тээврийн үйлчилгээнийх 25.8 хувь, боловсролынх 39.9 хувь тус тус өссөн нь ерөнхий индекс 22.1 хувиар өсөхөд нөлөөлсөн байна. Хүнсний гол нэрийн барааны 2008 оны Улаанбаатар хотын томоохон захуудын үнэ, ханшид үндэслэсэн хүнсний гол нэр төрлийн 19 төрлийн барааны үнийн судалгааг хийж үзэхэд 12 нэр төрөл нь импортоос шууд хамааралтай байна.

Хүнсний барааны нэр	Оны эхэн дэх үнэ	Оны дунд үе дэх үнэ	Оны эцсийн үнэ	Импортоос хамааралтай эсэх
Алтан тариа дээд гурил	704	948	910	
Орос дээд гурил	715	930	890	хамааралтай
Хятад дээд гурил	600	800	800	хамааралтай
Цагаан будаа	675	1361	1289	хамааралтай
Шар будаа	600	1057	1167	хамааралтай
Хонины мах (цул)	2850	4214	2860	
Үхрийн мах (цул)	3800	4961	3744	
Адууны мах	2350	3400	2300	
Элсэн чихэр	725	948	933	
Сүү	900	713	950	хамааралтай
Ургамлын тос	2250	2975	3057	хамааралтай
Байцаа	675	778	763	хамааралтай
Манжин	600	1033	1000	хамааралтай
Төмс монгол	650	1089	900	
Төмс хятад	350	606	539	хамааралтай
Лууван монгол	550	1289	967	
Лууван хятад	-	817	700	хамааралтай
Сонгино хятад	578	772	687	хамааралтай
Өндөг	180	211	207	хамааралтай

Сүүлийн саруудад барааны үнэ оны дунд үеийнхээс буурч өсөлтийн хурд саарсан нь хүнсний гол нэрийн бараа болох мах, гурилын үнэ болон бензины үнэ тодорхой хувиар

буурсантай холбоотой байна. Улаанбаатар хотын үнийн олон жилийн динамикаас харахад хэрэглээний үнэ 1-5 сарын хооронд өсөөд, 6-9 сарыг хүртэлх хугацаанд бууран, 10-12 сард дахин өсдөг хандлагатай байсан болно. Өвөл хаврын саруудад инфляци өсдөг нь дотоодын үйлдвэрлэл багасч, экспорт бууран, импортын хэрэгцээ ихэсдэг, хавар хүнсний гол нэрийн барааны нийлүүлэлт хомсддог зэргээс голлон шалтгаалдаг. Харин зуны дунд сараас намрын дунд сар хүртлэх хугацаанд инфляци харьцангуй буурдаг нь энэ хугацаанд манай орны эдийн засгийн гол үйлдвэрлэл явагдаж, бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгддэгтэй холбоотой. Харин 2007-2008 онд уг хандлагад өөрчлөлт орсон байна. Тухайлбал, 2007 оны хувьд хэрэглээний үнэ сар бүр оны эцэс хүртэл тасралтгүй өсч байсан бол 2008 онд хэрэглээний үнэ 9 сар хүртэл байнга өсч байснаа 10 сараас оны эцэс хүртэл буурчээ.

Инфляцид нөлөөлсөн хүчин зүйлийн талаарх тойм

Манай улсад сүүлийн жилүүдэд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тасралтгүй өссөөр байгаа нь хүмүүсийн амьдралд бодит дарамт болоод зогсохгүй цаашид ч үнийн өсөлтийг хязгаарлаж чадахгүй байх гэсэн болгоомжлол, бухимдлын бас нэг шалтгаан болж байна. Үнийн өсөлтийн улмаас цалин, тэтгэвэрт авч байгаа мөнгөний худалдан авах чадвар буурсаар байна. Инфляцид нөлөөлж байгаа хүчин зүйлийн талаар Үндэсний статистикийн хороо, Монгол банк, Сангийн яам өөр өөрийн тайлбарыг хийсэн³.

Статистикийн хорооны судалгаанд инфляци нэг талаар өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийн харьцаа, нийт хэрэглээний зардалд эзлэх хувийн жинтэй холбогдон өөрчлөгдөх боловч нөгөө талаас, мөнгөний нийлүүлэлт, валютын ханш, хүн амын орлогын өсөлт зэрэг үзүүлэлтүүд нөлөөлсөн гээд үүний нотолгоо нь 2008 оны эхний 2 улирлын байдлаар цалин 2006 оныхоос 2.9 дахин өссөн бол инфляци 1.4 дахин нэмэгдсэн. Төсвийн байгууллагын ажилчдын дундаж цалин 1.0 хувиар өсөхөд хэрэглээний индекс дараа улиралд 0.36 хувиар өсөх магадлалтайг тооцоолжээ. Инфляцид нөлөөлөх бас нэг хүчин зүйл бол үйлдвэрлэлийн зардлын өсөлт бөгөөд сүүлийн 3 жилийн судалгаагаар шатахууны үнэ 10 төгрөгөөр нэмэгдэхэд хэрэглээний үнийн индекс тухайн сардаа 0.3 пунктээр, дараагийн сард 0.5 пунктээр өсдөг гэж тэмдэглэжээ.

Монгол банк инфляцийн шалтгааныг өргөн хэрэглээний барааны эрэлт, нийлүүлэлтийн харьцаа (нийлүүлэлт эрэлтийг гүйцэхгүй байгаа)-наас шалтгаалсан үнийн өсөлт (2008 оны инфляцийн 2/3 гаруйг зөвхөн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт эзэлж байгаа) голлох байрыг эзэлж байгаа бөгөөд төсвийн зарлагын хэт өсөлт, цалингийн өсөлт (үнэ-цалин-үнэ гэж нэрлэгдэх нөлөөлөл) цалин ба хөдөлмөрийн бүтээмжийн харьцаа алдагдсан, мөнгөний зөөлөн бодлогыг сүүлийн 10 гаруй жилийн турш хадгалсантай холбоотой гэж тайлбарласан байна⁴.

Сангийн яам инфляцид нөлөөлсөн хүчин зүйлийг тайлбарлахдаа нийлүүлэлт талаас нэгд, хүнсний барааны өсөлт, хоёрт, нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлт, эрэлт талаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөөс шалтгаалсан гэсэн үзсэн ба эрэлттэй холбоотойгоор нийгмийн халамжийн төлбөр, зээлийн хэмжээ нэмэгдэж хэрэглэгчдийн төлбөрийн чадвар сайжрахын хэрээр зах зээл дээр бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж үнэ өсдөг гэдгээр тайлбарлажээ. Үүний зэрэгцээ эрдэмтэд судлаачид инфляцийн огцом өсөлтөнд мөнгөний нийлүүлэлтийн зэрэгцээ төсвийн зарлагын өсөлт (Засгийн газрын зардал ДНБ-д 42 хувийг, инфляцийн 11.0 хувийг эзэлж байгаа) импортын шатахуун, хүнсний барааны үнийн өсөлт ихээхэн нөлөөлснийг тэмдэглэжээ. Мөн дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал, хүнсний бүтээгдэхүүний хомсдол нөлөөлж байна гэж үзэж байна.

³ Т.Дорж, Ц.Аюурзана Санхүү, эдийн засгийн хямралыг даван туулах боломж, арга зам

⁴ Мөн тэнд

Дүгнэж үзэхэд, 2007 оноос огцом өссөн инфляци нь макро эдийн засгийн мөчлөгийн өсөлттэй үед илэрч эхэлсэн бөгөөд манай орны хувьд эдийн засгийн мөчлөг нь мал аж ахуй давамгайлсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, энэхүү үйлдвэрлэлийн улирлын мөн чанараар тодорхойлогддог. Сүүлийн 3 жилийн туршид мөчлөгийн өсөлтийн үе ажиглагдаж, эдийн засаг тодорхой хэмжээнд “хөөрөлтийн төлөвт” орсон. Эдийн засгийн голлох салбаруудын өсөлт татварын орлогыг нэмэгдүүлж, нийгмийн халамжийн олон төрлийн тэтгэлгийг урамшуулж, тодорхой хэмжээгээр эрэлтийн инфляци үүсэх шалтгаан болжээ. Мөн дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал гүнзгийрсэн, зах зээл дээр хүнсний бүтээгдэхүүний хомсдол үүссэн, нефть бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнээс манай гол импортлогч хоёр хөрш оронд инфляци хурдацтай өссөн нь худалдааны нэн хараат манай эдийн засагт үнийн өсөлт шууд импортлогдож байна гэж үзэх үндэстэй байна.

Бүхэлд нь авч үзвэл, инфляцийн оргил үед буюу 2008 оны 6.7 сарын үед нийт инфляци 34% байхад хүнс болон шатахууны бүлгийн үнийн өсөлт 28% орчим хуьтай байжээ.

Үүнээс үзэхэд инфляцийн өсөлтөнд дэлхийн зах зээлийн хүнс, шатахууны үнийн өсөлт, бууралт илүү нөлөөлсөн байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Мөн сүүлийн үед инфляцийн хүчин зүйлд эдийн засгийн бус хүчин зүйл буюу улс төрийн инфляци гэсэн судалгааны шинэ хандлага гарч ирсэн. Үүний жишээ нь, улс төрийн зорилгоор бэлэн мөнгийг хавтгайруулан амлаж, олгож байгаа нь төсвийн зардлыг нэмэгдүүлж, мөнгөний ханшийг унагаах инфляцийн потенциал шалтгаан болж байна гэдгийг хаа хаанаа хүлээн зөвшөөрч байх шиг байна.

Судалгааны явцад, Монгол улсын эдийн засгийн ерөнхий байдлыг хэмжих гол хэмжүүрийг зөвхөн ДНБ-ний үзүүлэлтээр гаргаж байгаа нь учир дутагдалтай нь харагдлаа. Цаашид Үндэсний нийт бүтээгдэхүүн (ҮНБ), Үндэсний цэвэр бүтээгдэхүүн (ҮЦБ) -ний үзүүлэлтийг тооцож явбал монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын компаниудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хасч эдийн засгийн цэвэр өсөлтийг тооцох, мөнгөний массын удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, ялангуяа ашигт малтмалын салбарт гадаадын компаниуд хэдий хэмжээний үйлдвэрлэл явуулж, ашиг орлого олж байгааг тооцох, Монгол улсын ашигт малтмалын нөөцийн хорогдолт, нөхөн сэргээгдэхгүй элэгдэл хорогдол зэрэг олон чухал асуудлуудыг судалж анализ хийх боломжтой болох юм гэж үзэж байна. (Статистикийн эмхэтгэлд энэ үзүүлэлт тусгагддаггүй)

Нобелийн шагналт эдийн засагч Ж. Штиглиц Монголын ашигт малтмалын баялгийн талаар “Байгалийн баялаг ихтэй орны ард түмэн яагаад ядуурдаг вэ” гэсэг өгүүлэлдээ байгалийн баялгийг хөрсний дээр гаргахад капитал болж хувирах ба энэ капиталынхаа нөөцөөс зарцуулбаас улс орон тэр хэмжээгээр ядуурч буй хэрэг болно гээд дэлхий нийтээр улс орны үйлдвэрлэлтийг ДНБ-ээр хэмждэг гэтэл энэ нь ялангуяа байгалийн нөөц, баялгийн хувьд учир дутагдалтай үзэл баримтлал юм гэжээ. Тэрээр цааш нь хамгийн зохистой хэмжүүр бол Үндэсний цэвэр бүтээгдэхүүн (ҮЦБ) байх ёстой учир нь ДНБ-ний үзүүлэлт бол байгалийн баялгийн хорогдлыг тооцдоггүй.

Харин ҮЦБ –ний үзүүлэлт нь байгалийн баялгаасаа хороож байгаа улс орон аж ахуйн нэгжүүд элэгдэл хорогдол тооцдогийн нэгэн адил байгалийн баялгийн хорогдлыг тооцдогийн дээр агаар болон усны бохирдол зэрэг байгаль орчны хохирлыг тооцох боломж олгодог. т.е. ҮЦБ-ний үзүүлэлт нь тухайн оронд үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүнийг бус тэр бүтээгдэхүүнээс тухайн оронд орж байгаа орлогыг тооцдог. Хэрэв тухайн орон байгалийнхаа баялгийн төлбөрт авбал зохих ёстой нөхөн төлбөрөө гүйцэд авахгүй бол түүнийг хууран мэхэлж байгаа хэрэг бөгөөд үүний үр дүнд уг орон ядуурч буй хэрэг юм гэжээ. 15 жилийн өмнө уул уурхайн баялагтай улс орнууд ҮЦБ- ний үзүүлэлтийг ашигладаг байснаа ДНБ-ний үзүүлэлтэд шилжсэн нь тэдний хувьд том алдаа байсан гэж Ж.Штиглиц тэмдэглэжээ. (Зууны мэдээ, 2006.03.08)

2.6. Валютын зах зээлийн өнөөгийн байдал, төгрөгийн ханшийг тогтворжуулах талаар

Гадаад валютын цэвэр албан нөөц 606.3 сая ам доллар болж өмнөх онохоос 496.9 сая ам доллар буюу 45%-иар буурсан байна. Энэ нь манай улсын импортын 8.7 хоног буюу 2.2 сарын хэрэгцээг хангахуйц түвшин байна. 2008 оны Үндсэн чиглэлд гадаад валютын цэвэр албан нөөцийг 1662.5 сая ам. Доллар буюу 38.5 хоногийн нөөцтэй байхаар төлөвлөсөн боловч энэ зорилт биелсэнгүй. Төгрөгийн ам доллартай харьцах ханш 2007 оны эцэстэй харьцуулахад 8.3%-иар суларчээ. Төгрөгийн ханшийг тогтворжуулах, Монгол улсын эдийн засаг санхүүгийн нөөцийг бүрдүүлэх хүрээнд гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх мөн алт тушаалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1. Валютын нөөцийн талаар

АНУ-ын долларын ханш сүүлийн жилүүдэд харцангуй тогтвортой байж байгаад 2008 оны 10 сараас нэлээд хурдацтай өсөж 2009 оны 1 сарын дундаж ханш 1370.0 төгрөгийн ханштай байна. Доллар, юань, иен, евротой харьцах төгрөгийн ханш өмнөх жилүүдтэй харьцуулахад суларсан хандлагатай байхад фунт, рубльтэй харьцах төгрөгийн ханш чангарсан байна. Төгрөгийн ханшны энэ уналтад нөлөөлөх олон хүчин зүйлүүд байгаа бөгөөд энэ нь импортоос хаамрч байгаа юм. БНХАУ-аас импортын барааны ихэнх хувийг авдаг учир юаний ханш сүүлийн жилүүдэд тогтмол өссөн байна.

Инфляци нь хөрөнгө оруулалтын шийдвэрийг гажуудуулдаг тул дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг тогтвортой өндөр байлгахын тулд Монгол улсын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ улсын өрийн дарамтыг багасгах чиглэлээр сүүлийн жилүүдэд гарсан нааштай үр дүнг хадгалж тогтвортой хэмжээнд байлгах нь чухал болоод байна. Түүнчлэн, уул уурхайн бизнесийн орчинг ил тод, тогтвортой, олон улсын хэмжээнд өрсөлдөхийц болгож хөгжүүлэх зайлшгүй шаардлага гарч ирж байна.

Экспортын гол бүтээгдэхүүн болох зэсийн үнэ унасан ч, импортын гол бүтээгдэхүүн шатахууны үнэ мөн адил унасан. Энэ нь зэсийн үнийн уналтаас үүссэн хүндрэлийг тодорхой хэмжээгээр саармагжуулна. Дэлхийн зах зээл дээр алтны үнэ эргээд өсөх хандлагатай болж одоо нэг унц нь 860 доллараас даваад байна.

Гадаад валютын нөөц оны эцсийн байдлаар 560 сая доллар байгаа нь хэдийгээр ашигт малтмалын үнийн хэт хөөрөгдлийн үетэй харьцуулахад ихээхэн багассан ч олон жилийн дундажаас дээгүүр үзүүлэлт юм.

Орос, Хятадаас Монголын эдийн засаг ихээхэн хамааралтай учир хятадын засгийн газарын аж үйлдвэрийн салбараа уналтаас хамгаалахын тулд ихээхэн хөрөнгө гаргаж байгаа нь Монголын экспортод эерэг нөлөө үзүүлнэ. Орос улс сүүлийн жилүүдэд гадаад валютын ихээхэн нөөцтэй болсон нь хямралыг хохирол багатай давах нөхцөлийг бүрдүүлжээ.

Төгрөгийн ханшийг тодорхой түвшинд барих бодлогын хүрээнд валютын интервенц хийж, нөөцийг өсгөх боломжуудыг ашиглах, харьцангуй өндөр түвшинд хүрээд байгаа долларжилтыг бууруулах зорилгоор гадаад валютын хэрэглээнд зарим нэг түр зуурын хязгаарлалт хийж болох юм.

Өнөөдөр банк хоорондын валютын арилжаа хумигдаж, валютын арилжаа ченжүүдийн гарт орсон нь ихээхэн хүндрэлийг үүсгэж байна. Төв банк болон төрөөс үүнд оролцож зохицуулалт хийх арга механизм тодорхойгүй байна. Валютын арилжааг зохион байгуулалттай, хяналттай явуулах нэг арга бол сонгодог утгаар нь Валют арилжааны төвлөрсөн бирж байгуулах явдал. Аливаа биржийн арилжаа нь тодорхой дүрэм журам, хяналт зохицуулалттай явагддаг.

2) Алтны нөөцийн талаар



Алтны хувьд хамгийн тогтвортой металл хэвээр байх төлөвтэй байна. Европын орнуудад алтанд хийх хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр үнэ тогтвортой байна. Иймд алтны хангалттай хэмжээний нөөц бүрдүүлэх шаардлагатай байна. 2004 онд 11.5 тонн, 2005 онд 15.2 тонн, 2006 онд 9.0 тонн, 2007 онд 10.4 тонн болж алт тушаалт буурсан үзүүлэлттэй байна. (2008 оны мэдээлэл хангалтгүй) Тухайн жилд олборлосон алтыг Монгол банкинд бүрэн тушаадаг болгох арга замыг судлаж хууль эрх зүйн хүрээнд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх ажлыг хөтөлбөр, төлөвлөгөөтэйгээр эхлүүлэх шаардлагатай.

2.7 Санхүүгийн хямралтай холбогдуулан төр засгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн

Засгийн газрын зүгээс: 2008 оны 11-р сард хямралын үед шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлжээ. Үүнд:

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын мөнгөн хадгаламжинд 2008.11.20-ны өдрөөс эхлэн 4 жилийн хугацаатай, 100%-ийн баталгаа гаргасан.(Үр дүн: Олон нийтийн банкинд итгэх итгэлийг сэргээсэн нааштай арга хэмжээ болсон гэж үзэж болохоор байна. Анод банкны хадгаламжийн эрсдэлд тодорхой хэмжээний хөрөнгө гаргасан мэдээлэл байна. Тодорхой тоо баримт дурьдах боломжгүй байна.)
- МУ-ыг хөгжүүлэх сангийн эрсдэлийн сангийн чөлөөт үлдэгдэлийг арилжааны банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх богино хугацааны дэмжлэг үзүүлэх боломж бий болгосон хуулийн өөрчлөлт болон ЗГ-ын тогтоолуудыг гаргасан.
- Нийт ургацын 50% болох 100 гаруй мянган тонн үр тариаг худалдан авах боломжийг бүрдүүлж, энэ арга хэмжээнд зориулж 40 тэрбум төгрөгийн санхүүжилт гаргаж нөөц бүрдүүлсэн. Үр дүн: (Атрын 3-р аяны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Хүнс хөдөө аж ахуйн яамнаас гаргасан тооцоо, судалгаанаас үзэхэд, ЗГ-ын хөтөлбөрт 1тн улаан буудайн өөрийн өртөг 158.0 мянган төгрөг байхаар туссан ба 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр томоохон аж ахуйнуудын 1 тн буудайн өөрийн өртөг 280-300.0 мянган төгрөг буюу дунджаар 300.0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байна. Гэтэл Улсын фондод 1тн буудайг 400.0 мян. төгрөгөөр худалдан авч, 1 тн бүрт 80.0 мянган төгрөгийн урамшил олгосон нь 1тн буудайн бодит өртгөөс 180.0 мянган төгрөгөөр хэтэрчээ.)
- Санхүү, эдийн засгийн холбогдолтой асуудлыг УИХ, Засгийн газрын түвшинд түргэвчилсэн журмаар шийдвэрлэх үүднээс УИХ-ын дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулж, улмаар Засгийн газрын хуралдааны дэгд зохих өөрчлөлтийг хийсэн.
- Нефтийн бүтээгдэхүүний үнийг тогтвортой түвшинд байлгах зорилгоор онцгой албан татвар болон НӨАТ-ийн тухай хуулиудад зохицуулалт хийх боломжийг бий болгосон. Нефтийн бүтээгдэхүүн импортлох буй компаниулын зарим төрлийн татварыг 1 сарын хугацаагаар хойшлуулж ногдуулдаг болсон. Мөн нефтийн бүтээгдэхүүний онцгой татварыг төгрөгөөр тогтоох шийдвэр гарсан.гараагүй Түүнчлэн бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрүүдэд гадаад валютаар тогтоосон татвар, хураамжийг төгрөгөөр тогтоох асуудлыг судалж, санал боловсруулах ажлын хэсгийг томилон ажиллуулсан байна.
- Нийгмийн эмзэг бүлгийг бодитойгоор тодорхойлж, хоол хүнсний тусламж үзүүлэх хөтөлбөрийг АХБ, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж эхлэсэн байна. Энэ нь нийгмийн халамжийн бодлогыг хавтгайруулахгүй, зөвхөн тусламж зайлшгүй шаардлагатай эмзэг бүлэгт чиглүүлж байх бодлогын өөрчлөлтийн эхлэл болжээ.
- Барилгын салбарын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор, тэдгээрийн хүсэлтийн дагуу орон сууцаар барьцаалсан арилжааны банкууд дахь зээлийн багцаар барьцаалан Монголбанкнаас зээлийн эх үүсвэрийг тухайн банкуудад олгох асуудлыг Засгийн газар Монголбанкт хамтран шийдвэрлэсэн. Засгийн газраас ХБНГУ-ын 4.5 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкууд дахь орон сууцаар барьцаалсан зээлийг багцалж худалдан авч банкуудын зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Монголын ипотекийн корпораци (МИК)-д дамжин зээлдүүлэх асуудлыг

шийдвэрлэжээ.

- Алтны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж улмаар Монголбанкинд тушаах алтны хэмжээг өсгөж, валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар (68 хувийн татвар) ногдуулах алтны босго үнийг 500-аас 850 ам. долларт хүргэсэн хуулийн өөрчлөлтийг хийсэн байна.

Засгийн газар санхүүгийн болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Манай улс хуучин ОУВС-тай хөтөлбөрийн тодорхой хүрээнд хамтран ажиллаж байгаад хөтөлбөрийн хугацаа дууссан тул одоо тэднээс ямар нэг санхүүгийн болоод бусад зээл тусламж авах эрхгүй болсон тул түүнийг сэргээх ОУВС-тай хөтөлбөртэй болж, хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээл авах асуудлаар хэлэлцээр хийж байгаа
- Олон улсын санхүүгийн зах зээлд 1.2 тэрбум ам. долларын Засгийн газрын бонд гаргах
- Найрсаг харилцаатай улс орнуудаас 3 хүртэл тэрбум ам. долларын арилжааны зээл авах саналыг хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд ярилцаж байгаа.
- Оюу толгой, Таван толгойн хөрөнгө оруулалтын гэрээний талаарх хэлэлцээрт урьдчилгаа төлбөр авах асуудлыг ярьж байгаа.
- Олон улсын санхүүгийн байгууллага болон донор орнуудаас амласан зээл тусламжийг яаралтай авах асуудлыг хурдавчлан зохион байгуулан ажиллаж байгаа байна.
- Олон улсын банк, санхүүгийн хямралын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, улирлын чанартай төсвийн дутагдлыг нөхөх зорилгоор дотоодын зах зээлд 300 гаруй тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас гаргах эрхийг УИХ-аас шийдвэр гаргуулсан зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Төв банкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- 2007 оны 7 сараас эхлэн 7 хоногийн хугацаатай Төв банкны үнэт цаасны хүүг мөнгөний бодлогын хүү болгон зарлаж инфляцийг бууруулах зорилгоор мөнгөний хатуу бодлого баримталж бодлогын хүүгээ 2007 онд 6.4-8.4% хүртэл өсгөж байсан бол 2008 онд мөн хатуу бодлогоо үргэлжлүүлж 10.25%-д хүргэсэн байна. 2008.10 сараас эхлэн бодлогын хүүг 0.5 нэгжээр бууруулж одоо 9.75 % тай байна
- Арилжааны банкны заавал байлгах нөөцийг 2008.01.01-нээс 0.5 нэгжээр нэмэгдүүлж 5.5% болгосон бол 2008.10 сараас 0.5 % бууруулж 5.0% болгожээ
- 2008 оны 2-р улирлаас эхлэн арилжааны банкуудын богино хугацаат эх үүсвэрийг зохицуулах үүднээс төгрөг-ам долларын своп хэлцэл, эх үүсвэр нийлүүлэх хэлцэл буюу урвуу репо-хэлцэл, орон сууцны зээлийн дахин санхүүжилт, Монгол банкны барьцаат зээллэг зэрэг хэрэгслүүдийг нэвтрүүлсэн байна
- Төв банкны мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах бодлогын үр дүнд мөнгөний нийлүүлэлт 2008 оны 11 сард 2007 онтой харьцуулахад өсөлттэй байсан бол 2008 оны эцэст өнгөрсөн оны мөн үеэс 2.5%-иар буурч, өсөлтийн хурд 2.8 пунктаар саарсан байна. Нөөц мөнгөний хэмжээ 18.4%-иар өссөн ба энэ өсөлтийн 51.9 % нь банкнаас гадуурхи мөнгө байна.

Үр дүн: Төв банкны явуулсан бодлого, үйл ажиллагаа нь үндсэндээ инфляцийг дарангуйлахад чиглэгдсэн хатуу бодлого байсан ба 2008 оны 10 сараас эхлэн бага зэрэг зөөлрүүлэх хандлагатай болсон байна.

* * *

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Монгол улсын эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, санхүүгийн хямралын явц байдлын талаар та бүхнийг дээрхи судалгаа, дүгнэлтээс цэгцтэй мэдээлэл авсан байх гэж найдаж байна. Засгийн газраас санхүү, эдийн засгийн хямралыг даван туулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан УИХ-аар хэлэлцэн батлуулахтай холбогдуулан төр засгаас баримтлах бодлого чиглэлийг тодорхой болгох, хэрэгжүүлэх арга механизмыг оновчтой болгох үүднээс онолын үзэл баримтлал, олон улсын практик жишиг, эдийн засгийн бодит байдалд хийсэн дээрхи судалгааны дүн, салбарын эрдэмтэн судлаачид болон олон улсын байгууллагуудын санал, зөвлөмжүүдийг харгалзан доорхи дүгнэлт зөвлөмжийг гарган хүргүүлж байна.

1. Дэлхийн нийтийг хамарсан энэ удаагийн хямрал нь зөвхөн санхүүгийн төдийгүй зах зээлийн талаархи онол, үзэл баримтлалын буруу зөвийг ялгасан үйл явдал болж байна гэдгийг олон улсын нэртэй эрдэмтэн судлаачид тэмдэглэн хэлж байна. Эдийн засаг болон хөгжлийг зах зээл өөрөө “үл үзэгдэгч гар” эрэлт, нийлүүлэлтийн механизмаараа дамжуулан зохицуулна, тиймээс төрийн оролцоо, зохицуулалт бага байх ёстой гэсэн либерал тулгуур онол, үзэл баримтлал, түүнийг үндэс болгосон бодлого, үйл ажиллагаа бүтэлгүйтэж Кейнсийн онол номнол илүү зөв зүйтэй байсныг хямрал харуулж өгсөн ба АНУ болон бусад орнуудын Засгийн газрын эдийн засгийг сэргээх чиглэлээр хийхээр төлөвлөж буй багц арга хэмжээ нь Кейнсийн эмчилгээний жорыг бүрэн хэрэглэхэд чиглэгдэж байгааг зарим том эдийн засагчид тэмдэглэж байна. Саяхан төрийн ордонд болж өнгөрсөн зөвлөлдөх уулзалтан дээр гарсан саналууд, гадаад, дотоодын нэр хүндтэй эрдэмтэн судлаачдын нийтлэлд тусгагдсан саналуудыг багцлан авч үзвэл ихэнхдээ Кейнсийн онол, үзэл баримтлалын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний саналууд байгааг дурьдах нь зүйтэй болов уу. Иймээс хямралын үед төр засгаас баримтлах бодлогын онолын үндэслэл, үзэл баримтлал, төрийн бодлогын концепц, загварыг зайлшгүй тодорхойлох ёстой болж байна. Ялангуяа манай улс шиг зах зээлийн эдийн засаг бүрэн утгаараа төлөвшиж чадаагүй, хөгжиж буй улс орны хувьд төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай гэдэг нь тодорхой бөгөөд төр засгийн дэмжлэг туслалцаатайгаар л бид энэхүү хямралыг даван туулах нь тодорхой болж байгаа юм.
2. Эдийн засаг, санхүүгийн ноцтой хямралын үед ямарч улс гүрэн хямралаас зөвхөн мөнгөний бодлогын арга хэрэгсэлээр гарч чадахгүй гэдэг нь тодорхой байна. Урьд жилүүдэд, ялангуяа сүүлийн 1 жилийн дотор Төв банкнаас явуулсан мөнгөний хатуу бодлого нь эдийн засгийн мөчлөгт хөгжлийн үе шатанд нийцээгүй, харин ч бүр хямралыг даамжруулах, зөвхөн инфляцийг дарангуйлах хэт нэг талыг баримталсан бодлого байсан гэдгийг нилээд олон эрдэмтэн судлаачид шүүмжлэн хэлж байгаа. Мөнгөний бодлогын арга хэрэгсэл нь эдийн засаг “халсан” үед илүү үр дүнтэй байдаг бол эдийн засгийн уналтын үед төсвийн бодлого, засгийн газрын шийдвэртэй оролцоо гол арга хэрэгсэл нь болдог гэдгийг эрдэмтэд олон жилийн судалгаан дээр үндэслэсэн тогтоосон байна. Үүний нэг гашуун сургамж нь Японы “алдагдсан 10 жил”-ийн хямралын сургамж юм.
3. Хямралын үед үйлдвэрлэл буурч, ажилгүйдэл гаарч, хүмүүсийн амьдрал доройтон тэр нь эдийн засагт улам бүр ноцтой хүндрэл учруулдаг. Тиймээс ийм цаг үед эдийн засгийн тэргүүлэх бодлого, зорилт нь аль болох олон хүнийг ажилтай, цалин хөлстэй байлгах бодлого байдаг. Ийм зорилтыг мөнгөний хатуу бодлогоор биш, харин аль болох олон хүнийг хамруулсан дорвитой бүтээн байгуулалтыг өрнүүлэх замаар шийдвэрлэдэг байна. Тиймээс Засгийн газрын зүгээс төсөв, санхүүгийн эх үүсвэрийг дайчлан төвлөрүүлж, ялангуяа дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтыг эхлүүлэх нь эдийн засгийг сэргээх арга, ирээдүйн хөгжлийн суурь болдог байна. Ялангуяа манай орны эдийн засаг импортоос ихээхэн хараат болсон өнөө үед эдийн засгийн бодит

салбарын хөгжлийг дэмжин урамшуулах замаар эдийн засгийн бүтцийг сайжруулах, дотоодын үйлдвэрлэлд тулгуурласан өөрөө өөрийгөө тэтгэх эдийн засгийн бүтцийг бий болгох асуудал чухлаар тавигдаж байна.

4. Ноцтой хямрал , уналтын үед инфляц, төсвийн алдагдал гол асуудал биш болдог гэдгийг эрдэмтэн судлаачид хэлж байна.Эдийн засаг хэвийн байгаа үед инфляцийг бууруулах, төсвийг тэнцвэржүүлэх нь чухал бол хямрал уналтын үед энэ асуудлыг тодорхой хэмжээгээр хойшлуулах, мөнгөний нийлүүлэлтийг эдийн засгийн өсөлтөд нийцүүлэн нэмэгдүүлэх, мөнгө-зээлийн уян хатан бодлого явуулах шаардлагатай болдог байна. Гагцхүү төсвийн зардлын үр ашгийг нэмэгдүүлэх, захиргааны болон тэвчиж болох зардлыг хэмнэх тухай асуудал яригдах учиртай болж байна. Төсвийн зардлыг “хэмнэх” ганцхан зорилгын үүднээс бид төсвийн хөрөнгө оруулалтыг хязгаарлах нь эргээд эдийн засгийн хөгжлийг сааруулах түр зуурын арга хэмжээ болно гэдгийг урт хугацаандаа бодолцох хэрэгтэй байна. Мөн төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн ашиглах, татварын бодлогыг эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан явуулах нь зүйтэй юм. Хямралын үед төр засгаас арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ ЗГ-ын өрийг хэт нэмэгдүүлэхгүй байхад анхаарах нь зүйтэй болов уу.
5. Хямралыг зөөллөх нэг арга бол жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих асуудал байдаг.Энэ салбарын бизнесийн үйл ажиллагааг төр засгаас дэмжих, ялангуяа хөнгөлөлттэй, харьцангуй урт хугацаатай зээл олгох боломж нөхцөлийг Төв банк, ЗГ-аас бүрдүүлэх хэрэгтэй болж байна.
6. Хямралын үеийн бас нэг чухал бодлого нь нийгмийн хамгааллын асуудал байдаг. Манайд цалин хөлс, нийгмийн халамж өссөнөөс болж инфляци гаарсан мэт өрөөсгөл буруу хандлага газар авч, Төв банк зөвхөн инфляцийг онилсон бодлого явуулж байгаа нь бодит байдалд төдийлөн нийцсэнгүй. Судлаачид эдийн засгийн хөгжлийн үе шатанд инфляц тодорхой хэмжээгээр байх ёстой, манай улсад өнгөрсөн жилд инфляц 30% хувьд хүрч өссөн нь дундаж түвшний үзүүлэлт гэж үзэж байна. Судалгаанаас үзэхэд, өнгөрсөн онд манайд инфляц цочмог өссөн нь дэлхийд нүүрлэсэн хүнс, шатахууны үнийн өсөлт, зарим бизнес эрхлэгчид түүнийг далимдуулан үнийг зохиомлоор хөөрөгдөх явдал газар авсантай холбоотой гэж үзэж байна. Тэрнээс биш цалингийн өсөлт, нийгмийн хамгааллын зардлаас болж инфляц өсөөгүй гэдгийг тоо баримт харуулж байгаа юм. Инфляцийн өсөлт бууралт нь Төв банкны бодлогын үр дүн гэхээсээ илүү импортын барааны үнийн өсөлт бууралт, ахиухан ургац хураалт, бензин шатахууны үнийн бууралт зэрэг үнийн өөрчлөлт зэрэг хүчин зүйлтэй илүү холбоотой байна. Тиймээс мөнгөний нийлүүлэлтийг хязгаарлах нь тодорхой хэмжээгээр мөнгөний хомсдолыг үүсгэж хэрэглээ хумигдах, үйлдвэрлэл буурах зэрэг сөрөг нөлөө үзүүлж, банкууд зээлээ хумиснаас зах зээл дэх мөнгөний хомсдолыг үүсгэж байгаа нь судалгаанаас харагдлаа.
7. Нөхцөл байдал нэгэнт ийм болсон тохиолдолд Засгийн газар хямралыг зөөлрүүлэх, эдийн засгийн чөлөөт уналтад оруулахгүй байх чиглэлээр дорвитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай болж байгаа юм. Төрийн санхүү, төсвийн байдал хүндрэлтэй байгаа учраас ийм үүрэг хариуцлагыг хүлээх нь төсвийн алдагдалыг нэмэгдүүлэх, ЗГ-ийн өрийг нэмэгдүүлэх боловч Засгийн газар, Төв банктэй хамтран хямралыг давж гарах арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй юм.
8. Манай улсын эдийн засаг өнгөрсөн цөөн жилд өсөлттэй байсан нь хөрөнгө оруулалтын үр ашгаас бус гол төлөв хөрөнгө оруулалтын хэмжээний өсөлтөөр хангагдсан нь манай эдийн засаг тогтворгүй, эмзэг, эрсдэлтэй нөхцөл байдалд байгааг харуулж

байна. Гадаад худалдааны төлбөрийн тэнцэл, экспорт, импортын хувьд алт, зэс, цайр, жонш, молибдений баяжмал, ноос, ноолуур зэрэг экспортын барааны дэлхийн зах зээлийн үнэ оны 2-р хагасаас ихээхэн унасан, импортын барааны нийт хэмжээний 64.2% нь үнийн өсөлт, 35.8% нь биет өсөлт байна. Мөн импортоор нийлүүлэгдсэн барааны 84.3% нь валютын төлбөртэй худалдаа байна. Үүнээс үзэхэд, манай улсын эдийн засаг бүхэлдээ экспорт, импорт болон дэлхийн зах зээлийн үнийн өсөлт, бууралтаас ихээхэн хамааралтай “хэврэг” өсөлттэй байна гэдэг нь харагдаж байна. Иймээс экспортыг нэмэгдүүлэх, боловсруулах үйлдвэрлэл болон импорт орлуулах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, инфляцийн импортын хүчин зүйлийг бууруулах шаардлагатай байна.

9. Хямралыг амжилттай давж гарахын тулд улс орны эдийн засаг, санхүүгийн нөөц(алт болон валют)-ийг нэмэгдүүлэх, төгрөгийн ханшийг тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээг Төв банкнаас авч хэрэгжүүлэх шаардлагатай.
10. Валютын арилжааг зохион байгуулалттай, цэгцтэй явуулахын тулд өнөөгийн нөхцөлд Валютын биржийг сонгодог утгаар нь (төрийн оролцоотойгоор) байгуулах нь зүйтэй юм. Засгийн газар болон Монгол банк үүгээр дамжуулан валютын нөөцөө удирдах, валютын үнэ ханшид хяналт тавих, зохицуулалт хийх боломжтой.

* * *



Хямралыг даван туулах, эдийн засгийн хөгжлийг хангах чиглэлээр төр засгаас баримтлах бодлого, авч болохуйц арга хэмжээний санал, ЗӨВЛӨМЖ

Бодлогын чиглэлүүд	Бодлогын зорилтууд (Урт хугацаанд)	Хэрэгжүүлэх арга механизм (Дунд болон богино хугацаанд)
Макро эдийн засгийг тогтворжуулах, эдийн засгийн бүтцийг сайжруулах чиглэлээр	<ul style="list-style-type: none"> • Эдийн засгийн бүтцийг сайжруулж, бодит үйлдвэрлэлийн салбарыг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх • Нэмүү өртгийг бий болгодог боловсруулах үйлдвэр, импорт орлуулах бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх • Үндэсний үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх • ХАА, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх • Эдийн засгийг хувийн хэвшилд тулгуурласан олон тулгууртай болгох • Монгол улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулж рейтингийн үнэлгээг өсгөх, улмаар олон улсын зах зээлд гарч хөрөнгө оруулалт татах тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх • Үндэсний эдийн засгийн хөгжлийн загвар, концепцийг боловсруулах • Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого боловсруулах, хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн тогтвортой орчинг бий болгох • Санхүүгийн хямралыг даван туулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцоолж, гадаадын зээл тусламж болон дотоод эх үүсвэрийг дайчлан татах арга хэмжээ авах • Аж ахуйн нэгжийн элэгдэл хорогдлын шимтгэлийн сан байгуулж, хөрөнгө оруулалтанд чиглүүлэхийг бодлогоор дэмжих • Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээрүүдийг харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчмаар хийж яаралтай эхлүүлэх, ингэхдээ улс орны эдийн засагт оруулах хувь нэмэр, гарах үр дагаврыг тооцоолох • Улсын чанартай томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх • Стратегийн ач холбогдолтой түлш, эрчим хүч, дулаан зэрэг чухал салбаруудын үнэ тарифын хязгаарлалтыг багасгаж ирээдүйд гарч болзошгүй эрсдэлээс хамгаалах, энэ салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эрчим хүчний аюулгүй байдлыг хангах • Шударга бус өрсөлдөөн, үнийн монополизлыг хянах, таслан зогсоох арга хэмжээнүүдийг авах, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэх механизмыг тодорхой болгох • Төрийн мэдлийн Хөгжлийн банк (Хөрөнгө оруулалтын банк) байгуулах асуудлыг шийдвэрлэж, чухал салбаруудыг хөнгөлөлттэй зээл тусламж болон хөрөнгө оруулалтын хямд эх үүсвэрээр дэмжих • Болзошгүй эрсдэлээс хамгаалах улсын нөөц бүрдүүлэх • Статистикийн мэдээллүүдийг боловсронгуй болгох замаар зах зээлийн байдалд урьдчилан дүн шинжилгээ хийж боломжтой арга хэмжээг яаралтай авах, мэдээллээр шуурхай хангах • Эдийн засгийн үзүүлэлтийг ҮНБ, ҮЦБ-нээр тооцох аргачлал боловсруулах • Улсын хэмжээний санхүүгийн орлого, зарлагын төсөөллийн нэгдсэн баланстай болох 	<ul style="list-style-type: none"> • Монгол улсын эдийн засгийг урт болон дунд хугацаанд хөгжүүлэх хөгжлийн бодлого, концепци боловсруулах, хямралын үед баримтлах төрийн бодлого, хөтөлбөр боловсруулах үндэсний зөвлөлийг УИХ, ЗГ, Эрдэм шинжилгээ судалгааны хүрээлэнгүүдийн оролцоотойгоор байгуулах, • Эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбогдуулан УИХ-аар батлуулан мөрдөж буй төрийн бодлогын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж бодлого, төлөвлөлтөд өөрчлөлт оруулах асуудлыг судалж шийдвэрлэх • Оюу толгой, Таван толгой зэрэг ашигт малтмалын томоохон ордуудыг ашиглаж эхлэх, ингэхдээ тухайн салбарыг дагалдуулан орон нутагт дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтуудыг эхлүүлэх • Цахилгаан болон дулааны эх үүсвэр, өндөр хүчдэлийн шугам, авто болон төмөр зам барих зэрэг дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтуудыг голон улсын болон 2 талын хөгжлийн байгууллага, засгийн газруудын туслалцаатайгаар барьж байгуулах • Орон сууцны болон нийгмийн хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх • Эдийн засгийн нөөц бололцоондоо тулгуурлан зарим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээгээр төрөлжин хөгжих, тэргүүлэх салбарууддаа дэмжлэг үзүүлэх • Хөнгөлөлттэй зээл тусламжийг ихэвчлэн томоохон дэд бүтэц, үйлдвэрлэлийн бодит салбарт чиглүүлэх • Аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлага, санхүүгийн сахилга батыг сайжруулах • Хямралыг хамтын хүчээр даван туулах нийгмийн хариуцлагыг төрийн болон төрийн бус байгууллагын түвшинд ойролцоож, хамтран ажиллах • Бүх шатандаа "хэмнэлтийн" горимд шилжих, удирдлага, менежментийн зөв бодлого явуулахыг төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, бизнесийн хүрээнийхэнд ойлгуулах, харилцан итгэлцлийг бий болгох • эдийн засгийн хямрал, төр засгаас авч байгаа арга хэмжээний талаар нийгэмд үнэн зөв, тэнцвэртэй мэдээлэл өгч байх, нийгмийн сэтгэл зүйг хямралыг даамжруулах чиглэлд хандуулахгүй байхыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд анхааруулах, ЗГ-ын зүгээс ил тод, шуурхай мэдээллээр хангах



Төрийн санхүү,
төсвийн
удирдлагыг
сайжруулах
чиглэлээр

- Хямралын үед төрийн зохицуулалт, төсөв татварын механизм чухал ач холбогдолтойг харгалзан төсвийн удирдлага, санхүүжилтийн нэгдсэн бодлого боловсруулах, төсвийн тодотголыг нарийн тооцоо судалгаатай хийх
- Төсвийн бодлогыг төрийн мөнгөний бодлоготой нягт уялдуулах, хамтарсан бодлого, төлөвлөгөө хэрэгжүүлэх
- Төсвийн орлого, зарлагын бүтцэд дүн шинжилгээ хийх, Засгийн газрын өрийг хэт нэмэгдүүлэхгүйгээр хямралыг даван туулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- Төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой хувилбаруудыг эрж хайх, татварын механизмуудыг оновчтой ашиглах
- Монгол улсын эдийн засаг дахь татварын ачааллыг ДНБ-ний өсөлттэй харьцуулан зохистой түвшинд тогтоон барих, хямралын үеийн татварын менежментийг оновчтой болгох
- Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийг багасгах чиглэлээр тодорхой хязгаарлалт тогтоож төсвийн зардлын төлөвлөлтийг хийх. Ингэхдээ :
- Төсвийн зарлагыг хянах, тэвчиж болох зардлыг хэмнэх, амлалтын болон үр ашиггүй зардлаас аль болох татгалзах
- Төсвийн хөрөнгө оруулалтыг танах биш, аль болох үр ашигтай, бодит үйлдвэрлэлийн салбарт чиглүүлэх
- Төрийн албан хаагчид болон нийгмийн халамж эдлэх ёстой эмзэг бүлгийн цалин, тэтгэвэр тэтгэмжийг бууруулахгүй байх бодлого баримтлах, инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээ авах
- Ажлын байр нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлийн төсөл хөтөлбөр боловсруулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг гадаад, дотоодын зах зээлээс бүрдүүлэх
- Хямралыг даван туулахад төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээг тооцоолж ЗГ-ын өрийн хэмжээг зохистой түвшинд байлгах
- Төсвийн хөрөнгө оруулалтыг багасгаж, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтыг дэмжих үүднээс элэгдэл хорогдлын бодлогод өөрчлөлт хийх
- Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл боловсруулах явцад хийсвэрлэх бус, үндэслэл сайтай, эрсдэлийг бүрэн тооцоолсон байдлаар тоцоо хийх
- Татварын орлогын төлөвлөлтөд тавигдах хяналтыг сайжруулах. Татварын орлогыг нэмэгдүүлэх ихээхэн нөөц байгааг анхаарч ТЕГ-аар тооцоо судалгаа хийлгэх
- Хямралыг даван туулахад шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцоолох, хөрөнгийн нэмэлт эх үүсвэрийг босгох арга хэрэгсэлүүдийг судалж сонирхогч орнууд, санхүүгийн олон улсын байгууллагуудтай гэрээ хэлэлцээр хийх, олон улсын болон дотоодын зах зээлээс хөрөнгө босгох шууд болон шууд бус (үнэт цаасны) арга хэрэгсэлүүдийг ашиглах
- Төсвийн зардлын төлөвлөлтийг хийхдээ бодлогын зорилтуудад тусгасан асуудлуудыг харгалзан оновчтой, үр ашигтай хуваарилалт хийх, төсвийн удирдлагын менежментийг сайжруулах
- Хямралыг даван туулахад төрөөс хийх санхүүжилт, төсвийн алдагдалыг нөхөх эх үүсвэрийн тооцоог холбогдох байгууллагуудаар гаргуулж, зарцуулалтыг төлөвлөх
- Иргэдийн хадгаламж болон бодлогын түвшинд дэмжих салбаруудын гадаад, дотоодын банк санхүүгийн байгууллагаас авах зээлд ЗГ-аас баталгаа гаргах асуудлыг судалж, дэмжих
- Засгийн газрын бонд (урт хугацаатай, хөрвөх нөхцөлтэй) гаргаж гадаад, дотоодын санхүүгийн зах зээлээс хөрөнгө дайчлан төвлөрүүлэх арга хэмжээ авах. Ингэхдээ ЗГ-ын өрийн хэмжээг зохистой түвшинд байлгах
- Төсвийн хөрөнгө оруулалтыг ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрт чиглүүлэх
- ЗГ-аас тодорхой төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зориулан бонд гаргаж банк хоорондын захаар арилжаалах замаар хөрөнгийн эх үүсвэрийг татах, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх боломжийг судлах



Төрийн мөнгөний бодлого, банк санхүүгийн системийг сайжруулах чиглэлээр

- Төрийн мөнгөний бодлогод дүн шинжилгээ хийж, эдийн засгийг бүхэлд нь дэмжсэн, эдийн засгийн мөчлөгт хөгжлийн зүй тогтолд нийцсэн, хямралыг зөөлрүүлэх төсөв, санхүү, мөнгө зээлийн уян хатан бодлого явуулах
- Эдийн засагт шаардагдах мөнгөний нийлүүлэлтийг тэлэх, мөнгөний массын зохистой харьцааг бий болгож, мөнгөний агрегатуудын удирдлагыг сайжруулах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх
- Төв банк мөнгөний удирдлагын хэрэгсэлүүдээрээ дамжуулан мөнгөний эрэлт, нийлүүлэлтийн харьцааг зохистой түвшинд байлгах, эдийн засгийн хямралтай холбогдуулан мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх боломж, арга механизмыг тодорхойлох
- Эдийн засгийн тодорхой салбаруудыг дэмжих хөрөнгө оруулалтын зээлийн бодлого явуулах, шаардлагатай бол зарим салбарын зээлийн хүүг хөнгөлөх, хугацааг сунгах арга хэмжээ авах
- Арилжааны банкуудын зээлийн чанар, эрсдэл даах чадварыг сайжруулж банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх арга хэмжээ авах
- Арилжааны банкуудын зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хадгаламж эзэмшигчдийн мөнгөн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах
- Төрийн мөнгөний бодлогод дүн шинжилгээ хийж, төсөв- мөнгөний бодлогыг уялдуулах .Монгол банк, Сангийн яам хамтарсан төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх
- Эдийн засагт байгаа нийт мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, хямралыг зөөлрүүлэх бодлого баримтлах, банкнаас гадуурхи мөнгийг эргэлтэнд оруулах, мөнгөний агрегатуудын харьцааг сайжруулах талаар Монгол банкнаас тодорхой арга хэмжээ авах
- Бодлогын түвшинд дэмжих эдийн засгийн салбарт олгох зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгах боломжийг судалж, хямралын үеийн мөнгө-зээлийн нэгдсэн бодлого явуулах
- Хадгаламж эзэмшигчдийн мөнгөн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах үүднээс арилжааны банкуудад тавих хяналтыг чангатгаж, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх
- Төв банкны мөнгөний удирдлагын хэрэгслүүдийг эдийн засгийн нөхцөл байдалд тохируулан оновчтой ашиглах, гарч байгаа үр дүнд анализ хийж үр дүнг УИХ, ЗГ-т шуурхай тайлагнадаг болох
- Арилжааны банкууд ашгийн хойноос хөөцөлдөж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч, зээлийн хүүг бууруулах,хүүг хөнгөлөх, эрсдэлийг багасгах, зээлийн чанарыг сайжруулах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах
- Арилжааны банкуудын зээлийн хүүгийн тодорхой хувийг төрөс хариуцах боломж бий эсэхийг тооцоолох
- Үйл ажиллагаа нь доголдсон банкуудад төрөөс дэмжлэг үзүүлэхдээ хувьцааг нь худалдан авах боломжийг судлах
- Арилжааны банкууд гадаадын банк, санхүүгийн байгууллагаас хөнгөлөлттэй зээл тусламж авахад дэмжлэг үзүүлэх, энэ эх үүсвэрийг хөрөнгө оруулалтанд чиглүүлэх арга хэмжээ авах



- Санхүүгийн зах зээлийг төлөвшүүлэн хөгжүүлэх, санхүүгийн зах зээлийн хэрэгсэлүүдийг ашиглан хөрөнгө оруулалтыг дайчлан татах чиглэлээр
- Санхүүгийн зах зээлийг олон тулгууртай болгох үүднээс үнэт цаасны зах зээлийг дэмжин хөгжүүлж, дотоодын зах зээлээс урт хугацаатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг татан төвлөрүүлэх, эдийн засгийн бодит салбарын хөрөнгө оруулалтанд чиглүүлэх хууль эрх зүйн болон эдийн засгийн орчинг бий болгох
 - Даатгалын тогтолцоог төлөвшүүлэн хөгжүүлэх, ялангуяа хямралын үед даатгалын байгууллагуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх. Даатгалын сангийн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах хууль эрх зүйн болон эдийн засгийн орчинг бүрдүүлэх
 - Тэтгэврийн даатгал, нийгмийн даатгал зэрэг даатгалын тусгай зориулалтын сангуудын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулж бодит салбарын хөрөнгө оруулалтанд чиглүүлэх арга хэмжээ авах. Хөрөнгө оруулалтын сан, Итгэмжлэлийн сан зэрэг институциональ хөрөнгө оруулалтын сангуудыг бий болгох хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх
 - Ипотекийн зээлээр баталгаажсан үүнэт цаасны хоёрдогч зах зээлийг бий болгож барилгын салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр хууль эрх зүйн болон эдийн засгийн орчинг бүрдүүлэх
 - Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, компанийн засаглалыг боловсронгуй болгох, компанийн санхүүгийн тайланг ил тод нээлттэй болгох, санхүүгийн сахилга батыг сайжруулах, хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах
 - Улсын хэмжээний таваарын арилжааны бирж - биржийн цахим сүлжээ байгуулж ноос ноолуур, түүхий эд, төмс хүнсний ногоо зэрэг хөдөө аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнийг малчид тариаланчдын гар дээрээс худалдан авах тогтолцоо, шаардагдах дэд бүтцийг бий болгох
 - Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, барьцаалан зээлдүүлэх байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, хариуцлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох
 - Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг хянаж, зохицуулах эрх бүхий байгууллагаас хямралын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг УИХ-аар хэлэлцэн баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавих, мэдээллээр шуурхай хайгах тогтолцоонд шилжүүлэх
- Гадаад худалдааны төлбөрийн тэнцлийг сайжруулах, валютын зах зээлийг тогтворжуулах, улсын алтны болон валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр
- Монгол улсын эдийн засгийн экспорт, импорт болон дэлхийн зах зээлийн үнийн өсөлт, бууралтаас хамаарах хамаарлыг багасгах бодлого, чиглэл боловсруулан хэрэгжүүлэх
 - Экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг боловсруулах үйлдвэрлэл болон импорт орлуулах бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих
 - Санхүүгийн хямралыг даван туулах нөөц (алт болон валютын)-ийг бүрдүүлэх, төгрөгийн ханшийг тогтворжуулах, инфляцийн импортын хүчин зүйлийг багасгах арга хэмжээ авах
- “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулах, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлох
 - Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаас гаргагчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, хяналтын механизмийг тодорхой болгох, мэдээллийн үнэн зөв, нээлттэй, ил тод байдлыг хангах, компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах
 - Хөрөнгө оруулалтын сан, Итгэмжлэлийн сангийн тухай зэрэг шаардлагатай хуулийг батлан гаргах арга хэмжээ авах
 - Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлж, төвлөрсөн болон төвлөрсөн бус арилжааны биржүүд (электрон арилжааны бирж), санхүүгийн зуучлалын компаниуд, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх компаниудыг бий болгох, тэдгээрт тавигдах мэргэжлийн болон хариуцлагын шаардлагыг өндөржүүлэх
 - нийгмийн даатгалын зарим сангууд төсөвтэй хутгалдсан байдлыг анхаарах, даатгалын сангуудыг хуримтлалын горимд шилжүүлж, хөрөнгийн чөлөөт үлдэгдэлийг үнэт цаасны зах зээлээр дамжуулан хөрөнгө оруулалтанд чиглүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх
 - Таваарын арилжааны бирж байгуулж хөдөө орон нутгийн малчид, тариаланчдын бүтээгдэхүүнийг гар дээрээс нь худалдан авах цахим сүлжээ, дэд бүтцийг бий болгох асуудлыг холбогдох яам, агентлагуудаар судлуулж, эрх зүйн орчинг бүрдүүлэх
 - Үнэт цаасны зах зээл, Даатгал, Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоо, Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, Валют арилжааны цэгүүдийн үйл ажиллагааны талаархи Санхүүгийн зохицуулах хорооны дүн шинжилгээ, тайланг УИХ-ын Байнгын хороодоор сонсож, холбогдох арга хэмжээ авах
- Импортын зарим барааны үнэ дэлхийн зах зээлд буурч байгааг харгалзан эдгээр бараа, бүтээгдэхүүний үнийг дотооддоо бууруулах арга хэмжээ авах
- Экспортыг дэмжиж гадаад валютын хангалттай нөөц бүрдүүлэх
 - Төгрөгийн ханшийг тогтворжуулах үүднээс валютын интервенц хийх, гадаад валютын хэрэглээнд хязгаарлалт тогтоох,
 - Монгол улсын гадаад валютын нөөц, харилцах, хадгаламж байрладаг банкуудын баталгаат байдлыг тогтмол хянаж, сонор сэрэмжтэй байх, гадаад валютын нөөцийг санхүүгийн элдэв эрсдэлтэй бүтээгдэхүүнээр солих, дилерийн арилжаа хийхийг түр зогсоох
 - Тухайн жилд олборлосон алтыг Монгол банкинд бүрэн тушаадаг болох эрх зүйн болон эдийн засгийн механизмийг бий болгох



<p>Хэрэглээний үнэ, инфляцийг бууруулах чиглэлээр</p>	<ul style="list-style-type: none"> • Инфляцийг бууруулах чиглэлээр урт хугацааны эдийн засгийн цогц бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх • Инфляцийн бодит өсөлт, импортын нөлөөллийг бууруулах, үнийн хөөрөгдлийг багасгах, төгрөгийн худалдан авах чадварыг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудаас хамтран арга хэмжээ авч хэрэгжүүлэх • Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг бууруулах • Улс төрийн" амлалт"-аас үүдэлтэй инфляцийн хүчин зүйлийн нөлөөллийг багасгах, инфляцид улс төрийн хүчин зүйлийн нөлөөллийг тооцдог хандлагыг хэвшүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Импорт орлуулах бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих • Зарим барааг гаалийн татвараас чөлөөлөх, хөнгөлөх • Дотооддоо үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний импортын гаалийн татварыг нэмэгдүүлэх • Фермерийн аж ахуй, газар тариалангийн аж ахуйнуудыг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх • Хөдөө аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт дэмжлэг үзүүлэх, техник технологийг сайжруулах • Үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмжийн гаалийн татвар хураамжийг хөнгөлөх, чөлөөлөх • Улс төрийн зорилгоор нийгмийн халамжийн шинэ амлалтуудыг авахгүй байх
<p>Нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах чиглэлээр</p>	<ul style="list-style-type: none"> • Сүүлийн үед эдийн засгийн онолын сэтгэлгээнд өөрчлөлт орж нийгмийн баримжаатай, төрийн зохицуулалттай эдийн засгийн бодлого, чиглэлийг баримтлах болсоныг харгалзан төсөв- мөнгөний нөөц бололцоогоо зөв хуваарилах бодлого баримтлах • Төсвийн бодлого нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах, ажилгүйдэл ядуурлыг бууруулахад чиглэгдсэн байх учиртайг харгалзан энэ чиглэлийн төсвийн зарлагыг танахгүй байх, зайлшгүй шаардлагатай нийгмийн халамжийн зардлын квотыг тогтоох, нэмэгдүүлэх арга хэмжээ авах • Одоо мөрдөгдөж буй хууль эрх зүйн хүрээнд олгогдож буй нийгмийн халамжийн зардал, тэтгэвэр тэтгэмж, тусламжийн байдалд дүн шинжилгээ хийж давхардлыг арилгах, айл өрхийн амьжиргааны түвшинд нийцүүлэн ялгавартай хуваарилах тогтолцоог бий болгох 	<ul style="list-style-type: none"> • Халамжийн тэтгэмж, тусламжийг айл өрхийн амьжиргааны түвшинг харгалзан ялгавартай тогтоох • Нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн тэтгэмж, тусламжийг нэмэгдүүлэх • Нийгмийн халамж ,үйлчилгээтэй холбоотой тэтгэвэр тэтгэмжийн байдалд тооцоо судалгаа хийж, төсвийн нийт зарлагын бүтцэд • Ажлын байр шинээр бий болгох, ядуурлыг бууруулах чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх • Төрийн албан хаагчид болон нийгмийн эмзэг давхаргын цалин хөлсийг бууруулахгүй байх, инфляцийн түвшинтэй уялдуулан зохист харьцаанд байлгах
<p>Гадаад харилцааг эдийн засагжуулах, гадаадын банк санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр</p>	<ul style="list-style-type: none"> • Гадаад харилцааг эдийн засагжуулах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх • Гадаад худалдааг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх • Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх • Эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлээр бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх • Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн чиглэлээр бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх • 2 талын болон бус нутгийн чөлөөт худалдааны хэлэлцээрт орох • Олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх • Олон улсын худалдааны хөнгөлөлтийн системд хамрагдах • Гадаадын шууд болон шууд бус хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх • Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрийг 2 талын болон олон улсын банк санхүүгийн байгууллага, гадаад зах зээлээс эрж хайх • Хөрөнгө оруулалтын тогтвортой орчинг бий болгох 	<ul style="list-style-type: none"> • Үндэсний хэмжээнд гадаадын зээл тусламжаар санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг боловсруулж аль улсын банк, санхүүгийн дэмжлэг тусалцаатайгаар санхүүжүүлэх боломжтойг судлах • Гадаад харилцааг эдийн засагжуулах бодлогын хүрээнд хууль тогтоомжид холбогдох өөрчлөлт оруулах • Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай шинэ технологи, шинэ бүтээгдэхүүн, шинэ зах зээлийг бий болгох талаар судалгаа хийх • Гаалийн болон бусад хязгаарлалтгүйгээр бараа бүтээгдэхүүнээ нийлүүлэх улс орон, зах зээлийг эрж хайх • Экспортын бүтцийг өөрчлөх, нэр төрлийг олшруулах, тарифын болон тарифын бус хориг саадыг багасгах • Импортыг бууруулах, импорт орлуулах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

* * *

Ашигласан материал

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль. 2002 он <http://www.parliament.mn/>

2. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль. 2002 он <http://www.parliament.mn/>
3. Татварын ерөнхий хууль. 2008 он. <http://www.parliament.mn/>
4. Банкны тухай хууль. 1996 он. <http://www.parliament.mn/>
5. Гаалийн тарифын тухай. 1996 он. <http://www.parliament.mn/>
6. Гаалийн тухай хууль. 2008 он. <http://www.parliament.mn/>
7. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал. 1994 он <http://www.parliament.mn/>
8. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай. 2007 он. <http://www.parliament.mn/>
9. Засгийн газрын тусгай сангийн тухай. 2006 он. <http://www.parliament.mn/>
10. Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр <http://www.open-government.mn/>
11. Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэл . УБ., 2008 он
12. Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл . 2008 он. <http://www.parliament.mn/>
13. Монгол Улсын статистикийн эмхтгэл. УБ., 2005 он
14. Монгол Улсын статистикийн эмхтгэл. УБ., 2006 он
15. Монгол Улсын статистикийн эмхтгэл. УБ., 2007 он
16. Монгол Улсын Засгийн газар. Монгол Улсын 2007 оны төсвийн гүйцэтгэл. УБ., 2008 он
17. Статистикийн бюллетень. 2008 оны 1-12 сар. ҮСХ, 2008 он
18. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн байдлын тухай танилцуулга. ҮСХ, 12/2008, УБ., 2008 он
19. Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл. ГЕГ, 2008 оны 1-4 сар. УБ., 2008 он
20. Монгол банкны статистик бюллетень. 12/2008, УБ., 2008 он
21. Монгол банкны судалгааны ажил. Монгол Банк. УБ., 2005 он
22. Монгол Банк. Жилийн тайлан 2006. УБ., 2007 он
23. Монгол Банк. Жилийн тайлан 2007. УБ., 2008 он
24. Төрөөс мөнгөний талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл. <http://www.mongolbank.mn/>
25. Монгол Улсын 2005 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн мэргэжлийн шинжилгээ. Сангийн яам, Дэлхийн банк, Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны зээлийн төсөл. УБ., 2006 он
26. Монгол Улсын 2006 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн мэргэжлийн шинжилгээ. Сангийн яам, Дэлхийн банк, Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны зээлийн төсөл. УБ., 2007 он
27. Монгол Улсын 2007 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн мэргэжлийн шинжилгээ. МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын Газар, ШУА-ийн харъяа Үндэсний Хөгжлийн Хүрээлэн. УБ., 2008 он
28. П.Жасрай. Эдийн засгийн онол. УБ., 2002 он
29. О.Чулуунбат. “Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал: уг сурвалж, учир шалтгаан, үйл явц, чиг хандлага” илтгэл, Төрийн ордон/зөвлөлдөх уулзалт. 2009.01.23.
30. С.Баярцогт. “Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал, Монгол улсад үзүүлж байгаа нөлөөлөл, төр засгаас авч явуулж байгаа бодлого, арга хэмжээ” илтгэл, Төрийн ордон/зөвлөлдөх уулзалт. 2009.01.23.
31. С. Батболд. “Гадаад орчны өөрчлөлт, гадаад эх үүсвэрийг дайчлах боломж, гадаад харилцааг эдийн засагжуулах шаардлага” илтгэл, Төрийн ордон/зөвлөлдөх уулзалт. 2009.01.23.
32. Ч.Хүрэлбаатар. “Төсвийн орлогыг нэмэгдүүлэх, хямралын нөхцөл дэх хэмнэлтийн бодлого” илтгэл, Төрийн ордон/зөвлөлдөх уулзалт. 2009.01.23.
33. Т.Дорж, Ц.Аюурзана. “Санхүү, эдийн засгийн хямралыг даван туулах боломж, арга зам” илтгэл, Төрийн ордон/зөвлөлдөх уулзалт. 2009.01.23.
34. ОУВС-гийн Суурин төлөөлөгч Бён Гюн Жанг, “Монгол улсад хямралын үзүүлэх нөлөөллийг багасгах асуудлууд” илтгэл, Төрийн ордон, 2009.01.23.

35. Дэлхийн банкны Суурин төлөөлөгч Аршид Саед. “Төгс шуургыг зохистойгоор удирдах нь” илтгэл, Төрийн ордон/зөвлөлдөх уулзалт. 2009.01.23. Монгол улс болон шилжилтийн улс орнуудын жижиг, дунд үйлдвэрлэлийн экспортыг дэмжих бодлого, арагчлал, арга хэмжээний талаарх судалгаа. УБ., 2004 он
36. Монгол улс: Сонгомол асуудлууд. ОУВС, УБ., 2008 он
37. Орлого ашгийг нэгтгэж, үсрэнгүй хөгжлийг удирдан төрийн үйлчилгээг сайжруулахад чиглүүлэх нь. Улсын зарлага ба санхүүгийн удирдлагын тойм судалгаа. УБ., 2008 он
38. Ц.Батсүх. Инфляцийн эсрэг макро эдийн засгийн бодлого. УБ., 2008 он
39. Ч.Баатар. Кейнсийн жор хямрал, уналтыг зөөллөх бодлогын гарц. “Зууны мэдээ”, 2009.1.26.№19
40. Роберт Ж. Шапиро. Монгол Улсын хувьд уул уурхай бол эдийн засгаа цаашид шинэчлэхэд хүргэх цорын ганц түлхүүр. www.news.mn
41. Лондонгийн металлын бирж - www.lme.co.uk
42. 2007 world copper fact book – International copper study group Lisbon, Portugal.
43. Монгол улсыг хөгжүүлэх сангийн гүйцэтгэл 2006, 2007, 2008 он /Сангийн яам/
44. www.bloomberg.com – санхүүгийн зах зээлийн веб хуудас
45. www.finance.yahoo.com – санхүүгийн зах зээлийн веб хуудас
46. www.kitco.com – үнэт металл алтны мэдээлэл бүхий веб хуудас
47. Mongolian mining journal. УБ., 2008/11; 2009/01 сар
48. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн сэдвээр өдөр тутмын сонинд нийтлэгдсэн нийтлэлийн түүвэр. УИХ-ын номын сан. I-III боть.



СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛТОЙ САЛБАРУУДАД ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ХУВЬЦАА ЭЗЭМШИХЭД ТАВИХ ХЯЗГААРЛАЛТ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Ц. Норовдондог (Ph.D), Д. Ариунаа (MSc)

Судалгаа, мэдээллийн зорилго нь бизнес-хөрөнгө оруулалтын хүрээ өргөжин тэлж байгаа глобалчлалын өнөө үед гадаадын компанид хөрөнгө оруулах болон гадаадын хөрөнгө оруулагчид стратегийн ач холбогдолтой үндэсний компанийн хувьцааг эзэмшихэд дэлхийн бусад орнуудад хуулиар тавьж буй хязгаарлалтууд, нийтлэг хандлага, хязгаарлалт тавих шаардлага, шалтгаан, ач холбогдолыг тодруулахад оршино.

1. Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах шаардлага

Гадаадын хөрөнгө оруулалтад тавих хяналтын нэг хэлбэр нь Гадаадын хөрөнгө оруулагчдын хувьцаа эзэмших эрхийг хязгаарлах явдал юм. Тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулагч тодорхой нэг компанийн хувьцааг эзэмшихийг бүрэн хориглох, тодорхой хувийг эзэмшихийг зөвшөөрөх(49%-иас доош хувь эзэмших), эсвэл холбогдох төрийн захиргааны байгууллагаас урьдчилж зөвшөөрөл авсаны үндсэн дээр хувьцаа эзэмших зэрэг аргуудыг бусад орнууд хэрэглэдэг байна.

Түүнчлэн янз бүрийн “ нууцлаг” барьерууд ч байдаг байна. Жишээ нь: Хэрвээ төрийн өмчит компанийг хувьчилж байгаа бол төрийн өмчийн хувьцааг гадаадын хөрөнгө оруулагчид ихээхэн өндөр үнээр худалдах, мөн гадаадын хөрөнгө оруулалттай компанийн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхи нь тухайн орны иргэн байх гэх мэт. Иймэрхүү шаардлагууд Европын холбооны орнуудад датгалын салбарт, Канадад санхүүгийн салбарт, Японд тээврийн салбарт тавигддаг байна.

Уламжлалаас үзэхэд, гадаадын хөрөнгө оруулалт, ялангуяа хувьцаа эзэмшихэд тавигдах хязгаарлалтууд хөгжиж буй орнуудын хувьд түгээмэл байдаг. Гэвч сүүлийн жилүүдэд АНУ, Баруун Европын өндөр хөгжилтэй орнууд ч гэсэн иймэрхүү хязгаарлалтуудыг тавьж эхэлсэн байна.

OECD-гийн гишүүн орнуудаас одоогийн байдлаар Исланд, Канад, Турк, Мексик, Австри, Австрали, Өмнөд Солонгос, Япон зэрэг орнууд гадаадын хөрөнгө оруулалт, тэр тусмаа гадаадын хөрөнгө оруулагчид хувьцаа эзэмшихэд хамгийн олон хязгаарлалтуудыг тавьж байна. Тухайлбал, Хятад, Япон зэрэг орнууд харилцаа холбооны компаниудын хувьцааг гадаадын хөрөнгө оруулагчид эзэмшихийг хориглосон байдаг. Исландад, загас агнуур, эрчим хүчний салбарт, Мексикт үндэсний нефтийн компаниудын хувьцааг гадаадын хөрөнгө оруулагчид эзэмшихийг бүрэн хориглосон .

Гадаадын хөрөнгө оруулагчдад хувьцаа эзэмшүүлэхийг хязгаарлах бодлого нь дараахь шалтгаанаас үүдэлтэй. Үүнд:

- Эдийн засгийн
- Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах
- Улс төрийн

Эдийн засгийн шалтгаан нь ихэвчлэн хөгжиж буй орнуудад түгээмэл байдаг бол үндэсний аюулгүй байдлыг хамгаалах шалтгаан нь өндөр хөгжилтэй орнуудад чухал шалтгаан болдог байна.



Гадаадын хөрөнгө оруулалт, тэр тусмаа гадаадын хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшихийг хязгаарлаж буй салбарууд нь ихэвчлэн байгалийн нөөц баялгийг ашиглах болон батлан хамгаалах салбар байна. Мөн эрчим хүч, тээвэр, харилцаа холбооны салбарт энэ хязгаарлалтыг түгээмэл хэрэглэдэг байна.

2. Дотоодын хөрөнгө оруулалтыг хамгаалахтай холбоотой хязгаарлалтууд

Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах эдийн засгийн шалтгаан нь юуны өмнө тухайн салбарын бодлоготой холбоотой. Тухайлбал, хэрвээ Төрийн зүгээс тодорхой салбарт дотоодын бизнесийг дэмжих бодлого барьж байгаа бол тухайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласнаар үндэснийхээ бизнесийн салбарыг “ томруулах” хөл дээр нь босгох бодлого барьж улмаар гадаадын хөрөнгө оруулалтад тавих хязгаарлалтыг хүчингүй болгосны дараа гадаадын хөрөнгө оруулагчтай өрсөлдөх хэмжээний үндэсний томоохон хэмжээний компанийг бий болгох зорилготой. Ийм бодлого бариагүй тохиолдолд санхүүгийн болон материаллаг бус нөөц боломж ихтэй гадаадын компаниуд зах зээл дээр монополь тогтоож, дотоодын компанийг өсөж хөгжихийг хязгаарлах магадлал их байдаг байна.

Тодорхой салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах бодлого нь түр зуурын шинжтэй байх ба үүнийг дэлхийн олон улс орнууд хэрэглэж байна. Хэдийгээр иймэрхүү хязгаарлалт тогтоох практик нь Олон улсын худалдааны байгууллагын тогтоосон де-факто буюу олон улсын худалдаа хийхэд ямар нэгэн саад тогтор үзүүлж буй ялгаварласан асуудал болох боловч ОУХБ нь эдийн засгийн тодорхой салбарт хязгаарлалт , хориг тавихыг зөвшөөрдөг байна. Гэхдээ тухайн улс орон тодорхой хугацааны дараа энэхүү хориг, саадыг өөрчлөх үүрэг хүлээх ёстой гэсэн нөхцөл тавьдаг.

Эдийн засгийн шалтгаанаар тодорхой салбарт хөрөнгө оруулахыг хязгаарласан орнуудын тоонд Латин Америкийн хэд хэдэн орнууд орж байна. Жишээ нь, Чили улс далайн тээвэр, атомын цахилгаан станцад гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан. Аргентин улс санхүүгийн салбарт, даатгал, радио телевизин салбарт, Бразил улс мөн санхүүгийн сектор, төмөр зам, уул уурхай, холбооны салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан байна.

Тухайн улс орон гадаадын хөрөнгө оруулалтын хязгаарлалтыг хэрхэн хуульчилсанаас шалтгаалан энэхүү барьерийг гадаадын хөрөнгө оруулагчид хэд хэдэн янзаар даван туулдаг байна. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулагчид тухайн улс оронд хэд хэдэн жижиг компани байгуулах замаар хориг тавьсан салбарын компаниудын хувьцааг худалдан авдаг. Гэхдээ цаад хөрөнгө оруулагч нь гадаадын ААН, хувь хүн байлаа ч гэсэн тухайн орны хууль болон Олон улсын гэрээгээр худалдан авагч компани нь гадаадын хөрөнгө оруулагч гэж тооцогдохгүй учраас маргаан үүссэн тохиолдолд уг компани гадаадын хөрөнгө оруулагчийн хувьд эрхээ хамгаалуулах боломжгүй болдог байна.

3. Үндэсний аюулгүй байдал болон улстөрийн шалтгаантай холбоотой хязгаарлалтууд

Энэ төрлийн хязгаарлалтууд нь ихэвчлэн өндөр хөгжилтэй орнуудад хэрэглэгддэг бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тодорхой компанийн хувьцааг эзэмших хэлцэл хийхийг тодорхой салбарын хувьд бүхэлд нь хориглох, эсвэл нэг удаагийн хязгаарлалт байж болдог. Эдийн засгийн шалтгаантай хязгаарлалтаас ялгаатай нь гэвэл ОУХБ-ын зүгээс үндэсний аюулгүй байдлын шалтгааныг харгалзан ямар нэгэн хориг тавихгүй бөгөөд үүнийг түр зуурын арга хэмжээ гэж үздэг. Тухайлбал, ОХУ 2008 онд “Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдолтой аж ахуйн нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулах тухай” хуулийг батлан гаргасан байна. Энэ хуулиар, ОХУ-ын Засгийн газар ашигт малтмал, батлан хамгаалах зэрэг хэд хэдэн салбаруудыг стратегийн болон

үндэсний аюулгүй байдлыг хангах ач холбогдолтой эдийн засгийн салбарт тооцож тухайн салбаруудад гадаадын хөрөнгө оруулалт оруулахад онцгой дэглэм тогтоосон байна.

Мөн АНУ-д агаарын тээврийн компаниудад гадаадын хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшихийг дээрхи шалтгаанаар хориглосон байдаг. Ер нь иймэрхүү төрлийн хориг, хязгаарлалтуудыг Европийн холбооны орнууд болон өндөр хөгжилтэй ихэнхи улс орнууд тогтоосон байдаг байна. Түүнчлэн зарим тохиолдолд гадаадын тодорхой нэг хөрөнгө оруулагчийг тухайн улсад хөрөнгө оруулах, аль нэг үндэсний компанийн хувьцааг эзэмшихийг хориглосон хязгаарлалт байдаг. Жишээ нь, АНУ-ын Гадаадын хөрөнгө оруулалтын комисс(CFIUS) нь хэрвээ гадаадын ямар нэгэн хөрөнгө оруулагч АНУ-ын аль нэгэн компанийн хувьцааг эзэмших нь үндэсний аюулгүй байдалд аюултай гэж үзвэл хэлцэл хийхийг хориглодог байна.

АНУ болон баруун Европын орнуудын гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримталж байгаа бодлого, хандлагад нэр бүхий судлаачид дүгнэлт хийснээс үзэхэд¹, ялангуяа Хятад, ОХУ-ын хөрөнгө оруулагчид АНУ болон баруун Европын компаниудын хувьцааг эзэмшихэд онцгой хориг тавих хандлага байна. (Ялангуяа худалдан авагч компани нь төрийн өмчтэй компани бол)

Иймэрхүү улс төрийн шалтгаанаар барууны орнууд хууль тогтоомждоо хориг, хязгаарлалт тавьсан заалтуудыг оруулж байна.

Тухайлбал, 2007 онд ХБНГУ гадаадын хөрөнгө оруулагч стратегийн компаниудад хувьцаа эзэмшихийг хязгаарласан өөрчлөлт оруулсан, мөн 2007 онд АНУ үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар гадаадын хөрөнгө оруулалтын процедурийн өөрчлөлтийг хуулиндаа тусгаж өгчээ.

Үүнээс гадна тухайн улс орон гадаадын хөрөнгө оруулагчдын хэлцлийг хориглох хязгаарлах санаа, далд зорилгоо ил гаргахгүй, шууд хориглохгүй ч гэсэн өөр ямар нэгэн байдлаар хөрөнгө оруулагч сайн дураараа татгалзах нөхцөлийг бүрдүүлдэг байна. Тухайлбал, 2007 оны 6 сард ОХУ-ын “Аэрофлот” компани Италийн төрийн өмчтэй агаарын тээврийн “Алиталія” компанийн хувьцааг авах гол өрсөлдөгч болж байгааг мэдэнгүүтээ хувьцааны үнийг нь хязгааргүй ихээр нэмэгдүүлсэнээс худалдан авагч компанийн хувьд уг компанийн хувьцааг эзэмших нь эдийн засгийн хувьд ямар ч ач холбогдолгүй болсон байна.

Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалт оруулах, дотоодын компанийн хувьцааг эзэмшихэд эдийн засгийн аль ч салбарт ямар ч хориг саад, хязгаарлалт тавьдаггүй зарим улс орнууд байна. Тухайлбал, Баруун Европын орнууд (Монгол улс ч гэсэн энэ ангилалд багтана.) Эдгээр орнуудад гадаадын хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшихдээ төрийн байгууллагаас ямар нэгэн зөвшөөрөл авахгүй бөгөөд хөрөнгө оруулсаныг төрийн байгууллагын зүгээс гэрчилдэг байна. Гэхдээ Унгар, ОХУ, Польш зэрэг улсуудад стратегийн компани болон зарим салбарт хөрөнгө оруулахдаа зөвшөөрөл авах, холбогдох төрийн байгууллагын дэмжлэгийг авах зэргээр зохицуулсан байдаг байна.

Сүүлийн жилүүдэд Олон улсын байгууллагын зүгээс гадаадын хөрөнгө оруулалтад тавигдаж байгаа хязгаарлалтыг багасгах талаар стандарт боловсруулж байна. Тухайлбал, Дэлхийн худалдааны байгууллага үйлчилгээний зах зээлд хөрөнгө оруулах стандартыг гаргасан. Энэхүү стандартын дагуу Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнууд үйлчилгээний зах зээлээ гишүүн орнуудад нээлттэй байлгах, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдад тэгш, шударга нөхцөлийг бүрдүүлэх, зэрэг шаардлагууд тавигддаг байна.

Дүгнэж хэлэхэд, Гадаадын хөрөнгө оруулалтыг хориглох, хязгаарлах талаар дэлхийн бусад улс орнуудын баримталж буй бодлого, хандлагаас үзэхэд хязгаарлалтууд үндсэндээ



стратегийн ач холбогдолтой салбаруудад голдуу тавигдаж байна. Үүнд: байгалийн нөөц ашиглах, батлан хамгаалах, тээвэр, дэд бүтэц, эрчим хүч, харилцаа холбоо, санхүүгийн салбар болон хэвлэл мэдээллийн салбарууд голлож байна.

Монгол улсын хууль тогтоомжоор гадаадын хөрөнгө оруулагч МУ-ын стратегийн ач холбогдолтой компанийн хувьцааг эзэмших, хөрөнгө оруулалт хийхэд ямар нэгэн хязгаарлалт тавигдаагүй байгаа ба “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хуульд зааснаар гадаадын хөрөнгө оруулагч Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн хувьцаа, бусад үнэт цаасыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу худалдан авч шууд хөрөнгө оруулалт хийх, ААН, салбар төлөөлөгчийн газраа дангаар буюу хамтарсан компанийн хэлбэрээр байгуулах, хөрөнгө оруулалтын тааламжтай нөхцөл, татварын хөнгөлөлт, тогтвортой байдлын гэрээ хийх асуудлууд хуульчлагджээ.

Уг хуулинд гадаадын хөрөнгө оруулагч Монгол улсын хуулиар хориглоогүй үйлдвэрлэл үйлчилгээг хориглосноос бусад нутаг дэвсгэрт явуулж болохоор зааснаас үзэхэд цаашид холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар ашигт малтмал, эрчим хүч, зам, тээвэр, банк санхүү зэрэг улс орны эдийн засагт стратегийн ач холбогдолтой салбаруудад гадаадын хөрөнгө оруулалт оруулах асуудлыг улс орны эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, үндэсний бизнесийн салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.

Улс орнуудын ашигт малтмалын хуулийн хүрээнд хийгдэж буй өөрчлөлтүүдийн тухай товч мэдээлэл

Улс орны нэр	Холбогдох хууль тогтоомжийн өнөөгийн байдал	Ашигт малтмалын хууль тогтоомжид хийгдсэн болон хийгдэх шаардлагатай өөрчлөлтүүд	Гадаадын хөрөнгө оруулалтын хувь хэмжээг тогтоосон байдал
Энэтхэг	Энэтхэгийн ашигт малтмалын багц хуулиудын зарим нь 1950-д оны үеэс эхлэн хэрэгжиж эхэлсэн ба дээрхи хуулиудаар байгалийн баялгийн нөөцийг илрүүлэх ашиглах явдалд гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлаж өгсөн ба үүнийгээ улс орны аюулгүй байдалтай холбон тайлбарлаж байв.	Энэтхэгийн Засгийн газар 2008 оны 3-р сард ашигт малтмалын бодлогоо шинэчлэн тодорхойлж, байгалийн баялагт түшиглэсэн аж үйлдвэрлэл явуулахдаа хувийн хөрөнгө оруулалтыг түлхүү ашиглах нь зүйтэй гэсэн саналыг дэмжжээ. Гэхдээ энэхүү бодлогыг Энэтхэгийн Парламентаар хэлэлцүүлж батлуулах шаардлагатай юм.	Ашигт малтмалын бодлогоор дараахь асуудлуудыг тодорхойлжээ. Үүнд, 1\ хайгуул хийж арилжааны чиглэлээр ашиглах нөөц илрүүлсэн бол концессоо өөр этгээдэд худалдаж ашиг олж болохоор, 2\ олон нийтийн санхүүжилттэй аж ахуйн нэгжүүдийн илрүүлсэн нөөцийн эзэмших эрхийг бусад хөрөнгө оруулагч нарт дуудлага худалдаагаар зарах зэрэг зүйлс багтжээ. Мөн уул уурхай эрхэлдэг пүүс компаниудын хүлээх үүрэгт ашгийнхаа тодорхой хувийг компаний нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэхэд зарцуулж байхаар тусгаж өгчээ.

<p>Өмнөд Африк</p>	<p>Өмнөд Африкийн Засгийн газар нь олборлох эрхийн роялтийн татварыг 2003 оноос анх авч эхэлсэн байна. Өнгөрсөн жил роялтийн хувь хэмжээг дахин шинэчилсэн ба роялтийн татварын хуулийн төслийг боловсруулсан байна.</p>	<p>Роялтийн хувь хэмжээг өөрчилсөн нь уул уурхайн компаниудын , ялангуяа төмрийн ордны компаниудын өрсөлдөх чадварыг бууруулах болно гэсэн эсэргүүцэлтэй тулгарсан тул Засгийн газрын зүгээс роялтийн татварын тооцооллыг хийх аргачлалдаа өөрчлөлт оруулахаар шийдвэрлэжээ. Тухайлбал, 2008 оны 6-р сард роялтийн татварыг ашигтай нь уяж тооцож байхаар шийдсэн ба тээврийн зардлын дараахь борлуулалтын орлогын 0.5-7 хувь хүртэлх хэмжээгээр роялтийн татварыг оногдуулж байхаар болжээ. Татварын шинэчилсэн аргачлалын дагуу элэгдэл хорогдлыг хасаж тооцохоор, өөрөөр хэлбэл, өмнө нь элэгдэл хорогдлыг хасаагүй татварын өмнөх ашгаас (EBITDA-earnings before interest, tax, depreciation and amortisation) роялти тооцдог байсныг болиулж шууд татварын өмнөх ашгаас (EBIT-earnings before interest and tax) тооцдог байхаар өөрчилжээ.</p>	<p>Шинээр тодорхойлсон роялтийн дэглэм нь хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл бүрдүүлж, дагаж мөрдөхөд харьцангуй хялбар болсон гэж бодлого тодорхойлогчид үзэж байна. Өмнө хатуу тогтоосон байсан роялтийн татвараас илүү их хэмжээний татварыг уул уурхайн компаниуд шударгаар төлнө хэмээн Засгий газар үзэж байна. Шинээр боловсруулсан роялтийн татварын хуулийн төслийг Өмнөд Африкийн Парламент хэлэлцэн баталснаар хүчин төгөлдөр мөрдөгдөх юм.</p>
<p>Гана</p>	<p>Ашигт малталын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, уул уурхайн салбараас орох орлогыг нэмэгдүүлэх зорилттой ажиллаж байна. Ганын эдийн засгийн өсөлтөд уул уурхайн салбарын хувь нэмэр хангалттай түвшинд хүрч чадахгүй байна хэмээн Ганын Засгийн газар үзэж энэ салбарыг илүү интеграцчилалд хамруулж, дотоодын эдийн засгийн өсөлтийг түргэтгэх зорилт тавин ажиллаж байна.</p>	<p>Ганын Засгийн газар нь бүх концессуудаа олгоод роялти татвараа авах эсвэл өөрөө уул уурхайн салбартаа орж ажиллах эсэх талаар шийдвэр гаргахаар ажиллаж байна.</p>	<p>Баруун Африкийн энэ улс дан ганц алтны үйлдвэрлэлээс гадна бусад ашигт малтмалын баялагаа зөв зохистой ашиглах тал дээр түлхүү анхаарал тавьж байна.</p>



Эквадор	Эквадор улс ашигт малтмалын хуулийн шиэчилсэн төсөл боловсруулсан нь шинжээчдийн зүгээс боломжийн үнэлгээ авсан бөгөөд дээрхи хуулийн төслийг боловсруулах явцдаа орон нутгийн засгийн газар, төрийн бус байгууллагууд, уул уурхайн компаниуд, хувь нийлүүлэгчидтэй өргөн хүрээний уулзалт ярилцлага, зөвөлгөөн хийж хамтран ажиллажээ.	Эквадорын Уул Уурхайн Яамны мэдэгдсэнээр шинэчилсэн хуулийн төслийг 2008 оны 6-р сард боловсруулж дуусгаад Эквадорын Ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүдийн саналыг авахаар хүргүүлжээ. Шинэчилсэн хуулийн төсөлд тусгагдсанаар уул уурхайн компанийн Эквадорт эзэмших концессийн /зөвшөөрөл/ дээд хэмжээг тогтоож өгчээ. Ашигт малтмалын концессийн дээд хэмжээг заавал тогтоож өгөх хэрэгтэй гэдэг дээр Эквадорын Засгийн газар бүрэн итгэлтэй байна.	Эквадорын ашигт малтмалын шинэчилсэн хуулийн төсөлд байгал орчны хяналтын асуудлыг онцлон тусгаснаас гадна гадаадын хөрөнгө оруулалтын таатай нөхцөлүүд бүрдсэн байхыг ч мөн орхигдуулсангүй.
ОХУ	ОХУ-н 1992 оны 2-р сарын 21-нд батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд (“Subsoil law”) нэмэлт өөрчлөлт оруулж “Улс орны батлан хамгаалах, аюулгүй байдлын стратегийн ач холбогдолтой компаниудад гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг (“On Procedures for Foreign Investments in Companies of Strategic Significance for National Defense and Security”) ОХУ-н ДУМ 2008 оны 4-р сарын 16-д баталжээ. Шинэчилсэн хууль нь 2008 оны 7-р сараас эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна. Энэхүү хуулиар гадаадын хөрөнгө оруулагч нарын стратегийн ач холбогдолтой компаниудад эзэмшиж болох хувьцааны дээд хэмжээг тодорхойлж өгчээ.	Хэрвээ геологийн хайгуулын явцад гадаадын хөрөнгө оруулагч эсвэл гадаадын хөрөнгө оруулалттай компани нь стратегийн ач холбогдолтой тооцогдох ордыг илрүүлсэн бол Засгийн газар уг ордыг эзэмших, үйлдвэрлэл явуулах эрхийг олгохгүй байх эрхтэй бөгөөд хэрэв хайгуул хийх, олборлох, үйлдвэрлэл явуулах эрхийг нэг дор авсан байсан бол уг эрхийг хүчингүй болгох, лицензийг цуцлах хүртэлх арга хэмжээ авах эрхтэй байна. Дээрхи тохиолдолд холбогдох зардлыг буцаан өгч, аж ахуйн нэгж компанид урамшуулал олгож болохоор шинэчилсэн хуульд тусгажээ.	ОХУ-ын стратегийн ач холбогдолтой ашигт малтмалд уран, алмаз, никел, кобальт болон платины бүлгийн металлууд ордог бөгөөд дээрхи металлуудыг олборлох эрх бүхий компаний хувьцааны 10 хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшихээр бол Засгийн Газраас зөвшөөрөл авахаар хуульчилжээ. Засгийн газар хувьцаа эзэмших зөвшөөрлийн хариуг 3 сарын, онцгой тохиолдолд 6 сарын дотор өгөх ёстой.

* * *

Ашигласан материал:

- Country mining law updates (www.mayerbrown.com)

ЭДИЙН ЗАСАГ САНХҮҮГИЙН ХЯМРАЛТАЙ ХОЛБОГДУУЛАН ТӨСВИЙН ТАЛААР ЗАРИМ ОРНУУДЫН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ, ЗАСГИЙН ГАЗРААС УИХ -Д ӨРГӨН БАРЬСАН ТӨСВИЙН ТОДОТГОЛ, ТҮҮНТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЗАРИМ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ГАРГАСАН САНАЛ ЗӨВЛӨМЖИЙН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Д. Ариунаа, Г. Билгээ, Ц. Батдорж, Ц. Элбэгзаяа, А. Пагма

Судалгааны сэдвийн агуулга

1. Төсвийн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн орчны тойм
2. Төсвийн тодотголтой холбоотой Засгийн газрын болон Төрийн бус байгууллагуудын саналыг харьцуулсан хүснэгт
 - 2.1 Орлогын талаар
 - 2.2 Зарлагын талаар
 - 2.3 Хөрөнгө оруулалт
 - 2.4 Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс
3. Улсын төсвийн чиглэлээр зарим орнуудын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
 - 3.1 Унгар улс
 - 3.2 ОХУ
 - 3.3 Казахстан улс
 - 3.4 Латви улс
 - 3.5 Украин улс
4. Ашигласан материалын жагсаалт

* * *

Монгол Улсын төсвийн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн орчин

Монгол Улсын төсвийн хүрээний харилцааг зохицуулж буй нол хуулиуд болон тэдгээрийн хамрах хүрээг ялган тодорхойлсон нь төсвийн харилцааг зохицуулах эрх зүйн орчинг боломжийн хэмжээнд бүрдүүлж чадсан байна.

- Монгол Улсын Үндсэн хуулиар улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулах, УИХ-д өргөн барих, гарсан шийдвэрийг биелүүлэх бүрэн эрхийг Засгийн газарт, улсын төсөв хэлэлцэн батлах бүрэн эрхийг УИХ-д тус тус олгосноор төсвийн харилцааг зохицуулах ёуурь орчин бүрджээ. Мөн энэхүү зохицуулалтыг УИХ-ын тухай, Засгийн газрын тухай хуулиудаар давхар хуульчилжээ.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай болон Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулиуд 2002 онд батлагдснаар төсөв, санхүүгийн тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлсэн. Дараах бодлогын баримт бичгүүд нь өнөөгийн төсвийн харилцааг зохицуулж буй голлох эрх зүйн актууд бөгөөд тэдгээрийн үндсэн агуулгыг товчхон дурдахад:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулиар Монгол Улсын нэгдсэн төсөв, түүний бүтэц бүрэлдэхүүн, төсөв захирагчийн эрх, үүрэг, төсвийн орлого, зарлагын ангилалаар төсвийн гүйцэтгэлийг тайлагнах, төсвийн бүртгэлтэй холбогдсон төсвийн ерөнхий харилцааг зохицуулж байна.
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар /ТБУСТХ/ төсөв зохиох, батлах, зарцуулах, тайлагнах үйл явц, төсвийн талаархи төрийн байгууллага,



албан тушаалтны эрх, үүрэг, төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны удирдлагын зарчим, улсын болон орон нутгийн төсвийн харилцаа, төсвийн хяналт хариуцлага зэрэг төсвийн үйл явцтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

- Энэхүү хууль хэрэгжиж эхэлснээс хойш төсвийн төлөвлөлтөнд баримтлах бодлогод зарчмын өөрчлөлт шинэчлэлт хийгдэж түүнд тулгуурлан боловсруулсан төсвийн байгууллагын хэтийн болон дунд хугацааны төлөвлөгөө, Төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох байгууллагаас гаргасан удирдамж, чиглэл, төсвийн төслийг зохиох үндсийг бүрдүүлжээ
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитийн тухай хуулиар бүх шатны Засаг даргын хяналт, шалгалт хийх бүрэн эрх, төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийг зохицуулжээ.
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндэс, төсөв, ИТХ, Засаг даргын бүрэн эрх, баг хорооны Засаг даргын цалин, бусад зардлын эх үүсвэрийг тодорхойлсон байна.
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /ЗГҮАХ/-т Засгийн газраас бүрэн эрхийнхээ хугацаанд эдийн засаг, нийгмийн хөгжил, төрийн удирдлагын хүрээний асуудлаар хийж гүйцэтгэх ажлын гол зорилт, хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээг тодорхойлохоор Засгийн газрын тухай хуульд заажээ.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл нь Монгол улсын Үндсэний хөгжлийн үзэл баримтлал, хөгжлийн стратеги, хөтөлбөр, ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэхэд тухайн жилд төрөөс баримтлах бодлогыг тодорхойлсон баримт бичиг юм. Үүнтэй агуулгаараа адил ЗГҮАХ-ийг хэрэгжүүлж арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газраас батлан хэрэгжүүлж байна.

Төсвийн тодотголтой холбоотой олон нийтийн байгууллагуудын саналуудын харьцуулсан хүснэгт (Арын хуудаснаа)



Бодлогын чиглэл	ЗГ-ын бодлого	Дүн, тэрбум төгрөг	МУХАУТанхимын санал	МАОЭНХолбооны санал
Орлогын өсөлт	Валютын ханшийн өөрчлөлтөөр нэмэгдэх орлого: Өнгөрсөн оны сүүлээс эхлэн ам.долларын ханш өсч, Монгол банкаас 2009 онд 1 ам.долларыг дунджаар 1384.0 төгрөг байхаар тооцож байгаатай холбогдуулан	123.3	<p>Жижиг, дунд бизнесийн зээлийн баталгааны санг Засгийн газрын тогтоолоор байгуулах, энэ зорилгоор 10 млрд төгрөг төсвөлөх, сангийн менежментийг МУХАУТ-д гэрээний үндсэн дээр шилжүүлэх</p> <p>Төрийн өмчтэй болон төрийн өмч давамгайлсан компаниудын үйл ажиллагааг нь хооронд нь уялдуулах, гинжин өр үүсгэхгүй байх, с/х, татварын хувьд харилцан бие биенээ дэмжих зэргээр үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг нь ЖДБизнесийг дэмжихэд чиглүүлэх, өртөг зардлыг хямдруулах зорилго бүхий тусгай зөвлөлийг ТӨХ, СЯ болон бизнесийн төлөөллийн байгууллагын оролцоотой байгуулан ажиллуулах</p>	<p>Дотоодын ашиглаж л болох бүх санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлж эдийн засгийн бодит секторыг хөгжүүлэх, ялангуяа экспортын болон импорт орлосон, мал аж ахуй, газар тариалан уул уурхайн түүхий эд, үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглүүлэхэд Засгийн Газрын болон Банк санхүүгийн байгууллагуудын сонирхол, анхаарлыг хандуулах,</p> <p>Хувийн хэвшлийн компаниуд гаднаас биеэ дааж зээл авах эрх зүйн орчныг бүрдүүлж, засгийн газар, банкны байгууллагаас дэмжлэг үзүүлэх,</p> <p>Хувийн хэвшлийн ГГҮ-үүдийн боловсруулсан бодит секторын өсөлтөд шууд нөлөөлөхүйц төсөл, арга хэмжээнүүдийг нэгтгэн авч үзэж, эхний ээлжинд хэрэгжүүлэх төслийн жагсаалт гарган дэмжлэг үзүүлэх</p>
	Импортын болон дотоодод үйлдвэрлэсэн тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлснээр нэмэгдэх орлого: Тамхины онцгой албан татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхээр Онцгой албан татварын тухай	7.1		

	хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэн Тамихны онцгой албан татварыг нэмэгдүүлэх тухай уг хуулийн төслийг УИХ-аар баталснаар			
	Газрын тосны бүтээгдэхүүний онцгой албан татварыг нэмэгдүүлснээр нэмэгдэх орлого: Онцгой албан татварын хувь хэмжээг Онцгой албан татварын тухай хуульд заасан хязгаарт багтаан ногдуулснаар	14.2		
	Эрдэнэт үйлдвэрийн 2007 оны ашгаас улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлого: Эрдэнэт үйлдвэрийн санхүүгийн хямралын улмаас 2008 онд улсын төсөвт төвлөрүүлээгүй ногдол ашгийн орлого болох 84.5 тэрбум төгрөгийг 2009.02 сард багтаан улсын төсөвт бүрэн хэмжээгээр нь төвлөрүүлснээр	84.5		
	Нүүрсний хилийн хураамжийг нэмэгдүүлснээр нэмэгдэх орлого: Экспортод гаргаж буй нүүрсний хураамжийн хэмжээг нэмэгдүүлж улсын төсөвт нэмж төвлөрүүлснээр	7.1		
	Тусламжийн орлогоос нэмэгдэх орлого: <ul style="list-style-type: none"> Япон Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газрын хоорондын нот бичигт гарын үсэг зурсны дагуу тусламжаар нефть бүтээгдэхүүн хүлээн авч нийт 12.0 тэрбум төгрөгийн тусламжийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээс нэмэгдэх тусламжийн орлого Азийн хөгжлийн банкаас 2009-2011 онд эмзэг бүлгийн ард иргэдийг хоол тэжээлээр хангах нийгмийн хамгааллын хөтөлбөрийн дагуу нийт 12.0 нийт сая ам долларын тусламжийг дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан олгохоор харилцан ойлголцлын санамж бичигт хоёр талаас гарын үсэг зурсанаас 2009 онд төсөвт шилжүүлэх тусламжийн орлого 9.0 сая ам доллар буюу 10.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт шилжүүлэх бөгөөд үлдэж буй 3.0 тэрбум төгрөгийг техник туслацааны төсөл санхүүжүүлэхэд зарцуулах юм. 	4.0 10.0		
	Импортын зарим нэр төрлийн барааны гаалийн татварын хувь хэмжээг нэмэгдүүлснээр нэмэгдэх орлого: Импортын сүүн, өндөг, төмсний гаалийн албан татварын хувь хэмжээг нэмэгдүүлснээр	4.3		
	Бусад нэмэгдэх орлого: Монголбанкны 2008 оны ашгаас улсын төсөвт 2009 онд нэмж төвлөрүүлснээр	5.0		
	ОРЛОГЫН ӨСӨЛТИЙН ДҮН:	259.1		

Орлогын бууралт		
<p>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын бууралт: Санхүү, эдийн засгийн хямрал, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, албан татвар ногдуулалт, төлөлтний статистик, Эрдэнэт үйлдвэрийн татвар ногдуулалт зэргийг харгалзан үзэж 2009 онд Улсын төсөвт төвлөрөх ААН-ийн албан татварыг төсөвт тусгаснаас бууруулахаар тооцсон дүн</p> <p>Ашигт малтмалын төлбөр ашигласны орлогын бууралт: Эдийн засаг, санхүүгийн хямрал, ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ ханш, үйлдвэрлэлийн хэмжээ болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл, ногдуулалт, төлөлт зэргийг харгалзан үзэж улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг төсөвт тусгаснаас бууруулан тооцсон дүн</p> <p>Ногдол ашгийн орлогын бууралт: Борлуулалтын орлогын бууралт, бусад зардалын өсөлттэй холбоотойгоор буурах шалтгааны улмаас Эрдэнэт үйлдвэрээс 2009 онд ногдол ашгийн орлогоор улсын төсөвт 100.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлэх боломжгүй болсонтой холбогдуулан бууруулан тооцсон дүн</p> <p>Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ-ын орлогын бууралт: Эдийн засаг, санхүүгийн хямрал, валютын ханшны өсөлт нь дотоодын үйлдвэрлэгч, бараа үйлчилгээ, эрхэлдэг ААН-ийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, улмаар хүн амын бодит орлого буурч, үүнээс үүдэн хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурч байгаагийн улмаас улсын төсөвт төвлөрөх дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ-ын орлогыг бууруулан тооцсон дүн</p> <p>Дотоодын архины онцгой албан татварын бууралт: ААН-үүдийн үйлдвэрлэл, борлуулалт буурсантай холбогдуулан дотоодын архины онцгой албан татварын орлогыг бууруулан тооцсон дүн</p> <p>Нийт импортын бууралт: Импортын хэмжээ буурч байгаатай холбогдуулан нийт импортыг бууруулан 2009 онд 3 177.0 сая ам доллар байхаар тооцоход гаалийн албан татварын орлого 25.7 тэрбум төгрөгөөр, импортын барааны НӨАТ-ын орлого 58.2 тэрбум төгрөгөөр тус тус буурхаар байна.</p> <p>Импортын газрын тосны бүтээгдэхүүний хилийн үнийн бууралт: 2009 онд 1 тонн 90 хүртэлх октантай бензиний хилийн үнэ дундажаар 523.1 ам.доллар, 90-ээс доош октантай бензиний хилийн үнэ дундажаар 584.5 ам.доллар, дезилийн түлшний хилийн үнэ дундажаар 656.2 ам доллар байхаар төлөвлөсөн хэмжээнээс бууруулан тооцвол улсын төсвийн орлого 101.9 тэрбум төгрөгөөр, үүнээс гаалийн албан татвар 32.9 тэрбум төгрөг, импортын барааны НӨАТ 69.0 тэрбум төгрөгөөр тус тус буурч байна.</p>	<p>-84.1</p> <p>-40.3</p> <p>-100.0</p> <p>-12.7</p> <p>-13.9</p> <p>-83.9</p> <p>-101.9</p>	<p>Жижиг, дунд бизнесийн эзлэлийн баталгааны санг Засгийн газрын тогтоолоор байгуулах, энэ зорилгоор 10 млрд төгрөг төсөвлөх, сангийн менежментийг МУХАУТ-д гэрээний үндсэн дээр шилжүүлэх Төрийн өмчтэй болон төрийн өмч давамгайлсан компаниудын үйл ажиллагааг нь хооронд нь уялдуулах, гинжин өр үүсгэхгүй байх, с/х, татварын хувьд харилцан бие биенээ дэмжих зэргээр үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, субконтрактын гэрээний үйл ажиллагааг нь ЖДБизнесийг дэмжихэд чиглүүлэх, өртөг зардлыг хямдруулах зорилго бүхий тусгай зөвлөлийг ТӨХ, СЯ болон бизнесийн төлөөллийн байгууллагын оролцоотой</p> <p>Дотоодын ашиглаж л болох бүх санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлж эдийн засгийн бодит секторыг хөгжүүлэх, ялангуяа экспортын болон импорт орлосон, мал аж ахуй, газар тариалан уул уурхайн түүхий эд, үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд Гаарын болон банк санхүүгийн байгууллагуудын сонирхол, анхаарлыг хандуулах,</p> <p>Хувийн хэвшлийн компаниуд гаднаас биеэ дааж зээл авах эрх зүйн орчныг бүрдүүлж, засгийн газар, банкны байгууллагаас дэмжлэг үзүүлэх,</p> <p>Хувийн хэвшлийн GGY-үүдийн боловсруулсан бодит секторын өсөлтөд шууд нөлөөлөхүйц төсөл, арга хэмжээнүүдийг нэгтгэн авч үзэж, нэгтгэн авч үзэж,</p>

<p>Суудлын автомашины онцгой албан татварын орлогын бууралт: 2009 онд импорттоор орж ирэх автомашины нийт тоог төлөвлөсөн хэмжээнээс бууруулан 18 мянга орчим байхаар тооцон суудлын авто машины онцгой албан татварын орлогыг бууруулахаар тооцов.</p> <p>Тусгай зөвшөөрлийн орлогын бууралт: 2009 онд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоор 33.4 тэрбум төгрөг төлөвлөхөөр тооцосныг энэ оны 1 сард буцаан хүлээлгэн өгсөн талбай болон цаашид гарах эрсдлийг бууруулан тооцов.</p> <p>Газрын тосны орлогын үнийн бууралт: 2009 онд 1 баррель газрын тосны үнийг 46 ам.доллар байхаар тооцож, ам.долларын ханшийн өсөлт зэргийг тооцон үзэж газрын тосны орлогыг бууруулан тооцжээ.</p> <p>Навигацийн орлогын бууралт: Олон улсын нислэгийн өнгөрөлт, буулт, хөөрөлтийн тоо нь дэлхийн эдийн засгийн хямрал, авиакомпаниудын төлбөрийн чадвартай холбогдон буурах хандлагатай байгаагийн зэрэгцээ нислэгийн аюулгүй байдлыг хангах үүднээс 2008, 10 сараас эхлэн нислэгийн богино зам шинээр үүсгэсэн нь нислэгийн дундаж тарифыг бууруулж нийт орлогод шууд нөлөөлж болон холбогдох зардал нэмэгдэж байгаа нь навигацийн орлогыг бууруулах үндэслэл болж байна.</p> <p>Хувь хүний орлогын албан татварын орлогын бууралт: Төрийн албан хаагчид, төсөвт байгууллагын ажиллагсадын цалинг бууруулж байгаатай холбогдуулан орлогыг бууруулан тооцжээ.</p> <p>Хүүгийн төлбөрийн орлогын бууралт: Дорнод бүсийн эрчим хүчний систем, ТӨХК, Шивээ овоо ХК, Багануур ХК, Улаанбаатар төмөр зам ХНН-ийн санхүүгийн байдал хүнд байгаа нь 2009 оны дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийг бууруулж байгааг харгалзан дамжуулан зээлдүүлсэн зээлийн хүүгийн төлбөрийн орлогыг бууруулан тооцжээ.</p>	<p>-44.2</p> <p>-16.9</p> <p>-18.8</p> <p>-7.0</p> <p>-9.0</p> <p>-3.5</p>	<p>байгуулан ажиллуулах</p>	<p>эхний ээлжинд хэрэгжүүлэх төслийн жагсаалт гарган дэмжлэг үзүүлэх</p>
<p>ОРЛОГЫН БУУРАЛТЫН ДҮН:</p>	<p>- 554.4</p>		
<p>Төсвийн орлогын өсөлт, бууралтын зөрүү</p>	<p>-295.3</p>		

Бодлогын чиглэл	ЗГ-ын бодлого	Дүн, тэрбум төгрөг	МУХАУТанхимын санал	МАОЗНХолбооны санал
Урсгал зарлагын бууралт	<p>Төрийн албан хаагчдийн цалингийн хэмжээг 2009 онд түр хугацаанд бууруулах</p> <p>Төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд зардлын хатуу хэмнэлтийг мөрдүүлэх, бараа үйлчилгээний зардлыг тодорхой хувиар бууруулах</p> <p>Орон тоог нэмэгдүүлэхгүй байх, орон тооны хязгаараас хэмнэгдэж байгаа болон сул байгаа орон тоонд шинээр ажилтан авахгүй байх</p> <p>Зарим төрлийн нийгмийн халамжийн тэтгэмжийн давхардлыг арилгах, хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжийг МУХС-ийн эх үүсвэрээс санхүүжүүлэх</p>	<p>-107.8</p> <p>-25.4</p> <p>2009 оны эцэст хэмнэлт гарах</p> <p>-56.6</p>	<p>Төсвийн урсгал зарлагыг наад зах нь 200 тэрбум төгрөгөөр бууруулах,</p> <p>Төсвийн бүх захирагчдад хэмнэлтийн хатуу бодлого хэрэгжүүлэх тодорхой даалгавар өгөх,</p> <p>Төсвийн хэмнэлтийн үйл ажиллагаанд хяналт-мониторинг хийх</p>	<p>Урсгал төсвийг алдагдалгүй болгох арга хэмжээг төсвийн зардлыг хэмнэх замаар бий болгох,</p>
Урсгал зарлагын өсөлт	<p>Нэг иргэнээр тооцсон нормативт зардлаар Өрхийн эмнэлгийн 2009 оны төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэн тооцжээ.</p> <p>АХБ-ний Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөрийн Монгол Улсын Засгийн газрын хариуцах урсгал зардалыг нэмэгдүүлэн тооцов.</p> <p>Валютийн ханшны өөрчлөлтийг харгалзан гадаад орнуудад суугаа дипломат төлөөлөгчдийн газрын урсгал зардлыг, нийт олон улсын гишүүний татварын зардлыг тус тус нэмэгдүүлэн тооцжээ.</p> <p>Дулааны үнэ, тариф, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгаар зарим аймгуудын дулааны үнэ тарифыг нэмэгдүүлэхээр тусгажээ.</p> <p>Төрийн албан хаагчдын цалинг 20 хувь бууруулж байгаагай холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэлийн орлого буурч байгаагаас улсын төсвөөс нийгмийн даатгалын санд олгох татаасыг нэмэгдүүлэн тооцжээ.</p>	<p>0.4</p> <p>0.08</p> <p>3.0</p> <p>1.3</p> <p>10.3</p>	<p>Төсвийн хэмнэлтийн үйл ажиллагаанд хяналт-мониторинг хийх</p> <p>Төрийн аудитийн болон ТББ-уудын хамтарсан зөвлөл байгуулж төсвийг хэмнэх альтернатив санал авах</p>	

<p>Хөрөнгө оруулалт</p>	<p>- Олон улсын болон Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж буй эзэл тусламжийн төслийн дотоод эх үүсвэр Монголын талын хүлээсэн үүргийн биелэлтийг хангах биелүүлэх, эдийн засгийн ач холбогдол бүхий томоохон арга хэмжээ, хямралыг даван туулах арга хэмжээний хэрэгжилтийг хангах бодлогын хүрээнд тусгагдсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарах.</p> <p>- 2009 онд шинээр эхлэх, амин чухал бус хөрөнгө оруулалт, өмнөх онд барихаар төлөвлөгдөн 2009 онд шилжиж байгаа боловч төслийн тендер зарлагдаагүй, барилгын ажлын гэрээ байгуулагдаагүй, барилга угсралтын ажил эхлээгүй, санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалтуудыг хойшуулах,</p> <p>- Төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах тоног төхөөрөмжийн зардлыг хязгаарлах,</p> <p>- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээг МУХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр шилжүүлэх,</p> <p>- Улсын комисс ажиллаагүйгээс 2008 онд төсөвлөгдсөн санхүүжилтээр бүрэн авч чадаагүй төсөл арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэх зарчмуудыг баримтлан төлөвлөснөөсөө 126.6 тэрбум төгрөгөөр буюу 26 орчим хувийг бууруулж 362.4 тэрбум төгрөг болохоор тусгасан байна.</p> <p>- Үйлдвэржилтийн жилийн төлөвлөгөөний хүрээнд орон нутагт үйлдвэржилтийг хувийн хэвшлийг дэмжих замаар хөгжүүлэх зорилгоор аймаг дүүргийн төсөв тус бүрт 1.0 ний 30.0 тэрбум төгрөгийг 2009 оны төсөвт тусгасныг тодотголд үргэлжлүүлэн тусгасан байна. Энэ хөрөнгө нь жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор эргэн төлөгдөх эзл хэлбэрээр хувийн хэвшилд олгогдохоор төлөвлөгдөж байна</p>	<p>-126.6</p>	<p>- Төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 300 тэрбум төгрөгөөр хэмнэх, царцаах, ялангуяа 2009 оны тендер зарлах болон зарласан бүх хөрөнгө оруулалт, 2009 ондоо үр дүн нь харахгүй объект, хөрөнгө оруулалт, нийгмийн дэд бүтэц бий болгох зориулалттай хөрөнгө оруулалтыг зогсоох, царцаах</p> <p>- Санхүүгийн хямралаас болж зогссон боловч 2009 ондоо багтааж бүрэн хэрэгжүүлэх боломжтой бизнесийн төсөл, хөрөнгө оруулалтын жагсаалтыг дунд болон том компаниудын дунд судалгаа хийсний үндсэн дээр гаргах үл хөдлөх хөрөнгөөр нь барьцаалах замаар төсөл, хөрөнгө оруулалтыг нь шууд санхүүжүүлэх механизмыг нэвтрүүлэх</p> <p>- Газар тариалангийн секторт эрчимжсэн аж ахуйнуудыг байгуулахыг бодлогоор дэмжих, бизнес эрхлэгчдийг санхүүгийн эх үүсвэр, үр, техник хэрэгслээр дэмжих үйл ажиллагааг шуурхай, ил тод, шударгаар хэрэгжүүлэх, -Улаан буудайнаас гадна гурвалжин будаа, эрдэнэ шиш болон бусад хүнсний үр тарианы үйлдвэрлэлийг санхүүгийн болон үр, техникийн хангамжийн хувьд дэмжих, дотоодод буй туршлагыг өргөнөөр дэлгэрүүлж, өрхийн хүнсний ногоо, тариалангийн аж ахуй эрхлэгчдийг дэмжих тусгай сан байгуулах</p> <p>- ҮДБизнесийн эзэлийн баталгааны санг Засгийн газрын тогтоолоор байгуулах, энэ зорилгоор 10 млрд төгрөг төсвөлх, сангийн менежментийг МУХАУТ-д гэрээний үндсэн дээр шилжүүлэх</p> <p>- Төсвийн урсгал зарлагыг наад зах нь 200 тэрбум төгрөгөөр бууруулах, төсвийн бүх захирагчдад хэмнэлтийн хатуу бодлого хэрэгжүүлэх тодорхой даалгавар өгөх, төсвийн хэмнэлтийн үйл ажиллагаанд хяналт-мониторинг хийх төрийн аудитийн болон төрийн бус байгууллагуудын хамтарсан зөвлөл байгуулж төсвийг хэмнэх альтернатив санал авах</p>	<p>Төсвийн хөрөнгө оруулалт, УХС-ын санхүүжилтээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2009 онд 60 хуваарь хянаж, хэмнэгдсэн хөрөнгийг үйлдвэрлэлийг дэмжихэд зарцуулах, /сумд руу тавих зам, өндөр хүчдэлийн шугам, сургууль, төрийн өмчийн байрны засвар, тохижилт гэх мэтийг зогсоох, УИХ-ын гишүүдийн мөнгийг аж үйлдвэржүүлэхэд чиглүүлэх г.м. арга хэмжээг яаралтай авч төсөвт тодотголт оруулах/</p>
--------------------------------	--	----------------------	---	---

**Улсын төсвийн чиглэлээр зарим орнуудын
Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний жишээ**

Улс орны нэр	Эдийн засаг, мөнгө, санхүүгийн чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ	Төсвийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ	Хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, хандлага
Унгар Улс	<ul style="list-style-type: none"> - Ханшийн түвшин харьцангуй тогтвортой болсон байна, олон улсын нөөц нэмэгдсэн, банкуудын гадаад санхүүжилт тодорхой хэмжээгээр нэмэгдсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалттай банкуудын гадаад эх үүсвэр нэмэгдсэн байна. Энэ нь хөрөнгө оруулагч банкуудын Унгарт үйл ажиллагаагаа явуулж буй банкуудаа дэмжих зорилгоор явуулсан арга хэмжээний үр дүнд бий болсон байна. - Банкны зээлийн өсөлт саарч байна. Эдийн засгийн хүндрэлээс үүдэн зээлийн эрэлт буурч, гадаадын хөрөнгө оруулалттай банкуудын хувьд зээлийн өсөлтөө нэмэгдүүлэхгүй байх бодлого баримталж байна. - Эх үүсвэрийг тогтвортой байлгахын тулд банкууд хадгаламжийн хүүгээ нэмэгдүүлж байна. Банкууд байгууллага аж ахуйн нэгжүүдэд зээлдүүлэхээсээ илүүтэйгээр иргэд өрх бүлд зээлийн үйлчилгээг түлхүү үзүүлэх сонирхолтой байна. Энэ нь эрсдлийн түвшинтэй холбоотой юм. - Банк дэмжих хууль батлан гаргасан нь Европын Холбооны санаачлага болон ОУВС-н хөтөлбөртэй нийцсэн арга хэмжээ болжээ гэдгийг ОУВС дүгнэж байна. - Санхүүгийн хянан шалгах байгууллагуудын үйл ажиллагааг дэмжсэн хууль тогтоомжуудыг хаврын чуулганаараа батлуулахаар холбогдох байгууллагууд хуулийн төслүүд дээр ажиллаж байна. - Иргэд өрх бүлийг ханшийн эрсдлээс хамгаалах зорилгоор банкууд сайн дурын үндсэн дээр зарим хөнгөлөлтүүдийг авч хэрэгжүүлэхээр тохиролцсон байна. Үүнд, гадаад валютаар олгосон зээлийн хугацааг сунгах, төлбөрийн нөхцөлийг зөөлрүүлэх, дотоодын валютад хөрвүүлэх зэрэг арга хэмжээ багтаж байна. Гэсэн хэдий ч маш цөөн зээлдэгчид хандсан байна. Энэ нь ханшийн тогтвортой байдалтай холбоотой бөгөөд цаашид байдал хүндэрсэн тохиолдолд нэмэлт арга хэмжээнүүдийг авах боломжтой гэж үзэж байна. - Төв банк аажмаар бодлогын хүүгээ бууруулж байна. Энэ нь зарим 	<ul style="list-style-type: none"> - Төсвийн үзүүлэлтүүд нь тогтвортой байна. НӨТ-тай холбоотой зарим нэг хүндрэлүүд гарч байгаа ч ерөнхийдөө татвар бүрдүүлэлтийн хувь өсөлттэй байна. Зарлагын сахилга бат сайн байна. Өнгөрсөн оны эцсээр төсвийн үзүүлэлтүүд тавьсан зорилтуудыг хангахаар байна гэж ОУВС-н шинжээчид дүгнэсэн байна. - Төсвийн алдагдлын хэмжээг (2008 онд ДНБ-ний 3,4 хувиас) 2009 онд ДНБ-ний 2,5 хувь гэж байхаар төлөвлөсөн байна. - Төсвийн орлогын хувьд татварын хувьд онцгой том өөрчлөлтүүдийг хийгээгүй байна. Харин зарлага тал дээрээ нэрлэсэн цалинг бууруулах хувь төсөвлөгдсөн хэмжээнээс бага байхаар байна. Цалингийн бууралтаас олох орлогын зөрүүг батлан хамгаалах болон боловсролын салбарын зардлаас гаргахаар байна. - Унгарын Засгийн газар Европын Холбооны санхүүжилтээр хийгдэх хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. - ЖДҮ-дээ дэмжих бодлого баримталж, дэд бүтцийн төслүүд болох төмөр зам, сургуулийн засвар шинэчлэлийг үргэлжлүүлэн 	<p>Унгар улсын хувьд ханш харьцангуй тогтвортой байгаа, Унгарт салбартай гадаадын банкууд дэмжлэгээ үргэлжлүүлэн үзүүлсээр байгаа болон олон улсын хангалттай нөөцтэй болсон байна.</p> <p>Гэсэн хэдий ч санхүүгийн хүндрэлүүд гарч болзошгүй байна. Гадаадын санхүүжүүлэгчид санхүүжилтээ нэмэгдүүлэх сонирхолгүй байгаатай холбогдуулан зээлийн өсөлт огцом буурах төлөвтэй байна.</p> <p>Төсвийн бодлогын хувьд 2009 онд тавьсан зорилтууд хангагдах хэдий ч зарим нэг эрсдлүүд үүсч болзошгүй байна.</p> <p>Шинээр батлагдсан Санхүүгийн хариуцлагын тухай хууль төсвийн эрх зүйн орчинтой холбоотой асуудлуудыг шийдэхэд чухал нөлөө үзүүлэхүйц санаачлага болсон байна гэж ОУВС үзэж байна.</p> <p>Банкуудын байдал харьцангуй тогтвортой, хөрвөх чадвар сайн байгаа хэдий ч гадны санхүүжилт улам бүр хомсдох, дэлхийн эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор банкуудын активт өөрчлөлт орж болзошгүйг анхаарах хэрэгтэй.</p>

	<p>томоохон төв банкууд хүүгээ бууруулсан, мөн инфляцийн зорилтот түвшин хангагдаж байгаатай холбогдуулан авсан арга хэмжээ гэж үзэж байна. Энэхүү арга хэмжээ нь санхүүгийн зах зээлд эерэг нөлөө үзүүлж эхэлсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> - Банкуудын заавал байлгах нөөцийг 5 хувиас 2 хувь хүргэн буурууллаа. Энэ нь Европын Холбооны улсуудын банкуудад тавигддаг заавал байлгах нөөцийн шаардлагын хувь хэмжээг хангасан үзүүлэлт юм. <p>Эдийн засгийн хөгжил</p> <ul style="list-style-type: none"> - ДНБ-ний өсөлт 2008 оны 3-р улирлын байдлаар 0,75 хувьтай байна. Энэ нь хөрөнгө оруулалт буурсан, хэрэглээ хумигдсан, экспорт буурсантай голчлон холбоотой байна. Өнгөрсөн оны 9 дүгээр сарын байдлаар ажилгүйдлийн түвшин 7,75 хувь болж өссөн байна. Хувийн секторын цалингийн өсөлт 8 хувиар буурсан байна. - Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляцийн түвшин 4,2 хувьтай байна (өнгөрсөн оны 9 дүгээр сарын байдлаар). - Төлбөрийн тэнцэлийн хувьд орлогын бууралттай холбоотойгоор төсөөлж байснаасаа илүү алдагдалтай байна. 	<p>хэрэгжүүлснээр эрэлтийг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг идэвхжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Унгарын Парламент Санхүүгийн Хариуцлагын тухай хуулийг өнгөрсөн оны 11 дүгээр сарын 17-нд баталсан байна. 2010-2012 онуудад төсвийн алдагдлын хувийг ДНБ-ний өсөлтийн хувийн 50 хувиас дээшгүй байхаар тогтоож өгсөн байна. Дээрхи хуулиар Төсвийн Зөвлөлийг Сангийн Яамнаас хараат бус ажиллуулахаар хуульчилсан бөгөөд энэхүү зөвлөл нь 2009 оны эцсээс ажиллаж эхлэх юм байна. 3 гишүүн, 1 нарийн бичигтэй ажиллах энэ зөвлөл нь макро эдийн засгийн прогноз, төсвийн агрегатуудын тооцооллолуудыг хийхээс гадна, төсөвтэй холбоотой санал зөвлөмжүүдийг хүргэхэд оршиж байна. 	<p>Бодлогын хүүгээ бууруулсан нь цагаа олсон шийдвэр болсон гэж үзэж байна. Инфляци 3 хувиас доош байхад энэ нь үр дүнгээ өгөх бөгөөд цаашид дахин хүү бууруулахдаа харин анхааралтай хандах хэрэгтэйг ОУВС зөвлөсөн байна.</p> <p>Төв банк банкуудын хөрвөх чадварыг хангах хэрэгслүүдийг оновчтойгоор боловсруулж ашиглах явдал нь сайшаалтай юм. Хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн эдийн засгийн бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг Унгар улсад ОУВС-хан зөвлөсөн байна.</p>
--	---	---	---

ОХУ	<ul style="list-style-type: none"> - Мөнгөний ханшийн бодлогын хувьд хөрөнгө мөнгөний гадагш урсах урсгалыг хязгаарлахын тулд Төв Банкны зээлийн хүүг 11 хувиас 13 хувь болгон нэмэгдүүлсэн ба мөн бодлогын хүүгийн хувийг өсгөсөн. - Эдийн засгийн байдлаас хамааран рублийн ханшийг аажмаар зохицуулах үүднээс валютын коридорын хүрээг нэмэгдүүлсэн. - Банкны системийг дэмжихийн тулд банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулсан. Зарим төрлийн барьцааг ашиглан зээлжих нөхцлийг зөөлрүүлсэн ба барьцаагүй зээл олгох ажлыг мөн хийж байна. - Харилцагч банкны эрх хураагдсан 	<ul style="list-style-type: none"> - Хямралын нөхцөлд татварын ачааллыг багасгах, татварын бодлогын урамшуулах үүргийг нэмэгдүүлж, ингэснээр эдийн засгийн бодит салбарыг идэвхжүүлэх, иргэдийн хэрэглээний эрэлтийг дэмжих бодлого баримталж байна. - НӨТ төлөлтийн дэглэмийг улирал бүр байсныг сар бүр 	<p>Орос улсын хувьд эдийн засгийн хүндрэлийг харьцангуй хохирол багатай даван туулах боломжтой гэж үзэж байна.</p> <p>Ялангуяа сүүлийн 5-7 жилийн хугацаанд Нөөцийн Санд хуримтлуулсан хөрөнгө, нөөцийг оновчтой хувиарлан зарцуулсанаар нийгмийн болон бусад зардлыг нөхөхөөр төлөвлөжээ.</p>
-----	---	---	--

<p>тохиолдолд алдагдал хүлээсэн арилжааны банкны алдагдлыг нөхөх эрхийг Төв Банканд олгосон.</p> <ul style="list-style-type: none"> - Зарим томоохон арилжааны банкуудад нийт 17 тэрбум рублийн зээл олгохыг дэмжсэн. - Улсын байгууллагуудын нийт 430 тэрбум рублийн хөрөнгийг арилжааны банкуудад байршуулсан. - Иргэдийн хадгаламжийн даатгалын хөрөнгийн нэмэгдүүлж нийт хадгаламжийн 98.5 хувийг хамгаалсан. - Гадны хөрөнгө оруулалттай цөөн хэдэн банкны хувьд бэрхшээл тулгарсан боловч тэдгээр нь богино хугацаанд балансын өөрчлөлт хийж чадсан. - Бүхэлдээ банкны систем тогтвортой байж, хадгаламж эзэмшигчдийн итгэл өндөр байна. Гэсэн хэдий ч ойрын хугацаанд анхаарах гол асуудал нь зээлийн эрсдэл гэж үзэж байна. Иймд зээлийн ангилалыг бодитой хийх, эрсдлийн сан бий болгох практикийг үргэлжлүүлэх, банк хоорондын хөрвөх чадварыг удирдах Төв банкны хэрэгслийг боловсронгуй болгоход анхаарч байна. - Мөн асуудал үүсч болзошгүй банкуудыг урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс авахад анхаарч байгаа ажээ. - Төв банк валютын ханшны чөлөөтэй хөвөгч дэглэм болон инфляцийг онилсон бодлого баримталж байна. 2009-2011 оны мөнгөний бодлогыг тодорхойлохдоо Оросын экспортын үндсэн барааны дэлхийн үнэ ханшны болзошгүй өөрчлөлтийг тусгажээ./юуны өмнө эрчим хүчний эх үүсвэрийн/ - Мөнгөний эрэлт, нийлүүлэлтийн зохистой харьцааг хангахын тулд Төв банкаас арилжааны банкуудад зээл олгох үйл ажиллагааг үргэлжлүүлнэ. Ингэснээр инфляцийг бууруулахад Төв банкны бодлогын хүүгийн гүйцэтгэх үүргийг өсгөнө. <p>Оросын Төв банк явуулж буй мөнгө-зээлийн бодлогодоо итгэх олон нийтийн итгэлийг төлөвшүүлэх, бодлогоо нээлттэй, тунгалаг байлгах, нийтэд бодлогоо танилцуулах, зорилгоо тайлбарлахад онцгой анхаардаг байна</p> <p>Эдийн засгийн хөгжил</p>	<p>болгон өөрчилж, түүнийг урьдчилсан төлбөрөөр хийх, экспортын арилжааны НӨТ-ын буцаан олголтыг түргэвчлэх зорилт тавьсан. Ер нь татвар төлөлтийг жигд болгохыг зорьж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Татварын өрийг төлөх дэг журмыг хөнгөвчилсэн. - Ашгийн татварын хувийг 24 байсныг 20 болгон бууруулсан. - 2009 онд татварын ачааллыг 550 тэрбум рублээр бууруулахаар төлөвлөжээ. - 2008-2009 онд татвар-төсвийн бодлогыг цаашид сулруулах чиглэл баримталж байна. - Төсвийн алдагдлын хэмжээг нефтийн орлогыг тооцохгүйгээр (2008 онд ДНБ-ний 6.8 хувиас) 2011 онд ДНБ-ний 4,5 хувь болж буурна гэж төлөвлөжээ. - Холбооны засгийн газрын зардлыг 2008 онд ДНБ-ний 17.9 хувь байсныг 2011 онд ДНБ-ний 16.6 хувь болгох шаардлага байгаа гэж үзэж байна. - 2009 онд сангийн бодлого нь мөчлөгийн эсрэг стимул дэмжлэг бий болгоход чиглэгдэнэ. <p>Түүнчлэн ЖДҮ-дээ дэмжих бодлого баримталж, ингэснээр шинээр ажлын байр бий болгох зорилго тавьж байна.</p>	<p>Түүнчлэн татварын хөнгөлөлт үзүүлэх, банкны системийг дэмжих, ханшийн уян хатан бодлого явуулах, ажилгүйдлийн тэтгэмжийг нэмэгдүүлэх, шинэ ажлын байр буй болгоход чиглэгдсэн нийгмийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зэрэг чиглэлд нэн тэргүүнд анхаарч байна.</p> <p>Банкны тогтолцоо эдийн засгийн хүндрэлийг хохирол багатай даван туулах боломжтой гэсэн нийтлэг дүгнэлттэй байна.</p>
--	---	---

	<ul style="list-style-type: none"> - ДНБ-ний өсөлт 2007 оны эцсээр эрс өсч 8,1 хувьд хүрч, энэ хандлага 2008 оны хагаст хадгалагдсан боловч 2008 оны эцэст 7.8 хувьд хүрч буурсан. - 2008 оны 9 дүгээр сард хэрэглээний үнийн өсөлт 2007 оны 12 сартай харьцуулахад 10.6 хувь, суурь инфляци 10.1 хувьтай байсан. Төсвийн алдагдал ДНБ-ний 5,6 хувьтай тэнцэж байна. <p>Ажилгүйдлын тэтгэмжийг нэмэгдүүлсэн. Ажлын байр аар хангах ажлыг зохион байгуулахад 50 тэрбум рубль төсөвлөсөн байна</p>		
--	--	--	--

<p>Казахстан Улс</p>	<ul style="list-style-type: none"> - 2007 оны хоёрдугаар хагаст эхэлсэн дэлхийн санхүүгийн зах зээлийн хямрал Казахстаны хөгжилд мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн. Энэ нь юуны өмнө банкууд гадаадаас шинэ санхүүжилт авах боломжгүй болж, үүний улмаас дотоодын зээлжилт буурч, эдийн засгийн өсөлт саарч, инфляци өсөх байдлаар илэрчээ. - Иймд 2007 оны 10 дугаар сараас Засгийн газраас яаралтай арга хэмжээ авч эхэлсэн байна. - Үүнд, юуны өмнө мөнгөө хэсэгчилэн төлж орон сууц бариулж буй иргэдийн эрх ашгийг хамгаалахын тулд барилгын компаниудад төсвөөс санхүүжүүлэн зээл олгосон. - ЖДҮ-ийн салбарыг дэмжин 155 тэрбум тенге зарцуулан санхүүжүүлсэн. - Газар тариалангийн үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлыг хангахад зориулж 135 тэрбум тенге зарцуулсан. - Банкны хөрвөх чадварыг сайжруулах, хямралын дараагийн үеийг даван туулахад банкны системийн бэлэн байдлыг дээшлүүлэхэд онцгой анхаарсан байна. - 2008 оны эхнээс Казахстаны Засгийн газар, Үндэсний банк, Санхүүгийн хяналтын Агентлагаас гадаад болон дотоод зах зээл дээрх эдийн засгийн нөхцөл байдлын хяналтыг хүчтэй болгосон. - Санхүүгийн байгууллагуудыг санаатайгаар дампууруулах ажиллагааны эсрэг арга хэмжээг чангатгасан. - “Санхүүгийн тогтолцоог бэхжүүлэх асуудлаар зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Казахстан Улсын Хууль баталсан. Уг хуулиар мөн иргэдийн мөнгөн хадгаламжийг баталгаажуулсан. - Банкны заавал байлгах нөөцийн хувийг 	<ul style="list-style-type: none"> - 2009 оноос шинэ Татварын хууль үйлчилж эхэлсэн байна. Уг хуулиар юун түрүүн эдийн засгийн түүхий эдийн бус секторын татварын ачааллыг ихээхэн хэмжээгээр бууруулсан. - 2009 онд байгууллага, ААН-ийн орлогын албан татварыг шатлалтайгаар 30 хувиас 20 хувь болгон буруулна. Дараа жилээс НӨТ-ын хувийг 13 хувь байсныг 12 хувь болгон бууруулахаар төлөвлөсөн. НӨТ ногдуулдаггүй бараа эргэлтийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлнэ. - Нийгмийн даатгалын татварыг шатласан бүтцээс нэгдсэн хувьд шилжүүлэн 11 хувиар тогтооно. - ЖДҮ-ийн орлогын албан татварыг урьчилан төлөх шаардлагыг хүчингүй болгосон. Бүхэлдээ татварын ачааллыг бууруулсанаар 2009 онд албан байгууллагуудын 500 тэрбум 	<p>Дэлхийн санхүүгийн хямрал Казахстаны эдийн засгийг гадаад орчноос ихээхэн хамааралтай болохыг харуулсан.</p> <p>Түүхий эдийн салбарын орлого, банкуудын гадаад зээл, улсын зардлын өсөлт нь эдийн засгийн “халалт”-д ихээхэн нөлөөлсөн. Ялангуяа банкны системд эрсдэл нэлээд хуримтлагдсан байна.</p> <p>Сүүлийн 7 жилд анх удаа эдийн засгийн өсөлт ихээхэн хэмжээгээр удааширсан явдал тохиолдсон байна.</p> <p>Харин цаг алдалгүй хямралын эсрэг 2007 оны намраас яаралтай арга хэмжээ авсны дүнд санхүүгийн салбарыг тогтворжуулах, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, ЖДҮ-ийг дэмжих, газар тариалан-аж үйлдвэрийн цогцолборыг хөгжүүлэх, аж үйлдвэр, дэд бүтцийн</p>
-----------------------------	---	---	---

	<p>бууруулсан .</p> <ul style="list-style-type: none"> - Банкуудад 4 тэрбум ам.долларын нэмэлт санхүүжилт хийгдэнэ. - Үндэсний Банк нь мөнгө-зээлийн зөөлөн бодлого баримталж байна. Харин санхүү-эдийн засгийн нөхцөл байдал тогтворжихын хэрээр макроэдийн засгийн тогтвортой байдлыг хангах, инфляцийг доод түвшинд барих зорилгоор мөнгөний бодлогоо хатууруулах юм. - Засгийн газар, Үндэсний Банк нь төлбөрийн тэнцэл, валютын ханшийн байдлыг хянах болно. - ҮБ-ны хувьд мөн л инфляцийг онилсон бодлого, валютын хөвөгч ханшийн бодлого баримталж байна. 2009 оны мөнгөний бодлогын гол зорилго нь инфляцийн түвшинг 7.5-9.5 хувьд барих явдал гэжээ. <p>Эдийн засгийн хөгжил</p> <ul style="list-style-type: none"> - 2008 оны эхний 9 сарын байдлаар ДНБ-ний өсөлт 4%, ажилгүйдлийн түвшин 7%, инфляцийн түвшин 8.8% байсан бол банкны татан төвлөрүүлсэн хөрөнгө 21.8 хувиар өссөн. 	<p>тенгетэй тэнцэх хөрөнгийг татвараас чөлөөлж эдийн засгийн хөгжилд зориулах боломжтой болно.</p> <ul style="list-style-type: none"> - “Улсын худалдан авах ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг яаралтай баталж дотоодын эрэлт, дотоодын үйлвэрлэгчдийг дэмжих үүднээс нэн түрүүнд казахстаны бараа нийлүүлэгчдээс бараа, үйлчилгээ худалдан авах чиглэл тогтоосон. - Засгийн газар нь 2009-2011 оны төсвийн төслөө хийхдээ дэлхийн санхүүгийн болон түүхий эдийн зах зээлийн байдал цаашид улам муудаж болзошгүй байдлыг харгалзан төсөвлөсөн ба тэргүүлэх чиглэлийн бус зардлыг хасах, зарим хөтөлбөрийн санхүүжилтийг хойшлуулах зэрэг арга хэмжээ авсан. - Харин нийгмийн чиглэлийн зардлыг хасаагүй байна. Төсвийн алдагдал 2009-2010 онд ДНБ-ний 3.4-3.5 хувь байх ба 2011 ДНБ-ний 2.4 хувь байхаар төлөвлөжээ. - Эдийн засгийн өсөлт буурсан нөхцөлд Засгийн газар мөчлөгийн эсрэг төсвийн бодлого явуулах юм байна. 	<p>салбарын төслүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хийгдэж байна.</p>
--	--	---	---

Латви

- 2000 оноос хойш Латвийн эдийн засаг

- Өнгөрсөн оны 11 дүгээр сард батлагдсан

улс	<p>маш хурдацтайгаар өсч, 2000-2007 онуудад ДНБ-ний өсөлт дунджаар 9 хувьтай гарч байв. Энэ нь Европын холбооны улсуудын хувьд хамгийн өндөр өсөлт юм. Эдийн засгийн өсөлт нь социализмын дараахь шинэчлэлтийг амжилттай хэрэгжүүлснээр үүдэлтэй бөгөөд улмаар 2004 онд Европын Холбоонд элссэнээр улам эрчимжсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> - Гэсэн хэдий ч 2006 оны дундаас эдийн засагт хэт халалт үүссэн байна. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгийн үнэ 2005-2006 онуудад 60 хувиар өссөн, зээлийн өсөлт 50-аас илүү хувьтай байсан зэргийг дурьдаж болох юм. Түүнчлэн, дотоодын эрэлт нэмэгдэж, ялангуяа хэрэглээ болон үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт өсч улмаар урсгал тэнцэлийн алдагдал 2006 оны сүүлээр ДНБ-ний 25 хувьд хүрэв. 2007 оны эхээр цалин үнэ хурдацтайгаар өсч 2007 оны дунд үед инфляц 10 хувьд хүрэв. <p>Өнөөгийн байдал</p> <ul style="list-style-type: none"> - Эдийн засаг хурдацтайгаар буурч байна. Үндсэн шалтгаан нь банкууд 2007 оноос хойш зээл олголтыг хумисан. Энэ нь гол төлөв гадаадын хөрөнгө оруулалттай банкуудын хувьд толгой банкууд Балтийн орнуудад оногдох зээлийн лимитийг баримталсантай холбоотой. Өөрөөр хэлбэл дээрхи бус нутагт нэмж эрсдэл хийхгүй байх бодлого баримталсан. Зээл багассантай холбоотойгоор хэрэглээ болон хөрөнгө оруулалт буурсан. Мөн экспортын хэмжээ буурч, ажилгүйдэл өссөн. - Эдийн засаг хумигдсанаас татварын орлого багасч, төсвийн алдагдал ДНБ-ний 3 хувьд дөхөж очихоор байна. - Нийт гадаад өр ДНБ-ний 130 хувь болж өсөв. Энэ нь Европын холбоонд шинээр элссэн улсуудын хувьд хамгийн өндөр үзүүлэлт юм. Нэг жилээс дотогш хугацаатай гадаад өр ДНБ-ний 50 хувьтай байна. Дунд болон урт хугацааны гадаад өр төлбөр ДНБ-ний 12 хувьд байна. - Нийт банкны зээлийн 2\3 нь үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан бөгөөд үл хөдлөх хөрөнгийн хөөс арилсантай холбоотойгоор зээлийн багцын чанарт өөрчлөлт орж болзошгүй байна. Латвийн банкны системийн 60 хувь нь Швед, Нордикийн банкуудын эзэмшилд байдаг бөгөөд дээрхи орнуудын засгийн газруудаас нь 	<p>төсвийн алдагдлыг ДНБ-ний 1 хувьтай байхаар тооцоолов. Гэсэн хэдий ч нөхцөл байдал хурдтай өөрчлөгдөж буйтай холбогдуулан 2009 оны төсвийн алдагдал ДНБ-ний 12 хувьтай тэнцэхээр байна. Дээрхи алдагдлыг санхүүжүүлэхэд маш хүндрэлтэй байхаар байна.</p> <ul style="list-style-type: none"> - Өнгөрсөн оны 12 дугаар сарын 11нд Унгарын Парламент шинэчлэгдэн оруулж ирсэн (төсвийн алдагдлыг ДНБ-ний 7 хувь) төсвийг баталсан байна. Өөрчлөлтийн 1\3-г орлого талд хийсэн тодотголууд (НӨТ нэмэх гэх мэт) зээлж байсан бол 2\3-г зарлагын (нийт зарлагыг 25 хүртэл хувиар бууруулж тооцсон, төсвийн байгууллагын нэрлэсэн цалингууд бууруулсан гэх мэт) өөрчлөлтөөс тооцож гаргажээ. Энэхүү арга хэмжээ нь богино хугацаанд нөлөөлөл үзүүлэх нь бага боловч дунд хугацаанд өсөлтийг дэмжихэд түлхэц болох юм. - Засгийн газрын зардлыг боломжит минимум түвшинд аваачин, орлогын эх үүсвэрүүдийг бүрэн дайчилснаар нийт эрэлтийг бууруулж, өрийн дарамт багасч, эрсдлийн түвшин ч буурах юм. - Латви улс татварын системийг шинэчлэн сайжруулах хөтөлбөрийг 2008 оноос санаачлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн гол зорилго нь татварын системийг хялбаршуулах, татварын бааз суурийг өргөжүүлэхэд чиглэгдэж байна. - 2008-2011 онуудад ДНБ-ний 4 хувийг шууд татвараас шууд бус татвар луу шилжүүлэн орлогын бааз сууриа өргөжүүлэхээр төлөвлөсөн байна. Татвар хураалтыг сайжруулж, татварын орлогыг хэрэглээнээс үйлдвэрлэл худалдааны сектор луу түлхүү чиглүүлэх бодлого баримталж байна. - Төсвийн зарлагыг хумих бодлого баримталж байгаа ч урт хугацаанд асуудал үүсгэж болохыг сайтар бодолцох хэрэгтэй байна. Мөн түүнчлэн орон нутгийн засаг захиргаанууд зардлаа зээлээр санхүүжүүлэхээс татгалзах алтан дүрмийг мөрдөх шаардлагатай байгаа бөгөөд энэ нь орон нутгийн засгийн газрын зээллэгээ 2009 онд ДНБ-ний 0,3 хувиас хэтрэхгүй байхаар тусгасан байдаг байна. Орон нутгуудтай хийсэн Бүтээгдэхүүн хуваах гэрээг 2009 оны 1-р улиралд дахин авч үзэхээр болжээ. - Латви Улсын Засгийн газар 2009 оны 1-р улиралд Санхүүгийн Хариуцлагын хуулийг боловсруулахаар төлөвлөж байна. Энэхүү хуулийн гол зорилго нь төсвийн ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэж байна. Төсвийн бодлогын гол зорилт бол дунд хугацаанд Маастрихтын шаардлагад нийцүүлэх, өөрөөр хэлбэл төсвийн алдагдлыг ДНБ-ний 3 хувьд барих гэсэн шаардлагыг хангахад оршиж байна. Үүний тулд төрийн санхүүгийн удирдлагын системийг
-----	--	---

	<p>банкуудаа аврах төлөвлөгөө гаргасантай холбогдуулан банкинд итгэх итгэл сэргэж, хадгаламжийг тогтворжуулахад нэмэртэй алхам болжээ.</p> <ul style="list-style-type: none"> - Үнэлгээний томоохон пүүсүүд Латви улсын үнэлгээг бууруулсан байна. Латвийн Төв банк 780 сая евро буюу ДНБ-ний 3,5 хувьтай тэнцэх мөнгийг банкуудынхаа төлбөрийн чадварыг сайжруулахад зориулсан байна. Нийт албан нөөцийнхөө 25 орчим хувийг ашигласан байна. - Ажилгүйдэлтэй холбоотой хүн амын орлого буурч, хэрэглээ хумигдаж эхлэв. Банкуудын зээл зогсож, хөрөнгө оруулалт огцом буурч байна. Гадаад орчны таагүй байдлаас үл шалтгаалан урсгал тэнцэлийн алдагдал 2008 онд байсан ДНБ-ний 14,75 хувиас 2009 онд ДНБ-ний 7,25 хувь болж буурахаар байна. 	<p>бэхжүүлэхэд техникийн туслалцааг авах ажлыг эхлүүлжээ. Мөн Дэлхийн банкаас төсвийн зарлагын удирдлагыг боловсронгуй болгохтой холбоотой зөвлөмж туслалцаа хүсч байгаа юм байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хямралтай холбоотойгоор хүндэрсэн банк санхүүгийн системийг аврахад зориулж 2010 оны турш ДНБ-ний 15-20 хувьтай тэнцэх зардал гаргах бөгөөд энэ нь засгийн газрын нийт өрийг ДНБ-ний 40 хувьд хүргэхээр байна. Банкны бүтцийн өөрчлөлтөнд зориулахад зарцуулагдах зардал нь банкинд хөрөнгө оруулалт хийх, хөрвөх чадварыг сайжруулах, банкны хадгаламжийн баталгааны төлбөрт тус тус зарцуулагдахаар тооцоологджээ - Өрсөлдөх чадварыг сайжруулж, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор Латвийн засгийн газар төсвийн секторын ажилтнуудын цалин урамшуулалыг 2009 онд 25 хүртэл хувиар бууруулахаар шийдвэрлэсэн байна. Үүнийг дагаад хувийн секторын ажилтнуудын цалинд мөн өөрчлөлт орохоор хүлээгдэж байна. 2009 онд урсгал тэнцэлийн алдагдал нь ДНБ-ний 7,25 хувьд хүрэхээр байгаа тул Латвийн Засгийн газар тодорхой хөтөлбөр хэрэгжүүлж эхлээд байна.
--	---	--

<p>Украин Улс</p>	<ul style="list-style-type: none"> - Украины ДНБ-ний өсөлт өнгөрсөн оны 10-р сард өмнөх сарын 5 хувиасаа 2 хувь болж буурсан байна. Шалтгаан нь барилгын секторын хямрал, жижиглэнгийн худалдааны салбарын бууралт, металлын бүтээгдэхүүний гарц буурсантай холбоотой юм. Инфляцийн түвшин мөн үед 22,3 хувьтай байсан. - Банкны салбарын хүндрэлээс болж өнгөрсөн оны 9-11-р саруудад нийт хадгаламжийн 14 хувь нь гадагшилсан байна. Экспортын орлого буурснаас шалтгаалан гадаад валютын хадгаламж мөн буурсан байна. Гэсэн хэдий ч 11-р сарын дундаас эхлэн иргэдийн гадаад валютын хадгаламж хүүгийн түвшин өссөнтэй уялдан нэмэгдсэн байна. Төмөрлөгийн болон эрчим хүч, барилгын салбарт олгосон гадаад валютын зээл чанаргүйтэх магадал өндөртэй байна. Украины үндэсний валют ривни бараг 50 хувь суларсан нь дээрхи байдалд ташуур өгч байна. Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын болон бусад намуудаас бүрдсэн эвсэл 2008 оны 12-р сарын 9-с ажиллаж эхлэв. 	<ul style="list-style-type: none"> - Төсвийн алдагдлыг оны эцэст ДНБ-ний 1хувиас доош барих бодлого хэрэгжих боломжтой боловч зарим эрсдлүүд тулгарч болзошгүй байна. Төсвийн зарлагын сахилга батыг дээшлүүлэх, шаардлагагүй хөрөнгө оруулалтуудыг хойшлуулах зэрэг арга хэмжээ авч байна. 2009 оны улсын төсвийн төслийн техникийн бэлтгэлийг эхлүүлсэн байна. - Хямралын үед татвар бүрдүүлэлт сулардаг олон улсын туршлагыг харгалзан консерватив өсөлтийг тооцоолж төсвийн төслийг боловсруулах нь чухал гэдгийг шинжээчид тэмдэглэсэн байна. - Украин улс нь олон улсын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох нь хаалттай байгаа бөгөөд дотоод нөөц болоцоо ч хомс юм. Засгийн газраас 2009 онд хувьчлагдах аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг баталсан ч дэлхийн санхүүгийн хямралтай холбогдуулан түр хойшлуулсан байна.
--------------------------	--	--

* * *

ДҮГНЭЛТ

Засгийн газраас УИХ-д өргөн барьсан Монгол улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төсөвт орох өөрчлөлт, төсвийг тэнцвэржүүлэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төсөл, тэдгээрийн макро эдийн засгийн уялдах байдалд тусгаснаар Монгол улсын нэгдсэн төсвийн орлого 554.4 тэрбум төгрөгөөр буурч, 259.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээр төсвийн орлого нийт дүндээ 295.3 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Нэгдсэн төсвийн орлогын бууралтад аж ахуй нэгжийн орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого, дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ-ын орлого, нийт импортын бууралт, импортын газрын тосны бүтээгдэхүүний хилийн үнийн бууралт, суудлын автомашины онцгой албан татварын орлого зэрэг гол гол орлогууд их хэмжээгээр буурснаас шалтгаалан нэгдсэн төсвийн орлого алдагдалтай гарахаар байна.

Олон нийтийн байгууллагууд хөрөнгө дайчлах, орлого нэмэгдүүлэх зорилгоор албан бус секторт ажиллагсаас НДШ, ЭМДШ зэргийг Засгийн газрын бодлогын дэмжлэгтэйгээр тусгай сан бий болгох мөн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, импортын татварыг тэглэх, бизнесийнхний татварын дарамтыг багасгаж татварын уян хатан бодлого баримтлах зэрэг саналтай байгаа юм байна.

Монгол улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төсөвт орох өөрчлөлт, төсвийг тэнцвэржүүлэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төсөл, эдгээрийн макро эдийн засгийн уялдах байдалд төсвийн урсгал зарлагын тодотголыг үндсэн таван хүрээнд хийхээр тооцсон байна. Эдгээрт, төрийн нийт албан хаагчдын цалинг 2009 онд 20 хувиар, төрийн өндөр албан тушаалтнуудын цалинг 30 хувиар бууруулснаар нийт 107,8 тэрбум төгрөгийн хэмнэлт гарахаар, халамжийн тэтгэмжийн давхардлыг арилгаснаар нийт 56,6 тэрбум төгрөг, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд зардлын хатуу хэмнэлтийг мөрдүүлснээр буурах зардлын дүн 25,4 тэрбум төгрөг болж, нийт 190 орчим тэрбум төгрөгийн хэмнэлт гарахаар тооцоолжээ. Харин зайлшгүй нэмэгдэх зарим зардлыг төсвийн тодотголд оруулж өгснийг хасвал нийт 173 орчим тэрбум төгрөгийн хэмнэлттэй байхаар байна.

Төсвийн урсгал зарлагыг бууруулах тухай олон нийтийн байгууллагуудаас гаргасан саналууд нь дараахь агуулгатай байна. Үүнд, төсвийн захирагч нарт хэмнэлтийн хатуу бодлого хэрэгжүүлэх, зардлын гүйцэтгэлд хяналт мониторинг хийх, төрийн аудитын болон төрийн бус байгууллагуудын хамтарсан зөвлөл байгуулах, урсгал төсвийг алдагдалгүй болгох зэрэг саналууд багтсан байна. Засгийн газраас УИХ-д 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсантай холбогдуулан Үйлдвэрчний эвлэлийн холбооноос цалин хөлсийг царцаахгүй байх тухай хүсэлтийг тавьж боломжит бусад хувилбаруудыг судалж үзэхээр болж хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан байна. 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийт хөрөнгө оруулалтыг 126.6 тэрбум төгрөгөөр бууруулан 362.4 тэрбум төгрөг байхаар тооцож оруулжээ.

Монголын ажил олгогч нэгдсэн холбооны саналд улсын төсвөөр хийх хөрөнгө оруулалтын дүнг 60 хувиар бууруулж хэмнэгдсэн хөрөнгийг үйлдвэрлэлийг дэмжихэд зарцуулах хэрэгтэй гэсэн байна. Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын хувьд төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 300 тэрбум төгрөгөөр хэмнэх, харин 2009 онд бүрэн хэрэгжүүлэх боломжтой бизнесийн томоохон төслүүдийг шууд санхүүжүүлэх механизмыг нэвтрүүлэхийг чухалчилсан байна.

Олон нийтийн зүгээс төсөвтэй холбоотой тодорхой саналуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд хүргэсээр байна. Эдгээрээс танилцуулбал, төсвийн хөрөнгө оруулалтаар хийх зарим шаардлагагүй ажлуудыг хойшлуулах, ач холбогдол

багатай төсөл хөтөлбөрүүдээс татгалзах, халамжийн тэтгэмжийг хавтгайруулан олгохгүй байх, цалингийн доод хэмжээг бүтээмжтэй уялдуулж тогтоох, ажлын байрыг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хэрэглээг урамшуулсан бодлого явуулах зэрэг саналуудыг дэвшүүлсэн байна.



ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ ТАЛААР БАРИМТАЛЖ БОЛОХУЙЦ ОЛОН УЛСЫН СТАНДАРТ АРГА ТУРШЛАГА

Д. Ариунаа (MSc)

Төсвийн орлого буурч, зарлага нэмэгдэх тохиолдолд төсвийн тодотголыг хийх нь зайлшгүй бөгөөд энэ үед аливаа улс орны Засгийн газар төсвийн тодотголын стандарт хэрэгслүүдийг ашигладаг байна.

Давагдашгүй хүчин зүйлийн улмаас улс оронд учирсан нөхцөл байдлууд болон санхүү эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс үүдэн улс орнууд төсвийн тодотголыг зайлшгүй хийх хэрэгтэй болдог. Тухайлбал, 2001 оны 9 дүгээр сарын 11-ны үйл явдлаас болж АНУ-ын Холбооны төсөвт дараах томоохон тодотголууд хийгдэж байжээ. 2002 оны санхүүгийн жилд нийт 26 муж улс нөөцийн сангаа ашигласан, 15 муж улс албан хаагчдыг цомхотгосон, 5 муж улс албан хаагчдыг эрт тэтгэвэрт гаргасан, 13 муж улс хөтөлбөрүүдээ дахин шинэчилсэн, 26 муж улс төсвийн нийт зарлагыг тодорхой хувиар жигд бууруулсан, 31 муж улс бусад арга хэмжээнүүдийг авч ажилласан байна. Эдгээрт, зарлагыг хойшлуулах, томилолтын зардлыг бууруулах, шинээр ажилд нэмж авахгүй байх, татвар хураамжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүд багтаж байна. Дээрхи байдлаар АНУ-ын 37 муж улс 2002 онд нийт 12.6 тэрбум ам долларын зарлагыг бууруулсан нь аль ч санхүүгийн жилд байгаагүй их хэмжээний зарлагыг бууруулсан явдал болжээ.

Батлагдсан төсвийн хүрээнд зарлагыг бууруулж тодотгол хийх нь улс орнуудын түгээмэл хэрэглэдэг стратеги бөгөөд үр нөлөө нь харьцангуй богино хугацаанд гардаг байна. АНУ-ын хувьд боловсрол, тэр дундаа дээд боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, олон нийтийн аюулгүй байдал, хот тосгодод үзүүлэх тусламж үйлчилгээний зарлага зэрэг нь бууруулах зарлагад ордоггүй бөгөөд төсвийн зарлагыг бууруулах стратегийн нөөц хомсдсоноос үүдэн дээрхи төрлийн зардлуудад тодотголыг хийхээр болсон байна. Төсвийн зарлагыг бууруулахад өргөн ашиглагддаг арга хэрэгслүүдээс гадна муж улс бүр өөр өөрийн онцлогт тохирсон аргуудыг хослуулан хэрэглэсэн жишээ нилээд байна. / Хавсралт 1-ээс үзнэ үү/.

Тухайн үед АНУ-ын Холбооны төсөвт тодотгол хийх стратеги арга зөвлөмжийг NASBO буюу Улсын Төсвийн захирагч нарын Үндэсний Холбооноос боловсруулсаны дагуу муж дагуу муж улсуудад хүргүүлж байжээ. Энэ нь зөвлөмжийг шинж чанартай саналууд байсан ба АНУ-ын Засгийн газар эдгээр саналуудыг бүрэн авч хэрэгжүүлсэн эсэх, үр дүнгийн талаархи хангалттай мэдээлэл байхгүй байна.

Хавсралт 1: NABSO-с /Улсын төсвийн захирагч нарын Үндэсний Холбоо/ гаргасан зөвлөмж

Төсвийн тэнцвэрийг хангах стратегийн аргууд	Жишээ тайлбар
Нийтээр нь хасах	Төрийн байгууллагуудын зардлыг бүхэлд нь болон ихэнхид нь тодорхой хувиар хасах

Тодорхой зардлаас хасалт хийх	-Төрийн ажилтны цалинг нэмэгдүүлэхгүй байх, ач холбогдол багатай төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилийг зогсоох, бууруулах -“Орон тоо царцаах комисс” /freeze committee/ байгуулж төрийн албаны орон тооны судалгаа хийж, орон тоо дутуу ажиллаж болох эсэхэд дүгнэлт гаргуулах -Төрийн албан хаагчдыг эрт тэтгэвэрт гаргах бололцоог бүрдүүлэх /тэтгэвэрийн насанд өөрчлөлт оруулах гэх мэт/
Төрийн албан хаагчдын томилолтыг багасгах	Төрийн албан хаагчдын гадаад томилолтыг бууруулах, цуцлах
Төсөл хөтөлбөрүүдийн чиглэлийг оновчтой тодорхойлж, дахин зохион байгуулах	Ажил үүргийн давхардлыг арилгах, удирдлагыг бэхжүүлэх, захиргааны нүсэр зардлыг бууруулах. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> • Зарим нэгжүүдийг татан буулгах, нэгтгэх, хөөлбөрүүдийн давхардлыг арилгах • Гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн төсвийн болон хүний нөөцийн бодлого боловсруулж мөрдүүлэх • Төрийн ажил үйлчилгээг авч буй практикт дүн шинжилгээ хийж илүү боловсронгй болгох
Орон нутагт үзүүлэх засгийн газрын тусламж	<ul style="list-style-type: none"> • Орон нутагт үзүүлэх тусламж үйлчилгээний зардлыг хойшлуулах, цуцлах • Татварын орлого хуваахыг бууруулах • Төлбөрүүдийг хойшлуулах богино хугацааны мөнгөн урсгалтай болох
Хувийн хэвшилтэй хамтран ажиллах, гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх	Нийтийн үйлчилгээг хувийн хэвслээр хийлгүүлэх, зарим ажлуудыг гэрээгээр гүйцэтгүүлэх
Татвар шимтгэлийг нэмэгдүүлэх	-Татварын бааз суурийг өргөжүүлэх, НӨТ, ХАОАТ, ОАТ зэрэг бусад татвар хураамжуудыг нэмэгдүүлэх - Шинээр татвар бий болгох /татвар ногдуулдаггүй бараа үйлчилгээнд татвар тооцож эхлэх/ - Татварын хугацаа дуусах бол хугацааг уртасгах - Үйлчилгээний хураамжуудыг нэмэгдүүлэх - Шатахуун, архи тамхины татварыг нэмэгдүүлэх - Байгальд хортой үйл ажиллагааны татвар хураамжийг нэмэгдүүлэх

Засгийн газрын зарлагыг царцаах	-Төсөвт тусгагдсан зардлуудыг зарцуулахгүй байх
Татвар нэмэгдүүлэх референда	-Татвар нэмэгдүүлэх эсэх талаар олон нийтээр хэлэлцүүлж саналыг нь авах

Зарлагын хяналт	-Засгийн газрын зарлагын өсөлтийг хүн амын өсөлтийн хувь болон инфляцитай уялдуулан хязгаарлах -Засгийн газрын зарцуулалтын хэмжээг орлогын төлөвлөгөөтэй уялдуулж хязгаарлах
Өрийн санхүүжилт хийх	-Засгийн газар богино хугацааны өрийн бичиг гаргаж зарлагаа санхүүжүүлэн ирээдүйд орох татварын орлогоороо өрөө төлөх, банкны зээлийн шугамай ижил ойлголт
Лотерей, хонжворт сугалаа явуулах	-Сугалаа, лотерейноос олох татварын орлогыг нэмэгдүүлэх
Өршөөлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх	-Татварын өртэй байгууллага, иргэдэд зориулсан 60 хоногийн татварын өршөөлийн хөтөлбөр хэрэгжүүлэх
Торгуулийг нэмэгдүүлэх	-Татварын өртэй болон хугацаандаа хамрагдаагүй бол торгуулийг ихэсгэх
Татварын хөнгөлөлтийн стандартыг шинэчлэх	-Татварын хөнгөлөлт эдлэхэд тавигдах шаардлагыг өндөржүүлэх, байгальд ээлтэй менежментийг дэмжих
Төрийн өмчит зарим барилга байгууламж, үндсэн хөрөнгийг зарж борлуулах, түрээслэх	-Төрийн мэдлийн онгоцнуудыг зарах, түрээслэх гэх мэт
Бондын санхүүжилт хийх	-Засгийн газрын бондыг дахин санхүүжүүлэх, хүүгийн хөнгөлөлт эдлэх
Татвар хураалтыг түргэтгэх	-Татвар хураалтыг уян хатан болгох -Татвар төлөх хугацаа, хувьд өөрчлөлт оруулах. Тухайлбал: аж ахуй нэгжийн 6-р сарын орлогын татварын 75 хувийг 6-р сарын 25-нд төлөх гэх мэт. Заавал 7-р сарын 20-нд төлөхийг хүлээхгүй байх
Хандивын аян зарлах	-хувийн хэвшил, байгууллага, сангуудаас өргөх хандивыг дэмжих
Олон жилийн таамаглал ашиглах	-Шийдвэр гаргагчдад бодлогын хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт хийх бололцоо олгох, тухайлбал, хөтөлөрүүдийг үргэлжлүүлж, татварыг бууруулах гэх мэт
Технологи ашиглалт	-Электрон засаглала Төрийн үйлчилгээг он-лайн хэлбэрт шилжүүлэх -Өндөр хурдны интернет тавьж алслагдсан орон нутгуудад хүрч үйлчлэх
Хуримтлуулах сонирхол төрүүлэх арга хэмжээнүүд авах	-Хуримтлал үүсгэсэн ажилтнуудад урамшуулал үзүүлэх -Санхүүгийн жилийн эцэст хэмнэлт гаргасан, хуримтлал бий болгосон байгууллагуудыг урамшуулах
Сургалтыг цуцлах	-Албан хаагчдын сургалтыг цуцлах

Бусад арга хэмжээнүүд	-Үзвэрүүдийн байгууллагуудын /музей, номын сан, амралтын хүрээлэн гэх мэт/ цагийн хуваарьт өөрчлөлт оруулах, эрт хаах -Шатахуун бага хэрэглэдэг тээврийн хэрэгсэл ашиглахыг урамшуулах
-----------------------	---

Тайлбар:

2009 оны төсөв болон төсвийн тодотголын орлогыг харьцуулан дараахь дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1. Төсөвт нийт орлого ба тусламжийн дүнг 2,223 тэрбум төгрөг байхаар тусгасныг төсвийн тодотголд 295 тэрбум төгрөг буюу 13.3 хувиар бууруулж 1,928 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.
2009 оны төсвийн тодотголд нийт орлогыг бүрдүүлэгч гол гурван орлого дараахь байдалтай тусгагдсан байна.
 - Урсгал орлого нийт дүнгээрээ 299 тэрбум төгрөгөөр буурч 1,904 тэрбум төгрөг буюу 13.6 хувиар бууруулан төлөвлөсөн байна.
 - Тусламжийн орлого 4 тэрбумаар нэмэгдэж 22 тэрбум төгрөг буюу 22.2 хувиар нэмэгдүүлсэн байна.
 - 2009 оны төсөвт тусгасан хөрөнгийн орлого нь төлөвлөгдсөн хэмжээнээсээ өөрчлөгдөөгүй байна.
2. 2009 оны төсөвт нийт орлого ба тусламжийн орлого ДНБ-ний 34.3 хувийг эзэлж байсан бол төсвийн тодотголд 30.6 хувь болгон 3.7 хувиар бууруулан төлөвлөсөн байна.

2009 оны төсөв болон төсвийн тодотголд Улсын нэгдсэн төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлагыг тус бүрээр нь харьцуулан судалж үзлээ.

1. 2009 оны нэгдсэн төсөвт нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 2,619.5 тэрбум төгрөг байхаар баталснаас төсвийн тодотголд 313.3 тэрбум төгрөгөөр бууруулан 2,306.2 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн байна. 2009 оны төсөвт Монгол улсыг хөгжүүлэх сангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 115,4 тэрбум төгрөгөөр баталсан бол төсвийн тодотголоор 67,4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 182,8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна. 2009 оны төсөвт Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 433,9 тэрбум төгрөгөөр баталсан бол 2009 оны төсвийн тодотголд 432,6 тэрбум төгрөг байхаар төлөвлөж 1.3 тэрбум төгрөгөөр бууруулжээ.
2. 2009 оны төсөвт Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн нь ДНБ-ний 40.4 хувийг эзэлж байсан бол төсвийн тодотголд 36.6 хувь болгон 3.8 хувиар бууруулан төлөвлөсөн бол Монгол улсыг хөгжүүлэх сангийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн төсвийн тодотголд ДНБ-ний 2.9 хувийг эзлэхээр тусгагджээ. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2009 оны төсөвт ДНБ-ний 6.7 хувийг эзлэхээр төлөвлөгдсөн байсан бол төсвийн тодотголд 6.9 болгон 0.2 хувиар нэмэгдүүлсэн байна.
3. Засгийн газраас УИХ-д өргөн барьсан Монгол улсын 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 2009 оны Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийн тэнцэлийн зүйл ангиудад зөрүү байгаа эсэхийг шалгаж үзэхэд Монгол Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөвт зөрүүгүй байна. Харин Нэгдсэн төсвийн зарлагын Бараа үйлчилгээний зардал, Тагаас ба урсгал шилжүүлэгүүд нь зөрүүтэй гарсан. Үүнийг Сангийн яамнаас тодруулахад Нэгдсэн төсөв дээр давхардлын залруулга хийгдсэн учир тусгай аргачлалаар дахин хянаж

үзэхэд зөрүү гараагүй гэсэн тайлбарыг өгсөн.

II. Монгол Улсын Засгийн газраас УИХ-д өргөн барьсан 2009 оны төсвийн тодотголтой холбогдуулан орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах талаар тодорхой санал боловсруулах хүсэлтийг эрхэм гишүүн Г.Занданшатар таниас ирүүлсний дагуу Төвийн зарим судлаачдын хийсэн судалгаа, тооцоон дээр үндэслэсэн дараахи саналыг одоогоор хүргүүлэх боломжтой байна. Үүнд:

1. УИХ-ын Тамгын газрын СШОНХТөвийн судлаач доктор Р.Батсүх, Д.Живгаагүнсэл, Д.Золбоо нар “Атрын 3 дахь аян хөтөлбөрийн эдийн засгийн үр дүн” сэдэвт судалгаа хийж, тус хөтөлбөрийн хүрээнд тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, хувь хүмүүст эдийн засгийн хувьд нэн таатай нөхцөл боломж олгохын тулд Засгийн газраас үзүүлсэн урамшуулал, хөнгөлөлтийг нарийвчлан судалж үзсэн байна. Энэхүү судалгааны дүнд эдгээр судлаачид буудайн санд авсан буудайг тухайн үеийн дэлхийн болон хөрш орны зах зээлийн үнээс тн тутмыг нь 143.9-155.4 мянган төгрөгөөр илүү үнээр авсан болохыг тогтоосон ба буудайн сан, улсын нөөц, гурилын үйлдвэрт буудай тушаасан 393 аж ахуйн нэгжид 1 тн буудай тутамд 80.0 мянган төгрөгөөр бодож 11.1 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон нь дэлхийн зах зээлийн үнээс өндөр үнээр буудай худалдан авсан хэдий ч давхцуулан урамшуулал олгосон гэсэн дүгнэлт хийсэн байна. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх “Атрын 3 дахь аян” газар тариалангийн үндэсний хөтөлбөрт 2009 оны төсөвт 30.3 тэрбум төгрөг төсөвлөснийг төсвийн тодотголд хэвээр үлдээжээ. Судлаачдын хийсэн дүгнэлт нь “Атрын 3 дахь аян” хөтөлбөрийн ерөнхий ач холбогдлыг бууруулах үндэслэл болохгүй боловч төсөвлөсөн 30.3 тэрбум төгрөгийн хөрөнгийг дор хаяж 11.1 тэрбум төгрөгөөр хэмнэх боломж байгааг харуулж байна.
2. Олон орны засгийн газрууд төсвийн зарлагаа бууруулах уу, хямралын эсрэг авах арга хэмжээгээ нэмэгдүүлэх үү гэсэн сонголттой тулгарч байгаа бөгөөд тухайлбал, ОХУ-ын Засгийн газрын хувьд төсвийн зарлагаа бууруулна, гэхдээ тэтгэвэр, төсвийн байгууллагын ажилтнуудын цалин, ажилгүйдлын тэтгэмж зэргийг бууруулахгүй гэсэн бодлого баримталж байна. ОХУ-ын Сангийн яамны сайд А.Л.Кудрин нийгмийн шинж чанартай зардлуудыг танахын оронд харин эрүүл мэнд, боловсрол гэх мэт салбарын хөрөнгө оруулалтыг, тухайлбал, эдгээр салбарт шинээр барих барилга, байгууламжийг яг одоо энэ үед барих шаардлагатай юу гэдгийг цэгнэж үзэх хэрэгтэй гэж 2009 оны 2 дугаар сарын 16-ны өдөр мэдээллийн Ройтер агентлагт өгсөн ярилцлагтаа дурьджээ.

Энэ туршлагаар манай орны хувьд 2009 оны төсвийн тодотголоор төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрийн багцад төсөвлөгдсөн шинээр барьж байгуулах барилга байгууламж, зарим хөрөнгө оруулалтын хугацааг хойшлуулах боломжтой байж болох юм.



**2009 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛТОЙ ХОЛБОГДУУЛАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХААР УИХ-д ӨРГӨН БАРЬСАН ХУУЛИУДЫН ХАРЬЦУУЛАЛТ**

Макро эдийн засгийн багийн судлаачид

Төсвийн ерөнхийлөн захирагч	2009 оны төсөв Дүн /сая төг/	2009 оны төсвийн тодотгол Дүн /сая төг/	Зөрүү	
			Өсөлт	Бууралт
Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2.6-р зүйлд зааснаар төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах төсөв:				
Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар	1,816.4	1,627.7		-188.7
Монгол Улсын Их Хурлын дарга	11,537.3	9,478.3		-2,059.0
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	1,283.4	1,162.2		-121.2
Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч	850.5	672.3		-178.2
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	9,854.4	8,464.6		-1,389.8
Улсын ерөнхий прокурор	6,571.3	5,335.0		-1,236.3
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга	560.9	473.6		-87.2
Монгол улсын ерөнхий сайд	26,429.3	18,817.0		-7,612.3
Монгол улсын тэргүүн шадар сайд	17,516.4	19,746.6	2,230.2	
Монгол улсын шадар сайд	69,833.9	63,177.4		-6,656.5
Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	8,167.2	8,143.6		-23.7
Гадаад харилцааны сайд	23,964.5	24,601.6	637.2	
Сангийн сайд	304,576.3	283,085.4		-21,490.9
Хууль зүй дотоод хэргийн сайд	101,642.2	83,681.2		-17,961.0
Байгаль орчин аялал жуулчлалын сайд	24,317.0	19,828.0		-4,489.0
Батлан хамгаалахын сайд	57,164.1	49,474.4		-7,689.7
Боловсрол соёл шинжлэх ухааны сайд	485,131.4	429,498.6		-55,632.8
Зам тээвэр барилга хот байгууллалтын сайд	193,548.0	113,818.2		-79,729.8

Эрдэс баялаг эрчим хүчний сайд	68,229.4	42,442.8		-25,786.5
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	421,215.7	352,673.5		-68,542.2
Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд	77,776.4	61,238.0		-16,538.4
Эрүүл мэндийн сайд	229,853.0	205,227.8		-24,625.1
Төрийн албаны зөвлөлийн дарга	288.6	306.9	18.3	
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	4,194.8	4,156.6		-38.2
Хүний эрхийн үндэсний комиссын дарга	225.1	174.6		-50.5
Улсын ерөнхий аудитор	568.6	476.0		-92.6
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1,086.2	932.5		-153.7
үндэсний статистикийн хорооны дарга	3,885.9	3,350.0		-535.9
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга	536.5	512.4		-24.1
Авлигатай тэмцэх газрын дарга	3,063.4	2,643.2		-420.2
Орон нутгийн засаг захиргаа	37,911.6	13,351.3		-24,560.3
Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн захирал	7,357.7	6,999.3		-358.4
Нийт дүн	2,200,957.4	1,835,570.6	2,885.7	-365,386.8

Тайлбар:

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас 3 ерөнхийлөн захирагчдын багцыг нэмэгдүүлэн тооцсон байна. Үүнд:

- 2009 оны төсөвт Монгол улсын Тэргүүн шадар сайдын багцыг 17,516.4 сая төгрөгөөр баталсныг тодотголоор 2,230.2 сая төгрөгөөр нэмж оруулснаар 19,476.6 сая төгрөг болгон тусгажээ.
 - Чөлөөт бүсийн зөвлөлийн ажлын албаны зардлыг 41.7 сая төгрөгөөр, Улсын бүртгэлийн ерөнхий газрын төсвийг 3,965.3 сая төгрөгөөр тус тус нэмж төлөвлөжээ.
 - Тэргүүн шадар сайдын харьяаны байгууллагуудын зардлыг 1,776.9 сая төгрөгөөр бууруулжээ.
- Гадаад харилцааны сайдын багцыг 637.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсон нь Гадаад харилцааны яамны төсвийг 921.2 сая төгрөгөөр, Дипломат төлөөлөгчийн газрын төсвийг 370.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын төсвийг 34.4 сая төгрөгөөр, ГХЯ-ны хөрөнгө оруулалт, их засварыг 450.0 сая төгрөгөөр тус тус хассантай холбоотой байна.

- Төрийн албаны зөвлөлийн даргын багцад багтах Төрийн албаны зөвлөлийн хөрөнгө оруулалтыг 12.5 сая төгрөгөөр хасч, харин Төрийн захиргааны албаны зөвлөлийн төсвийг 30.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт Төрийн албаны зөвлөлийн даргын багцыг 18.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсон байна.

Бусад 29 ерөнхийлөн захирагчдын багцыг 2009 оны батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 16.6 хувиар буюу 365.4 тэрбум төгрөгөөр бууруулж тооцсон байна.

Зарлага, орлогын төрөл	2009 оны төсөв Дүн /сая төг/	2009 оны төсвийн тодотгол Дүн /сая төг/	Зөрүү	
			Өсөлт	Бууралт
Монгол Улсын хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн1 дүгээр зүйлд зааснаар нэмэгдэх зардлын хэмжээ:				
Монгол Улсын 2009 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрт	-	219,600.0	219,600.0	-
Газрын тосны болон хүнсний улаанбудайн нөөцийн хадгалалтын хөлсийг	-	3,298.1	3,298.1	-
Нийт нэмэгдсэн зардал	-	222,898.1	222,898.1	
Монгол Улсын хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн (2 дугаар зүйлд зааснаар өөрчлөлт оруулсан зардлын хэмжээ:				
Нийт орлого ба тусламжийн дүн	45,232.8	49,132.8	3,900.0	-
Хөрөнгө оруулалт	79,867.3	122,289.3	42,422.0	-
Урсгал шилжүүлэг	35,542.8	57,184.5	21,641.7	-

Тайлбар:

- Монгол Улсын хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд зааснаар Монгол Улсын 2009 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, Газрын тосны болон хүнсний улаанбуудайн нөөцийн хадгалалтын хөлсөнд нийт 222,898.1 сая төгрөгийг нэмж оруулахаар тусгажээ. Мөн уг хуулиар 2009 оны нийт төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 3,900.0 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтыг 42,422.0 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 21,641.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр тусгажээ.



Зарлага, орлогын төрөл	2009 оны төсөв Дүн/сая төг/	2009 оны төсвийн тодотгол Дүн /сая төг/	Зөрүү	
				Өсөлт Бууралт
Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар өөрчлөлт оруулсан төвлөрүүлэх орлогын доод хэмжээ:				
Аж ахуй нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	102,430.6	102,430.5	-	-
Даатгуулагчаас төлөх шимтгэл	139,636.2	131,421.2	-	-8,215.0
Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	57,037.8	48,021.3	-	-9,016.5
Төр бүрэн хариуцах даатгуулагчийн ЭМД-ын хураамж	8,094.3	8,094.3	-	-
Нөхөн олговор авагсадын нийгмийн даатгалын шимтгэл	39.2	39.2	-	-
Сайн дурын даатгуулагчаас төлөх	2,751.8	2,751.8	-	-
Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	2,815.4	2,815.4	-	--
Бусад орлого	5,194.0	5,194.0	-	--
Нийт орлого	317,999.2	300,767.8	-	-17,231.5
Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар өөрчлөлт оруулсан зарлагын хэмжээ:				
Тэтгэвэрийн сан	331,932.7	331,932.7	-	-
Тэтгэмжийн даатгалын сан	14,477.2	14,477.7	-	-
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	15,627.4	15,627.4	-	-
Ажилгүйдлийн даатгалын сан	3,341.6	3,341.6	-	-
Эрүүл мэндийн даатгалын сан	56,060.6	56,060.6	-	-
Үйл ажиллагааны зардал	9,287.4	7,934.4	-	-1,353.0
Бусад зардал	235.3	235.3	-	-
Хөрөнгө оруулалт	3,000.0	3,000.0	-	-
Нийт зарлага	433,962.2	432,609.3	-	-1,353.0

Тайлбар:

- Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тодотголоор Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэх орлогыг доод хэмжээг 17,231.5 сая төгрөгөөр, зарлагыг 1,353.9 сая төгрөгөөр тус тус бууруулахаар тооцжээ.

ДЭЛХИЙН ЗАРИМ УЛС ОРНЫ ТӨВ БАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ⁵*Д. Ариунаа (MSc)*

	Төв Банкууд	Одоо мөрдөгдөж буй бодлогын хүү	Хамгийн сүүлд өөрчлөлт оруулсан байдал	Дараагийн уулзалтын тов
1	Холбооны Нөөцийн Сан (АНУ)	0.00% - 0.25%	12/16/08 0.75 %-р бууруулсан	01/28/2009
2	Европын Төв Банк	2.00%	01/15/09 0.50 хувиар бууруулсан	02/05/2009
3	Английн Төв Банк	1.0%	2009 оны 1-р сард 0.50 хувиар бууруулсан	02/05/2009
4	Швейцарийн Төв Банк	0.00%-1.00%	11/06/08 0.50 хувиар	03/12/2009
5	Австралийн Нөөцийн Банк	4.25%	12/01/08 1 хувиар бууруулсан	02/02/2009
6	Канадын Төв Банк	1.00%	01/20/08 0.50 хувиар бууруулсан	03/03/2009
7	Шинэ Зеландын Нөөцийн Банк	5.00%	12/03/08 1.5 хувиар бууруулсан	01/28/2009
8	Японы Төв Банк	0.10%	12/19/08 0.20 хувиар бууруулсан	01/21/2009
9	Өмнөд Солонгосын Төв Банк	5%	09/10/08 0.25 хувиар бууруулсан	
10	Гон-Конгийн Төв Банк (Monetary authority)	2%	09/10/08 0.5 хувиар бууруулсан	
11	Тайваний Төв Банк	3.25%	09/10/08 0.25 хувиар бууруулсан	
12	Оросын Төв Банк	13%	01/12/08 1 хувиар нэмэгдүүлсэн	
13	Хятадын Төв Банк	5.31%	2008 оны 11-р сард 0.27 хувиар бууруулсан	
14	Монгол Улс	9.75%	11/19/08 0.5 хувиар бууруулсан	
15	Беларусийн Төв Банк	14%	08/01/09 2 хувиар нэмэгдүүлсэн	
16	Казахстаны Төв Банк	9.5%	05/02/09	

⁵ 2008 оны 10-р сарын 08-д Дэлхийн томоохон Төв Банкууд бодлогын хүүгээ зэрэг буулгасан байна.

17	Малайзийн Төв Банк	2.0%	21/01/2009 0.5 хувиар бууруулсан	
18	Унгарын Төв Банк	9.5%	2008 оны 10-р сард 0.5 хувиар бууруулсан	
19	Чехийн Төв Банк	1.75%	2009 оны 1-р сард 0.5 хувиар бууруулсан	
20	Польшийн Төв Банк	4.0%	2009 оны 1-р сард 0.25 хувиар бууруулсан	
21	Сингапурын Төв Банк (Monetary Authority)	0.06%	2008 оны 9-р сард 0.44 хувиар бууруулсан	

* * *

Швейцарийн Төв Банк мөнгөний бодлогын хэрэгжилтийг улиралд нэгээс доошгүй удаа авч хэлэлцдэг бөгөөд мөнгөний бодлогоор гаргах шийдвэр нь тодорхой хугацаагаар хязгаарлагддаггүй, аль ч үед шийдвэр гаргах боломжтой байдаг байна. Төв Банкуудаас Японы Төв Банкны бодлогын хүү хамгийн бага нь буюу 0.5%-с 0.1% болгон бууруулсан байна. Дэлхийн томоохон зургаан Төв Банк 2008 оны 10-р сарын 8-ны Лхагва гаригт зэрэг хүүгээ буулгасны маргааш буюу Пүрэв гаригт Азийн зарим томоохон орнуудын Төв Банкууд бодлогын хүүгээ бууруулсан байна. Дээрхи хугацаанаас хойш зарим Төв Банкууд бодлогын хүүгээ хэрхэн бууруулсныг Хүснэгт 1-с харах боломжтой. Хүснэгт 2 -с зарим Төв Банкуудын бодлогын хүүгийн динамик болон бодлогын хүүгийн тухай харьцуулсан мэдээлэлтэй танилцана уу?

Улс Орон	Тайлбар	Бодлогын хүүгийн динамик
АНУ	Мөнгөний бодлогын асуудлаар АНУ-н Холбооны Нээлттэй Зах Зээлийн Хороо (Federal Open Market Committee FOMC) болон АНУ-н Холбооны Нөөцийн Сангийн (Federal Reserve) Захирлуудын Зөвлөл хамтран хэлэлцэх эрхтэй байдаг. Бүс нутгийн Холбооны Нөөцийн Банкнаас ирүүлсэн саналыг үндэслэн Холбооны Нөөцийн Захирлуудын Зөвлөл бодлогын хүүнд өөрчлөлт оруулах эсэх талаар шийдвэр гаргадаг. Харин FOMC нь нээлттэй зах зээлийн үйл ажиллагааны талаар буюу Төв Банкнаас шаардагдах мөнгөний хэмжээ болон зах зээлийн хүүгийн талаар шийдвэр гаргадаг	<p>United States Interest Rate</p> <p>— Central Bank Overnight Rate</p> <p>source: Federal Reserve</p> <p>www.tradingeconomics.com</p>

<p>ОХУ</p>	<p>ОХУ-н хувьд бодлогын хүүгийн шийдвэрийг Төв Банк нь (Central Bank of the Russian Federation) гаргадаг. Албан ёсны бодлогын хүү (refinancing rate) нь зээлийн хүүгийн дээд лимит байх ба энэ нь татварын төлбөрийг тооцоолоход ашигладаг бенчмарк хүү юм.</p>	<p>— Central Bank Overnight Rate</p> <p>source: Central Bank of Russia www.tradingeconomics.com</p>
<p>Хятад</p>	<p>Хятадын Ардын Банкны (The People's Bank of China) Мөнгөний Бодлогын Хороо нь (Monetary Policy Committee) бодлогын хүүгийн талаар шийдвэр гаргадаг. Хятадын Төв Банк нь хоёр төрлийн бодлогын хүүгийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Нэг жилийн хугацаатай зээлийн бэнчмарк хүү, нөгөөх нь Төв Банкны зээлийн хүү буюу дахин хямдруулсан (rediscount rate) хүү юм.</p>	<p>— Central Bank Overnight Rate</p> <p>source: The People's Bank of China www.tradingeconomics.com</p>
<p>Япон</p>	<p>Японы Төв Банкны Бодлогын (Bank of Japan) Зөвлөл бодлогын хүүгийн асуудлаар шийдвэр гаргадаг. Японы Төв Банкны албан ёсны бодлогын хүү нь хямдруулалтын хүү (discount rate) юм. Мөнгөний бодлогын зөвлөлийн хурлаар мөнгөний зах зээлийн үйл ажиллагааны зөвлөмжийг баталдаг.</p>	<p>— Central Bank Overnight Rate</p> <p>source: Bank of Japan www.tradingeconomics.com</p>
<p>Чех</p>	<p>Чехийн Төв банк (Czech National Bank) бодлогын хүүгийн асуудлаар шийдвэр гаргадаг. Албан ёсны бодлогын хүү нь арилжааны банкуудаас тухайн өдрийн төгсгөлд Төв Банкндаа байршуулж буй илүүдэл нөөцөд төлж буй хүү юм.</p>	<p>— Central Bank Overnight Rate</p> <p>source: FRIBOR PANEL BANK DATA www.tradingeconomics.com</p>



<p>Польш</p>	<p>Польшид бодлогын хүүгийн асуудлаар Польшийн Төв Банк (National bank of Poland) шийдвэр гаргадаг. Бодлогын хүү нь Төв Банкнаас арилжааны банкуудад санал болгодог жилийн хүүгийн түвшин юм.</p>	<p>Poland Interest Rate</p> <p>— Central Bank Overnight Rate</p> <p>source: National Bank of Poland www.tradingeconomics.com</p>
<p>Малайз</p>	<p>Малайзид бодлогын хүүгийн асуудлаар Малайзийн Төв банк (Bank Negara Malaysia) шийдвэр гаргадаг. Албан ёсны бодлогын хүү нь овернайт хүү байдаг. Бодлогын хүү гэсэн тодорхойлолтод зээлийн жилийн хүүг ойлгож байна.</p>	<p>Malaysia Interest Rate</p> <p>— Central Bank Overnight Rate</p> <p>source: Bank Negara Malaysia www.tradingeconomics.com</p>
<p>Унгар</p>	<p>Унгарын Төв Банкны (Hungarian National Bank) Мөнгөний Зөвлөл бодлогын хүүгийн асуудлаар шийдвэр гаргадаг. Бодлогын хүү гэдэг нь Төв банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад нэг жилээс дээш хугацаатай олгодог зээлийн хүү юм.</p>	<p>Hungary Interest Rate</p> <p>— Central Bank Overnight Rate</p> <p>source: National Bank of Hungary www.tradingeconomics.com</p>
<p>Сингапур</p>	<p>Сингапурын Мөнгөний Хороо (Monetary Authority of Singapore) бодлогын хүүгийн асуудлаар шийдвэр гаргадаг. Албан ёсны хүү нь Сингапурын банк хоорондын хүү юм (Singapore Interbank Offered Rate Sibor).</p>	<p>Singapore Interest Rate</p> <p>— Central Bank Overnight Rate</p> <p>source: Monetary Authority of Singapore www.tradingeconomics.com</p>
<p>Их Британи</p>	<p>Их Британид бодлогын хүүгийн асуудлыг Төв Банк нь (the Bank of England) хариуцдаг. Албан ёсны бодлогын хүү нь репо хүү юм. Репо хүү нь Английн Төв Банкны арилжааны банкууд, барилгын нийгэмлэгүүд, үнэт цаасны пүүсүүдтэй нээлттэй зах зээлийн харилцаанд оролцоход ашигладаг хүү юм.</p>	<p>United Kingdom Interest Rate</p> <p>— Central Bank Overnight Rate</p> <p>source: Bank of England www.tradingeconomics.com</p>

Зарим Төв банкуудын зүгээс бодлогын хүүгийн таамаглалыг олон нийтэд зарлах нь зах зээлийн үйл ажиллагааг гажуудуулах сөрөг талтай гэж үзэж байна. Энэ асуудлаар BIS (Bank for International Settlement) буюу Олон Улсын Төв Банкны эдийн засагчид судалгааны ажил хийсэн байна. Дээрхи судлаачид Төв банкуудын бодлогын хүүний тухай олон нийтэд өгч буй мэдээлэл нь санхүүгийн зах зээлийг гажуудуулж буй эсэхийг судлах зорилгоор АНУ, Еврогийн бүс болон Шинэ Зеландийн зах зээлийн төлөв байдлыг судалж холбогдох дүгнэлтүүдийг хийсэн байна. Хэрэв шаардлагатай бол энэ тухай мэдээллийг бэлтгэн өгөх боломжтой.

* * *

Ашигласан материал:

1. “Central Bank Policy Rate Guidance and Financial Market Functioning” by Richhild Moessner and William R. Nelson, Bank for International Settlements Federal Reserve Board
2. “Asian Central banks cut interest rates” by Financial Times reporters
www.ft.com
3. “World central banks make historic joint rate cut” by Glenn Sommerville, Reuters
www.reuters.com
4. www.tradingeconomics.com
5. www.mongolbank.mn



2

БҮЛЭГ

УУЛ УУРХАЙ, ДЭД БҮТЭЦ, АШИГТ МАЛТМАЛЫН САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДАЛ

**МОНГОЛ УЛСЫН НЕФТЬ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ, ХИЛИЙН БОЛОН ЗАХ
ЗЭЭЛИЙН, ЖИЖИГЛЭНГИЙН ҮНИЙН ХАРЬЦУУЛАЛТ**
(Шударга бус өрсөлдөөний аспект)

Ц. Батдорж

Шатахууны зах зээлийн өнөөгийн байдал.

Монголын шатахууны зах зээлийг цөөхөн тооны компани хариуцан ажилладагч зах зээлд үнэ тогтоохдоо үгсэн хуйвалдаж Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийг зөрчдөг боловч тодорхой арга хэмжээ авахгүй байгаа тухай олон эх сурвалжид хөндсөөр байгаа билээ. Манай улсад зах зээл дээр газрын тосны бүтээгдэхүүний импорт бусад үйлчилгээг явуулдаг 20 гаруй компани байдаг бөгөөд эдгээрээс шатахууний жижиглэнгийн борлуултын үйлчилгээ үзүүлдэг 6 компани байдаг байна.

НИК, Петровис, Магнай трейд, Шунхлай групп, Жаст-Ойл, Сод Монгол гэсэн зургаан компани шатахууны жижиглэнгийн үйлчилгээ эрхлэдэг бөгөөд НИК, Петровис компани импортын шатахууны 40 шахам хувийг дангаараа нийлүүлдэг нь энэхүү зах зээлд өрсөлдөөн биш монополь байдалтай гэж үзэж болохоор байна.

Манай улсын нефть бүтээгдэхүүний 2008 оны хэрэглээ 845 мянган тонн буюу 890 сая ам долларын нефть бүтээгдэхүүн экспортлон хэрэглэсэн бөгөөд 2008 онд 1 тонн автобензиний импортын хилийн дундаж үнэ 669.7 ам.доллараас 963.3 ам доллараар хэлбэлзэж байжээ.

2009 оны нэгдүгээр улиралд импортын хилийн үнэ маш хангалттай буурсанч нийлүүлэгч компаниудын үнэ, ОХУ-ын нефть бүтээгдэхүүний экспортын гаалийн татвар буурсан болон манай улсын нэмэгдсэн өртөгийн болоод гаалийн татварыг тэглэсэн байхад хүртэл үнээ буулгахгүй байсаар байна.

“Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар”-аас Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлсэн нь Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийг зөрчсөн эсэхийг тогтоох зорилгоор хийсэн хяналт шалгалтаар газрын тосны бүтээгдэхүүн импортлогч зарим аж ахуйн нэгжүүд “Нефть хий ассоциац”-ийн нэрийн дор бүтээгдэхүүнийхээ үнийг нэг цаг хугацаанд, нэг ижил хэмжээгээр нэмэгдүүлсэн нь өөр хоорондоо шударгаар өрсөлдөхөөс зайлсхийж “үнийг харилцан тохиролцсон” болохыг тогтоосон. Иймээс хуулийн дагуу 6 аж ахуйн нэгжид 1500,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулахаар шийдвэрлэсэн бөгөөд харин бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлсэн шалтгаан нь бодитой бөгөөд хэт ашиг олох зорилгоор үнэ хөөрөгдсөн гэж үзэх үндэслэлгүй болохыг тогтоожээ.

Мөн УИХ-ын 48 дугаар тогтоол болон Засгийн газрын 2008 оны 247, 282 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх зорилгоор “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар”-аас улсын нөөц хэлбэрээр байршуулах газрын тосны бүтээгдэхүүнийг худалдан авч, хадгалах ажлын хүрээнд НИК ХК, Петровис ХХК, Магнай трейд ХХК-иуд зах зээлд олсон байр сууриа ашиглан нефтийн бүтээгдэхүүн хадгалах үнийг хэт өсгөсөн эсэхийг хянан, шалгаж өгөхийг хүссэн Сангийн сайдын албан тоотыг үндэслэн дээрхи нэр бүхий компаниудын агуулахуудын байдалтай газар дээр нь очиж танилцан, бүтээгдэхүүн хадгалахад гарах өртөг, зардлын тооцоог хийж үнийг харилцан тохиролцож асуудал шийдвэрлэсэн байна.

Шатдаг хийн түлшний зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа “Юнигаз” ХХК-ийн бүтээгдэхүүний үнэ үндэслэлтэй эсэхийг шалгаж өгөх талаар өрсөлдөгч аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдлын дагуу шалгалт хийсэн. Шалгалтийн хүрээнд авто тээврийн хэрэгсэлд зориулсан шингэрүүлсэн хийн борлуулалтын зах зээл дээр “Юнигаз” ХХК нь давамгайл байдалтай болохыг тогтоожээ.



Монголын зах зээл дээрх газрын тосны бүтээгдэхүүний үнийн тухай

2002 оноос хойш дотоодын зах зээлийн үнэ хурдацтай нэмэгдэж, хөгжилтэй орнуудын зах зээлийн үнэд дөхөж очсон байна. Олон улсын үнэлгээний GTZ компани дэлхийн 170 гаруй улс орнуудын худалдаалж буй газрын тосны бүтээгдэхүүн буюу шатахууны үнэ ханшийн талаархи судалгааг хийсэн. Энэхүү судалгаагаар 2007 оны эхний хагас жилийн байдлаар манай дотоодын зах зээл дээрх шатахууны үнэ ханш Таджикстан, Узбекистан, Грузин зэрэг орнуудын үнэ ханштай ойролцоо байсан бөгөөд дэлхийн дундаж үнэтэй улс орнуудын тоонд багтажээ.

Газрын тосны бүтээгдэхүүнийг манай улс 100 хувь импортоор оруулж ирдэг бөгөөд 90 гаруй хувийг ОХУ –ын газрын тосны бүтээгдэхүүн экспортлогч “Роснефть” компанитай байгуулсан гэрээний дагуу импортолдог. 2007 оны сүүлээс 2008 оны эхэнд ОХУ манай улсад экспортлох бензин, шатахууны гадаад үнээ 1 тн тутамд 69-137 ам.доллараар өсгөсөн байна. Гадаад үнийн өсөлтөөс зах зээлийн үнийг хамгаалах, өргөн хэрэглээний барааны үнийн хөөрөгдлийг бууруулах зорилгоор Засгийн газрын 2007 оны 357 –р тогтоолоор дотоодод худалдаалах шатахууны зах зээлийн үнийг 2008.02.15 –ныг хүртэл өсгөхгүй байх үүргийг шатахуун импортлогч компаниудад өгч, нийт 12,3 тэрбум төгрөгийн нөхөн олговрыг тус компаниудад олгосон байна.

Газрын тосны бүтээгдэхүүний хилийн үнэ:

Огноо	A-80	Үнийн өөрчлөлт		Аи-92	Үнийн өөрчлөлт		Дизель түлш	Үнийн өөрчлөлт	
	Үнэ	\$/тн	Өөрчлөлт	Үнэ	\$/тн	Өөрчлөлт	Үнэ	\$/тн	Өөрчлөлт
2007.10.	728	33	5%	798	36	4.7%	748	74	11.0%
2007.11	750	22	3%	827	29	3.6%	793	45	6.0%
2007.12	831	81	11%	896	69	8.3%	897	104	13.1%
2008.01	835	4	0.48%	896	0	0%	930	33	4%
2008.02	835	0	0.00%	896	0	0%	930	0	0%
2008.03	835	0	0.00%	896	0	0%	930	0	0%
Нийт өөрчлөлт		140			134			256	

Газрын тосны бүтээгдэхүүний зах зээлийн үнэ:

Огноо	A-80	Үнийн өөрчлөлт		АИ-92	Үнийн өөрчлөлт		Дизель	Үнийн өөрчлөлт	
	Үнэ	₮	Өөрчлөлт	Үнэ	₮	Өөрчлөлт	Үнэ	₮	Өөрчлөлт
2007.10.	890	55	6.6%	1015	30	3.0%	1045	70	7.2%
2007.11	995	105	11.8%	1140	125	12.3%	1155	110	10.5%
2007.12	990	-5	-0.5%	1135	-5	-0.4%	1150	-5	-0.4%
2008.01	990	0	0%	1135	0	0%	1150	0	0%
2008.02	990	0	0%	1135	0	0%	1150	0	0%
2008.03.18	1100	110	11%	1225	90	8%	1315	165	14%
Нийт өөрчлөлт		265			240			340	

Засгийн газраас 2-3 дугаар сарын алдагдал болох 8,8 тэрбум төгрөгийн нөхөн олговрыг олгох боломжгүй гэж шийдвэрлэсэнтэй холбоотойгоор 2008.03.15-нд зах зээлийн үнэ 90-165 төгрөг буюу 8-14%-иар өсгөсөн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний өртгийн судалгаа:

		2008.04.01, ханш 1173 төгрөг					
№	Үзүүлэлтүүд	А-80		АИ-92		Дизелийн түлш	
		\$	₮	\$	₮	\$	₮
1	Хилийн үнэ (тн/\$)	835.00	979,455.00	896.00	1,051,008.00	930.00	1,090,890.00
2а	Гаалийн татвар (5%)	41.75	48,972.75	44.80	52,550.40	46.50	54,544.50
2б	Албан татвар (тонн татвар тутмаас)		20,350.00		25,700.00		2,140.00
2в	НӨТ (10%)		97,945.50		105,100.80		109,089.00
2г	Онцгой албан татвар	38.00	44,574.00	43.00	50,439.00	48.00	56,304.00
2	Нийт татварын зардал		211,842.25		233,790.20		222,077.50
3а	Төмөр замын тээврийн зардал		7,947.00		7,947.00		7,947.00
4	1 тн бүтээгдэхүүний өртөг		1,199,244.25		1,292,745.20		1,320,914.50
4а	Хувийн жин		0.74		0.77		0.84
4б	1000 кг-ийг литрээр илэрхийлбэл (V=m/нягт)		1,353.18		1,298.03		1,193.32
5	1 л бүтээгдэхүүний өртөг		886.24		995.93		1,106.93
6	1 литр бүтээгдэхүүний зах зээлийн үнэ		1,100.00		1,225.00		1,315.00
7	1 л бүтээгдэхүүний үнэ, өртгийн зөрүү		213.76		229.07		208.07

УИХ-ын ТГ-ын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв

Нефть бүтээгдэхүүний импортын мэдээ /2008-04-01-ээс 2009 оны 04-28 хүртэл/

2008.04.01-ээс 2008.12.31											
Код	Барааны		Тоо хэмжээ	Нэгж үнэ USD /тонн тутамд/	Гаалийн үнэлгээ		Татвар /мян.төг/				
	Нэр	нэгж			Мян.ам долл	Мян.төг	гааль	онцгой	Н.Ө.Т	албан	дүн
2710	Бензин 90 хүртэл дээш октантай	кг	131018337	1014.1	132866.80	153419339.28	3866258.83	2004860.81	7298089.40	2634110.95	158033320.00
2710	Бензин 90 -ээс дээш октантай	кг	116423306	1069.8	124551.85	144641466.19	3713899.43	2883221.87	7654025.57	2918715.26	17169862.13
2710	Дизелийн түлш	кг	306850600	1142.1	350459.54	405977438.39	8388309.30	7737587.81	15732733.73	648992.53	32507623.37
Нийт бензин дизель		кг	554292243		607878.19	704038243.87	15968467.56	12625670.49	30684848.71	6201818.74	65480805.50

2009.01.01-ээс 2009.04.28											
Код	Барааны		Тоо хэмжээ	Нэгж үнэ USD /тонн тутамд/	Гаалийн үнэлгээ		Татвар /мян.төг/				
	Нэр	нэгж			Мян.ам долл	Мян.төг	гааль	онцгой	Н.Ө.Т	албан	дүн
2710	Бензин 90 хүртэл октантай	кг	25922987	484.9	12571.18	18457992.22	916761.74	1412528.81	2117530.63	525389.63	4972210.80
2710	Бензин 90 -ээс дээш октантай	кг	41312710	471.1	19463.15	28437466.83	1421873.34	3052917.52	3396830.00	1056042.32	8927663.18
2710	Дизелийн түлш	кг	72604721	613.9	44568.65	64732269.61	2594154.51	5117011.87	5910794.22	153635.67	13775596.26
Нийт бензин дизель		кг	139840418		76602.98	111627728.66	4932789.58	9582458.20	11425154.85	1735067.61	27675470.25

УИХ-ын ТГ-ын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв

Газрын тосны бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаа /2008-05-01-ээс 2009 оны 05 сарын 04 хүртэл/

Огноо	А-80		Үнийн өөрчлөлт		Аи-92		Үнийн өөрчлөлт		Дизель түлш		Үнийн өөрчлөлт	
	Үнэ	Үнийн зөрүү	Өөрчлөлт %	Үнэ	Үнэ	Үнийн зөрүү	Өөрчлөлт %	Үнэ	Үнэ	Үнийн зөрүү	Өөрчлөлт %	
2008-05-01	1100	0	0	1225	0	0	0	1315	0	0	0	
2008-06-01	1100	0	0	1225	0	0	0	1315	0	0	0	
2008-07-01	1100	0	0	1230	5	0.4	0.4	1340	5	1.9	1.9	
2008-08-01	1260	160	14.5	1405	175	14.2	14.2	1630	290	21.6	21.6	
2008-09-01	1510	250	19.8	1685	280	19.9	19.9	1920	290	17.8	17.8	
2008-10-01	1400	-110	-7.3	1500	-185	-11.0	-11.0	1800	-120	-6.2	-6.2	
2008-11-01	1300	-100	-7.1	1400	-100	-6.7	-6.7	1600	-200	-11.1	-11.1	
2008-12-01	1050	-250	-19.2	1140	-260	-18.6	-18.6	1400	-200	-12.5	-12.5	
2009-01-01	1050	0	0	1140	0	0	0	1400	0	0	0	
2009-02-21	890	-160	-15.2	990	-150	-13.1	-13.1	1190	-210	-15.0	-15.0	
2009-03-01	890	0	0	990	0	0	0	1190	-210	0	0	
2009-04-01	1050	160	18.0	1150	160	16.2	16.2	1350	160	13.4	13.4	
2009-05-04	900	-150	-14.3	1000	-150	-13.0	-13.0	1100	-250	-18.5	-18.5	
Нийт өөрчлөлт	1123.1	-200	-10.8	1236.9	-225	-11.7	-11.7	1426.9	-445	-8.6	-8.6	

УИХ-ын ТГ-ын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв

Огноо	2008 он										2009 он				
	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар		
Барааны нэр															
Дэлхийн зах зээлийн үнэ	үнэ														
	өөрчлөлт														
Гаалийн үнэ	үнэ														
	өөрчлөлт														
Монголын зах зээлийн үнэ	үнэ	1100	1100	1100	1260	1510	1400	1300	1050	890	890	1050	810		
	өөрчлөлт	0	0	0	160	250	-110	-100	-250	-160	0	160	-240		
Дэлхийн зах зээлийн үнэ	үнэ														
	өөрчлөлт														
Гаалийн үнэ	үнэ														
	өөрчлөлт														
Монголын зах зээлийн үнэ	үнэ	1225	1225	1230	1405	1685	1500	1400	1140	990	990	1150	910		
	өөрчлөлт	0	0	5	175	280	-185	-100	-260	0	0	160	-240		
Дэлхийн зах зээлийн үнэ	үнэ														
	өөрчлөлт														
Гаалийн үнэ	үнэ														
	өөрчлөлт														
Монголын зах зээлийн үнэ	үнэ	1315	1315	1340	1630	1920	1800	1600	1400	1190	1190	1350	1010		
	өөрчлөлт	0	0	25	290	290	-120	-200	-200	-210	0	160	-340		

2008 онд нефтийн бүтээгдэхүүний импортын биет хэмжээ 52,1 мянган тонноор өсч, 1 тонны импортын хилийн дундаж үнэ 705.0 ам доллараас 1053.0 ам доллар хүртэл өсч импортын үнийн нийт дүн 331.0 сая ам доллараар өсчээ. Мөн 90-ээс доош октантай автобензины импортын дундаж үнэ 669.7 ам доллараас 963.3 ам доллар, 90-ээс дээш октантай авто бензиний хилийн дундаж үнэ 719.8 ам доллараас 1015.4 ам доллар хүртэл өсч дизель түлшний нийт импортын хэмжээ 197.3 сая доллараар нэмэгдэж импортын дундаж үнэ 394.3 ам доллараар өссөн байна. 2009 оны 01.01-ээс 04.28 хүртэл импортоор орж ирсэн нефтийн бүтээгдэхүүний хэмжээ дэрх байдалтай байгаа бөгөөд татваруудыг оруулан тооцож нийт дүнгээр нь хүснэгтлэн орууллаа.

Зах зээлд шатахууны жижиглэнгийн үнэ буюу зах зээлийн үнэ, үнийн өөрчлөлтийг 2008 оны 5 сараас 2009 оны 5 сар хүүнгэтээр харууллаа. Хүснэгтээс харахад шатахууны жилийн дундаж үнэ А-80 бензин 1123,1 төгрөг, Аи-92 бензин 1236,9 төгрөг, Дизель түлш 1426.9 төгрөг байна.



**“БИЧИЛ УУРХАЙ БОЛОН ГАР АРГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ АСУУДЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА (Харьцуулсан судалгаа)**

*Д. Мягмарцэрэн, Ч. Базар (Ph.D), Г. Чулуун,
О. Дорждагва, Ц. Болормаа*

Сэдвийн агуулга

- Удиртгал
- Дүгнэлт
- Санал зөвлөмж
- Тайлангийн дэлгэрэнгүй:
 1. Бичил уурхайгаас ашигт малтмал олборлох харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин /харьцуулсан судалгаа /
 2. Бусад орны эрх зүйн зохицуулалт, туршлага, хандлага /харьцуулсан судалгаа/
 3. Монгол улс дахь бичил уурхайн үйл ажиллагааны талаархи баримт, мэдээлэл (Хэвлэлийн контент анализ)

* * *

УДИРТГАЛ

“Бичил уурхайгаас ашигт малтмал олборлохтой холбоотой асуудлыг зохистойгоор шийдвэрлэх арга зам” судалгааг УИХ-ын ээлжит чуулганаар “Бичил уурхайн тухай” хуулийн төслийг хэлэлцэхтэй холбогдуулан СШОНХТөвийн санаачлагаар хийж гүйцэтгэв.

Монгол улсад уул уурхайн салбарын харилцааг зохицуулах зорилгоор 1997оноос “Ашигт малтмалын тухай” хууль болон түүнтэй холбоотой бусад тогтоол, дүрэм, журмуудыг батлан гаргасан. Гэвч иргэдийн гар аргаар ашигт малтмал олборлохтой холбогдсон аливаа харилцаа дээрх хууль болон дүрэм журмуудын зохицуулалтын гадна үлдсэн нь байгаль орчин болон нийгмийн харилцаанд олон сөрөг үр дагавар бий болгож байна. Иймээс энэхүү харилцааг зохицуулахын тулд бие даасан хууль батлан гаргах нь зайлшгүй шаардлагатай гэдэг нь харагдаж байгаа ба дэлхийн бусад улс орнууд ч ийнхүү тусгайлсан хууль батлан гаргах замаар уг харилцааг зохицуулдаг байна. Тухайлбал, 2002 онд Үйлдвэр худалдааны яамнаас гаргасан

“Үйлдвэрлэлийн бус аргаар ашигт малтмал олборлох түр журам”-аар албан бусаар алт олборлогчдыг бүртгэлжүүлэх, зохион байгуулалтанд оруулах, байгаль орчин, татвар, олборлосон ашигт малтмалын борлуулалт, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны асуудлуудыг зохицуулах оролдлого хийсэн боловч өнөөг хүртэл эдгээр асуудал нь шийдвэрлэгдээгүй тулгамдсан асуудал хэвээр байна. Иймээс энэхүү судалгаанд дээрх тулгамдсан асуудлуудыг зохистойгоор шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг хичээсэн болно.

Судалгаанд 2005 оноос эхлэн гаргаж байсан холбогдох хуулийн төслүүд, гадаадын зарим орны туршлага, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй бодлогын баримт бичиг, энэ асуудлаархи ТББ-ын судалгаа, мэдээлэл, 2001 оноос хойшхи хэвлэлүүдээр цацагдсан мэдээ баримт зэргийг харьцуулан судалсан болно.

* * *

ДУГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд гар аргаар ашигт малтмал олборлогчдын тоо эрчимтэй нэмэгдэж баталгаатай бус тоогоор 130 гаруй мянгад хүрсэн байна. Энэ тоо улирлын чанартай буурах үе байдаг ч хичнээн буурсан ч байгаль орчин болон хүний амь нас, эрүүл мэндэд үзүүлэх хор хохирол, гэмт хэрэг, хүүхдийн хөдөлмөр зэрэг нийгмийн шинжтэй сөрөг нөлөө нь тэр бүр багасдаггүй байна. Учир нь, нийгэмд ажилгүйдэл, ядуурал газар авсанаас үүдэн иргэд гар аргаар ашигт малтмал олборлох үйл явцад ихээр татагдан орж байгаа бөгөөд энэ тоо жил ирэх бүр нэмэгдэх хандлагатай байгаа нь **“Тогтвортой бичил уурхай”** төслийн хүрээнд хийгдсэн судалгаануудаас харагдаж байна.

Иймээс нийгмийн шинжтэй үндсэн эх сурвалжыг нь арилгалгүйгээр цаашид өсөн нэмэгдэж байгаа энэ үйл явцыг хуулиар нэг мөр хориглох боломжгүй учраас тодорхой зохион байгуулалтад оруулан хуулийн дагуу нарийвчлан зохицуулах нь зүйтэй юм. Учир нь, Гар аргаар ашигт малтмал олборлох харилцааг зохицуулж буй одоогийн дүрэм журмууд нь дараахь асуудлуудыг зохистойгоор нарийвчлан зохицуулж чадахгүй байна.

Үүнд:

- **Ашигт малтмал олборлосноос улсын төсөвт орох орлого хаагдсан.** Өөрөөр хэлбэл, Гар аргаар ашигт малтмал олборлогчид нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур амьдралтай иргэд байдгаас олборлосон ашигт малтмалаа хуулийн дагуу борлуулахад татвар болон тээврийн зардалтай холбоотой хүндрэл учирдагаас хууль бус аргаар хямд үнээр ченжүүдэд зарж борлуулдаг байна. Иймээс жилд хэдий хэмжээний ашигт малтмал олборлож байгаа талаарх нэгдсэн бүртгэл мэдээлэл хийх боломжийг хаадаг, нөгөө талаас ашигт малтмалаас олох татварын орлого төдий хэмжээгээр буурч байна.
- **Байгаль орчинд хортой химийн бодисийн хэрэглээг хянах боломжгүй байна.** Бүртгэл хяналтгүйгээр иргэд дур мэдэн химийн хорт бодис хэрэглэснээр хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд их хэмжээний хохирол учирч байгаа боловч хохиролын хэмжээг нарийн тооцож, дараагийн арга хэмжээг авах боломжийг бүрэн хааж байна. Гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 2009 оны байдлаар 1000 гаруй га газар өртөөд байгаа талаархи тойм судалгааг Байгаль орчин аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн газраас гаргасан байна.
- **Нөхөн сэргээлтийн ажил хийх боломж байхгүй.** Гар аргаар ашигт малтмал олборлогчид нүүдлийн шинж чанартай /тодорхой газар нутаг дээр хэсэг хугацаанд ажилласныхаа дараа олж буй ашиг нь муудаж эхэлбэл шинэ газар луу нүүдэг/, нөхөн сэргээлт хийх эдийн засгийн боломжгүйгээс өөрөөсөө мөнгө гаргаж нөхөн сэргээлт хийхийг хүсдэггүй. Үүний дараа тухайн талбай химийн хорт бодисоор хордогдсон, эвдэрсэн газар болж үлддэг.
- **Нийгмийн шинжтэй сөрөг хүчин зүйлүүд байсаар байна.** Гар аргаар ашигт малтмал олборлож буй газруудад нийгмийн аливаа төрлийн үйлчилгээ /эрүүл мэнд, даатгал, боловсрол, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа гэх мэт/, хууль сахиулах байгууллагын хяналт, үйлчилгээ тэр бүр хүрэх боломжгүйгээс гэмт хэрэг, хүний эрхтэй холбоотой зөрчлүүд их хэмжээгээр гардаг. Тухайлбал, насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр, сургууль завсардалт, архидан согтуурал, биеэ үнэлэлт, хулгай дээрэм, зарим тохиолдолд хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн хэвээр байна.

Үүнээс гадна дэлхийн бусад улс орнууд гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хуульчлан зохицуулдаг бөгөөд ингэхдээ энэ үйл ажиллагааг хамт олны бүлэг болгон бичил уурхайн хэлбэрээр ажиллуулах, цаашдаа хөгжиж компанийн хэмжээнд хүргэх бодлого баримтладаг байна. Манай улсын хувьд мөн адил гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хэн дуртай нь хаа дуртай газраа ухах хэлбэрээр

биш, хамт олны бүлэг болж хариуцлагатай бичил уурхайн хэлбэрээр ашиглан хөгжихийг дэмжих, энэ шаардлагад нийцээгүй ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хууль бусад тооцон таслан зогсоох бодлого баримтлах нь зүйтэй юм. Учир нь, нэгэнт байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа тохиолдолд үүнийг амьжиргааны эх үүсвэр, амьдрах арга хэмээн зөвтгөж болохгүй юм. Ингэх тохиолдолд энэ нь хулгай хийх гэх мэт бусад эрүүгийн гэмт хэргийг амьдрах арга хэмээн хүлээн зөвшөөрч байгаагаас ялгаагүй юм. Иймээс судалгааны баг дараах санал зөвлөмжийг боловсруулж байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Санал зөвлөмжийг боловсруулахдаа бичил уурхайг хөгжүүлэн нийгмийн хариуцлага хүлээх чадвар бүхий томоохон компаниуд болгон өргөжүүлэх чиглэл баримтласан тул хуулинд оруулж болох шалгуур бий болгоход голлон анхаарсан.

- **Газар олголт** – газар олгохдоо тухайн хамт олны бүлэгт (нөхөрлөл гэх мэт) Ашигт малтмалын тухай хуульд заасан журмын дагуу газар олгох. Хуучин журмаар (Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам, ЗГ-2008-72) нөхөрлөлд олгох газар нь ихэвчлэн эдийн засгийн үр ашиг багатай газруудыг олгохоор заасан байсан нь иргэдийг энэ журмыг дагаж мөрдөхгүй байх үндсийг бүрдүүлж байсан. Иймээс тухайн нөхөрлөлөөс зөвхөн нөхөн сэргээлтээ хийж чадах эсэхийг нь гол шалгуур болгох ба хэрэв хангалттай хэмжээний санхүүгийн чадавхитай нь нотлогдох тохиолдолд зохих хэмжээний газрыг олгох нь уг нөхөрлөлийг санхүүгийн хувьд цаашид өсөн дэвжих боломжийг бүрдүүлэх юм.
- **Нөхөн сэргээлт** – нөхөн сэргээлтэнд зарцуулагдах хөрөнгийн хуримтлалын санг бүрдүүлэх аргачлалыг өөрчлөх. Учир нь, одоогийн хэрэглэж буй аргачлалаар бол хайгуул болон олборлолтын үйл ажиллагаанд зарцуулагдсан хөрөнгийн 50%-тай тэнцэх хөрөнгийг хуримтлалын санд байршуулдаг. Энэ журам өнөөгийн амьдралд нийцдэггүйг нь нөхөн сэргээлт хийдэггүй компаниудын талаарх мэдээллээс харж болно. Иймээс уг аргачлалыг өөрчлөн 1мкв талбайд нөхөн сэргээлт хийхэд зарцуулагдах хөрөнгийн стандарт хэмжээг тооцон гаргаад энэ хэмжээг тодорхой хугацааны дараа инфляци зэрэг эдийн засгийн үзүүлэлтүүдийг харгалзан нэмэгдүүлж хуримтлалын сандаа оруулж байх журам гаргах. Хэрэв энэ хэмжээнд хуримтлалын сангаа бүрдүүлж чадахгүй тохиолдолд тухайн нөхөрлөлд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлан уг талбайд хүсэлт гаргасан өөр нөхөрлөлд шилжүүлэх зарчим баримтлах нь зүйтэй.
- **Техник технологи** – байгаль орчин болон хүний эрүүл мэндэд хортой техник технологи хэрэглэхийг эрс хориглох ба үүнээс бусад техник технологийн хувьд санхүүгийн боломж, чадавхи нь хангалттай тохиолдолд ямар нэгэн хязгаарлалт тавихгүй байх. Хэрэв санхүүгийн чадавхи хангалтгүйгээс буюу бусад нөхцөл шалтгааны улмаас өөрсдийн боломжид таарсан техник технологи хэрэглэж чадахгүй байгаа тохиолдолд тэднийг дэмжих хөрөнгө санхүүгийн болон сургалтын төсөл хөтөлбөрүүдэд хамруулахад төрөөс дэмжлэг үзүүлэх чиглэл баримтлах.
- **Хүний нөөц** – иргэдийг нөхөрлөлийн зохион байгуулалтад ороход саад болж буй хамгийн гол хүчин зүйл бол тэднийг хүн нэг бүрээр нь бүртгэх, тухайн орон нутагт бүртгэлтэй байхыг шаардаж байгаа явдал юм. Иймээс нөхөрлөлийн гишүүдийг төлөөлж чадах удирдлагад нь бүх хариуцлагыг үүрүүлэх байдлаар зохицуулах. Энэ удирдлага нь хэдэн ч хүн, дотроосоо сонгогдсон буюу нөхөрлөлийг үүсгэн байгуулсан зэрэг ямарч байдлаар байх боломжтой. Мөн энэ нь нөхөрлөлд гишүүн элсүүлэх, тэднийг бүртгэх зэрэг үүргүүдийг хүлээлгэсэн байх тохиолдолд нутгийн захиргааны зэрэг төрийн бусад байгууллагуудаас хүн нэг бүрчлэн бүртгэх зэрэг иргэдэд үүсдэг бэрхшээлийг арилгаж иргэдийг нөхөрлөлийн зохион байгуулалтад орох үйл ажиллагааг хялбарчлах болно. Ингэснээр төрийн байгууллагуудад ирэх ачаалал ч бас багасч, зөвхөн хүний эрх болон байгаль орчинтой холбоотой зөрчлийг хянах, шийдвэрлэх үүрэг л үлдэнэ.

- **Татвар** – нөхөрлөлд татвар тооцоходоо илт хөнгөлсөн татвар тогтоох нь зохимжгүй юм. Ингэснээр компаниуд нөхөрлөлийн хэлбэрт орж татвараас зугтаах оролдлого бий болгох талтай. Иймээс нөхөрлөлд ноогдох татварын хэмжээг компаниудаас илт багаар тогтоохгүй байх ба нөхөрлөлийн цаашдын хөгжлийг дэмжих зорилгоор харьцангуй бага хэмжээтэй байхаар тогтоох нь зүйтэй юм. Энэхүү дундаж зохист хэмжээгээр тогтоосон татварыг нөхөрлөл бүрд шууд ноогдуулалгүйгээр тухайн нөхөрлөлийн нэг хүнд оногдох хөдөлмөрийн бүтээмж, ордын нийт нөөц ба олж болох ашиг зэргийг нарийвчлан тооцож тусгай зөвшөөрөл эзэмшүүлэх гэрээ хийхдээ нөхөрлөлийн болон компанийн гэсэн татвараас сонгон тооцохоор зохицуулах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, энэ нь олон хүн ажилладаг, ордын нөөц бага, нэг хүнд оногдох ашиг харьцангуй бага нөхөрлөлд бага хэмжээний татвар ноогдох бол цөөн хүнтэй, нөөц ихтэй талбай бүхий харьцангуй их хэмжээний ашиг олох боломжтой нөхөрлөл өндөр татвар төлөх юм.

1. БИЧИЛ УУРХАЙГААС АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БҮЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ичил уурхайгаас ашигт малтмал олборлох харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин

Хувиараа ашигт малтмал олборлох буюу бичил уурхайгаас ашигт малтмал олборлох тухай асуудал 2001 оноос эхлэн яригдаж байгаа боловч төрийн бодлого болон батлагдсан хугацаа 2008 оноос эхэлдэг байна.

Үндсэн баримт бичиг:

- Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам, ЗГ-2008-72
- Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр, ЗГ-2008-71
- Мөнгөн усыг ашигт малтмалын олборлолт, боловсруулалтад ашиглахыг хориглох тухай, БОЯ-2008-135
- Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай, ЗГ-2008-28
- Налайхын нүүрсийг хувиараа ашиглаж байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай, ЗГ-2008-89

Өөрөөр хэлбэл, бичил уурхайгаас ашигт малтмал олборлохтой холбогдсон аливаа харилцааг зохицуулах бие даасан хууль байхгүйгээс энэхүү харилцааг 2008 оноос эхлэн Засгийн газрын **Бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм, заавар батлах тухай** 72 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан **“Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”** –аар голлон зохицуулж байна. Түр журам хэрэгжиж эхэлснээр гар аргаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн гол баримт бичигтэй болсон бөгөөд албан ёсны бүртгэлгүй байсан гар аргаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад орох үндсийг нь тавьж өгсөн. Гэвч, хүчин төгөлдөр үйлчилж буй түр журмын зохицуулалтад дараахь дутагдалтай зохицуулалтууд ажиглагдаж байгааг цаашид бие даасан хууль батлан гаргахад анхаарууштай гэж үзэж байна. Үүнд:

- **Нөхөрлөлийн гишүүдэд тооны дээд хязгаар тавьсан. /Түр журмын 14-р зүйл/** Энэ нь иргэд нэгдэж нөхөрлөлийн зохион байгуулалтад орох боломжийг хязгаарлаж байна. Учир нь ашигт малтмал олборлож болох тухайн талбайг нэг нөхөрлөлд эзэмшүүлэхээр заасан байдаг. Иймээс нөхөрлөлийн гишүүний тоо гүйцсэн тохиолдолд үлдсэн иргэд хууль бусаар ашигт малтмал олборлогч болох нөхцөлийг бүрдүүлдэг байна.
- **Тайлбайн ашиглах хугацааг хатуу заасан /Түр журмын 18-р зүйл/** Талбайн ашиглалтын хугацааг нэг жилээр заасан нь тогтвортой бичил уурхай хөгжих, түүний



дагаж иргэдийн тогтвортой суурьшил бий болгох боломжгүй заалт юм. Түр журамд хэдийгээр гэрээг сунгаж болох тухай заасан ч төвөг чирэгдэлгүй байх үүднээс бусад улсын жишгийг харгалзан 3-5 жилийн хугацаатай байх нь зүйтэй.

- **Гэрээ байгуулах үе шат хэтэрхий олон шат дамжлагатай. /Түр журмын 19, 20, 21, 28-р зүйл/** Түр журмын 21-р зүйлд заасны дагуу нөхөрлөлийн гишүүдээс чухал шаардлагагүй олон тооны бичиг баримт шаарддаг нь иргэд нөхөрлөл байгуулж зохион байгуулалтад орж ажиллахад нилээд хүндрэл, бэрхшээл тулгардаг байна⁶.
- **Нөхөн сэргээлт хийх стандарт тодорхойгүй. /Түр журмын 6.9-р зүйл/** Энэхүү журмын зохицуулалтаар ашигт малтмал олборлосны дараа нөхөн сэргээлтийг хэн хэрхэн яаж гүйцэтгэх нь тодорхойгүй байна. Урьд ашиглаад нөхөн сэргээлт хийгээгүй орхисон уурхайгаас гар аргаар ашигт малтмал олборлосон иргэд олборлолтын дараа нөхөн сэргээлт хийнэ гэдэг нь боломжгүй зүйл. Мөн дүрмийн 4.1.1, 4.1.2, 4.3-т заасан хүчин чадалтайгаар нөхөн сэргээлтийн ажлыг хийх боломжгүй нь “Тогтвортой бичил уурхай” төслийн 2008 онд гүйцэтгэсэн судалгаанаас харагдсан байна.
- **Ашигт малтмал гар аргаар олборлогчид ямар төрлийн татварыг хэрхэн яаж төлөх нь тодорхойгүй.** Түр журам гар аргаар ашигт малтмал олборлогчид орон нутгийн төсөвт татвар төлөх эсэх, татвараас чөлөөлөгдөх эсэх /татварын хөнгөлөлт эдлэх эсэх/, төлбөл ямар төрлийн татварыг ямар хэмжээгээр төлөх зэрэг болон талбай ашигласны төлбөр нь тодорхойгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ журмаар татварын асуудлыг зохицуулаагүй.

Түр журам гарсантай холбогдуулан 2008 онд Засгийн газар бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх үндэсний дэд хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 3 тэргүүн зорилготойгоор хэрэгжүүлэхээр баталсан байна. Одоогоор хөтөлбөрийн тайлант хугацаа болоогүй учраас хөтөлбөрийн талаар дүгнэх нь эрт юм. Хөтөлбөрийн тэргүүн зорилгуудын хүрээнд хийгдэх үйл ажиллагаа нь одоо тулгамдаж буй асуудлыг бүрэн хамарсан гэж үзэж байна.

2. БУСАД ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА, ХАНДЛАГА

Нэг. Өнөөгийн байдал, хандлага

Гар аргаар ашигт малтмал олборлох нь олон орны Засгийн газар, донор байгууллагуудын хоорондын / хоёр болон олон талт/ хэлэлцэх хамтын ажиллагааны асуудал болж байна. Дэлхийн олон улсад гар аргаар болон бичил хэлбэрээр ашигт малтмал олборлох үйл ажиллагаа тасралтгүй явагдаж энэхүү үйл ажиллагаанд оролцогсдын тоо их хэмжээний үйлдвэрлэлийн олборлолт явуулж байгаа уул уурхайд ажиллагсдын тооноос багагүй байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) болон MMSD /Mining, Minerals and Sustainable Development project буюу “Уул уурхай, эрдэс баялгийн тогтвортой хөгжил” төсөл”-ээс сүүлийн үед хийсэн судалгаагаар дэлхийн хэмжээнд 13 сая хүн жижиг хэмжээний ашигт малтмал олборлолтонд оролцож байгаа бөгөөд үүний ихэнх нь хөгжиж байгаа улсуудад хамрагдаж байна. Энэ салбарт ажиллагсдын ихэнх хувийг харамсалтай нь эмэгтэйчүүд, хүүхдүүд эзэлж байна.

Сүүлийн 10 жилд олон улсын Донор байгууллагууд гар аргаар ашигт малтмал олборлох, бичил уурхай болон ядуурлын хоорондын нягт холбоог хүлээн зөвшөөрөөд байна. Гол бодлого нь ядуурлыг бууруулах замаар хөдөөгийн хөгжилд нэмэр болох, энэ салбарын бизнесийн таатай орчин бүрдүүлэх, тогтвортой байдал хангах, энэ салбараас олох Засгийн газрын орлогын хэмжээг тогтмол байлгахад чиглэгдэж байгаа юм.

⁶ Тогтвортой бичил уурхай төсөл, Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”, түүний хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээ. УБ., 2008 он

Зарим орон уул уурхайн хуулиндаа гар аргаар ашигт малтмал олборлох болон бичил уурхайн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөөгүй байдаг ч энэ чиглэлийн хөтөлбөрүүдтэй байдаг.

Энэ чиглэлийн эрх зүйн зохицуулалттай орнуудад тухайлбал Бразилийн “Гаримпо” буюу “Гаримпоген”-ий хуулинд дараах шалгууруудыг гол болгодог байна.

- Бүтээгдхүүний хэмжээ
- Үр ашигтай нэгж дэх хүний тоо
- Ашиглаж буй хөрөнгийн хэмжээ
- Хөдөлмөрийн бүтээмж
- Олборлолтын хэмжээ
- Нөөцийн хэмжээ
- Борлуулалтын хэмжээ
- Үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа
- Үйлдвэрлэлийн найдвартай ажиллагаа
- Олборлолтын мөчлөгийн/улирлын хугацаа

Шалгуур тус бүр тухайн улс орон, уурхайн төрөл, олборлож байгаа эрдэс баялаг, улс төрийн нөхцөл байдал болон тухайн орны уурхайчдын тоо зэргээс хамааран өөрийн давуу болон сул талуудтай байна. Ихэнхдээ гар арга болон бичил уурхайн үйл ажиллагааг тодорхойлох оролдлого хийж байгаа боловч түүнд тохирох нийтлэг тодорхойлолтыг одоо болтол олоогүй байна. Орон орны нутгийн тодорхойлолт нь тухайн орны макро эдийн засгийн нөхцөл, геологийн ажлын хүрээ, уул уурхайн түүх болон хууль зүйн тогтолцооноос болж улс бүрт өөр байдаг. Хэдий тийм ч энэхүү асуудал нь хэд хэдэн ижил нөхцлөөр тодорхойлогдож байдаг.

Гар аргаар болон бичил уурхайн ашигт малтмал олборлолтын нийтлэг асуудлууд:

1. Геологи:

- Боломжийн хүдрийн биет байхгүй
- Хүдрийн биетийн тухай мэдээлэл хангалтгүй

2. Хууль:

- Хөрөнгө оруулалтын уур амьсгал таатай биш
- Нийгмийн хамгаалал байхгүй
- Гар арга болон бичил уурхай нь хууль бус
- Улс төр болон эрх зүйн тогтвортой бус байдал
- Ашигт малтмалын олборлолтыг хуульчлахад бэрхшээлтэй
- Албаны баримт бичиг хоорондоо зөрчилтэй

3. Зах зээл:

- Зөвхөн түншлэгчийн тусламжаар зах зээлд гардаг
- Зах зээлийн бэрхшээлүүд
- Зах зээлийн зохицуулалт

4. Техник, технологи:

- Хүний эрчимтэй хөдөлмөр шаардсан
- Үнэ цэнэ болон болон цаг их зарцуулдаг технологи ашигладаг



- Бодит зах зээлийн хариуцлага тооцох явдал хангалтгүй

5. Хүний нөөц:

- Мэдлэг боловсролгүй ажиллах хүчин
- Бичгээр хийсэн гэрээ байхгүй
- Нийгмээс хамааралтай
- Өв соёлыг ойлгодоггүй

6. Уул уурхайн талаарх нийгмийн хандлага

- Амь зуулгын эдийн засаг хангалтгүй
- Мэдлэг дутмаг
- Хонжвортой тоглоомчны сэтгэл зүйтэй
- Гадаадын зөвлөхүүдэд оролцох боломж хязгаарлагдмал

7. Хөрөнгө, санхүү:

- Техник эдийн засгийн үнэлгээг хямд
- Эдийн засгийн үр ашиггүй хөрөнгө оруулалт
- Бэлтгэхэд бэрхшээлтэй бүртгэл хөтлөлт болон зардлын тооцоо
- Хөрөнгө хангалтгүй
- Татварын болон ашигт малтмалын нөөц боломж ашигласны төлбөрийн дарамт
- Гадаад валютад оролцох хязгаарлагдмал
- Хөрөнгө оруулах ба шударгаар хөрөнгө авахад оролцох боломж хязгаарлагдмал

8. Байгууллага/бүтэц:

- Шүхэр байгууллага байхгүй
- Засгийн газраас үзүүлж байгаа үйлчилгээ байхгүй
- Улирлын чанартай ажил эрхэлдэг
- Уурхайнуудын тархай байрлалаас болж бэрхшээлтэй зохицуулалт, хамтын ажиллагаа

Ихэнх оронд гар арга болон бичил уурхай нь албан бус салбарт хамаарагддаг. Гэсэн хэдий ч ашиглалт, олборлолт явуулж байгаа хүмүүс хууль эрх зүйн шаардлагыг дагаж мөрдөх ёстой байдаг.

- Ашиглалтын эрхтэй /концесс, өргөдөл болон бусад/ эсвэл ашиглалтын талбайн эзэнтэй хийсэн хүчин төгөлдөр гэрээтэй байх
- Байгаль орчны хууль тогтоомжийг дагаж мөрдөх
- Байгаль орчны үйл ажиллагааны лицензтэй байх
- Аж ахуйн нэгжийг уул уурхайн зохих албаны байгууллагад бүртгүүлсэн байх ба эсвэл бусад мөнгө санхүүгийнэрх мэдэлтэй байх
- Татваруудыг төлсөн байх
- Үндэсний нийгмийн халамжийн тогтолцоонд ажиллагсад хамрагдах
- Бүтээгдхүүнийг хуулийн дагуу экспортлох /экспортын лиценз буюу татвар/

Яг үүний эсрэгээр гар арга болон бичил уурхай албан бус хэвээр үлддэгийн гол шалтгаан нь хууль эрх зүйн шаардлагуудын талаар мэдлэггүй, орон нутгийн соёл,

уламжлалын байдал, ЗГ-аас албан ёсоор ажиллуулах сонирхол бага, татварын дарамт их, ашигт малтмал олборлох эрхийн бичиг авах боломж хязгаарлагдмал, албан ёсны үйл ажиллагаа явуулахад хүнд суртал бүхий журамтай, шийтгэл хязгаарлагдмал ба үүн дээр хээл хахуулиас болж хууль завхруулах нь нилээд нийтлэг байдаг. Гэвч улс орны Засгийн газрууд энэ салбар ядуурлыг бууруулах, үндэсний орлогыг бий болгох чухал эх үүсвэр гэдгийг хүлээн зөвшөөрч, таатай орчин бий болгохыг чармайж байна. (Хавсралтаас үзнэ үү)

Хоёр. Түүхэн үечлэл, орчин цаг

1960 – 1970 оны үе.

Буурай хөгжилтэй гэж байсан улс орнууд улс төрийн эрхээ шаардаж байсан үед буюу 1962 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 18-р чуулганы 1802 тоот тогтоолоор улс орнуудын өөрийн байгалийн баялагийг байнга бүрэн эзэмших эрхийн зарчмыг тунхагласан байна. Энэхүү баримт бичиг нь колони орнууд өөрсдийн байгалийн баялагаа олборлон, улмаар эдийн засгаа хөгжүүлэх нэг арга хэрэгсэл болгон үйлдвэржсэн орнуудтай түншлэн шударга ашиг олох, эрх дархтай болоход ихээхэн түлхэц өгсөн юм. Байгалийн баялагийг олборлох нь хөгжлийн санхүүгийн чухал эх үүсвэр гэсэн үзэл хандлага давамгайлж байсан тэр үед гар арга болон бичил уурхай нь тун өчүүхэн хувийг эзэлж байжээ. Чухамдаа улсын үйлдвэрийг хөгжүүлэх, харин хувийн үйлдвэрийг хязгаарлах бодлого энэ үед хүчтэй байсан гэж хэлж болно.

1980-аад оны үе.

Төрд төвлөрсөн чиглэлтэй бодлогоос ухарч эхэлжээ. Түүхий эдийн уналт нь өндөр хүүтэй хослон уул уурхайн салбарт бууралт авчирчээ. Нэг ёсондоо шинэ бодлогоор уул уурхайг хөгжүүлэх шаардлага тулгарсан бөгөөд уул уурхайг зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татан оролцуулахад чиглэсэн эрх зүйн шинэ тогтолцооны үе эхэлжээ. Хэдий саад бэрхшээл байсан ч уян хатан чанараараа илүү давуутай жижиг уурхайнууд үүд хаалгаа нээж, түүний бүтээмжийг өсгөх зорилгоор Латин Америк, Өмнөд Африкт Германы GTZ, Шведийн SGAB, Их Британийн BGS, Францын BRGM зэрэг олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөө хэрэгжүүлжээ.

Энэ үед алт үнэ тэнгэрт хадаж байсан бөгөөд алтны тодорхой тооны уурхайнууд бий болж улмаар гар аргаар алт олборлогчид эрх бүхий том уурхайн газарт хууль бусаар алт олборлох, эсвэл эсрэгээр нь гар аргаар олборлогчдын талбайгаас уурхайнууд газрын зөвшөөрөл авах гэсэн оролдлого хийсэн нь зөрчилдөөнийг бий болгосон байна. 1980-аад оны сүүлээр улс орнууд уул уурхайн менежментийг сайжруулах зорилгоор хуулиндаа өөрчлөлт хийж, Латин Америкт Бразил, Африкийн Гана, Ази Номхон далайн бүсийн Филиппин улс бусдад сайн жишиг болжээ.

1980 - 2000 оны үе.

Интеграцлалын үе гэж нэрлэдэг бөгөөд хөгжиж буй орнуудад хөрөнгө оруулах сонирхол ихээхэн нэмэгджээ. Гэвч гар арга болон бичил уурхайн салбар дахь төрийн бодлого хөшүүн хэвээр байв. Харин энэ салбарын хурдац өндөр байсан учраас хуульчлах нь зайлшгүй шаардлагатай гэсэн хандлага ихээхэн батжиж байв. 2000 оноос олон нийтийн хэлэлцүүлэгт тогтвортой хөгжлийн гурван баганыг ихээхэн ярилцах болсон бөгөөд үүний томъёолол нь байгаль орчиндоо ээлтэй, ядуурлыг бууруулахад чиглэсэн төрийн оновчтой бодлогод оршиж байна. Гар болон бичил уурхайн чадавхийг сайжруулах, нэмэгдүүлэх, засаглал, жөндөр, олон нийтийн оролцоонд тулгуурласан бүтцийг шинэ бодлого нь ядуурлыг бууруулах замаар тогтвортой хөгжилд хүргэх арга зам гэдгийг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрч эхэлжээ.



Гар арга болон бичил уурхайн хуулийн ерөнхий тодорхойлолт

Энэ салбарт яагаад хууль хэрэгтэй вэ? Ашигт малтмалын тухай ерөнхий хуулиар зохицуулж болохгүй юу? Дэлхийн олон орон, олон улсын байгууллагууд, донор орнууд энэ чиглэлд анхаарлаа хандуулж байна. Эцэст нь дараах шалтгаанаар, нэгдүгээрт, уул уурхайн уламжлалт хууль нв гар арга болон бичил уурхайн ашиг сонирхолд нийцдэггүй, хоёрдугаарт, хууль бий болгох, шинэчлэх нь энэ салбарыг албан ёсны болгох ач холбогдолтой хэмээн үзэж байна. Нааштай хандлага байгаа нь сүүлийн үеийн үйл явдал, ухаарал, сургамж, нэгдсэн ойлголтын ачаар олон орон энэ салбарыг албан ёсны болгоход анхаарч эхэлжээ.

Гурав. Бусад орны туршлага, сургамж:

Бүртгэх журам.

Хувиараа буюу ганцаараа ашигт малтмал олборлож байгаа хүмүүсийг нэг бүрчлэн бүртгэлтэй болгох гэж зарим улс орон хуулиндаа тусгасан байна. Бүртгэлийн журмыг маш энгийн зөвхөн /нэр, нас, иргэний үнэмлэхний дугаар/ хийхгүй бол хэрэгжих магадлал бага байдаг байна. Тухайлбал БНАСУ-ын 2002 оны уул уурхайн хуулиар гар аргаар олборлогчид бүгд бүртгэгдсэн байх жилийн хураамжаа төлсөн тохиолдолд үнэмлэх олгохоор зохицуулжээ. Гэвч 3 жилийн дараа цөөхөн хүн үнэмлэх авсан бөгөөд харин энэ салбарт хүмүүс мянга мянгаараа ажилласан хэвээр байжээ.

Хамтлаг, хамт олноороо ажиллах боломжийг бүрдүүлэх.

Олборлогчдыг нэг бүрчлэн бүртгэх нь тийм ч сайн арга биш бөгөөд харин тэднийг аажмаар бүртгэлжүүлэх механизмыг сонгох нь сайн хувилбар. Тухайн хүн бүрийн бүртгэлийн хялбар маягтаар түүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх, эсвэл албан бусаар захиргаанд төлөөлөх маягийн завсрын зжуучлах механизмыг хуульд тусгах аргыг улс орнууд чухалчилж байна. Нэг ёсондоо хувь хүнийг төлөөлөх арга замыг эхлээд олох бөгөөд дараа нь бүгдийг бүртгэх замаар албан ёсны болгож болох юм. Завсрын зуучлагч бүлэг нь хоршоо, бүлэг, хамтлаг, хот айл ямар ч хэлбэрээр байж болох юм.

Лицензжүүлэх.

Лицензийн тогтолцоонд шилжихдээ улс орнууд дараах зүйлд анхаардаг байна. Үүнд:

- Гар арга болон бичил уурхай оршин тогтнож буйг хүлээн зөвшөөрөх /тодорхойлолт/
- Гар арга болон бичил уурхайд хэн оролцож буйг хүлээн зөвшөөрөх /бүртгэх/
- Гар арга болон бичил уурхайн бүсийг тогтоон хүлээн зөвшөөрөх /эрхийн бичиг, талбай болон хүчинтэй байх хугацаа/
- Гар арга болон бичил уурхайн ажиллагааг хүлээн зөвшөөрөх/төлөвлөх, олборлох, боловсруулах болон бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа/
- Эрх олгох үүрэг хариуцлага зэрэг болно.

Жижиг уурхайн лицензээр хайгуул хийх, олборлох онцгой эрх олгодог улс орнууд байна. Бусдын туршлагаас харахад, хориглосон заалт оруулах нь дамлан худалдахаас мөн ажлаа эхлэхгүй удахаас сэргийлсэн арга хэмжээ болдог.

Тайлан тооцоо гаргахыг заавал шаардах, лиценз шилжүүлэхийг зөвшөөрөх нь ихэнх орны хуулинд байдаг. Мөн гүний хязгаарлалтыг тогтоож эрх олгосон Индонези, Гвиней, Этиофи, Филиппин зэрэг хэд хэдэн орон бий. Нилээн түгээмэл зохицуулалт бол бодист тогтоох хязгаарлалт хийх замаар олгодог лиценз юм. Энэ нь карьерийн нөөц болон барилгын материалын лицензээс тусад нь алт, алмаз, үнэт чулуу зэрэгт тус тусад нь олгодог лиценз юм.

Бүлэг хүмүүст зөвшөөрөл олгох тогтолцоо нь зөвшөөрлийн үйл ажиллагааг хялбарчилж, хяналтыг хөнгөвчилж, хүмүүсийг хоршоо болон бусад хэлбэрээр нэгтгэхэд тус дөхөмтэй. Үйл ажиллагаанд тавих хязгаарлалт буюу хайгуул хийх, уурхай байгуулах, олборлох, боловсруулах, эрдсийн түүхий эдийн маркетинг хийхтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг нэг лицензид хамааруулах аргыг ихэнх орнууд хэрэглэдэг.

Албан бус лицензээр зохицуулж буй орнууд ч байна. Үүнийг уул уурхайн холбогдох хуулинд заалт хэлбэрээр оруулдаг. Нутгийн уурхайчид, уугуул иргэд, газрын аль эзэнтэй нэг дор байхыг хувиарладаг харилцаа юм. Жишээ нь Папуа Шинэ Гвинейн 1992 оны хуульд “Хувь хүн өөрийн харьяалагдах газар дээр /олборлох лицензгүй бол түрээслэж буй газар орохгүй/ уурхайн /Аюулгүй ажиллагааны/ хуульд нийцүүлэн аюулгүй ажиллагааг ханган үйрмэг эрдэсийн механикжаагүй уурхай ажиллуулж болно” гэжээ. Венесуэльд мөн албан ёсны зөвшөөрөл авахгүйгээр үйрмэг эрдсийн олборлолт, гар аргаар алт угаахыг зөвшөөрдөг байна. Замби, Уганда, Филиппин зэрэг орнууд газрын эзэн, төрийн байгууллага өөрийн газар дээр эрдэс /ялангуяа барилгын материал/ олборлохыг хууль ёсны болгожээ.

Бусад буюу гэрээ, санхүүгийн түрээс гэх зэргээр энэ харилцааг бас зохицуулж болно. Төвлөрлийг сааруулах. Энэ нь зөвшөөрлийг олгох, хянах эрхийг үйл ажиллагаа явж буй газрын ойр орших байгууллагад олгох тухай ойлголт юм. Мадагаскар зэрэг орнуудад энэ арга үр дүнтэй хэрэгжсэн.

Бусдын үйл ажиллагаанаас сургамж авахад, хяналт тогтоох газар нь улс, орон нутгийн засаг захиргаа биш мэргэжлийн чиглэлийн төлөөлөгч ажиллуулсан тохиолдолд ашиг хонжоо харах, авилга авах эрсдэл бий болсныг анхаарууштай. Энэ чиглэлийн ТББ-ийг чадавхжуулах замаар хяналт тавьж бас болно.

Нутгийн иргэдийн эрх.

Энэ чиглэлийн сайн жишээнд Перуг дэлхийд дурьдаж байна. Перу нутгийн иргэдийн оролцоотойгоор дүрэм журмаа боловсруулжээ. Хууль хэрэгжүүлэх үйл явцад нутгийн иргэдийн оролцоо тун чухал гэдгийн сайн жишиг юм. Филиппины 1991 “Ардын жижиг уурхайн” хуульд “Амьжиргаа нь жижиг уурхайд төвлөрсөн нийгэм, эдийн засаг, соёлын уламжлалтай тодорхой хүмүүсийг уламжлалт жижиг хэмжээний уурхайчид гэнэ” гэж заажээ. Энэ заалт нь нэг дор суурин суудаг, амьжиргаа, цаашлаад хөгжил нь уул уурхайгаас хамааралтай хүмүүст ихээхэн тохирсон эрх зүйн орчин ажээ.

Байгалийн нөөц баялагийг ашиглах тухай ямар ч хуулийг нутгийн уугуул иргэдийн шууд болон төлөөллийн оролцоотойгоор боловсруулах нь үр дүнтэйг улс орнууд онцолж байна. Үүний зорилго нь уугуул иргэдийн нутагт уул уурхайн олборлолт болон ашиглалтыг хориглох бус, мөн уг хууль нь уул уурхайн олборлолт болон ашиглалт хийх зорилготойгоор газар нутгийг албадан хураах хязгааргүй эрхийг улсад олгохоос сэргийлэх ач холбогдолтой юм. Үүний сөрөг жишээгээр олон улс 2001 онд батлагдсан Колумбийн уул уурхайн хуулийг жишээлдэг. Уг хууль Үндсэн хуульд заасан уугуул иргэдийн хамгаалагдсан эрхийн эсрэг байжээ. Уг хуульд “хууль бус” гэдэг тодорхойлолтод уурхайн эрхийн бичиг байхгүй хүмүүсийг оруулах талаар заасан нь зөрчилдөөнд хүргэсэн байна. Уурхайн эрхийн бичиггүй жижиг хэмжээний олборлолт хийдэг уурхайчдын үйл ажиллагааг “хууль бус” гэж хуульчилснаараа ихээхэн зөрчлийг бий болгосон байна. Энэ хууль гарахаас өмнө олон мянгаараа гар аргаар олборлолт хийж байсан хүмүүс “хууль бус” гэсэн гэж гадуурхагддаггүй байжээ.

Дөрөв. Маркетинг:

Гэрчилгээжүүлэлтийн асуудал энд хамаарах бөгөөд гар аргаар болон бичил уурхайн олборлогчдын бүтээгдхүүнийг боловсруулалтын төвлөрсөн нэгжид худалдахыг дэмжвэл,



нэгдүгээрт, эрдэс бүтээгдхүүнийг гэрчилгээжүүлэх, хоёрдугаарт, худалдааны нуугдмал сүлжээг хянахад хялбар болно. Мөн байгаль орчинд сайн талтай гэж үздэг. Учир нь боловсруулах лиценз олгоходоо Байгаль орчинд үзүүлэх үнэлгээний тухай тайланд нийцүүлэхийг шаардаж болно.

Үүнээс гадна сайн тал нь боловсруулалтыг мэргэжлийн түвшинд хийнэ. Сул тал нь уурхайчин албан ёсоор нэг үйлчлүүлэгчтэй тулгарч болох талтай. Хэрвээ боловсруулагчдийн хоорондын өрсөлдөөн хүчтэй эсвэл үр дүн муутай байвал уурхайчдын заримыг үл тоомсорлох аюултайв Ийм үед орон нутгийн захиргаанаас худалдан авах үнийн хамгийн доод хязгаарыг тогтоон баталгаажуулж цөөнхийг шударгаар бүтээгдхүүнээ борлуулах эрхийг нь баталгаажуулж болно.

Хоршооллууд:

Олон оронд уурхайчдийг нэгтгэн хоршоолол байгуулах замаар эрх зүйн зохицуулалтыг нь хийжээ. Сайн тал нь орон нутгийн болон засгийн газрын агентуудтай харьцахад хялбар байжээ. Ийм менежмент нь зухайн орны Төрийн байгууллагын тогтолцоо хэр их үр ашигтай эсэхээс ихээхэн хамаарна.

Худалдан авах оффис.

Хууль бус наймаа, татвараас зайлсхийхээс сэргийлдэг. Худалдаж авах албан ёсны үнийг зөв тогтоож чадсан тохиолдолд энэхүү оффис үр ашигтай ажиллаж чадна. Өөрөөр хэлбэл, олон улсын үнэ ханшийг баримтална гэсэн үг. Оффисоос уурхайчдад санхүүгийн болон тонног төхөөрөмжийн зээл олгож болно.

Татвар.

Энэ салбарын онцлог байдлыг татварын хуульд зөв тусгах зорилгоор УЕМОА Нийтийн уул уурхайн хуулийн /2003 он/ 20-р зүйлд “жижиг хэмжээний болон гар аргын уурхайтай холбоотой эрхийн бичиг эзэмшигчид нь татвар төлөх ба татварын хэмжээг нутгийн өвөрмөц нөхцөлтэй уялдуулан тогтооно” гэжээ. Татварыг тогтоохдоо энэ салбарыг эмзэг байдлыг харгалзан үзэх нь хамгаас чухал. Олон улсын үнэ, эрдэсийн нөөц нь тодорхой бус байдлыг харгалзахаас гадна олборлогчид ядуурал руу хальтран орохдоо хамгийн амархан бүлэг хүмүүс гэдгийг ойлгох нь их чухал ажээ. Олон улс оронд орлогоо нэмэгдүүлэх татварын бодлогоос илүүтэй уурхайн эрхийн бичиг /зөвшөөрөл лиценз/ олгоходоо хураамж авдаг байна. Татварын тогтолцоо нь засаг захиргааны хувьд энгийн хялбар, тавар төлөгчийн хувьд ил тод, төвөггүй байх ёстой. Боливын жишээнээс үзэхэд, татварыг үйлдвэрлэгчдийн түвшинд бус хурааж авдаг оффис дээр ноогдуулж байна. Жишээ нь: хүдэрт ноогдуулахын оронд цэвэршүүлсэн металлд ноогдуулах, эсвэл экспортын татвар ноогдуулна гэсэн үг.

Тав. Хандлага, дэвшил

Гар арга болон бичил уурхайн зохистой хөгжил нь хоёр болон олон талт олон улсын доноруудын хэлэлцэх гол асуудлуудын нэг ч болжээ. Жишээ нь, Германы GTZ, BGR хөтөлбөрүүдийг Гана, Колумби болон Зембабвид хэрэгжүүлж, Их Британий Олон улсын хөгжлийн газрын тусламжийг загварчлах хөтөлбөр, Швейцарийн байгаль орчныг хамгаалах хөтөлбөр Латин Америкт хэрэгжсэн байна. Дэлхийн банк Болив, Буркино Пасо, Эквадор, Гана, Гвиней, Мадагаскар, Мозамбик, Папуа Шинэ Гвиней, Танзани зэрэг улсад хэрэгжиж байгаа төслүүдийг санхүүжүүлж байна. Дээрх хөтөлбөрүүд энэхүү салбарыг ядуурлыг бууруулах замаар тогтвортой хөгжилд хүргэх зорилгыг агуулж байгаа юм.

Амьжиргаа ба тогтвортой хөгжил

Хүн амд хохирол учруулахгүйгээр ядуурлыг бууруулах, улмаар тогтвортой хөгжлийн үндэс бий болгоход зорилго нь оршино. Үүнд хэрхэн хүрэх нь уул уурхайн нөхцөл байдлаас голлон шалтгаалдаг. Жишээ нь олборлолт нь гэнэт богино хугацаанд хийгдэж байгаа бол орон нутгийн хүн амын тогтвортой байдлыг хангах тухайлбал тухайн нутгийн бизнес,

сургууль, эмнэлгийн үйлчилгээг дэмжихэд түлхүү анхаардаг байна. Өмнө нь бичил уурхайн үр өгөөжийг сайжруулах, тэдэнд эрх зүйн болон байгаль орчныг хамгаалахтай холбоотой дэмжлэг үзүүлж байсан нь томоохон уурхайн аж ахуйд л дэмжлэг үзүүлэхээс хэтрээгүй байна. Өөрөөр хэлбэл, тэнд ажиллагсадын болон тэр нутгийн хүн амын тогтвортой хөгжилд ямар ч дэвшил гараагүй байна. Тийм учраас асуудлыг бүтцийн хувьд цогцоор нь буюу эрх зүйн дэмжлэг үзүүлэх, ирээдүйтэй талбайд эрх авах боломж олгох, сургалт явуулах, туршлага дэлгэрүүлэх, бизнесийн удирдлагаар хангах, зээл олгох, зэрэг арга хэмжээнүүдийг авч эхэлжээ. Тухайлбал НҮБ-аас Мали, Этиопи, Гана болон Гвиней дэх гар аргаар алт олборлолт хийдэг нутгийн иргэд, бүлгүүдэд хэрэгжүүлж байгаа тогтвортой амьжиргааны туршилтаар үр ашигтай аргачлал боловсруулж, зөвлөмж гаргасан байна. Үүнд:

- Ядуурлыг бууруулах үр ашигтай салбарын нэг гэдгийг хүлээн зөвшөөрч, үндэсний бодлогод тусгах
- Өсч төлөвшиж байгаа олон нийтийн байгууллагын бүтцийн чадавхийг бэхжүүлэхийн тулд хүмүүсийн оролцоог хангаж, тэдэнд ядуурлаас сэргийлэх стратегийн шалгуурын тусламжтайгаар хандаж, асуудлыг доороос дээшээ тавих удирдлагын аргыг илүүд авч үзэх
- Төрийн оролцоог аль болох багасгах чиглэлийг барьж, хувийн аж ахуй байгуулах, ялангуяа бичил аж ахуй, хоршоо бий болгоход чиглүүлэх
- Энэ чиглэлийн ядуурлыг бууруулах бүхий л хувилбарыг дэмжих зэрэг болно.

Бусдын сургамжаас үзэхэд, ашигт малтмалын хуульчлахдаа олборлолтын үйл ажиллагааг зохицуулаад зогсохгүй, нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалахад давхар анхаарсан нь үр дүнгээ өгч байна.

Бичил санхүүгийн нөлөө, дотоод худалдаа ба ажиллах хүч

Малигийн Садолины алтны уурхайн жишээгээс харахад, гар аргаар ашигт малтмал олборлох салбарыг орон нутгийн нийгэм, эдийн засгийн тооцоо, эргэлтэнд оруулах шаардлагатай гэдэг нь харагддаг. Өөрөөр хэлбэл, гар аргаар олборлосон ашигт малтмалын орлого нь тогтвортой орлоготой өөр бизнес эрхлэх хөшүүрэг болгоход нь дэмжлэг үзүүлэх замаар ядуурлаас гарах, улмаар орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх нэг эх үүсвэр болж, улмаар орон нутгийн тогтвортой хөгжлийг бий болгодог туршлагыг эндээс харж болно.

Бусдын сургамжаас үзэхэд, гар арга болон бичил уурхайн шигт малтмал олборлолт нь орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулснаар бүс нутгийн тогтвортой хөгжлийг бий болгодог байна.

Нийгмийн эрүүл мэндийн халамж

Англо-Гоулд Майнинг компани нь “Садолиа Алт” төслийг хэрэгжүүлснээр нийтийн хөгжлийн санг бий болгох, олсон ашгаар эргүүлэн хөрөнгө оруулалт хийх, ногоо тарих, саван, будаг хийх, жимсний мод тарих, загас үржүүлэх сан байгуулж уурхайн талбайг сайжруулах, талхны үйлдвэр, хоолны газар, мужааны цех зэрэг жижиг төслүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, нийтийн эрүүл мэндийн төв байгуулах зэрэг ажлыг хийсэн байна. Энэхүү үйл ажиллагаа нь нийгэм эдийн засгийн бүлэг чадавхийг бий болгох замаар жижиг, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлж, хүмүүст чиглэсэн нийгэм, эрүүл мэндийн халамжийг бий болгож чаджээ.

Жендэрийн асуудал

Олон улс энэ салбарт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Эмэгтэйчүүдийн орлогоо гэр бүл, аж амьдралаа авч явахад зарцуулдаг хариуцлагатай чанарыг нь хөхүүлэн дэмжихдээ нутгийн иргэдийн бүлгийн дотор эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх нь ядуурлыг үлэмж их хэмжээгээр бууруулахад тустай гэж үздэг. Гэхдээ жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйн хувьд олборлолтын үе шатан дахь



оролцоог ялгавартай авч үзэх нь зайлшгүй.

Энэ чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагыг төрөөс дэмжиж хамтран ажиллавал үр дүнд хүрэх магадлалтай. Жишээ нь Танзаний эмэгтэй уурхайчдын холбоо нь эмэгтэй уурхайчдын болон тэдний гэр бүлийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд олборлолт, байгаль орчныг хамгаалах, хөрөнгө оруулалт хийх, зээл авах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад нь зориулсан сургалт, маркетингийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан байна.

Хүүхдийн хөдөлмөр

Хүүхдүүд энэ салбарт ажиллах нь ядууралтай холбоотой. Гэхдээ хүүхдийг энэ хөдөлмөрөөс ангид байлгах нь зайлшгүй бөгөөд боломжтой гэдгийг Перугийн Санта Филоменагийн оролцооноос харж болно. IPEC 1998 оноос тус уурхайд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг зогсоох талаар “Cooperacion to run programme” ТББ-ыг санхүүжүүлсний дүнд 3 үе шаттай стратеги хэрэгжүүлсний дүнд уурхайн ажлаас бүх хүүхдүүдийг чөлөөлсөн, өөрөө өөрийгөө зохицуулах ба хүүхдүүд уурхайд ажиллахгүй байхыг янз бүрийн нийгмийн хяналтуудаар хянах болсон байна. Туршлагаас үзэхэд, аливаа төсөл, хөтөлбөрт олборлолтод орон нутгийн иргэдийг бүхэлд нь хамруулж, сургалт, сурталчилгаа явуулах нь илүү үр дүнтэй гэдэг нь харагдаж байна.

Эрх зүйн болон захиргааны асуудлууд

Сүүлийн жилүүдэд Перу, Колумб, Танзани, Өмнөд Африк зэрэг улсад уг салбарыг дэмжсэн эрх зүйн зохицуулалт хийхдээ Засгийн газраас нь хэд хэдэн гол асуудалд анхаарлаа хандуулж байна. Үүнд:

- Эрдэс баялгийн нөөцийн ашиглалтыг удирдан зохион байгуулах
- Салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих
- Ашиглалтын талбайг лицензжүүлэх
- Гар арга болон бичил уурхайн хэвийн үйл ажиллагааг хуульчлах явдлыг дэмжих зэрэг болно.

Үүний зэрэгцээ ашиглалтын эрх авах болон албан ёсны бүтээгдэхүүн гаргах боломжийг хялбар байлгахад чиглэсэн захиргаадалтын бус зохицуулалтын механизм бий болгохыг Засгийн газрууд чухалчилж байна. Энэхүү салбарт оролцох Засгийн газрын үүрэг хариуцлага нь норматив тогтоох хяналтын асуудлаар хязгаарлагддаг. Гардан хэрэгжүүлэх үйл ажиллагааг хувийн болон ТББ-ын салбарт хариуцуулж ажиллахад чиглэгдэж байна.

Нэмүү үнэ цэнэтэй бүтээгдхүүний үйлдвэрлэл

Боливын Засгийн газар албан бус зах зээл дээрээс худалдан авсан алтанд “өөрөө өөрийгөө тунхаглах систем” тогтоосон байна. Одоогоор үнэт чулууны дархнаас татварыг авдаг бөгөөд харин экспортод гаргадаг үнэт чулууг НӨАТ-аас чөлөөлдөг ажээ. Энэ нь Засгийн газар албан бус зах зээлээс авсан алтны дотоодын зах зээлийн үнийг олон улсын зах зээлийн жишиг үнээр авч байна гэсэн үг. Ингэснээр улсдаа нэмүү өртөг өртөг бий болгохын зэрэгцээ Боливын аж үйлдвэрийг олон улсын зах зээл дээр өрсөлдөх чадварыг дэмжсэн бодлого болж чадаж байна. Туршлагаас үзэхэд, гар арга болон бичил уурхайн албан бус зах зээлийг хумихад энэхүү үйл ажиллагаа тустай ажээ.

Хүрээлэн байгаа орчин

Улс орны жишээнээс харахад байгаль орчны хуулиа тодорхой, хэрэгжихүйц гарган Засгийн газар шууд хэрэгжүүлж эхэлсэнд оршино. Мөн олборлогчид болон нутгийн иргэдийн хамтын оролцоог хангах нь маш чухал ажээ. Гэхдээ ашиглалтын лицензийг хамтран эзэмших эсэх гэх мэт маргаантай, судалгаа шаардсан ажлуудад донор байгууллагууд

анхаарч байна.

- Хяналт хатуу байх ёстой.
- Ус бохирдуулсан зэрэг байгаль орчны шалтгаанаар лицензийг шинээр олгохоос Захиргаа татгалзах боломжтой байх
- Байгаль орчныг дээдлэх нь цаашдын уурхайн эрхийн хүчинтэй байх эсэхийн нөхцөл нь болж байх
- Нутгийн байгууллагууд нь техник болон чанарын шалгууруудын асуудлыг шийдэх чадвартай байх ёстой зэрэг шалгуур их чухал юм.

Санхүү, зээл

Энэ чиглэлийн бүтээлч шийдлүүд тухайлбал, олборлогчдын өөрсдийнх нь хөрөнгө мөнгийг оролцуулах, хамтарч хувь нийлүүлэх, адил тэгш оролцох, эрсдлийн хөрөнгө / үүнд хайгуулын сан ба олборлолт санхүүжүүлэх банк/-тэй байх, түрээсийн лизинг ашиглах боломжтой байх зэрэгт хууль эрх зүй, Засгийн газрын бодлого уян хатан байх ёстойг донор байгууллагуудын судалгаа харуулж байна. Үүний зэрэгцээ зээлийн нөхөн төлөлтийн хувиарийг тогтооходоо тоног төхөөрөмж нийлүүлсэн байдлаар бус харин бизнесийг удаан хугацаанд тогтвортой үргэлжлэхээр тооцох нь зүйтэй гэдгийг анхааруулж байгаа юм.

Татвар

НӨАТ хэрэглэх нь Засгийн газраас энэхүү олборлогчдын албан бус нөхцөл байдлыг дэмжих шалтгаан болдог. Аливаа зээл болон нийлүүлэгчдээсээ худалдан авсан бараанд хөнгөлөлт байдаггүй, тэдгээрээс ямар нэг ашиг хүртдэггүй тул олборлогчдын албан бус байдал нь тэднийг НӨАТ-ын эцсийн хэрэглэгч болгодог.

Эцэст нь тэмдэглэхэд, олон улсын энэ салбарыг зохицуулж буй харилцаа, хэрэгжилт, туршлага сургамжаас харахад албан ёсны болгох нь хоёр талдаа ашигтай байхгүй л бол хэрэгждэггүй байна. Аль ч тохиолдолд гар аргаар болон бичил уурхайн чиглэлээр ажиллаж буй хүмүүст хоёр талдаа ашигтай байна гэдэг нь Перугийн жишээгээр /2000-2002/ тодорхой цаг хугацаанд үнэлэгдэж, жишиг болохуйц байжээ. Албан ёсны болгох амжилт нь нь алт угаагчдын ашиг сонирхол тухайн үеийн улс төрийн зорилготой ер бусын байдлаар нийцсэн байжээ. Улсын талаас олгох эрх, үүргийн шаардлага, уурхайчны талаас эрх шаардах, үүрэг биелүүлэх хоёр сонирхол яв цав нийцсэний үр дүн гэж хэлж болох юм.

3. БИЧИЛ УУРХАЙ АШИГЛАХ АСУУДЛААР ЗАРИМ СОНИН ХЭВЛЭЛИЙН НИЙТЛЭЛД ХИЙСЭН КОНТЕНТ АНАЛИЗ

“Бичил уурхайгаас ашигт малтмал олборлохтой холбоотой цогц асуудлыг зохистой шийдэх арга зам” сэдэвт судалгааны ажлын удирдамжийн дагуу өдөр тутмын томоохон сонины нийтлэлд контент анализ хийв. Сонин хэвлэлийн нийтлэлээс түүвэр судалгаа хийхийн өмнө бид, тухайн сэдэв чиглэлд холбогдох шийдлээ хүлээсэн томоохон ажил асуудлуудыг ижил төсөөтэйгээр нэгтгэн бүлэглэж, дотоод “дэд гарчгийн хамрах хүрээ” –г дараахь байдлаар багцалж тодорхойлсон болно. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
 - 1.1. Ашигт малтмалыг гар аргаар олборлох хууль гаргах;
 - 1.2. Нутгийн удирдлагын оролцоо;
 - 1.3. Хөдөлгөөнт төрийн асуудал;
 - 1.4. Лицензийн зөвшөөрөл олгох, шилжүүлэх;
 - 1.5. Орон нутгийн хөгжилд бичил уурхайн оруулж буй хувь нэмрийг өргөтгөх;



2. Хөрөнгө оруулалт, нөөцийн татвар;
3. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа;
 - 3.1. Албан бус уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийг устгах;
4. Байгаль хамгаалал, нөхөн сэргээлт;
 - 4.1. Байгаль хамгаалах чиглэлээр ажилладаг Төрийн бус байгууллагын оролцоо;
5. Гэмт хэрэг;
 - 5.1. Хүний эрхийн зөрчил;
 - 5.2. Гэмт хэрэгтэй тэмцэх;
 - 5.3. Лицензийн наймаа;
6. Бусад (Уул уурхайн ерөнхий сэдвийн хүрээнд);

* * *

Хэвлэлийн агуулгын түүврийг хийхдээ бид, тухайн материалын хэлбэр хэмжээ статистикийн тоон үзүүлэлтүүдэд бус, харин засаг төрийн анхааралд толилуулах чиглэлд “асуудал дэвшүүлсэн байдал” талаас нь голлон анхаарсан. Сонин хэвлэлээс тодорхой сэдэв чиглэлээр хийсэн түүвэр судалгаанд хамруулсан нийтлэл материалын “гарчиг нь агуулгаа илэрхийлж ...” байгаа гэдгийг мөн эш болгов.

* * *

№	Нийтлэлийн нэр	Дэвшүүлсэн асуудал	Сонины нэр, дугаар	Нэмэлт тайлбар
1.	З. Энхболд, Хариуцлагатай уул уурхай , нийтлэл	(1, 6)	Өнөөдөр сонин, 2008.4.25, №96	
2.	Т. Бат – Оргил, Уул уурхайгаар улстөр хийгээд байвал энэ салбар бүхэлдээ уналтан орно , ярилцлага	(1, 1.4, 1.5, 6)	Өнөөдөр сонин, 2008.01.31, №25	
3.	Гар аргаар ашигт малтмал олборлохыг хориглоод амжилт олсон нэг ч улс орон байдаггүй , Уулзалтын тэмдэглэл, Өдрийн сонин, 2008.01.25, №20	(1, 2, 3, 4, 5, 6)	Өдрийн сонин, 2008.01.25, №20	
4.	Ж. Сүрэн, Бичил уурхайн олон улсын бага хурлыг үр дүнтэй боллоо гэж гадаадынхан дүгнэлээ , мэдээ мэдээлэл	(1, 2, 3, 4, 5, 6)	Ардын эрх, 2007.9.11, №77	

5.	Л. Болд, Ашигт малтмалын оргил үе ирсэн, ашгийг нь харин луйвардуулах ёсгүй , ярилцлага	(1, 6)	Өдрийн сонин, 2007.3.23, №20	
6.	Г. Энхбаатар, Нэрэндээ зохицох гэж дээрэм хийдэг болоо юу , өгүүлэл	(5.1, 6)	Ардын эрх, 2006.7.31, №144	
7.	Я. Содбаатар, Уул уурхайн салбарт төрийн малгай зайлшгүй хэрэгтэй байсан , ярилцлага	(1, 6)	Ардын эрх, 2006.7.31, №144	
8.	С. Авирмэд, Алт эрдэнэс алганы салаагаар савирч байна , нийтлэл	(1, 2, 6)	Монголын мэдээ, 2001.01.13, №9	
9.	С. Авирмэд, Лицензийн асуудал нь хар захын наймаа шиг болсон , редакцийн уулзалтын тэмдэглэл	(1, 1.2, 2, 5.3, 6)	Өнөөдөр сонин, 2002.5.21, №122	
10.	Б. Сандаг, Аливаа хуулийн сан муугийн шалгуур нь зохицуулж байгаа салбараа хөгжүүлэх чадвар юм , нийтлэл,	(1, 6)	Зууны мэдээ, 2002.6.28, №160, 161	
11.	Д. Жаргалсайхан, Оюу толгойн орд манай гарагийн уул уурхайн ертөнцөд шуугиан дэгдээсэн , ярилцлага	(1.4, 6)	Зууны мэдээ, 2002.9.19, №227	Зарим хэсэг нь бичил уурхайн асуудалд хамаатай
12.	М. Пүрэв, “Мод мухар” -ыг булаахад ах нарыг эрэмшүүлсэн далд гар , эрэн сурвалжлага,	(5.1, 5.3, 6)	Монголын мэдээ, 2002.10.09, №200	
13.	М. Пүрэв, Баянголын дэнж дэх луйвар , эрэн сурвалжлага	(5.3, 6)	Монголын мэдээ, 2002.10.09, №200	
14.	М. Пүрэв, Тэгш хэмийн тухай шинэ нээлт , эрэн сурвалжлага	(5.2, 5.3, 6)	Монголын мэдээ, 2002.12.17, №248	
15.	Б. Ганчимэг, Эрснээ ийм замаар олдог бол дэндүү харамсалтай , шуух хурлын сурвалжлага	(5.2, 5.3, 6)	Өдрийн сонин, 2002.3.26, №75	

16.	Б. Ганхүү, 100 гаруй цагдаагийн десант бууж бидэн рүү дайрсан , ярилцлага	(5.2, 5.1)	Монголын мэдээ, 2004.4.28, №84	
17.	Гар аргаар алт олборлогчдын нэгдсэн холбоо, “Дэмжигчиддээ сонордуулах нь”, мэдэгдэл	(1, 5)	Монголын мэдээ, 2004.4.28, №84	
18.	Ж. Гангаа, Дархан газрын алт юу болсон бэ , сурвалжлага	(4, 4.1)	Өдрийн сонин, 2004.5.01, №105	
19.	Геологч Д. Чулуун, Алттай газар заагаад өгвөл өвлийн идшийг чинь бэлдээд өгье , ярилцлага	(2, 6)	Монголын мэдээ, 2004.6.08, №112	
20.	Х. Дуламсүрэн, Аз дайрахыг хүлээх алтчидын амьдрал дэндүү осолтой , гар аргаар алт олборлогчтой хийсэн ярилцлага	(1, 2, 3, 4, 5, 6)	Монголын мэдээ, 2004.8.25, №167	
21.	Ж. Гангаа, Зүүнхараа – Бороо гоулд , замын тэмдэглэл,	(4, 6)	Өдрийн сонин, 2004.9.08, №222	
22.	Б. Туул, Уул уурхайн үйлдвэрлэлд нөөцийг бүрэн ашиглах ёстой , нийтлэл	(2)	Өдрийн сонин, 2004.9.16, №230	
23.	Г. Цэцэг, Налайхын уурхайд осол болж 3 хүн амиа алдав , дэлгэрэнгүй мэдээ	(3, 5)	Өнөөдөр сонин, 2004.9.16, №217	
24.	Н. Наран, Монголд 123 компани алт олборлож байна , нийтлэл	(1, 2, 6)	Зууны мэдээ, 2004.9.16, №220	
25.	Ц. Эрдэнэ, Уурхайчид шаварт дарагдаж амиа алджээ , Налайхаас хийсэн сурваалжлага	(3)	Монголын мэдээ, 2004.9.21, №186	
26.	Сумын засаг дарга М. Эрдэнэдалай, Заамараас 35 тн. алт олборлоод байна , ярилцлага	(1, 2, 1.2)	Зууны мэдээ, 2004.9.24, №227	

27.	Я. Цэдэнбалжир, “Нинжа” –нуудад зориулсан хууль батлагдсанаар эмх замбараагүй байдал цэгцрэх болно , нийтлэл	(1, 2, 3, 4, 5, 6)	Үнэн сонин, 2004.10.21, №207	
28.	С. Батболд, Лицензийн далд бизнесийг ил болгоно , мэдээлэл	(1.4, 5.3)	Өдрийн сонин, 2004.11.01, №269	
29.	Б. Хажидмаа, Уурхайн нөхөн сэргээлтийг энэ жил илүү сайн хянана , сурвалжлага – мэдээлэл	(4, 4.1)	Өдрийн сонин, 2005.3.17, №67	
30.	Д. Өрнөд, Заамарт Монгол Улсын хууль үйлчилдэггүй гэж үү , нийтлэл	(1.5)	Зууны мэдээ, 2005.3.19, №71	
31.	Ц. Цэвээнхэрлэн, Мөнгөн усны бизнес ба алтны ангуучид , асуудал дэвшүүлсэн өгүүлэл	(3, 3.1, 4)	Өнөөдөр сонин, 2005.4.12, №91	
32.	Ц. Эрдэнэцэцэг, “Алтан дорнод” –ын газрыг дээрэмдсэн нинжа нарт алттай газар зааж өгөхөөр болжээ , ярилцлага	(1, 3, 5, 6)	Монголын мэдээ, 2005.8.02, №149	
33.	Б. Цогнэмэх, Заамар + Алт + Нинжа = ? , асуудал дэвшүүлсэн өгүүлэл	(1.2, 5.1, 5.2)	Зууны мэдээ, 2005.8.06, №186	
34.	Н. Даваа, Засаг төрдөө заазлагдсан хүмүүс , тусгай сурвалжлага	(1, 1.2, 1.3, 3.1, 5.1, 5.2)	Монголын мэдээ, 2005.8.09, №154	Гар аргаар алт олборлогчдын тухай
35.	Ж. Гангаа, Алтчин , тусгай сурвалжлага	(1, 3, 4, 5, 6)	Өдрийн сонин, 2005.8.09, №189	
36.	Б. Цогнэмэх, Бид Алтан дорнод компанийн төлөө ажиллаагүй , Цагдаагийн хурандаа Х. Энхжаргал-тай хийсэн ярилцлага	(5, 5.1, 5.2)	Өнөөдөр сонин, 2005.8.11, №190	



37.	Р. Эмүжин, Хүрэгүй уурхайчны хүрэх цэг , аян замын сурвалжлага	(1, 2, 3, 4, 5, 6)	Өнөөдөр сонин, 2005.8.25, №199	Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх гадаадын зарим туршлага
38.	Ц. Элбэгдорж, Нинжа нар бол байх ёстой хүмүүс, гэхдээ алдуул мал шиг амьдрах ёсгүй , уулзалт ярилцлага	(1, 2, 3, 4, 5, 6)	Үнэн сонин, 2005.9.27, №168	
39.	Д. Дамдиндорж, Нөхөн сэргээл-тийн явцад үзлэг явуулна , мэдээлэл	(4)	Үнэн сонин, 2005.9.27, №168	
40.	Б. Янжмаа, Нинжагийн үгийг төрийн ордонд сонслоо , сурвалжлага	(1, 2, 3, 4, 5, 6)	Өдрийн сонин, 2005.8.25, №205	
41.	Нинжа нарыг удахгүй хуультай болгож өгнө , нээлттэй хэлэлцүүлэг	(1, 2, 3, 4, 5, 6)	Монголын мэдээ, 2005.8.27, №168	
42.	З. Бадмаараг, Нинжаанууд жилд 50 – 100 сая доллар олдог , сурвалжлага – мэдээлэл,	(1, 2, 3, 4, 5, 6)	Ардын эрх, 2005.8.29, №168	
43.	И. Отгонжаргал, Нинжа нарыг ад үзэж болохгүй , сурвалжлага	(1, 2, 3, 4, 5, 6)	Өнөөдөр сонин, 2005.8.29, №201	
44.	З. Ядам, Гар аргаар алт олборлогчид төрд үгээ хүргэсэн 7 хоног , тойм мэдээлэл	(1, 2, 3, 4, 5, 6)	Өдрийн сонин, 2005.8.29, №206	
45.	Уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчдын олон улсын чуулга уулзалтын өмнө , танилцуулга – мэдээлэл	(2)	Өнөөдөр сонин, 2005.9.03, №207	
46.	Н. Сарангэрэл, Нинжа нартай ажиллах өвөрмөц арга , нийтлэл	(4, 5)	Өнөөдөр сонин, 2005.10.13, №241	



47.	С. Энхтуул, Ганц компанийн лицензээс болж засаг захиргааны нэгжээ нүүлгэх хэрэг үү, сурвалжлага	(1.2, 1.3, 1.4)	Өдрийн сонин, 2005.10.20, №252	
48.	Н. Сарангэрэл, Алтанд барьцаалагдсан тосгоны хувь заяа, сурвалжлага	(1.2, 1.3, 1.4)	Ардын эрх, 2005.10.26, №210	
49.	Ц. Мөнхжаргал, А. Ганзориг, Ашигт малтмалын хуулийг хэрэгжүүлж байгаа бусад улс орнуудын туршлага, судалгаа	(1, 2, 4, 6)	Өдрийн сонин, 2005.12.05, №291	Бичил уурхайд төдийлэн хамаатай бус, гэхдээ ...
50.	Г. Энхлэн, Нинжа нарыг бичил уурхай эрхлэгчид болгоно , АМГТХЭГ –ын УУГ –ын хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С. Баттулгатай хийсэн ярилцлага	(1, 2, 3, 4, 5, 6)	Ардын эрх, 2005.12.07, №240	
51.	Д. Баярсайхан, Жонш тойрсон бодол , асуудал дэвшүүлсэн өгүүлэл	(1.1, 1.2, 6)	Зууны мэдээ сонин, 2005.12.20, №304	
52.	“Бэрх – Уул” уул уурхайн компанийн захирал М. Болдбаатар, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хэлэлцүүлэгт, санал	(1, 2, 6)	Өнөөдөр сонин, 2005.12.22, №300	Уул уурхайн жижиг компанийн эрх ашигт холбогдох багц санал
53.	Д. Баасанжаргал, Голуудын дуудлага , эсээ нийтлэл	(4)	Монголын мэдээ, 2006.02.14, №29	
54.	Б. Сэлэнгэ, Үзлээ – харлаа – ирлээ, (Нинжаа нар бийлэгжүү болсон байна) тусгай сурвалжлага	(1, 3, 4, 5, 6)	Монголын мэдээ, 2006.5.20, №103	
55.	Д. Гал, Нөхөн сэргээлтйн тухай нэхэн сануулах ину , нийтлэл	(4)	Өдрийн сонин, 2006.6.06, №145	



56.	“Уул уурхай, эрх зүйн зохицуулалт, байгаль орчин”, сэдвээр зохиогдсон Үндэсний зөвлөлгөөнөөс гаргасан зөвлөмж	(1, 2, 3, 4, 5, 6)	Өдрийн сонин, 2006.6.12, №150	
57.	Б. Болд, “Бороо гоулд” –ын эсрэг тэмцэл түр өндөрлөв , мэдээлэл, ярилцлага	(1, 2, 3, 4, 5, 6)	Өдрийн сонин, 2006.9.19, №156, 157	
58.	Б. Алтантуул, Дотоодын цэргийг ард түмнийх нь эсрэг хэн турхирав , сурвалжлага	(1, 5)	Өдрийн сонин, 2006.6.20, №147	
59.	Г. Пүрэвбаатар, Ханаж цаддаггүй эзэд , өгүүлэл	(1, 2)	Өдрийн сонин, 2006.7.01, №168	“Жижиг дунд ордоор улс орон хөгждөггүй” гэсэн дэд гарчигтай
60.	Г. Цолмон, “Ирак толгой”, “Кувейт толгой” –г эзэлсэн нинжаанууд Өвгөн овооны чиглэлд давшиж явна , сурвалжлага	(1, 3, 4, 5, 6)	Өнөөдөр сонин, 2006.7.03, №155, 156	
61.	Ш. Болд, Үндэсний үйлдвэрлэгч яагаад нинжа нарын гарт өртөв , өгүүлэл	(1, 3, 5, 6)	Үнэн сонин, 2006.7.19, №139	
62.	Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын мэдэгдэл	(1, 5)	Үнэн сонин, 2006.7.19, №139	
63.	Б. Монголмаа, Баялгийн эзэн Монгол орон аль замаар явах вэ , нийтлэл	(1, 2)	Өдрийн сонин, 2006.7.22, №181	
64.	Х. Мөнгөн, Алт дагасан маргаан дахин дэгдлээ , өгүүлэл	(1, 4, 5)	Үнэн сонин, 2006.7.25, №143	
65.	Б. Болд, Нинжа нарыг зохицуулах чиглэлээр төр засаг юу хийж байна вэ , өгүүлэл	(1, 4, 5, 6)	Өдрийн сонин, 2006.7.25, №183	
66.	Б. Майцэцэг, Заамар дахь нинжа нарын эрх зөрчигдөж байна уу , өгүүлэл	(5)	Монголын мэдээ, 2006.7.25, №143	

67.	“Нинжа” нар уурхайчин болох замд	(1, 2, 3, 4, 5, 6)	Бизнесийн мэдээ сонин, 2006.4.20	
68.	Х. Болормаа, Химийн бодистой тэмцэхдээ нинжа нарыг мартаж болохгүй, өгүүлэл	(3, 3.1, 4, 4.1)	Өдрийн сонин, http://www.mongolnews.mn/unuudur.php?n=	
69.	...			

* * *

Тэмдэглэх нь:

1. Нийтлэлийн түүврийг “Монголын мэдээ”, “Зууны мэдээ”, “Өнөөдөр”, “Ардын Эрх”, “Өдрийн сонин” (2004 - 2006) –оос хийв. “Бичил уурхайгаас ашигт малтмал олборлохтой холбоотой цогц асуудлыг зохистой шийдэх арга зам” –ын талаархи нийгмийн бодомжийг сонирхож байгаа (тухайн сонинны нийтлэлийн бодлогыг бус) болохоор бид хамруулсан хэвлэлийн нэр хүрээг зөвхөн нэг сониноор хязгаарласангүй.
2. Түүвэрт орсон нийтлэлийн агуулга руу өнгөц ажиглахад, нэр бүхий 69 гарчгийн дор бичил уурхайг дэмжих, гар аргаар ашигт малтмал олборлох иргэдийн үйл ажиллагааг төр засгаас алсын хараатай зохицуулахад чиглэсэн 234 асуудал давхардсан байдлаар хөндөгджээ. Тэдгээрийн 25% (57) нь хууль бусаар ашигт малтмал олборлогч иргэдийн хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулж, тэднийг төрийн үйлчилгээгээгээр хангах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд, 12% (28) нь тухайн “үйлдвэрлэл” –ийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хянаж зохицуулахад, 14% (33) нь байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн холбогдолтой ажил асуудалд, 20% (47) нь гэмт хэрэг зэрэг зөрчлөөс сэргийлэхэд тус тус чиглэжээ. Нийтлэлийн дотоод агууламжийн бүтцийн харьцуулсан эдгээр тоон үзүүлэлт нь:
 - Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг, хамгийн түрүүнд эрх зүйн бодлогын талаас нь дэмжин зохицуулж албан ёсоор баталгаажуулахын төлөө манай өдөр тутмын сонинууд дуу хоолой нэгтэй байгааг харуулж байна;
 - Хөндөгдсөн давтамжаар нь авч үзвэл, дараагийн хурц асуудалд “нинжа” нарыг ёс юм шиг дагадаг гэмт хэрэг зэрэг зөрчлийн нэн аюултай орчинг эрүүлжүүлэх багц ажил орж байна. Улирлын чанартай ажил эрхэлдэг, нүүж сууж хөдөлдөг ажлын байрыг дагаж үйлчлэх Хөдөлгөөнт засаг захиргааны түр нэгж, хөдөлгөөнт аврах анги ... –ийн асуудал нь энэ чиглэлд туршигдаж байгаа нэг шинэ зүйл юм байна.
 - Эхний 3 –т багтаж жагссан бас нэг том бүлэг ажил нь байгаль хамгаалах, хөрсийг нөхөн сэргээх, нутгийн иргэдийн эрх ашгийг хангах чиглэлд хамаатаж байна.
3. Жагсаалтад авагдсан өгүүлэл нийтлэлийн утгын ерөнхий агууламж нь “Бичил уурхайгаас ашигт малтмал олборлохтой холбоотой цогц асуудлыг зохистой шийдэх арга зам” –ыг эрэлхийлэх чиглэлээр зохион байгуулагдсан тухайн үеийн Олон улсын зөвлөлгөөн, Үндэсний зөвлөлгөөний албан ёсны баримт бичигт хураангуйлагдсан хэлбэрээр тусгалаа бүрэн олсон гэж үзэж болохоор байна.
4. “Бичил уурхайгаас ашигт малтмал олборлохтой холбоотой цогц асуудлыг зохистой шийдэх арга зам”, түүнтэй уялдсан төрийн бодлогыг оновчтой тодорхойлох чиглэлээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Дэлхийн банк, Нэгдсэн үндэстний байгууллага, Швейцарын хөгжил хамтын ажиллагааны агентлаг, Монголын ашигт малтмал, газрын тосны ХЭГ, Улсын мэргэжлийн хяналтын газар, Монголын ажил олгогчдын эздийн холбоо, Бичил уурхайг дэмжих төсөл, ХБНГУ –ын Байгалийн нөөц,

Геошинжлэх ухааны хүрээлэн хамтарч ажиллан Бодлогын зөвлөмжийн чанартай нэгдсэн баримт бичиг боловсруулж гаргасан.

5. Сонинхэвлэлийн нийтлэл, хэрэгжүүлсэн төсөл, холбогдох чиглэлээр зохион байгуулсан төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоотой семинар зөвлөлгөөний материалд дор дурдсан “шийдвэрлэвэл зохих асуудал” –ууд давтамжлаг байдлаар тусчээ. Үүнд:
 - Бичил уурхай эрхлэлтийг уул уурхай, ашигт малтмалын салбарын бодлого, үйл ажиллагаатай нэгтгэн уялдуулах;
 - Бичил уурхайн хэтийн зохистой хөгжлийг тэтгэхэд чиглэсэн төрийн бодлого бий болгож, түүнд холбогдох эрх зүйн зохицуулалтын орчинг бүрдүүлэх;
 - Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг албан ёсоор бүртгэлжүүлж, тэдэнд лизенци, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ил тод болгох, орон нутгийн удирдлагын санал, шийдвэрийг бодлого эрх зүйн орчинд тусгаж, хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлж, хөдөөгийн тогтвортой хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах;
 - Иргэдийн хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааны албан бус зохион байгуулалтыг тойрсон хэрэг зөрчлийг нэн тэргүүнд шийдэж зохицуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;
 - Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэдлэг, туршлага, технологийг дэмжин, байгаль орчинд ээлтэй, зардал хэмнэлттэй, үр ашигтай, аюулгүй технологийг бичил уурхайн хүрээнд турших, дэлгэрүүлэх;
 - Бичил уурхайн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар мэдлэг, мэдээлэл, сурталчилгааг бий болгох;
6. Гарчиглан түүвэрлэсэн нэр бүхий 69 нийтлэлийг бие биенээс нь саланги тусгаар авч үзвэл, дотор нь, манай сонирхсон асуултад харьцангуй дөхөмтэй хариулт өгч чадах тийм материал бас ховор юм. Гэвч, бид бусдаас илүү амьд өгүүлэмжтэй, дотоод агуулга өргөнтэй гэж үзсэн тодорхой хаягтай нэг нийтлэлийг зориуд сонгон авч ард хавсаргав. (Хавсралт 1.)

* * *

(Хавсралт 1.)

Бичил уурхайн бодит төрх (Хэвлэлийн нийтлэлээс гарсан зураг)

Манай улсад янз бүрийн ашигт малтмалыг гар аргаар олборлодог хувиараа хөдөлмөр эрхлэгч “нинжа” нарын тоог 60000 хүрсэн гэж 2002 оны намар албан ёсоор мэдээлж байв. Энэ тоо 2 жилийн дараа 100000 хол давжээ. Монголын мэргэжлийн “жинхэнэ уурхайчид” –ын тоо энэнээс олон дахин бага юм.

Ашигт малтмалыг гар аргаар олборлогч хүмүүс зөвхөн Заамарт байсан үе өнгөрч, эдүгээ тэд монголын говь, хангай ... хаа сайгүй тааралдах болов. Гар аргаар ашигт малтмал олборлогч “хараар ажиллагсад” дотроо алтныхан, нүүрснийхэн, жоншныхон гэж хуваагддаг. Ийм ажил үйл эрхлэгчид социализмын өмнөх үед ч монголд мөн байсан бөгөөд бөгөөд голцуу хятадууд алт угааж байжээ.

Мэдээ судалгаанаас үзвэл монголын “нинжа” нар 2005 онд 1515 кг алт, 521400 тонн нүүрс, 512 тонн жонш олборложээ. Энэ нь монголын уул, уурхайн нийт бүтээгдэхүүний 10 орчим, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 4.5 хувьтай тэнцэх үзүүлэлт юм. 2003 оны зун Төв аймгийн Заамарын “Алтан Дорнод Монгол” уурхайн эзэмшил талбайд удаан хугацаагаар үргэлжилсэн “орд булаалдсан” тэмцлийн үеэр гар аргаар хууль бусаар “алдсан” гэх алтны хэмжээний тухайд, компанийн удирдлагууд дурдсанаас хавьгүй илүү тоо хэлж байв.

“Нинжа” нартай нэг хэсэг цагдаагийн хүчээр тэмцээд “хөөж” дийлээгүй. Одоо байдал эсрэгээр өөрчлөгдөж, тэднийг дэмжих тухай дээр доргүй бодож сэтгэж эхэлжээ. Нинжа нар хөдөлмөр хамгааллын талын наад захын шаардлагыг хангалгүйгээр, ил далд газар ихээр малтан осолд өртөж амь насаа алдах явдал олноор гарч байна. Иймээс уул уурхайн хөдөлгөөнт аврах ангиуд ч байгуулагджээ. Налайх дахь аврах ангийг техникийн баазад түшиглэн, Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агентлагаас бичил уурхай эзэмшигчдэд зориулан Сургалт, мэдээллийн төв байгуулсан.

“Нинжа” нар монголын баруун, зүүн, өмнөд, умард хязгаар, улсын хил .. зах хязгаар хүртэл өргөн уудам нутагт тархан “цыган” маягаар нэг газраас нөгөөд шилжин нүүдэллэн аж төрдөг улс. Зудад малаа барсан, ажил төрөлгүй болсон хүмүүс ... зуны амралтаараа яваа оюутнууд дээрх нинжаагийн легионы гол цөмийг бүрдүүлдэг. Дотор нь найман настнаас наян настай буурлууд ч бий. Зарим газар (жишээ нь, Баянхонгорт) амралтын өдрөөр сумын дунд сургуулийн багш сурагчид бараг цөмөөрөө төмпөн саваа хангинуулаад олз хайх тус тусын ажилдаа ханцуй шамлан гардаг байна. Эмх замбараагүй ажилладаг нь тэдний үндсэн бэрхшээл юм. Гэмт хэрэг, архидалт, биеэ үнэлэх, ... мөрийтэй тоглоом, дамын наймаа тэднийг ямагт дагалдахаас гадна дов дошны овгорууд дор дороосоо төрөн атмандаж дарамтлах элбэг байна.

Хот суурин, төвлөрсөн газраас мэргэжлийн геологичид ч хөдөөгийн уул талыг зорьж, орон нутгийнхны дэмжлэгтэйгээр алттай газрын хайгуулд гарч, эрснээ олж гэмээнэ, тэндээ “нинжа” нарыг “даллан” оруулж өөрсдөө гардан удирддаг болжээ. Үндсэн ордын алттай чулууг бутлах няцлах зэрэг тоног төхөөрөмжийг түрээслүүлэн чамлахааргүй хэмжээний мөнгө хийж орлого олдог хүн олширсон гэнэ.

Алтны компаниудын ашиглаад өнгөрсөн ядмаг агуулгатай шороог дахин угаах маягаар бага зэргийн алт олдог “нинжа” нар эдүгээ улам бүр эрүүл газарлуу “давшиж” том уурхайн хажуу бөөрийг хадарч халдах болов. Тэд, хуучин хэрэглэдэг байсан уур нүдүүрээ гар хийцийн тоног төхөөрөмжөөр сольж ... жижиг үйлдвэрлэгч, “мэргэжлийн” уурхайчны дүрд улам бүр шилжин хувирсаар ажгуу. Гар аргаар алт олборлах хууль эрх зүйн шийдвэр үгүйлэгдэж байгаа юм. Одоо нэгэнт хүчээ авсан нинжа нарыг төр засгийн зүгээс дэмжиж, аль болох зохион байгуулалтад оруулах л дутаж байна.

Монголд, бичил уурхайг хөгжүүлэх гадаадын төслүүд ч хэрэгжиж байна. Баянхонгор аймгийн Бөмбөгөөр суманд Швейцарын хөгжил, хамтын ажиллагааны агентлагаас Бичил уурхайг дэмжих буюу “Гар үйлдвэрлэлийн аргаар ашигт малтмал олборлогчдыг зохицуулах нь” нэртэй төсөл хэрэгжиж улсын зөвлөлгөөн хүртэл зохион байгуулагдсан. Тус аймгийн Баян-Овооны Дөвөнт, мөн Бөмбөгөр, Шинэжинст зэрэг сумдууд бичил уурхайд “таарах” сул алттай ... тэнд аль дээр үеэсээ ердийн хөсгөөр шороо зөөж гар аргаар угааж байжээ. Ялангуяа, Дөвөнтөд нэг хэсэг 10000 орчим “нинжа” байршиж байсан бөгөөд тэнд ажилладаг “МонголБолгарГео” хамтарсан үйлдвэрийнхэнтэй эрх ашгийн сэжмээр нилээд зөрчилддөг байв. Дээрх сумдад эдүгээ 4000 гаруй иргэн гар арга алт ухдаг гэсэн тоо байна. Швейцарын төслийнхөн Бөмбөгөрт эхний удаад 100 гаруй өрхийг сонгон бүртгэлжүүлж, тэднийг албан ёсны харъяалалтай болгон ажлаа эхэлж, хуулийн хүрээнд олборлолт явуулахад нь туслан дэмжжээ. Тэднийг хэсэг бүлгээр нь нэгтгэн тодорхой талбайг зааж өгч “эзэмшүүлдэг” байна. Оноосон газраас алтаа олборлоод дуусмагц тэнд нь хөрсний нөхөн сэргээлтийг хийлгээд дараагийн газар руу оруулна.

Гишгэсэн хүрз ухсан шороо болгон мөхөл дагуулна, мөнгөн ус хэрэглэвэл хөрс, усны бохирдол хэцүүднэ гэхээ больж хэдийнээ амжив. Цоо эрүүл газрыг цоолж нүхлэн алт малтах, түүнийгээ эргээгээд дарахад техникийн хүч хэрэгтэй. Цахилгаан эрчим хүч ч шаардагдаж мэднэ. Төсөл хэрэгжүүлэгчид энэ тал дээр ч ихээхэн анхаарч байгаа бололтой. Эхнээсээ жижигхэн гар ажиллагаатай төхөөрөмжүүд олгосон байна. АНУ –д үйлдвэрлэсэн ийм маягийн төхөөрөмж 600 орчим долларын үнэтэй байдаг гэнэ. Харин



төслийнхөн түүнээс санаа аван монголчилж, модоор шахам бүтээсний үнэ 70.000 төгрөгт багтаж байгаа аж.

Бүртгэлтэй, нэг дор суурьшсан олборлогчид зохион байгуулалтанд орон “өөртөө итгэлтэй” болж ... улмаар зохион байгуулалтгүй нөгөө хэсэгтэйгээ зөрчилдөж эхэлнэ. Зохион байгуулалтгүй хэсэг нь мориндоо ганзгалж тэмээндээ тэгнээд, машин унаанд ачаалаад гэрийнхээ гадаа угаадаг “сонирхогч” нинжа нартайгаа нанчилдахгүй гэх баталгаагүй. Нутгийнхан алттай элс шороог илрүүлж мэдвэл ихэд нууцалж, сэм зөөн нуувраар зайлж жаахан шар юм олдог гэнэм. Албан ёсны бус бүлгүүд ч “шалгарч тодорсон нэг босс” –ын гарыг харан ажиллаж байгаа. Энэ маягаар алтны олборлолтод хэд хэдэн янзын хэлбэр хэлбэршил бий болох шинжтэй байгаа бөгөөд үйл явцын нийтлэг нь тэмүүлэл нь, тэд яван явсаар бичил уурхайчин, мэргэжлийн олборлогчийн дүр төрхийг улам бүр олсоор байгаад оршиж юм.

Томоохон тоног төхөөрөмж ажиллуулахад хүрвэл дизель станц хэрэгтэй. Ийм хэмжээний мөнгө тэдэнд мэдээж байхгүй. Тэгээд ч, сав л хийвэл нэгнийгээ алж хядчих гээд байдаг зүсэн бүрийн ааштай “танихгүй” хүмүүс санаа сэтгэл, хөрөнгө мөнгөө нийлүүлэх эсэх нь эргэлзээтэй. Ингээд бодохоор зэрэг, гал галаараа тасран ажиллах талыг сонгох магадлал нь илүү өндөр байгаа юм. Тээр жил Заамарт 200 цагдаа оролцсон “төр иргэн хоорондын тулгаралт” шахуу явдал болсноос хойш 2002 оны зун мөн баахан цагдаа очиж 8000 мянга орчим хүнийг бороохойдон тарааж, орон гэрийг ачаалаад ондоо газар буулгаж байлаа. Эдүгээ, төр, засаг тэднийг буруутгасан чиглэлд төдийлэн юм ярихаа байчихаж. Харин, орон нутгийн засаг захиргааныхан, уурхайн удирдлагууд “нинжа” нартай илтэд сөргөлдөх болж, нутгийнхаа алтыг ухуулсан ч уугуул иргэдээ оруулах өмчийн эрхийн сэтгэлгээ ихээхэн сэргэж ирж байгаа бололтой.

“Нинжа” –гийн түүхээс өгүүлэхэд, уг үзэгдэл АНУ –д 200 жилийн тэртээ ид оволзоод намдсан, түүнийг тухайн цагт нь “алтны галзуурал” хэмээн нэрийдэж байжээ. Латин Америкт төр засаг нь тэдэнтэй тэмцээд дийлэлгүй сүүлдээ арга буюу эвийн гэрээ байгуулсан байдаг. Африк тив ч цагтаа мөн “нинжа” элбэгтэй байв. Манай улсад эхлээд түлшний нүүрсэн дээр, 1996 – 1997 оны үест алтан дээр ийм “үзэгдэл” түгэн дэлгэрэв. Одоо бол үнэт эрдэнийн чулуу ... үнэ хүрэх юу л байна түүнийг санаан зоргоороо ухдаг болсон. Хуурай газарт нэн ховор тохиодог шүрэн ордыг хүртэл очоод тэд ухчихдаг. Энэ тухай УИХ -ын гишүүн хүн ярьж байсан. Ховор чухал орд газарт хараа хяналт байдаггүй, үнэт чулууны ченж ... жижиг үйлдвэрүүд элбэг болчихсон, хэрэглэгчид ч чулуун эдлэлийг илүү сонирхож эхэлсэн тийм цаг үе юм, өнөөдөр.

Монгол орон “нинжа” –гүй болтлоо их удна, лавтайяа 30 - 40 жил болно гэж мэргэжлийн байгууллагынхан тооцоолж байна. Тэгэхээр, талууд хангалттай урт хугацаанд харилцан ашигтай хамтран ажиллах бодлогоо аль болохоор эртхэн тодорхойлоод авах нь хэн хэндээ өлзийтэй бөгөөд хожмын үр дүн нь илүү эффе́кт сайтай байх болно.

* * *

Ашигласан материал

1. Монголын өдөр тутмын сонин хэвлэл (Дугаарыг өмнө хүснэгтэд заасан)
2. Интернет мэдээллийн сан, холбогдох сайтууд
3. <http://www.onair2.tv/www/index.php?action=news.view&newsId=1321>
4. “Бизнесийн мэдээ”... бусад сонин, сэтгүүл



АЛТ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭЭС ҮҮССЭН СӨРӨГ ҮР ДАГАВАРУУД (БОАЖЯ -наас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн бэлтгэв)

Д. Мягмарцэрэн

Уул уурхайн үйлдвэрлэлийн эрчимтэй үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчинд тодорхой хэлбэрээр сөрөг нөлөө үзүүлж, үүсмэл өөрчлөлтийг бий болгож байгаа нь, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх асуудалд онцгойлон анхаарах шаардлагатайг харуулж байна.

1991 онд Засгийн газраас “Алт” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлснээр 2005-2006 оны алт олборлолт 1991 онтой харьцуулбал 28 дахин өссөн байна. Гэвч Төв аймгийн Заамар, Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Галуут, Сэлэнгэ аймгийн Ерөө, Архангай аймгийн Цэнхэр сумдын нутагт хэдэн зуун гектар газар, газрын хэвлий эвдэгдэж, онгойсон нүх, овоолсон шороотой үлджээ.

“Алт” хөтөлбөр хэдийгээр байгалийн баялагийг эргэлтэнд оруулж, улсын эдийн засагт түлхэц өгсөн боловч, түүний улмаас мал аж ахуй, газар тариалан, экологид учруулсан хохирлыг одоогоор тооцож тодорхойлоогүй бөгөөд уг хөтөлбөрт алт олборлосноор байгаль орчин, экологид учруулах сөрөг үр дагавар, хохирлыг тооцоогүй, эвдэрч сүйдсэн газар, газрын хэвлийг нөхөн сэргээх талаар огт тусгаагүй байна.

Уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж эхэлснээс хойшхи хугацаанд ойролцоогоор 14565 га газрыг эвдрэлд оруулснаас гар аргаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаанд 1000 гаруй га газар өртсөн тойм судалгаа гарч байна. Үүнээс 2008 он хүртэл нийт 3386.6 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж, нөхөн сэргээлт хийгдээгүй байгаа 10000 орчим га газар байна.

2007 оны байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайланг 124 аж ахуйн нэгж байгууллага ирүүлж, тэдгээр тайланд аймаг, орон нутгийн БОА, МХГ-ын гаргасан дүгнэлтээр 1158.5 га газарт техникийн нөхөн сэргээлт, 958.3 га газарт биологийн нөхөн сэргээлт хийсэн нь тухайн жилд эвдэрсэн газрын 90 гаруй хувьд нөхөн сэргээлт хийгдсэн байгаа юм.

2008 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр батлуулсан 243 аж ахуйн нэгж, байгууллага байгаагаас нийт 1335.3 га газар олборлолтод өртөж, түүний 1216.57 га газарт техникийн нөхөн сэргээлт, 1064.28 га газарт биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөгөө батлуулан ажиллав. Эдгээр байгууллагууд нь нийт 956.07 сая төгрөг, 100000 ам.доллар төвлөрүүлээд байна.

Гэвч үүний зэрэгцээ нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон талбайнууд нэлээд их байна. Давхардсан тоогоор 30.0 га-аас их талбайд нөхөн сэргээлт хийгээгүй нийт нөхөн сэргээлт хийх талбайн 83% буюу 57 лицензийн талбай, 50 га-аас их талбайд нөхөн сэргээлт хийгээгүй нийт нөхөн сэргээлт хийх талбайн 77% буюу 37 лицензийн талбай, 80 га-аас их талбайд нөхөн сэргээлт хийгээгүй нийт нөхөн сэргээлт хийх талбайн 68% буюу 20 лицензийн талбай байна.

Зөвхөн 1999 оноос хойш шороон ордын алтыг олборлосноос улсын хэмжээгээр нийт 276 сая шоометр газрын хэвлийг эвджээ. Тойм судалгаагаар 1990-1998 он хүртэлх хугацаанд 100-120 сая шоометр газрын хэвлий эвдрэлд өртсөн урьдчилсан тооцоо гарч байна. Ихэнх алтны шороон ордууд голын хөндийд байрладаг тул голын гольдрилыг түр өөрчлөх тохиолдол гарч байна. Одоогоор голын гольдрилыг өөрчлөхийг хориглосон байгаа бөгөөд хууль гарахаас өмнө өөрчлөгдсөн гольдрил, голын ай савд үйл ажиллагаа явуулсан ашигт

малтмалын үйл ажиллагаанаас голын экологид үзүүлсэн нөлөөллийн хэмжээг Дээд судалгааны хүрээлэнгээс 2006 онд “Алт олборлох явцад ширгэсэн голуудыг сэргээх” төслийн хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судласан байна. (судалгааны товч тайланг хавсаргав) Судалгаанд ямар учраас алт олборлолт нь гол усыг ширгээж байгаа талаар тодорхой тайлбарлахын зэрэгцээ өнөөгийн нөхөн сэргээлтийн арга ажиллагаа тэр бүр оновчтой байж чадахгүй, хөрөнгө мөнгө дэмий үрсэн, нүд хуурсан үйл ажиллагаа болохыг баримттайгаар дурьдсан байна.

Иймээс нөхөн сэргээлтийн талаарх бодлогын түвшний арга хэмжээнүүдийг шинэчлэх, засаж залруулах, нөхөн сэргээлтийг үр дүнтэй, оновчтой болгох, экологийн хохирлыг тооцох зэрэгт шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүйг боловсруулах чухал шаардлагатай болж байна.

Энэхүү судалгаа мэдээлэлд Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газраас ирүүлсэн нөхөн сэргээлтийн талаарх тайлан болон нөхөн сэргээлтийн талаар Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тайлан зэргийг хавсаргав. Бусад төрийн болон төрийн бус байгууллагуудаас мэдээлэл хүссэн боловч энэ талаарх мэдээлэл, тоо, баримтууд хэт ихээс тодорхой заагдсан хугацаанд ирүүлж амжаагүй болно.



ДАРХАН ЦААЗАТ БОГДХАН УУЛАН ДАХЬ ГАЗАР АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ГАРЧ БУЙ ЗӨРЧИЛ, ЦААШИД АНХААРАХ ЗҮЙЛС

Ч. Базар (Ph.D), Д. Мягмарцэрэн

Мэдээлэл цуглуулсан арга барил:

- БОЯ, УМХГ, “Богд уулын хамгаалалтын захиргаа”, “Туул голыг хамгаалах үндэсний хөдөлгөөн” зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудад албан мэдээлэл хүссэн бичиг явуулж, хариуг авсан болно.

Мэдээллийн эх сурвалж:

1. БОЯ
2. УМХГ
3. “Богд уулын хамгаалалтын захиргаа”
4. WWF буюу Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн Монгол дахь Хөтөлбөр
5. “Туул голыг хамгаалах хөдөлгөөн”
6. “Монгол улсын эдийн засаг, экологийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдал”. UNDP Mongolia. х106. УБ., 2005
7. “Байгалийн үнэт баялаг барагдсаар-ядуурал үргэлжилсээр”. “Шинэ Зеландын байгалийн хүрээлэн-Хүн төвтэй байгаль хамгаалал” ОУБ. х 35. УБ., 2006
8. www.gaf.de/mongolia_mining/
9. “Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар, Богдхан уулын дархан цаазат газарт Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан тухай” тайлан. 2007. УМХГ, УБ

Товчилсон нэрс:

1. БОЯ - Байгаль Орчны Яам
2. БОАЖЯ- Байгаль орчинь аялал жуулчлалын яам
3. БОС – Байгаль Орчны Сайд
4. НИТХ – Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
5. НҮБХХГ – Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Газар
6. ТББ – Төрийн Бус Байгууллага
7. УМХ - Улсын Мэргэжлийн Хяналтын Газар

* * *

БОГДХАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ ГАЗАР

1. Богдхан уулын дархан цаазтай газрын талаарх товч мэдээ баримт

<ul style="list-style-type: none"> • Түүхэн мэдээлэл 	<ul style="list-style-type: none"> - 1778 онд анх дархалсан - 1957 онд АИХ-ын Тэргүүлэгчдийн 31-р, 1974 онд АИХ-ын Тэргүүлэгчдийн 248-р, 1995 онд УИХ-ын 26-р тогтоолоор тус тус дархалсан. - 1997 онд “Дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээ”-нд хамрагдсан байна.
<ul style="list-style-type: none"> • Дархан цаазтай газрын хэмжээ, га 	<ul style="list-style-type: none"> • 41651

Бүсийн тоо, хамрах хэмжээ	<ul style="list-style-type: none"> • 3 • Онгон бүс- нийт нутаг дэвсгэрийн 17.3% буюу 7115.3 га, • Хамгаалалтын бүс- нийт нутаг дэвсгэрийн 54.2% буюу 22291.9 га, • Хязгаарлалтын бүс- нийт нутаг дэвсгэрийн 28.5% буюу 11721.8 га
Голлох экосистем	<ul style="list-style-type: none"> • Ойт хээр, уулын хээр
Хил хязгаар	<ul style="list-style-type: none"> • Хойд талаараа нийлэл Улаанбаатар хот, урд талаараа Төв аймгийн Зуун мод, Сэргэлэн сум
Нийт байгаль хамгаалагчдын тоо	<ul style="list-style-type: none"> • 23
Тусгай хамгаалалттай газар дотор өөрийн малтайгаа амьдардаг байгаль хамгаалагчдын тоо	<ul style="list-style-type: none"> • 12
Хамгаалалтын захиргааны ажилтнууд	<ul style="list-style-type: none"> • 13
Тусгай хамгаалалттай газарт нэвтрэх цэгийн тоо	<ul style="list-style-type: none"> • 8
Тусгай хамгаалалттай газрын хилийн тэмдэгжүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Урд талын хэсэгт хийгдсэн
Газар ашиглалтын байдал	<ul style="list-style-type: none"> • 391 орчим иргэн, аж ахуйн нэгж газар ашиглаж байна Одоогийн байдлаар 91 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна¹.
Зуслангийн тоо	<ul style="list-style-type: none"> • 100
Өвөлжөөний тоо	<ul style="list-style-type: none"> • 60
Малын тоо	<ul style="list-style-type: none"> • 20 000 илүү
Бэлчээрийн дарамтын зэрэг	<ul style="list-style-type: none"> • Хүчтэй. /Бэлчээрийн даац нь 2 дахин ба түүнээс хэтэрсэн

* * *

1988 онд хамгаалалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй, илүү үр өгөөжтэй явуулах зорилгоор Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааг байгуулсан. Хамгаалалтын захиргаанаас хэрэгжүүлж буй гол ажил нь 1-рт, Богдхан уулын 32 амны 23-ыг нь хамгаалагчтай болгосон, 2-рт, байгаль хамгаалагчдыг холбооны болон бие хамгаалах хэрэгслээр хангаснаар гарах зөрчлийг өмнө нь илрүүлэх, хоорондоо холбоо барьж ажиллах боломжтой болжээ.

2. Богдхан уулын дархан цаазтай газар дахь газар ашиглалтын байдал

2002-2008 оны байдлаар ТХГН-ийн хуулийн дагуу 391 иргэн, аж ахуйн нэгж 26 аманд газар ашиглах зөвшөөрлийг БОАЖЯ-наас шийдвэр гарч газар олгосон. Одоогийн байдлаар 97 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Зөвшөөрөл авсан иргэн, аж ахуйн нэгжийн

ашиглахаар авсан талбайн хэмжээ нь 1414 га буюу хязгаарлалтын бүсийн 12 хувийг эзэлж байна.

Зайсангийн амны хязгаарлалтын бүсэд 152 иргэн, аж ахуйн нэгжид 303.5 га, Арцатын аманд 53 иргэн, аж ахуйн нэгжид 247.7 га, Нүхтийн аманд 22 иргэн, аж ахуйн нэгжид 95.4 га, Чандманы аманд 12 иргэн, аж ахуйн нэгжид 14.8 га, Хүүшийн аманд 11 иргэн, аж ахуйн нэгжид 31.9 га газрыг тус тус олгосон нь ашиглалтын даац хэтэрсэн гэж БОЯ үзэж байна. Мөн үүний зэрэгцээ аж ахуйн нэгж, айл өрхийн зөвшөөрөлгүй талбайн нийт хэмжээ 103.2 га байна. Богдхан уулын дархан цаазтай газрын хязгаарлалтын бүсэд газар олгосон байдлыг ам тус бүрээр харуулбал⁷

№	Амны нэр	Иргэн, аж ахуйн нэгжийн тоо	Талбайн хэмжээ/га-гаар
1	Зайсан	152	303.5
2	Богино	11	38.6
3	Багатэнгэр	7	72.7
4	Бичигт хад	3	7.1
5	Залаат	13	24.0
6	Зуунмодны ам	3	6.5
7	Хүрхрээ, Хүрэл тогоот	11	77.0
8	Чулуут	3	6.8
9	Бумбат	6	20.0
10	Төрхурах	15	44.7
11	Шажинхурах	6	25.4
12	Ширдэгт, Шаварт	4	47.0
13	Ихбулаг	1	10.0
14	Баруунзуун мод	1	1.0
15	Манзушир	4	6.0
16	Зүүндэлгэр	2	32.0
17	Баруундэлгэр	4	23.2
18	Түргэн	18	121.7
19	Ташгай	12	74.0
20	Тайна	7	25.5
21	Жаргалант	7	14.1
22	Нүхт	22	95.4
23	Арцатын ам	53	247.1

⁷ БОАЖЯ-наас ирүүлсэн мэдээлэл. 2009.06.19

24	Энхтайван	3	35.6
25	Хүүш	11	31.9
26	Чандмана	12	14.8
	Нийт дүн	391	1414.0

* * *

3. Богдхан уулын ДЦГ дахь газар ашиглалтын төлбөрийн байдал

- Газар ашиглалтын төлбөрийг НИТХ-ын 1997 оны 02 тоот тогтоолыг үндэслэн ТХГН-т 3 дахин өсгөж авдаг.
- Газар ашиглах гэрээнд зааснаар газар ашиглалтын төлбөрийн 30 хувийг хамгаалалтын захиргаанд, 70 хувийг дүүргийн Газрын албанд тушаадаг. Энэхүү шийдвэр нь БОС-ын 2001 оны 218 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар тогтоогдсон бөгөөд үүнийг УМХГ хууль зөрчсөн үйлдэл хэмээн үзэж “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай” хуулийн заалтыг хэрэгжүүлэхийг шаарддаг.
- 2003-2009 оны эхний улирал хүртэл 987.5 сая төгрөг төлөгджээ.

4. Богдхан уулын дархан цаазтай газарт учирч буй бэрхшээл

Богдхан уулын дархан цаазтай газрын Зайсан, Богино, Чандмана, Нүхт, Хүүш, Арцат зэрэг амд газар ашиглалтын даац хэтэрч, хөрс, ургамал талхлагдаж, зарим зүйлийн ургамал устсан, ан амьтны бэлчээр хумигдаж, Дархан газрын экосистет алдагдаж орон сууц баригдан суурин газар үүсэхэд хүрээд байна. /Судалгааны явцад Мэргэжлийн Хяналтын Газраас авсан зөрчлийн мэдээг Хавсралт 2-д үзүүлэв/.

4.1. Газрын даац хэтэрсэн шалтгаан

- Газар зохион байгуулалтын төлөвлөгөө хангалтгүй
- Хот төлөвлөлт замбараагүй
- Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх бодлого муу
- Газрын лицензийг тооцоо судалгаагүй олгосон
- Лицензийн зориулалтыг өөрчилсөн
- Суурьшмал иргэд, өрхийн тоо олширсон

Сөрөг үр дагавар:

- Орон нутгийн захиргаа хууль зөрчин газар эзэмшүүлэх зөвшөөрөл олгосон
- Жуулчны бааз, орон сууц, барилга байгууламж олноор баригдсан
- Томоохон хэмжээний хотжилт үүсэн хүн ам хэт их суурьшсан
- Малын тоо ихэссэнээс бэлчээрийн даац хэтэрсэн

Бууруулах арга зам:

- Хуулийн хэрэгжилтийг сайжруулах /"ТХГН-ийн тухай хууль", "Газрын тухай", "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай", "Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай" хуулиуд/
- Газрын даацын судалгаа хийх

- Газар ашиглуулах шийдвэр гаргах, газар ашиглах гэрээ байгуулах, гэрчилгээжүүлэх ажлыг шинэчлэх
- Газар ашиглалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах
- Газрын татвар нэмэх
- Жуулчны баазуудтай жил бүр гэрээ хийж, үр дүнг тооцох
- Хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг сайжруулах

4.2. Байгаль орчны доройтлын шалтгаан

- Хулгайн ан ихэссэн
- Хууль бусаар самар, жимс түүх нь эрс ихэссэн
- Гол горхи ширгэсэн, усны бохирдол нэмэгдсэн
- Ой модны өвчлөл ихэссэн
- Ой модны хулгай ихэссэн
- Малын тоо нэмэгдсэнээр бэлчээр маш их талхлагдсан
- Хуурайшил нэмэгдсэн, хүмүүсийн буруу үйл ажиллагаанаас үүдсэн түймэр
- Хог хаягдал /аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбоотой/

Бууруулах арга зам:

- Хуулийн хэрэгжилтийг сайжруулах, тусгай журам гаргаж мөрдүүлэх
- Олон нийттэй хамтран ажиллах, тэдний оролцоог нэмэгдүүлэх
- Мод шилжүүлэн суулгах, ан амьтан нутагшуулах бодлого
- Байгаль хамгаалах олон нийтийн боловсролыг дээшлүүлэх
- Хяналтыг сайжруулах
- Хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг сайжруулах
-

4.3. Бусад шалтгаан

- Хотын иргэдийн зүгээс үзүүлэх сөрөг нөлөө /Туул голын дагуу загасчлах, зугаалга, түлшний мод бэлтгэх, жимс, самар түүх/
- Дээрээс ирэх дарамт шахалт
- Санхүүжилт хангалтгүй
- Цалин хүрэлцээгүй
- Судалгааны ажил хийгдээгүй
- Боловсон хүчнийг мэргэшүүлэх ажил хангалтгүй
- Удирдлагын тогтвортой үйл ажиллагаа алдагдсан
- Зөрчлийг баримтжуулах техник хэрэгсэл муу
- Байгаль хамгаалагчийг урамшуулах ажил хуулийн дагуу хийгддэггүй
- Хяналтгүй аялал жуулчлал

Бууруулах арга зам:

- Орон нутгийн захиргаа болон ТББ-тай хамтран ажиллах
- Судалгааны тоног төхөөрөмжөөр хангах, судалгааны зөвлөмжийг хэрэгжүүлэх
- Байгаль хамгаалагчдийг мэргэшүүлэх, дэмжих, хуулийн дагуу урамшуулал олгох
- Байгаль хамгаалагчдийн тоог нэмэгдүүлэх



- Тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг төсөвт тусгах
- Хамгаалалтын захиргааны үйл ажиллагааг сайжруулах
- Хууль эрх зүйн орчинг илүү төгөлдөржүүлэх
- Хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг сайжруулах

5. Дүгнэлт

- Богдхан уулын дархан цаазтай газарт голлон тохиолдож буй бэрхшээлийг зэрэглэлээр нь эрэмблэн үзэхэд газрын асуудал хамгийн түрүүн тавигдаж байна. Дархан цаазтай газарт газар ашиглалтын даац хэтэрсэн бөгөөд энэ нь дээрээс ирэх дарамт шахалтын бэрхшээлтэй уялдаж байна. Аялал жуулчлалын бааз хөгжүүлэх, байр орон сууц барих зэргээр тэнд бага хэмжээний хотжилт үүссэн бөгөөд нийт 300 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа нь анхаарал татсан асуудал юм. Эдгээр нь газар олголтын талаарх хууль зөрчсөн шийдвэр, түүнд хүлээлгэх хариуцлага сул, орон нутгийн захиргааны хяналт алдагдсан, иргэдийн болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, хяналт, хамтын ажиллагаа байхгүй байгаатай холбоотой аж. НҮБХХГ-ийн “Монгол улсын эдийн засаг, экологийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдал” судалгаагаар “...эмзэг байдлыг багасгахын тулд шийдвэр гаргах, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг сайжруулах, хууль, удирдлага, санхүүгийн ил тод, ойлгомжтой байдлыг бий болгох, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, удирдлагад олон нийтийн оролцоог хангах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж өргөн цар хүрээг хамруулж байж амжилтанд хүрнэ” гэж дүгнэсэн байдаг.
- Богдхан уулын дархан цаазтай газарт хотын иргэдийн зүгээс учруулдаг дарамт их байгаа нь /загасчлах, түлшний мод бэлтгэх, самар, жимс түүх/ шууд утгаараа ажилгүйдэл, ядууралтай холбоотой. Жимс, самар, эмийн ургамал зэрэг ойн дагалдах баялаг, загас зэрэг нь ядуу болон нэн ядуу өрхүүдийн хувьд орлогын гол эх үүсвэр болж байна. “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль”, “Ойн менежментийн тухай Монгол улсын хууль” – д ТХГН-т нөхөрлөл байгуулахыг хориглосон заалт байдаг. Гэвч хориглосноор ТХГН-ийн байгалийн болон ойн дагалдах баялаг хамгаалагдаж байгаа нь үгүй юм. “Ядуу иргэд байгалийн нөөцөөс хүртэх боломжит баялаг болох талаасаа доогуур үнэлэгдэж, эко-системийн үйлчилгээтэй хамааралтай байдаг орон нутгийн иргэдийн амьжиргаа нь заримдаа үл ойшоогдож байгаагаас гадна бүс нутгийн болон үндэсний хэмжээнд эко-системийн үйлчилгээг анхаарч үзэхгүй байна. Хэрэв нутгийн иргэд байгалийн нөөц, газар эзэмших эрхтэй, эко-систем болон нөөцүүдийг ямар их үнэ цэнтэй болохыг ухаардаг бол, хэрэв орон нутагт орох орлогыг дэмжсэн хууль, тогтоомж байсан бол байгалийн нөөцөөс орон нутагт орох орлого болон хөдөөгийн эдийн засгийн өгөөжийн талаарх мэдлэгийн цоорхой байхгүй байсан бизээ”⁸ гэж олон улсын байгууллагын бас нэгэн судалгааны дүгнэлтэнд өгүүлсэн байна.
- Богдхан уулын дархан цаазтай газарт хийсэн үнэлгээнээс харахад “дээрээс учруулах дарамт, шахалт их” гэсэн бэрхшээл нилээд өндөр үзүүлэлттэй байна. Газар олголт замбараагүй болсон, Газар өмчлөл, ТХГН, байгаль орчны тухай гээд хууль хэрэгждэггүй, орон нутгийн засаг захиргааны удирдлагын оролцоо, хяналт муу байдаг ажээ. Хэдийгээр Дэлхийн байгаль хамгаалах сан /WWF/-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын хийсэн судалгаагаар Богдхан уулын дархан цаазтай газарт 300 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг гэсэн тоо гарсан боловч Монгол улсын нутаг дэвсгэр дээр янз бүрийн зориулалтаар

⁸ “Монгол улсын эдийн засаг, экологийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдал”. UNDP Mongolia. х106. УБ., 2005

үйл ажиллагаа явуулахаар авсан 5600 гаруй лиценз бүхий газруудаас ганцхан нь л Туул гол хавиар үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн нь сонирхол татаж байна. /Бүртгэлийн дугаар № 1071. Лиценз № 3096. Лицензний төрөл М. Лиценз эзэмшигчийн нэр: JNPE компани. Үйл ажиллагааны зориулалт: Барилга байгууламж. Талбайн хэмжээ: 102 га. Байрлал: Улаанбаатар, Хан-Уул дүүрэг. Туул⁹/ Туул голыг тойрсон зөрчлүүдийн талаарх зарим мэдээллийг “Экологийн боловсрол төв”, “Туул голыг хамгаалах хөдөлгөөн”-өөс авсныг /“Хавсралт- 1” –д/ бүрэн эхээр нь оруулав.

- Богдхан уулын дархан цаазтай газрын Зайсангийн аманд аялал жуулчлалыг хөгжүүлэх ажил бодлогогүй явагдаж байна. Аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах эрх авчихаад орон сууцны барилга барих, иргэдэд үл хөдлөх хөрөнгө болгон худалдаалах хууль зөрчсөн үйлдлүүд тасралтгүй явагддаг байна. ТХГН-ын хязгаарлалтын бүсэд баригдсан орон сууцны барилгыг Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газар бүртгэн авч үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ олгож байгаа нь ТХГН-ийн тухай болон Газрын тухай хуулийг зөрчсөн үйлдэл болж байна.¹⁰ Тайланд Зайсангийн аманд “Энигма группын Богдхан жуулчны бааз”, “Мантууш” ХХК, “Анома” ХХК, “Сарнайх” ХХК, “Дабу” ХХК-ийн “Хатан Туул цогцолбор”, “Мапекс” ХХК, “Бөхбат” ХХК, “ТФикс” ХХК, “Чингис Эко -Тур” ХХК, Жаргалантын ам- Буянт –Ухаа” цогцолбор зэрэг компаниуд аялал жуулчлал хөгжүүлэх лицензтэй боловч бүгд орон сууцны барилга барьжээ. Зөвшөөрлийг 2004-2006 оны хооронд БОЯ, Нийслэлийн Засаг дарга зэрэг хүмүүс олгож, ерөнхий төлөвлөгөөг БОЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, нийслэлийн ерөнхий архитектор нар баталж байсан байна.
- Богдхан уулын дархан цаазтай газруудын амуудад зөвшөөрөлгүй айл өрх ихээр суурьшиж, мал маллан амьдарч байгаа нь бэлчээрийн даацыг хэтрүүлэхээс гадна ТХГН газар нутаг талхлагдах, улмаар цөлжих явцыг түргэсгэж байна. Зөвшөөрөлгүй талбайн нийт хэмжээ 103.2 га байна.

* * *

6. ЗӨВЛӨМЖ

1. Холбогдох мэргэжлийн байгууллага, олон улсын байгууллагын санал

1.1. ТХГН-ийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох

- Нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, Монгол улс нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийнхоо өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага, төвлөрлийг сааруулах төрийн бодлого, орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлах тогтвортой хөгжил, байгалийн баялгийг ашиглах замаар хамгаалах бодлогын үүднээс ТХГН-ийн эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлага урган гарч байна. Тиймээс ТХГН-ийн Үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, ТХГН-ийн талаарх олон улсын байр суурийг дэмжих, бодлогоо уур амьсгалын өөрчлөлт, хөгжлийн хандлагад нийцүүлэх, ТХГН-уудын тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор эрх зүйн тааламжтай орчныг бүрдүүлэх

1.2. ТХНГ-ийн ангилалд өөрчлөлт оруулах, хил хязгаарыг өөрчлөх

⁹ “Байгалийн үнэт баялаг барагдсаар-ядуурал үргэлжилсээр”. “Шинэ Зеландын байгалийн хүрээлэн-Хүн төвтэй байгаль хамгаалал” ОУБ. х 35. УБ., 2006

¹⁰ www.gaf.de/mongolia_mining/

- Зайлшгүй хамгаалвал зохих ландшафт, тухайлбал голын татмын ой, гол усны эх орчмын газар зэргийг хамгаалал зорилго бүхий хамгаалалттай ландшафт гэсэн ангилал бий болгох. Судалгаа, шинжилгээний үндсэн дээр зарим ТХНГ-ийн хил заагийг өөрчлөх /чөлөөлөх бус/

1.3. ТХНГ-т үр дүнтэй менежмент бий болгох

- Энэ хүрээнд олон зүйлийг боловсронгуй болгох шаардлагатайг судалгаанд өгүүлсэн билээ. Харин зөвлөмжид чухалчилж буй зүйл нь ТХНГ-т дарамт үүсгэж буй сөрөг хүчин зүйлс, салбарын бодлогод үл нийцэх асуудлуудыг олж тогтоох, арилгах, сөрөг нөлөөллийг бууруулах, үр дүн нь байгаль хамгаалал рүү чиглэсэн хөшүүрэг байхаар эрх зүйн орчныг бүрдүүлэх

1.4. Биологийн төрөл зүйлийг хамгаалах зорилгоор зарим газрыг тусгай хамгаалалтад авах

- Ховор, ховордсон ургамал, амьтныг хамгаалах нөөц газруудын судалгааг бүхий л талаар дэмжиж, биологийн төрөл зүйлийг хамгаалах зорилгоор тусгай хамгаалалттай газруудыг нэмэгдүүлэх асуудлыг УИХ төрийн бодлогын хэмжээнд авч үзэх

1.5. Газар нутгийг тусгай хамгаалалтаас гаргах асуудлыг төрийн оновчтой бодлогоор шийдвэрлэх

- Тухайн газар нутгийг хамгаалах, эсвэл орд газрын хэлбэрээр ашиглах үйл ажиллагааны өнөөгийн болон цаашдын хөгжилд үзүүлэх эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг нь сайтар судалж, шинжилсний үндсэн дээр шийдвэр гаргах нь чухал юм. Орон нутгийн эдийн засгийн явцуу сонирхлоор ашигт малтмал ихтэй газрыг орон нутгийн хамгаалалтад зориудаар авч, эргээд тусгай хамгаалалтаас гаргах замаар ашиглалтын лиценз олгодог явдал орон нутагт ихээхэн тохиолдож байна. Лиценз олголтыг экологийн ач холбогдлыг нь харгалзан шийдвэрлэдэг байх, орон нутгийн удирдах байгууллага лиценз олгох шийдвэр гаргадаг тогтолцоог өөрчлөх эрх зүйн үндсийг бий болгох. Түүнчлэн нэгэнт хамгаалсан газрыг эргээд чөлөөлөх бус “Тухайн ТХНГ-ийн дотоод бүсийн хил заагийг өөрчлөх”, “ТХНГ-ийн ангиллыг өөрчлөх”, “ТХНГ-ийн тухай хуульд заасан дэглэм, түүнд нийцүүлэн гаргасан хамгаалалт, ашиглалтын нийтлэг болон онцолсон горимд өөрчлөлт оруулах” замаар асуудлыг зохицуулж болох судлаачдын саналыг судалж үзэх

1.6. ТХНГ-т нутгийн иргэд, олон нийттэй хамтран ажиллах үйл ажиллагааг дэмжих

- Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний хил залгаа орчны нутгийн үйл ажиллагаанд нутгийн иргэд, нөхөрлөл, ТББ, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, тэдний дэмжлэгийг авах хэрэгтэй байна. Менежментийн бодлогодоо тэдний оролцоог /санал сонсох, зөвлөлдөх, оновчтой шийд гаргах, тайлагнах/ чухалчлахын зэрэгцээ байгалийн баялагийг хамгаалах ашиглахтай холбогдсон харилцааг “Байгаль хамгаалах тухай Монгол улсын хууль”- тай уялдуулах

1.7. Олон улсын чанартай тусгай хамгаалалттай газар нутаг байгуулах үйл ажиллагааг идэвхжүүлэх

- Ховор, ховордсон амьтад, нүүдлийн шувуудын амьдрах орчин, экологийн тогтолцооны иж бүрдлийг хамгаалах зорилгоор хөрш орнуудтай хамтарсан тусгай хамгаалалттай газар нутаг байгуулах зорилгоор ОХУ, БНХАУ-тай хамтран ажиллах төрийн бодлогыг эрчимтэй явуулах

1.8. ТХНГ-т аялал жуулчлал хөгжүүлэх эрх зүйн үндсийг боловсронгуй болгох

- ТХНГ-т аялал жуулчлал явуулах үйл ажиллагааг Байгаль орчны сайдын

2002 оны 6-р сарын 11-ний өдрийн 117 тоот тушаалаар батлуулан мөрдүүлж байна. Гэвч ТХГН-т даацыг тооцолгүйгээр аялал жуулчлал явуулах эрхийг хавтгайруулан олгосноос байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Нэг ёсондоо аялал жуулчлал явуулах олон улсын стандарт энд орхигджээ. Тийм учраас ТХГН-т аялал жуулчлал явуулах үйл ажиллагааг “Аялал жуулчлалын тухай Монгол улсын хууль”-тай уялдуулах эсвэл” ТХГН-ийн тухай Монгол улсын хууль”-д тодорхой тусгах шаардлагатай байна.

Хоёр. Холбогдох байгууллага буюу Улсын мэргэжлийн хяналтын газрын санал

- ТХГН-ийн тухай болон Газрын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах
- Байгаль орчин, Боловсрол, Соёл шинжлэх ухаан, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2003 оны 90/167/127 тоот тушаалаар баталсан “Богдхан уулын дархан цаазтай газрын Зайсангийн амыг 2015 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө” болон түүнийг дагаж гарсан Байгаль орчны сайдын 2003 оны 164 дүгээр тушаалыг хянаж хүчингүй болгох
- ТХГН-ын хязгаарлалтын бүсэд амьдарч байгаа нутгийн үндсэн иргэдийн газар ашиглалтын талаарх журам гаргах
- ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах эрхийн зориулалтыг өөрчилж орон сууцны барилга барьж, иргэдэд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ олгож буй явдлыг зогсоож, БОЯ, УМХГ, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын уялдаа холбоо, үйл ажиллагааны зааг, хариуцлагыг тодотгосон эрх зүйн харьцааг боловсронгуй болгох
- Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол улс ТХГН-т газар ашиглах зөвшөөрөл олгох түр журам”-д газар ашиглах хүсэлт гаргах, шийдвэр гаргах, гэрээ байгуулах, гэрчилгээ олгох үйл ажиллагааг “Газрын тухай” хуулинд нийцүүлэн хэн, хэрхэн гүйцэтгэхийг тодорхой зааж өгөх зэрэг болно.

* * *

ТУУЛ ГОЛЫН ЭРГЭН ТОЙРОН ДАХЬ ГАЗАР АШИГЛАЛТЫН ЗӨРЧЛҮҮД

Хавсралт I

Туул гол нь Хэнтий нуруунаас эх аван 704 км урсахдаа 3 аймгийн 11 сум, Нийслэл хотоор 80 орчим км урсан өнгөрч, нийслэлчүүдийн ундны болон ахуйн усны хэрэгцээг дангаараа хангаж, улмаар Байгаль далайд цутган гадаад далайд гардаг. Туул нь Монгол улс төдийгүй гадаад стратегийн ач холбогдол бүхий гол юм. Туул голыг тэтгэдэг цутгал голууд, булаг шанд, горхиууд өнөөдөр шургаж ширгэж алга болсоор байна.

“Экологийн боловсрол олгох төв” нь 2007 оны 8-р сараас эхлэн Туул голын сав дагуу усны мэргэжилтэн, эрдэмтэн, мэргэжлийн хяналтын байцаагчид, нийслэлийн байгаль хамгаалах газар, тухайн гол дагуу орших суугч иргэдийн оролцоотойгоор хууль хэрэгжилтийн мониторинг хийсэн. Үүний үр дүнд Туул голын дагуу дахь зөрчил дутагдлыг тоочин гаргаж хэвлэл мэдээлэлээр 2008 оны 02 сараас эхлэн мэдээлж байна.

Зөрчлийг зэрэглэн ангилж албан тушаалын авилгал хээл хахууль, эрх мэдлээ ашиглан дур мэдэн хууль зөрчсөн, төсөл хөтөлбөр нэрээр хөрөнгө мөнгө шамшигдуулсан, олон



нийийн эрх эрхийг ноцтой зөрчсөн, байгаль экологид хор учруулсан экологи эдийн засгийн хохиролыг тооцох зэрэг төрлөөр ангилан доорхи зөрчил дутагдлуудыг сонгон авч анализ хийж ажилласан. Үүнд:

1. Яармагийн гүүрний баруун талд Туул голын салаанд баригдаж байгаа орон сууцны хорооллын суурийг тавьж эхлэх үеэс хууль зөрчиж байгааг баримтаар илрүүлэн хор холбогдлыг таниулан ажилласан. Яармагийн иргэд эсэргүүцэн барилгын хашааг буулгах хүртэл эсэргүүцлийн акц хийсэн. Үүний үр дүнд манай “Туул голоо хамгаалах үндэсний хөдөлгөөн”-ий залуусыг Хан-уул дүүргийн Эрүүгийн цагдаад байцаагдаж 20 сая төгрөг нэхэмжилсэн. /Холбогдох албан тушаалтан: Нийслэлийн хот байгуулалт төлөвлөлтийн дарга асан Нацагдорж, Хан-уул дүүргийн Засаг дарга асан Загджав
2. “Дүнжингарав” худалдааны төвийн барилгыг экологи эдийн засгийн нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй, цэвэр усны худагт үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдөр гаалийн баталгаат агуулах болохоор Амгалангаас төмөр зам татсан. Гаалийн агуулахад химийн хорт бодис болон болохгүй бүхий л бодис материал хадгалагддаг. /Холбогдох албан тушаалтан: Нийслэлийн ИТХТ-ийн дарга Н.Болормаа, Нийслэлийн Засаг дарга дарга асан Д. Батбаяр/
3. Туул голын эхэнд Галтайн гол дээр байрлах “Эм жи Эм Эм” компанийн алтны уурхайн голын голдирлыг өөрчлөн химийн хорт бодисоор алт олборлож байсан хууль бус үйл ажиллагааг баримтаар нотлон энэ талаар 2008оны 03, 04, 05 сард сурвалжлага хийж холбогдох байгууллагууд үйл ажиллагааг зогсоосон боловч одоо Эрүүгийн цагдаад хэрэг үүсгэгдээд 1 жил илүү болж байгаа боловч Туул голд учруулсан хохирол асар их хэвээр үлдэж байна. / Холбогдох албан тушаалтан: 2 сумын Засаг Даргын захирамж, АМХГ/
4. БЗД-ийн 20 хороо буюу Гачуурт тосгонд 13,58 га газрыг “Туул ривер контрисайд” ХХК гольф аялал жуулчлалын зориулалтаар ашиглахаар Улаанбаатар хотын ундны усны дээд эх үүсвэр дээр хууль бусаар үйл ажиллагаа явуулж байсныг орон нутгийн иргэдтэй хамтран зогсоосон. Захиргааны хэргийн шүүхэд 5 удаа буцаж хойшлогдон байж хууль бус байгааг нотлуулсан боловч дээд шүүхээр давж заалдсан нь дахин хүчингүй болж уг компанийн хууль бус үйл ажиллагааг зогсоосон. Одоо экологи эдийн засгийн хохирол болох 840 сая төгрөгийг гаргуулж нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох эздүүдээр хийлгүүлэх ажлыг зохион байгуулж байна./ БЗД-ийн 3Дарга асан УИХ -ын гишүүн Мөнхочир/
5. Хан-уул дүүргийн 1 хорооны нутаг Туул голын далан дагуу баригдаж байгаа хорооллын бохир усны шугам нь хууль зөрчин голын усанд нөлөөлж байгааг мөн л баримтаар олон нийтэд мэдээлж арга хэмжээ авахыг холбогдох газруудад хандсан. Туул гол дагуу газрын наймаа дээд цэгтээ хүрсэн. 700 м.кв газрыг 1 сая доллараар зарах зар өгч байна.
6. Түгээмэл тархацтай ордууд болох элс хайрганы карьерүүдийн талаар холбогдох эзэн, лицензүүдийн талаар зогсоохыг шаардсан 2008 оны 05-р сард нийслэл, ашигт малтмалын газар, БОЯ хамтарсан тушаал гарган олборлохыг зогсоон боловч одоо ч БЗД-ийн нутаг У булангийн дээр шинээр элс олборлож эхлүүлсэн байна. 2009 оны 06 сарын мониторингоор хуучин элсний карьерүүд ажиллаж байсан.
7. Арьс ширний 27 үйлдвэрийн бохирдол Туул голд шууд орсон хэвээр байна.
8. Барилгын компанууд хог хаягдлаа Сонгино хайрхан уулын өвөрт өдөр шөнөгүй зөөж хогийн цэг болгосоор, хайргыг нь зөөсөөр л , бэлчээр нутгийг нь талхалсаар л байна.
9. Туул голын сав дагуу иргэн, аж ахуйн нэгж, аялал жуулчлалын компаниуд хууль бусаар гүний худаг гарган хэмжээ хязгааргүй зарцуулсаар байна. / Албан бус тоогоор 2008 оны 04 сар зөвхөн Тэрэлжид 120 гүний худаг тоологдсон /
10. Туул, Сэлбэ голын хөгжлийн гарц нэртэй 400 сая долларын хөтөлбөрийн 200 сая төгрөг үр дүнгүй зарцуулагдсан. Энэ мэт үргүй зардлууд маш ихээр гарч ямар ч тайлан олон нийтийн хяналтгүй зарцуулагдаж байна. Усны газар, УСУГ, Мэргэжлийн

хяналтын газар, шүүх, цагдаа зэрэг холбогдох байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо нэгдсэн бодлого алга байна.

Анхаарах зүйл:

- Хамгийн гол нь тухайн орон нутгийн иргэдийн хүч, идэвхи санаачилга, мэргэжлийн хүмүүс болон сайн дурынханд түшиглэсэн хамтын оролцоотой ажил маш их дутагдаж байна. Туул голыг эрх мэдэлтнүүд бизнесийн ашиг сонирхол мөнгө олдог хэрэгслээ болгон хууль зөрчсөн үйлдэлд хөрөнгө оруулалт хийж байгаа нь харамсалтай. Туул голын сав газрыг зөв зохион байгуулж, хөрөнгө мөнгө, эрх мэдлийг нь тогтоон иргэдийн хяналт, оролцоотой байгуулж ажиллах нь чухал болов уу.

Мэдээллийг бэлтгэсэн “Туул голыг хамгаалах үндэсний хөдөлгөөн”. Ц.Туяацэцэг



3

БҮЛЭГ

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ, ГАДААД БОДЛОГЫН АСУУДАЛ

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТӨРӨӨС ОЛГОДОГ ОДОН, МЕДАЛЬ, ЦОЛНЫ ТАЛААРХИ СУДАЛГАА

Ш. Хишигсүрэн

Гадаадын зарим орны төрөөс олгодог одон, медаль, цолны талаархи судалгааг 2009 оны 4 дүгээр сарын 3-10-ны хооронд Улсын Их Хурлын гишүүн Ш.Сайхансамбуугийн 2009 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 9/1913 дугаар Судалгаа гаргуулах тухай хүсэлтийн дагуу хийж гүйцэтгэв. Уг судалгаанд Англи, Герман, Турк зэрэг орнуудыг хамааруулсан бөгөөд Бүгд Найрамдах Солонгос Улсын төрөөс олгодог одон, медаль, цолны тухай хангалттай мэдээлэл олдоогүй тул Солонгос, Япон Улсыг судалгаанд хамааруулаагүй болно.

Судалгааг төрөөс олгодог одон, медаль, цолны нэр /эх хэлээр/, тухайн шагналыг олгох эрх бүхий субъект, тухайн шагналыг дагалддаг урамшуулалын хэмжээ, тухайн шагналыг зохицуулсан эрх зүйн акт, ямар болзол, шалгуурыг харгалзан олгодог гэсэн үндсэн үзүүлэлтүүдээр, интернэтийн хайлтын систем болон тухайн улсын холбогдох цахим хуудсыг ашиглах аргачлалаар гүйцэтгэсэн болно. Судалгааны хугацаа давчуу байсантай холбогдуулан мэдээллийг зөвхөн интернэтээс хайх аргачлалаар цуглуулсан ба Оросын Холбооны Улсын одон, медаль, цолны тухай ном хэвлэгдэн гарч байсан байна. Харин гадаадын бусад улсын төрөөс олгодог одон, медаль, цолны талаархи судалгаа, мэдээлэл байдаггүй байна.

Судалгаанд хамаарагдсан орны төрөөс олгодог одон, медаль, цолыг дагалдах мөнгөн болон эд хөрөнгийн урамшууллын хэмжээний талаар мэдээлэл хомс байсан ба зарим улсад иймэрхүү урамшуулал олгодоггүй байна. Судалгаанд хамаарагдсан орны төрийн одон, медаль, цолны талаар танилцуулбал:

Нэг. БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС

Турк Улс нь төрийн одон, медалийг Медаль болон Одонгийн хууль /Хуулийн № 2933, Баталсан огноо: 1983.10.24/, Төрийн медаль болон одонгийн журмаар тус тус зохицуулдаг байна. Төрийн одон, медалийг зохион байгуулах ёслолын арга хэмжээг Ерөнхийлөгч, эсхүл түүний томилсон төлөөний этгээд гардуулдаг. Хэрэв шагнагдагч нас барсан бол түүний хамгийн том хүүд нь, хүү байхгүй бол охинд нь, хүүхэд байхгүй бол эцэгт нь, эцэг нь байхгүй бол ээжид нь, ээж нь байхгүй бол эхнэрт нь олгодог.

Төрийн одон, медальтай холбоотой бүх зардлыг ерөнхий сайдын төсвөөс гаргадаг ба шагналын бүртгэлийн асуудлыг Ерөнхий сайдын Боловсон хүчний ерөнхий захирлын ажлын алба хариуцдаг байна. Тус албанд шагналд нэр дэвшигчийн тодорхойлолт, төрийн байгууллагын уламжилсан санал, бусад мэдээллийг ирүүлдэг.

Төрийн одон, медаль авах Турк Улсын иргэдийн жагсаалтыг жил бүрийн 10 дугаар сарын 29-нд Ерөнхий сайдын ажлын албанаас мэдэгддэг бөгөөд тус мэдэгдэлд шагналыг хэзээ, хаана гардуулахыг товлон заадаг. Ерөнхийлөгчийн өөрийн гардуулах медаль болон одонг Ерөнхийлөгчийн Тамгын газар тогтоодог ба энэхүү ёслолын протоколыг Гадаад хэргийн яам хөтөлдөг.

Төрийн албан хаагчдад гадаад орны төрийн одон, медаль олгох тохиолдолд Турк Улсын зохих байгууллагын зөвшөөрөл авдаг байна. Төрийн албан хаагч бус Турк Улсын иргэн гадаадын төрийн одон, медаль авахад зөвшөөрөл шаардлагагүй бөгөөд харин гадаадын одон, медалийг Ерөнхий сайдын Боловсон хүчний ерөнхий захирлын ажлын албанд бүртгүүлснээр зүүх эрхтэй байдаг байна. Төрийн эсрэг үйлдсэн гэмт хэргийн улмаас



шүүхээр шийтгүүлсэн тохиолдолд шүүхийн шийдвэрт төрийн одон, медалийг эгүүлэн авахыг заадаг байна.

Дараахь эрх бүхий этгээд, байгууллага төрийн одон, медальд нэр дэвшүүлэх эрхтэй. Үүнд:

1. Туркийн Үндэсний Их Хурлын дарга,
2. Ерөнхий сайд,
3. Туркийн Зэвсэгт хүчний жанжин штабын дарга,
4. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл,
5. Хууль зүйн ямаар дамжуулан Шүүхийн дээд ерөнхий хороо,
6. Туркийн Үндэсний Их Хурлын даргаар уламжлан Төрийн аудитын дарга,
7. Гадаад хэргийн ямаар уламжлан элчин сайдтай дүйцэх гадаадын төлөөлөгчид,
8. холбогдох ямаар уламжлан төрийн байгууллага.

Харин Турк Улсын хууль тогтоох байгууллага болох Туркийн Үндэсний Их Хурлаас хүндэтгэлийн болон онц зүтгэлтэн шагнал гэсэн хоёр шагналыг олгодог байна. Туркийн Үндэсний Их Хурлын “Хүндэтгэлийн шагнал”-ыг жилд нэг удаа нэг хүнд уг шагналыг олгодог бөгөөд шагналд нэр дэвшигсэд өөрсдийнхөө холбогдох материалыг шагналын тухай зарыг Туркийн Үндэсний Их Хурлын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлахад нь өөрийн биеээр болон шуудангаар хүргэдэг. Нэр дэвшигсдийн материалыг хүлээн авсны дараа Туркийн Үндэсний Их Хурлын Соёл, Урлаг болон Хэвлэлийн хороо урьдчилан сонгон шалгаруулалт хийгээд Туркийн Үндэсний Их Хурлын даргын ажлын албанд хүргүүлдэг.

Туркийн Үндэсний Их Хурлын “Хүндэтгэлийн шагнал”-ыг жил бүрийн 4 дүгээр сарын 23-ны өдрийн Үндэсний засаг ба Хүүхдийн баярыг тэмдэглэх долоо хоногт Туркийн Үндэсний Их Хурлаас зохион байгуулдаг ёслолд Туркийн Үндэсний Их Хурлын дарга олгодог байна. Харин Туркийн Үндэсний Их Хурлын “Онц зүтгэлтэн” шагнал хувьд олгох цаг хугацаа, тооны ямар нэгэн хязгаарлалт байдаггүй. Уг шагналд нэр дэвшигчдийг Хотын захирагч, Дүүргийн захирагч, эсхүл Засаг даргын саналаар мужийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тогтооно. Шагналыг Туркийн Үндэсний Их Хурлын Соёл, Урлаг болон Хэвлэлийн хорооны тогтоосон хугацаанд зохион байгуулах арга хэмжээнд Туркийн Үндэсний Их Хурлын дарга олгодог.

“Биеийн тамир болон онц зүтгэл гаргагчдыг шагнах тухай” журмын дагуу дотоодын болон олон улсын биеийн тамирын уралдаан тэмцээнд өндөр амжилт гаргасан тамирчид, тэдгээрийн клуб, дасгалжуулагч, амжилт гаргахад хөдөлмөр нь оролцсон бусад этгээдэд олгодог. Энэхүү шагнал нь мөнгөн буюу эд хөрөнгийн хэлбэрээр олгодог бөгөөд тэмцээнд оролцогчдод хийсэн допингийн дүн гарахаас өмнө шагнал олгодоггүй. Мөн уралдаан тэмцээний дүнгээс шагнал авах клуб, шагнал авах амжилт гаргасан тамирчин уралдаан тэмцээн эхлэхээс хамгийн багадаа 6 сарын өмнө тус клубт бүртгэгдсэн байх ёстой байна. Шагналыг биеийн тамирын нийгэмлэгийн даргын санал, шагналыг үнэлэх комиссын санал, Залуучууд болон Бие тамирын ерөнхий хорооны даргын шийдвэрээр олгодог байна.

Хоёр. АНГЛИ УЛС

Англи Улсын хувьд одон, медаль, цол нь нэлээд уламжлагдан ирсэн хэдэн зуун жилийн түүхтэй, тэдгээрийг тусгай комиссийн шийдвэрийг үндэслэн Хатан хаан олгодог. Тухайлбал, Гартерийн хамгийн дээд одонг Эзэн хаан, Хатаны гэр бүл, Уэлсийн хунтайж болон бусад 24-өөс илүүгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс олгохоор шийдвэрлэдэг бөгөөд Англи, Уэлсд 1348 оноос уг шагналыг олгож эхэлсэн байна.

Англи Улсад төрийн одон, медаль, хэргэм цолыг дагалдан хэдий хэр хэмжээний мөнгөн урамшуулал олгодог талаархи мэдээлэл хомс ч Викторийн загалмайг дагалдаж жилд 1495 фунт стерлингийн тэтгэлэг олгодог бөгөөд тус загалмайг батлан хамгаалах салбарт байгуулсан гавьяаг үнэлэн олгодог, энэ салбарын хамгийн дээд одон юм. Уг одонг 1856 оноос эхлэн олгож байгаа бөгөөд нийт 1356 хүнд олгосон байна.

Харин Британийн эзэнт гүрний сүр жавхлантай дээд одонг Британийн эзэнт гүрний медаль дагалддаг /The British Empire Medal/ бөгөөд шагнал хүртэгсэд өөрийн нэрний урд “Sir”-эр, “Dame”-эм цол авах эрхтэй болдог. Уг шагналыг нийгмийн бүх салбарынханд (нийгэм ба батлан хамгаалах салбарынханд голлон) 1917 оноос эхлэн олгож байгаа юм байна. Англи Улс нь эзэн хаант улс тул уламжлагдан ирсэн хэргэм, цол, одон, медальтай бөгөөд хэргэм, цолыг ихэвчилэн удам дамжуулдаг ба язгууртнуудад олгодог уламжлалтай.

Гурав. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Герман Улсын хувьд Дэлхийн II дайны дараагаар одон, медаль, цолыг шинэчлэн олгох болсон байна. Нэр цол, одон, алдарын тухай хууль болон холбогдох тогтоомжоор ХБНГУ-ын төрийн одон, медалийг зохицуулсан бөгөөд улс төр, эдийн засаг, нийгэм, оюуны салбарт өндөр амжилт гаргасан, ХБНГУ-ыг энхийн замаар хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан хүнд Гавьяаны одонг олгодог. Уг шагналд дараахь эрх бүхий этгээд санал гарган нэр дэвшүүлнэ. Үүнд:

- Мужын захиргаа
- Гадаад Харилцааны Яам
- Холбооны сайд
- Албан газрууд
- Аж ахуйн болон спортын холбоод санал гаргах эрхтэй.

Герман Улсад төрийн одон, медалийг Ерөнхийлөгч олгодог байна. Герман Улсын Ерөнхийлөгч нь өөрийн бүрэн эрхийн хугацаанд гадаадын гурван улсын төрийн тэргүүн, түүний гэргийд Дээд зэрэглэлийн агуу загалмай олгох эрхтэй байдаг байна. Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс хуучин социалист дэглэмийн хүрээнд нэлээд олон төрлийн төрийн одон, медаль, цол гавьяатай байсан ба хоёр Герман нэгдснээс хойш Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын төрийн одон, медаль, цолны хууль тогтоомж үйлчлэх болсон байна. Герман Улсын төрийн одон, медаль нь Хар бүргэдийн зураг бүхий дугуйг загалмай дээр байршуулсан хэлбэртэй байдаг байна.



ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТӨРӨӨС ОЛГОДОГ ОДОН, МЕДАЛЬ, ЦОЛНЫ ТАЛААРХИ СУДАЛГАА

Д/д	Төрөөс олгодог одон, медаль, цолны нэр /эх хэлээр/	Тухайн шагналыг олгох эрх бүхий субъект	Тухайн шагналыг дагалддаг урамшуулалын хэмжээ	Тухайн шагналыг зохицуулсан эрх зүйн акт	Ямар болзол, шалгуурыг харгалзан олгодог
Нэг. БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС					
1.	Төрийн хүндэтгэлийн медаль /Devlet Şeref Madalyasi/	Засгийн газрын саналаар Ерөнхийлөгч	Шагналыг дагалддаг урамшуулал олгох тухай хууль болон журамд тусгай зохицуулалт байхгүй болно.	Медаль болон Одонгийн хууль /Хуулийн 1 2933, Баталсан огноо: 1983.10.24/, Төрийн медаль болон одонгийн журам /Засгийн газрын тогтоолын огноо болон 1 - 04/07/1988 - 88/13039/	Бүгд найрамдах улсыг мөнхөд оршин байх, улс болон үндэсний хуваагдашгүй нэгдмэл байдлын, нийтийн нэгдмэл эрх ашгийн тусын тулд дотоод болон гадаадад өндөр чармайлт, хичээл зүтгэл, амжилт гаргасан Турк болон гадаадын иргэнд олгодог.
2.	Төрийн бахархлын медаль /Devlet Цына Madalyasi/	Холбогдох яамны саналыг үндэслэн Засгийн газрын зөвшөөрлөөр Ерөнхийлөгч	Мөн адил	Мөн адил	Дотоодод эсхүл гадаадад хариуцлагатайгаар болон хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ чармайлт, хичээл зүтгэл, амжилт болон ашиг тус дүүрэн ажиллаж БНТУ-ын болон Турк үндэсний нэрийн өмнөөс үнэнч шударга бахархлын үндэс болсон этгээд болон түүний өв залгамжлагчид олгодог.

* * *

3.	Төрийн онц зүтгэлтний медаль /Devlet бстын Hizmet Madalyasi/	Холбогдох яамны саналыг үндэслэн Засгийн газрын зөвшөөрлөөр Ерөнхийлөгч	Мөн адил	Мөн адил	Дотоодод эсхүл гадаадад аливаа нэг салбарт чармайлт, хичээл зүтгэл, хүчин чадал бүхий хөдөлмөрөөрөө улсын болон дэлхийд үлгэр жишээ амжилт үзүүлж Улсынхаа нэр төрийг дээшлүүлж, үндэснийхээ эрх ашигт их хэмжээний хувь нэмэр оруулсан Турк улсын иргэнд олгодог.
4.	Дайны Медаль /Devlet Savaş Madalyasi/ Дайны медаль нь нэгдүгээр зэргийн болон хоёрдугаар зэргийн гэж хоёр төрөл байдаг	Туркын зэвсэгт хүчний командлагчийн мэдэгдлээр Батлан хамгаалах сайд болон Ерөнхий сайдын гарын үзэг бүхий тогтоолыг дагуу Ерөнхийлөгч	Мөн адил	Мөн адил	
	4.1. Дайны нэг дүгээр зэргийн медаль /1 inci derece Devlet Savaş Madalyasi/	Мөн адил	Мөн адил	Мөн адил	Дайны нэг дүгээр зэргийн медалийг 926 дугаар бүхий Турк Зэвсэгт хүчний боловсон хүчний хуулийн 189 болон 190 дүгээр зүйлийн дагуу дайны хүндэтгэлийн гэрчилгээгээр шагнагдсан этгээдэд олгодог.
	4.2. Дайны хоёрдугаар зэргийн медаль /2 nci derece Devlet Savaş Madalyasi/	Мөн адил	Мөн адил	Мөн адил	Олон улсын хуулиар хууль ёсны гэж тооцсон тохиолдол Туркын нэгдэн орсон гэрээний хүрээнд оролцож буй дайнд, Турк болон хамтын нөхөрлөлийн хүчинд болон түүнээс тусдаа үүрэг авсан Туркын эсхүл хамтын нөхрийн дайсантай хийж буй дайнд амжилт гарган дайнд ялсан, дайнд ялахад бэлтгэл болон дэм болсон эсхүл дайсантай тулалдахад үүргээ онц баатарлагаар болон зориг үзүүлэн биелүүлсэн Турк болон гадаадын иргэншилтэй цэргийн хүнд болон онц их зүтгэл, баатарлаг, зориг гаргасан анги, салаанд олгодог.

5.	Төрийн одон /Devlet Nişanı/	Засгийн газрын тогтоол ба Ерөнхийлөгч	Мөн адил	Мөн адил	Бүгд Найрамдах Турк Улстай найрамдлын харилцааг хөгжүүлэхэд болон үндэстэй хоорондын ойр дотно харилцааг бий болгосон улсын төрийн тэргүүнд олгодог.
6.	Бүгд найрамдах одон /Cumhuriyet Nişanı/	Засгийн газрын тогтоол ба Ерөнхийлөгч	Мөн адил	Мөн адил	Бүгд Найрамдах Турк Улстай найрамдлын харилцааг хөгжүүлэхэд болон үндэстэй хоорондын ойр дотно харилцааг бий болгосон улсын Ерөнхий сайд, сайд, болон гадаад дахь төлөөлөгчдөд олгодог.
7.	Гавьяат зүтгэлтний одон /Liyakat Nişanı/	Гадаад хэргийн яам болон Ататурк Соёл, Хэл болон Түүхийн Дээд хорооны саналыг аван холбогдох сайдын саналаар Ерөнхий сайдын зөвшөөрөлтэйгээр Ерөнхийлөгч	Мөн адил	Мөн адил	Шинжлэх ухаан, урлагт БНТУ-ыг олон улсын талбарт танилцуулан, нэр хүндийг нь дээшлүүлсэн гадаадын иргэдэд олгодог.
8.	Туркын Үндэсний Их Хурлын хүндэтгэлийн шагнал /TBMM Onur Cdьы/	ТҮИХ-ын Даргын зөвлөл	Жил бүр дагалдах мөнгөн урамшууллын хэмжээг ТҮИХ-ын Соёл, Урлаг болон Хэвлэлийн хороо тогтоодог.	Туркын Үндэсний Их Хурлын дотоод дэгийн 74 дүгээр зүйл, ТҮИХ-ын хүндэтгэлийн болон онц зүтгэлтэн шагналын тухай журам	Олон улсын талбарт үзүүлсэн гарамгай амжилтаар Туркыг төлөөлж, таниулахад хувь нэмэр оруулсан хүнд олгодог.

* * *

2.	Thistle-ийн хамгийн дээд ба эртний одон /The Most Ancient and Most Noble Order of the Thistle/	Хатан хаан	Тодорхой мэдээлэл алга	Шотланд удмын 16 гишүүн болон хааны гэр бүлээс бүрдсэн баг шагнал олгохыг шийддэг.	Шотландын иргэн, 1687 оноос олгож байгаа.
3.	Bath-ийн хүндэт одон /The Most Honourable Order of the Bath/	Хатан хаан	Тодорхой мэдээлэл алга	Тогтоомж болон шагнал олгохыг зохицуулдаг тусгай томилогдсон хороо байдаг.	Нийгмийн салбарт үр бүтээлтэй удаан ажилсан: ахмад зүтгэлтэн болон цэргийн салбарынханд 1725 оноос олгогдож байгаа.
4.	Гэгээн Михайл болон гэгээн Жоржийн гавьяаны одон /The Most Distinguished Order of Saint Michael and Saint George/	Хатан хаан	Тодорхой мэдээлэл алга	Тодорхой мэдээлэл алга	Гадаад харилцаанд гавьяа байгуулсан дипломатууд 1818 оноос олгогдож байгаа.
5.	Алдарт зүтгэлтний одон /The Distinguished Service Order/	Хатан хаан	Тодорхой мэдээлэл алга	Тодорхой мэдээлэл алга	Дайнд оролцогсод
6.	Викторийн хааны одон /The Royal Victorian Order/	Хатан хаан	Викторийн хааны медаль, Викторийн хааны гинж дагалддаг /The Royal Victorian Medal, The Royal Victorian Chain/	Энэ одонг хүртэх эрх 6 орны хүмүүст нээлттэй байдаг бөгөөд тус тусдаа өөр олгодог систем, медальтай байдаг. Үүнд Австрали, Канад, Шинэ Зеланд, Англи, Уэльс, Шотланд, Хойд Ирланд багтана.	Хатан хааны төлөө зүтгэгчид, үйлчилгээнийхэнд 1896 оноос олгож байна.
7.	Меритийн одон буюу Гавьяатын одон /The Order of Merit/	Хатан хаан	Шагнал хүртэгсэд өөрийн овгын араас О.М гэсэн дагавар авах эрхтэй.	24 гишүүн болон хааны гэр бүлээс бүрдсэн баг шагнал олгохыг шийддэг.	Цэргийн салбарынхан болон шинжлэх ухаан, урлаг, утга зохиол, соёлын салбарынханд 1902 оноос олгож байна.

* * *

Гурав. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС					
1.	Гавьяаны одон	Ерөнхийлөгч	Холбогдох мэдээлэл байхгүй байна.	Нэр цол, одон, алдарын тухай хууль, холбогдох журам Холбооны Засгийн газар ХБНГУ-д онц их зүтгэл гарган этгээдэд нэр цол, одон алдарыг олгохдоо Нэр цол, олон, алдрын тухай хуулийг баримтлана. /Gesetz ьber Titel, Orden und Ehrenzeichen/	Улс төр, эдийн засаг, нийгэм, оюуны салбарт амжилт гаргаж, энэ нь эх орны бүтээн байгуулалтад нөлөөлсөн, ХБНГУ-г энхийн замаар хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан хүнд - Мужын захиргаа - Гадаад Харилцааны Яам - Холбооны сайд - Албан газрууд - Аж ахуйн болон спортын холбоод санал гаргах эрхтэй.
2.	Гавьяаны загалмай	Ерөнхийлөгч			Цэргийн офицер
3.	1-р зэрэглэлийн гавьяаны загалмай	Ерөнхийлөгч			Цэргийн офицер
4.	Агуу гавьяаны загалмай	Ерөнхийлөгч			Цэргийн командлагч
5.	Агуу гавьяаны загалмай /одтой	Ерөнхийлөгч			
6.	Агуу гавьяаны загалмай /одтой, туузтай/	Ерөнхийлөгч			
7.	Агуу загалмай	Ерөнхийлөгч			
8.	Онцгой гавьяаны агуу гавьяаны загалмай	Ерөнхийлөгч			Өнөөг хүртэл зөвхөн Конрад Аденауэр, Хелмут Коль нар авсан
9.	Дээд зэрэглэлийн агуу загалмай	Ерөнхийлөгч			Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хугацаандаа гадаадын төрийн тэргүүнд гурваас илүүгүй удаа олгох эрхтэй.



**АВЛИГА, ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНД СУРТАЛ, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АШИГ,
СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН АСУУДЛААР ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ ТОЙМ**
(СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ)

У. Мөнхбат, К. Пүрэвсүрэн, Ш. Хишигсүрэн

Авлигын асуудлаар хийгдсэн судалгааны тойм

Авлига, авлигатай тэмцэх асуудлаар 1990-ээд оноос хойш төрийн бус байгууллага, судлаач, эрдэмтдийн хийсэн нэлээд олон судалгаа байх ба мөн мэдээлэл, лавлагаа, нийтлэлийн хэлбэрээр уг асуудлыг өргөн хүрээнд авч үзсэн байна. Нийт судалгааг авлигатай тэмцэх хууль тогтоомж боловсруулах, авлигын асуудал эрхэлсэн байгууллага байгуулах зэрэг тухайн цаг үеийн тулгамдсан асуудлуудын хүрээнд олон талаас нь авч судалсан байна. Авлигын асуудлаар хийгдсэн судалгаануудын талаар товч тоймлон авч үзвэл:

Нэг. Монгол дахь авлигын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь

Энэхүү судалгааг Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд 1999 онд хийжээ. Уг судалгаа нь анх удаа улсын хэмжээнд өргөн хүрээг хамран явагдсан, судлаачид нь судалгаа шинжилгээний ажлын туршлагатай, багт олон улсын зөвлөхүүд орж ажилласан, эцэст нь хамгийн гол зүйл болох судалгааны үр дүн авлигын эсрэг төрийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтэд шууд хэрэглэх боломжоор хангагдсанаараа давуу талтай юм.

Хөтөлбөрийн хүрээнд доктор Я.Шуурав, Р.Вандангомбо, Х.Гүндсамбуу, П.Увш нарын 27 эрдэмтэн, судлаач гүйцэтгэсэн байна. Судалгааг авлигын эсрэг бодлого боловсруулах, стратегийг тодорхойлох, үндэсний хөтөлбөр боловсруулахад болон энэ чиглэлээр хийгдэж буй ажлын үнэлгээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Улаанбаатар хот, 9 аймаг, 30 гаруй сумын хэмжээнд явуулжээ.

Судалгаа нь:

- авлигын талаархи монголчуудын ой дурсамж
- авлигын талаархи олон нийтийн төсөөлөл, хандлага
- авлигын тархалт, төрөл, хэлбэр
- авлигад нөлөөлөгч хүчин зүйлс
- авлигын жишиг, ханш
- авлигатай хийж буй тэмцлийн байдал
- авлигатай тэмцэх эрх зүйн орчны бүрдэл
- авлигатай тэмцэх олон нийтийн идэвхийн байдал
- авлигатай тэмцэх байгууллагын талаархи олон нийтийн санаа бодол
- авлигын талаархи олон нийтийн хүлээлт


гэсэн бүтэцтэй байна.

Судалгааг авлигын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурийг хувь хүнээс эхлээд нийгмийн томоохон бүлэг давхрааны түвшинд тал бүрээс нь судалснаараа онцлог байна. Үүний гол агуулга нь авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон нийтэд хор уршгийг нь тайлбарлан таниулах, төрийн албан хаагчдын авлигад автах эрсдлийг багасгах явдал юм.



Судалгааны бүтэц дэх зарим онцлог тоон үзүүлэлтийг жишээ болгон харуулбал: Авлигын талаархи олон нийтийн төсөөлөл, хандлага гэсэн хэсэгт судалгаанд оролцогчдын олонхи буюу 39.0 хувь нь авлига гэдгийг албан тушаалтныг худалдан авах, харин үүнээс багагүй буюу 38.7 хувь нь авлигыг шан харамж авч, өгөхийг авлига гэсэн утгаар ойлгосон үзүүлэлт гарсан байна.

Авлигын тархалт, төрөл, хэлбэр гэсэн хэсэгт 49.6 хувь нь монголд авлига хавтгайрсан, 42.6 хувь нь нэлээд газар авсан гэж үзсэн бол 1.4 хувь нь хариулахад бэрхшээлтэй байна гэжээ. Гааль, банк, шүүхийн байгууллага, УИХ авлигын түвшингээрээ тэргүүлсэн ба бусад байгууллагууд маш бага зөрүүтэй байна. Үүнийг, уг судалгааны хэсгээс зургаар харуулбал:



Эх сурвалж: “Монгол дахь авлигын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь судалгааны тайлан

Авлигад нөлөөлөх хүчин зүйлс гэсэн хэсэгт хамгийн өндөр үзүүлэлтэй нь албан тушаалтны хариуцлага бага хүлээдэг байдал 54.8 хувь, мөн өмч хувьчлал шударга бус байдгаас 49.8 хувь, харин хуулийнхан шударга бус ханддаг байдал 42.2 хувь гэсэн үзүүлэлттэй гарсан байна. Үүнийг дэлгэрүүлэн судалгааны хэсгээс зургаар үзүүлбэл:


Авлигатай тэмцэх олон нийтийн байдал гэсэн асуудлын хүрээнд судалгаанд оролцогчдын 44.9 хувь нь тэмцэгч, 41.6 хувь нь дундыг баригч, 13.5 хувь нь үл тэмцэгч гэсэн үзүүлэлт гарсан байна. Энэ тоон үзүүлэлт болон энэ хүрээний судалгааны байдлаас үзэхэд олон нийт авлигыг үл тэвчих, тэмцэхээсээ илүү авлигын тухай мэдээллийг үнэлэх, худалдах сонирхолтой, энэ утгаараа ил тод байдлыг хангахаас илүү нууцлалыг нэмэгдүүлэх саналыг түлхүү тавьсан байна.

Авлигатай тэмцэх байгууллагын талаархи олон нийтийн саналыг авахад судалгаанд оролцогчдын 80.5 хувь нь авлигатай тэмцэх тусгай байгууллага байх нь зүйтэй гэж үзсэн байна. 10 дугаар асуудлын хүрээнд оролцогчдын олонхи нь авлига энэ хэвээрээ байна гэсэн хариулыг өгсөн байна.

Энэхүү судалгаагаар нь манай улсад авлига, хээл хахууль хэр зэрэг газар авч байгаа, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байгаа талаар тодорхой санал, дүгнэлт гарсан байна. Тухайлбал, судалгааны дүгнэлтэд тэмдэглэснээр “улс төр, эрх зүй, эдийн засгийн бүлэглэлүүдийн нөлөө, тусгал хууль тогтоох байгууллага, улс төрийн байгууллагуудад авлига аль хэдийн бүрэлдэн бий болсон” гэж үзжээ.

Авлигын үнэн байж болох магадлалыг стандарт сурвалжлагын аргаар илрүүлэхэд дараахь дүр зургийг судалгаанаас гаргасан байна. Үүнд:

- Түгээмэл авлига: дүн тавиулах, эмнэлэгт хэвтэх, үзүүлэх, сургуульд элсэх г.м
- Зах зэлийн авлига: тендерт оролцох, лиценз, хувьчлал, албан тушаал г.м
- Луйврын авлигууд: банкны зээл чанаргүй болгох, гааль, татварынхантай тохиролцох зэрэг. Энэ нь сүүлийн үед нэлээд зохион байгуулалтын шинжтэй болж байгаа тухай мэдээлэл их байдаг
- Завсрын авлига: үлэмж ашигтай шийдвэрийг УИХ, ЗГ-аар гаргуулах, хориотой бараа борлуулах, далд шахалт үзүүлэх, төсөл дээр ажиллах г.м
- Уламжлалт хандив: энэ нь найр наадам хийх замаар хандив цуглуулах, бай шагнал нэрээр авлига өгөх хэлбэр юм.



Авлигын эдгээр төрлийг авч үзэхэд зарим төрлийн авлигын ханш, тоо хэмжээг тэр бүр гаргах боломжгүй байдаг. Энэ нь тухайн асуудал тодорхой нууцлагдмал хүрээлэлд маш сайн зохион байгуулалтад орж байгаагийн илрэл юм. Иймээс хууль тогтоомжийг илүү боловсронгуй болгож мэдээлэгчид урамшуулал олгох, хариуцлагыг өндөржүүлэх зэрэг заалтыг дахин хянаж үзэх нь авлигыг багасгах, таслан зогсооход нэлээд хувь нэмэр оруулна гэж үзсэн байна.

Хоёр. “Монгол дахь ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт” төсөл

Уг төслийн хүрээнд Монгол дахь ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлтийн судалгааг 2003 онд хийж гүйцэтгэсэн ба Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын Олон улсын 5 дугаар Бага хурлын шийдвэрийн дагуу Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгээр хэрэгжүүлжээ. Энэ судалгаа нь ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлтийг боловсруулах асуудлаар Монголд анх удаа хийгдэж байгаа иж бүрэн шинжтэй судалгааны ажил болжээ. Энэ судалгааны ажлын “Авлигын эсрэг үйл ажиллагаа” сэдвийн хүрээнд дараахь асуудлыг авч үзжээ. Үүнд:

- Төрийн албаны сонгууль болон сонгуульд бус ажил үүргийн хүрээг тухайн албан тушаалтны намын харьяалал, хувийн бизнес, гэр бүлийнх нь ашиг сонирхлоос заагласан байдал хэр үр ашигтай үйлчилж байна вэ?
- Албан хаагчид болон ард иргэдийг авлига, хээл хахуульд татагдан орохоос хамгаалсан арга хэмжээнүүд хэр оновчтой, үр дүнтэй байгаа тухай,
- Сонгуулийн кампани, нэр дэвшигч болоод сонгогдсон төлөөлөгчдийг санхүүжүүлэхтэй холбогдсон дүрэм журам нь тэдгээрийг бүлгийн явцуу ашиг сонирхолд автахас хэр зэрэг сэргийлж чадаж байна вэ?,
- Хүчирхэг корпорациуд болон бизнесийн арилжааны томоохон ашиг сонирхлууд олон

нийтийг хамарсан бодлого шийдвэрт зүй бусаар нөлөө үзүүлэх явдлыг хяналтдаа байлгах асуудал хэрхэн зохицуулагдаж байна вэ, тэдгээр нь авлигад өртөх, үүний дотор олон улсын шинжтэй авлигын сүлжээнд татагдан орох явдалтай хэр зэрэг үр өгөөжтэй тэмцэл явуулдаг вэ?,

- Төрийн албан тушаалтнууд болон төрийн үйлчилгээ хүргэгч байгууллагууд авлигад хутгалдаагүй цэвэр байгаа гэдэгт хүмүүс хэр итгэлтэй байдаг вэ?
- Энэ салбарт олон түмний зүгээс гаргаж тавьсан асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ авсан бэ?, Эдгээр арга хэмжээг тэргүүлэх ач холбогдолтой гэж үздэг үү?, Олон нийт хэр дэмждэг вэ? гэсэн асуултуудыг тавьж, үүнийхээ дагуу тухайн асуудлын хүрээн дэх хууль, эрх зүйн орчин хэр боловсронгуй байгаа, хэрэгжилт ба эерэг, сөрөг тал нь ямар байдаг дээр тулгуурлан хийсэн байна.

Судалгааны хууль, эрх зүйн орчны хүрээний хуулийн хэрэгжилтэд юу саад болж байна вэ? гэсэн асуултад иргэд хариулахдаа:

- | | |
|---|-----------|
| • хяналт сул гэж | 43.1 хувь |
| • хариуцлага тооцох явдал хангалтгүй гэж | 31 хувь |
| • албан тушаалтнууд өөрсдөө хууль зөрчдөг гэж | 37.8 хувь |
| • хуулийг эрх мэдэлтнүүд завхруулдаг гэж | 76 хувь |
| • хуулийн хэрэгжилт замхардаг гэж | 67.1 хувь |

нь хүлээн зөвшөөрсөн хариулт өгсөн байна. Энэ нь нөгөө талаас хуулийн уялдаа холбоо, нарийвчлал бага байхтай холбоотойгоор албан тушаалтнууд дур зоргоороо ашиглах, авлигалд автах бололцоог бүрдүүлж байна гэж дүгнэжээ.

Энэ судалгаа нь бүхэлдээ өргөн хүрээг хамарсан, судалгааны олон аргыг хэрэглэн боловсруулснаараа онцлог байна.¹¹ Мөн 2004 онд явуулсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн мониторингийн судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд оролцогчдын дийлэнхи олонхи буюу 88.9 хувь нь Монголд авлига дэлгэрсэн гэж хариулжээ.¹² Харин төрийн албан тушаалтнууд авлигад хамгийн их автагддаг болох нь 2005 оны 9, 10 дугаар сард Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлтийг боловсруулах төслийн хүрээнд явуулсан судалгааны дүнгээс харагдаж байна.¹³

Гурав. Монгол дахь Авлигын асуудалд холбогдох ном зүй

Авлигын асуудлаар хийгдсэн судалгааны бүтээлийн эмхтгэлийг Нээлттэй Нийгэм Форумгаас санаачлан 2005 онд гаргажээ. Уг судалгааны эмхтгэлийг:

- ном товхимол /орчуулгын болон орчуулгын бус/
- эрдэм шинжилгээний судалгаа, тайлан
- хурал, чуулганы илтгэл, мэдээлэл
- ном, сэтгүүлд нийтлэгдсэн нийтлэл

гэсэн ангилалаар түүвэрлэн хийжээ.

Авлига өнөөгийн Монголын нийгмийн хамгийн ноцтой, хамгийн тулгамдсан асуудал болж, улс орны хөгжилд сөрөг нөлөө учруулж байгаа учир авлигатай цаг алдалгүй, шийдвэртэй

¹¹ Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ, /21-р тал/

¹² “Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт” мониторингийн судалгаа УБ 2004.

¹³ АЗШҮБТ-ийн хүрээнд хийсэн социологийн судалгаа УБ 2005.

тэмцэх явдал хамгаас чухал байна. Иймээс “Авилгалын асуудалд холбогдох ном зүй”-г нэгтгэн гаргах явдал чухал ач холбогдолтой гэж эмхтгэгчид нь үзжээ.

Уг ном зүйг С.Баяраа /Зориг сангийн зөвлөх/, Д.Ламжав /”Цэх” төрийн бус байгууллагын тэргүүн/, Н.Баяраа /ШУА-ийн Философи, социологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан/, О.Цэрэннадмид /Зориг сангийн гүйцэтгэх захирал/, Ч.Батбямба /Зориг сангийн төслийн ажилтан/ нарын судлаачид эрхлэн бэлтгэжээ.

Ном зүйг бүрдүүлэхдээ цаг хугацааны хувьд 1990 оноос хойшхи хугацааг хамарсан бөгөөд аль болох олон эх сурвалж ашиглах, хэрэглэхэд дөхөм хэлбэрт оруулах бодлого барьсан байна. Ном зүйд орсон материалуудыг агуулгаар нь:

- Авлигын тухай ерөнхий сэдэв
- Авлига ба засаглал
- Авлига ба иргэний нийгэм
- Авлига ба хувийн хэвшил
- Авлига ба хэвлэл мэдээлэл

гэсэн ерөнхий таван бүлэгт хувааж нэгдсэн дарааллаар байрлуулсан байна.¹⁴

Дөрөв. Төрийн ил тод байдлын эрх зүйн орчин, нийгмийн баялгийн хуваарилалт

Энэ судалгааны хүрээнд төрийн ил тод байдлын зарчим алдагдснаар нийгэмд авлига, хээл хахуулийн сүлжээ, нийгмийн ёс суртахуун, сэтгэхүйн доройтол бий болдог гэдгийг судалгаагаар гаргаж харуулахыг зорьжээ. Ил тод байдал нь ардчиллын тулгуур зарчмуудын нэг бөгөөд засаглалыг бэхжүүлэх, авлигыг хянах, сонирхолын зөрчлийг шийдвэрлэх үр нөлөөтэй хэрэгсэл гэж үздэг. Тийм ч учраас ардчилсан улс орнууд төрийн үйл ажиллагааг ил тод болгоход чиглэсэн эрх зүйн зохицуулалтад ач холбогдол өгдөг. Харин “Монгол Улсын хууль тогтоомжид ил тод байдлын зарчмыг тодорхойлсон, түүний агуулгыг илэрхийлсэн болон хэрэгжилтийг хангасан хэм хэмжээгээр ачаалагдсан эсэх нь тодорхойгүй, ялангуяа нийгмийн баялгийн хуваарилалтын ил тод байдлын талаар дагнасан судалгаа хийгдээгүй байна” гэж уг судалгаанд тэмдэглэжээ.

Судалгаа нь ил тод байдлын зарчим, төрийн үйл ажиллагааг зохицуулсан болон нийгмийн баялгийг хуваарилахтай холбоотой хууль тогтоомжид тусгагдсан байдал, ил тод байдлыг хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилготой юм. Судалгааг дараахь сэдвийн дагуу хийжээ. Үүнд:

- Төрийн ил тод байдлын эрх зүйн үндсийг тодорхойлсон нийтлэг зохицуулалт (Г.Эрдэнэбат)
- Улсын төсвийн зарцуулалтын ил тод байдал (М.Батсуурь)
- Улсын төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах үйл явцын ил тод байдал (М.Батсуурь)
- Газар олголтын ил тод байдал (Г.Эрдэнэбат)
- Ашигт малтмалын лиценз олголтын ил тод байдал (Г.Эрдэнэбат)

Уг судалгаанд тэмдэглэсэнээр:

- Нийтлэг зохицуулалтын хүрээнд төрийн ил тод байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн үндэс ерөнхий байдлаар бүрдсэн боловч төрийн үйлчилгээний анхдагч нэгжид мэдээллийн хүртээмжийг хүргэх арга, журам, баталгаа нь хангалтгүй;
- Хэм хэмжээ тогтоосон дүрэм журам, шийдвэрүүдийг мэдээлэх эрх зүйн орчин бүрдсэн

¹⁴ Хавсралт 2-оос үзнэ үү.

атлаа төрийн байгууллага, албан тушаалтанаас тодорхой асуудлаар гаргасан актыг мэдээлэх талаар эрх зүйн зохих зохицуулалт шаардлагатай байгаа;

- Иргэд, олон нийтэд шаардлагатай мэдээллийг ил тод болгоогүйгээс хуулийн хариуцлага хүлээх зохицуулалт дутмаг;
- Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай хуулиудын зөрчилдөөнтэй зохицуулалтаас үүдэн байгууллага, албан тушаалтан өөрийн дур зоргоор мэдээллийг нууцлах боломжтой байна гэж судлаачид онцолжээ.

* * *

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ АСУУДЛААР ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОЙМ

№	Судалгааны сэдэв (хэзээ хийсэн, хаанаас санхүүжүүлсэн)	Үр дүн, зорилго
	<p>Авлигатай тэмцэх үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт /харьцуулсан судалгаа/</p> <ul style="list-style-type: none"> • 2005 он 11 сар • Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр /НҮБХХ/ 	
	<p>“Авлигатай тэмцэхэд чөлөөт хэвлэлийн үүрэг”</p> <ul style="list-style-type: none"> • 2008.03.24 • Хэвлэлийн хүрээлэнгийн ахлах судлаач Г.Цогтбаатар 	<p>Хэвлэл мэдээллийн хэрэгсэл /ХМХ/-д нийтлэгдэж буй авлигын талаарх мэдээлэл хэр бодитой байгаа ба авлигатай тэмцэхэд ХМХ-ийн үүрэг роль ямар байх, чөлөөт хэвлэл аль нэг нам хүчний харьяаллын хэвлэл хоёрын нийтлэлийн зөрчлийн талаар уг судалгааг хийжээ.</p>
	<p>Монгол улс дахь авлигын байдалд хийсэн үнэлгээ /эцсийн тайлан/</p> <ul style="list-style-type: none"> • 2005.08.31 • Casals & Associates, INC.”, Азийн сан, Вашингтон дахь ОУХА нар хамтран гаргасан • Санхүүжүүлэгч АНУХХА, Азийн сан 	<p>Авлигын эсрэг шинэ хуулийг боловсруулан батлахтай холбоотойгоор уг судалгааг хийжээ.</p>
	<p>Улс төрийн боловсролын академи ба Герман Улсын Конрад Аденаурын сантай хамтран явуулсан авлигын талаархи санал асуулга</p> <ul style="list-style-type: none"> • 1994 оны 8 сар • Улс төрийн боловсролын академи ба Герман Улсын Конрад Аденаурын сан 	<p>Уг санал асуулгын дүнд яам, төрийн байгууллагуудад ажиллаж байгаа албан хаагчид авлигад их автаж байна гэсэн дүгнэлтийг хийжээ. /Үндэсний шударга ёсны тогтолцоо түүний үзүүлэлтүүд ном, 2003 он./</p>

	<p>“Монгол дахь Авлигын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь”</p> <ul style="list-style-type: none"> • 1999 он • Төслийн үндсэн баг болон дэмжих баг гүйцэтгэсэн. Багийн ахлагч доктор, профессор Я.Шуурав • Санхүүжүүлэгч МУ-ын ЗГ, НҮБ -ын Хөгжлийн хөтөлбөр 	<p>Судалгааны зорилго нь МУ-ын Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр боловсруулахад ашигласан¹</p>
	<p>“Авлигын талаарх олон нийтийн санаа бодол, байр суурь 1999-2002” харьцуулсан судалгаа</p> <ul style="list-style-type: none"> • НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөр / тайланг тус хөтөлбөрөөс бүрэн эхээр нь авах боломжтой • Санхүүжүүлэгч Монгол Улсын ЗГ, НҮБ-ийн “Сайн засаглал хөтөлбөр” 	<p>МУ-ын Авлигын эсрэг хуулийг шинэчлэн батлах</p> <p>/Авлигын эсрэг хууль болон Үндэсний хөтөлбөртэй болсон хэрнээ нэг их ахиц дэвшил байхгүй байсан тул Авлигын эсрэг хуулийг шинэчлэн батлах шаардлага байсан/</p>
	<p>Бизнес эрхлэгчдийн дунд хийсэн авлигын талаархи судалгаа</p> <ul style="list-style-type: none"> • 2000-2003 • Монголын Үндэсний Худалдаа, Аж үйлдвэрийн танхим /МҮХАҮТ/ • Санхүүжүүлэгч МҮХАҮТ, Соросын сан 	<p>3 жилийн хугацатай төсөл хэрэгжүүлж, Авлигын индексийн судалгаа гаргасан. Улс төрийн хүрэн дэх авлига зэрэг судалгааг гаргах оролдлого хийсэн /Соросын сангаас судалгааг бүрэн эхээр нь авах боломжтой/</p>
	<p>Монгол дахь авлигын эсрэг тэмцэлд дэмжлэг үзүүлэх төсөл</p> <ul style="list-style-type: none"> • ирэх 3 жилд • Азийн сан болон АНУ-ын ОУ-ын Хөгжлийн агентлаг • Санхүүжүүлэгч Азийн сан, USAID 	<p>Монгол Улс Транспэранси Интернэшнлийн Авлигын индекст 3.0 оноотойгоор Армен, Мадагаскар, Румынь улсуудтай зэрэгцэн 85-р байранд явж байна. Уг төслийн үр дүнд Монгол Улсыг эхний 75-д багтахар ажиллана.</p>
	<p>“Үндэсний шударга ёсны үнэлгээ”</p> <ul style="list-style-type: none"> • 2001 он • Ардчилсан засаглалын институцуудын чадавхийг дээшлүүлэх төслийн үндэсний зохицуулагч, судлаач Ж.Оюунтуяа • Санхүүжүүлэгч Ардчилсан засаглалын институциудын чадавхийг бэхжүүлэх төсөл, НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөр 	<p>Монголын төр засгийн шударга байдлыг бий болгох, дээшлүүлэх, хангах чиглэлээр ямар ч байгууллага зохицуулалт байхгүй байна гэсэн дүгнэлтийг гаргажээ.</p>
	<p>Монголын засаглалын үнэлгээ</p> <ul style="list-style-type: none"> • 2004 он • Хайлт хийгээд олоогүй, Азийн Хөгжлийн банкинд хандах • Санхүүжүүлэгч Азийн хөгжлийн банк /АХБ/ 	

	<p>Шүүхийн системийн төсөөлөл</p> <ul style="list-style-type: none"> • 2001, 2003, 2005 • Сант марал төвөөс тайлан авах боломжтой • Санхүүжүүлэгч <p>Сант марал</p>	
	<p>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, авлигатай тэмцэх талаарх олон нийтийн санаа бодол</p> <ul style="list-style-type: none"> • 2004 он • Социологийн академи, судалгааны багийн ахлагч Д.Ганхуяг 	
	<p>Азийн сангийн судалгаа</p> <ul style="list-style-type: none"> • 2007- 2008 • Сант марал төвийн тогтмол судалгаа, 6 удаа явагдсан 	Захиргааны авлига, өрхийн судалгаа
	<p>Улс төр, хууль хяналтын байгууллагын шинжээчийн судалгаа</p> <ul style="list-style-type: none"> • 2008 • ШУА-ийн Философи, Социологийн эрхийн хүрээлэн • Санхүүжүүлэгч Мянганы хөгжлийн зорилтын /МХЗ/ Хүний эрх, Ардчилсан засаглалыг бэхжүүлэх төслийн хүрээнд хийгдсэн 	МХЗ-ийн Хүний эрх, Ардчилсан засаглалыг бэхжүүлэх төслийн хүрээнд хийгдсэн судалгаа
	<p>Монгол улсын авлигын тандалтын судалгаа</p> <ul style="list-style-type: none"> • 2008 он • АТГ-ын судалгаа шинжилгээний алба 	Авлигын эсрэг хуулийн 18.1.3-р зүйлийг хэрэгжүүлэхэд анхдагч мэдээлэл цуглуулах зорилгоор хийгдсэн тандалтын судалгаа. Танилцуулга нь АТГ-ын цахим хуудсанд.
	<p>“Монгол дахь авлигын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь”</p> <ul style="list-style-type: none"> • 1999 он • Хөтөлбөрийн хүрээнд доктор, профессор Я.Шуурав, П.Увш, доктор, дэд профессор Р.Вандангомбо, Х.Гүндсамбуу нарын 27 эрдэмтэн, судлаач 	Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд хийсэн. Уг судалгаа нь анх удаа улсын хэмжээнд өргөн хүрээг хамран явагдсан, судалгааны үр дүн авлигын эсрэг төрийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтэнд шууд хэрэглэх боломжоор хангагдсанаараа давуу талтай юм.

	<p>“Үндэсний шударга ёсны системийг сайжруулах” төсөл</p> <ul style="list-style-type: none"> • 2005 он • “Үндэсний шударга ёсны системийг сайжруулах” төсөл, Гадаад хэргийн яам • Санхүүжүүлэгч АТҮХХАЗХТҮЗ болон НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөрөөс хамтран 	<p>Уг төслөөс “Монгол Улс ба Авлигын эсрэг НҮБ-ын Конвенци” сэдэвт семинар зохион байгуулж байгаатай холбогдуулан уг конвенцийг орчуулах ажлыг зохион байгуулсан.</p>
	<p>“Монгол дахь ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт” төсөл</p> <ul style="list-style-type: none"> • 2003 он • Төслийн судалгааг Үндэсний судлаачдын баг гүйцэтгэсэн • Санхүүжүүлэгч Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын ОУ-ын 5-р Бага хурлын шийдвэрийн дагуу Монгол Улсын ЗГ, НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн 	<p>Энэ судалгаа нь ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлтийг боловсруулах асуудлаар Монголд анх удаа хийгдэж байгаа иж бүрэн шинжтэй судалгааны ажил. Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтын ес дэх зорилт болгон ардчилсан засаглал, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хүний эрх, авлигатай тэмцэх асуудлыг нэмж УИХ-аар баталсан нь энэ судалгааны ач холбогдлыг нэмэгдүүлсэн.</p>
	<p>Авлигатай тэмцэх үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт /харьцуулсан судалгаа/</p> <ul style="list-style-type: none"> • 2005 • НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөрийн Бангкок дахь бүсийн төв, Монгол дахь НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөр болон Хөгжлийн бодлогын товчооны Ардчилсан засаглалын бүлгийн судлаачид • Санхүүжүүлэгч НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөр 	<p>Энэ судалгаа нь 2 үндсэн хэсгээс бүрдэнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Ерөнхий тойм ба бодлогын зөвлөмж 2. Улс орнуудын тойм илтгэл <p>1-р хэсэгт:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигатай үр дүнтэй тэмцэх байгууллагын ач холбогдол • Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц болон авлигатай тэмцэх бүтэц, зохион байгуулалтын тухай • Авлигатай тэмцэх тусгай байгууллага буюу комисс • Авлигатай тэмцэхэд оролцдог бусад байгууллага • Авлигатай тэмцэх тусгай байгууллагагүй орнууд • Зохицуулалт гэсэн бүтэцтэй. <p>Энэхүү судалгаагаар янз бүрийн улс орны авлигатай тэмцэх байгууллагын бүтэц, зохион байгуулалтад дүн шинжилгээ хийжээ. Гэхдээ Авлигатай тэмцэх байгууллага байгуулснаар энэ асуудлыг шийдвэрлэх боломжгүй ба цогц эрх зүйн орчинд, төрийн дээд түвшний дэмжлэгийг авч байх шаардлагатай. Мөн эдийн засгийн хангалттай бааз суурьтай байж, авлигын хэргийг бүх шатанд мөрдөн шалгах боломжтой байх үүднээс хараат бус, хүн хүч, техник, зохион байгуулалтын нөөцтэй байх, түүнчлэн маш өндөр түвшний ёс зүйн хэм хэмжээ бүхий удирдлага дор ажиллах зэрэг зохион байгуулалтын талаас нь байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулах, бодлого хэрэгжүүлсний үр дүнд уг асуудлыг хүлээн зөвшөөрч болохуйц боломжтой түвшинд барьж байх боломжтой гэсэн дүгнэлтийг гаргажээ.</p>

<p>“Үндэсний шударга ёсны тогтолцоо, түүний үзүүлэлтүүд” ном</p> <ul style="list-style-type: none"> • 2003 он • НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөрөөс гэрээлсэн үндэсний мэргэжилтнүүд, Монгол Улсын ЗГ-ын ХАБХСЗХөтөлбөр <p>Санхүүжүүлэгч Монгол Улсын Засгийн газар Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийг / ХАБХСЗХ/ дэмжих төсөл, НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөр</p>	<p>Энэхүү номыг тус хөтөлбөрийн хүрээнд Шударга ёсны тогтолцооны нийтлэг шалгуур үзүүлэлтүүдийг иш үндэс болгон боловсруулжээ. Энэ нь:</p> <ul style="list-style-type: none"> • Хууль тогтоох байгууллага • Гүйцэтгэх засаглал • Шүүх засаглал • Чөлөөт шударга сонгууль • Ерөнхий аудит • Төрийн алба • Омбудсман • Хэвлэл мэдээлэл • Хоточ нохой • Иргэний нийгэм • Хувийн хэвшил • Нутгийн удирдлага • Авлигын эсрэг хууль тогтоомжууд • Авлигын талаархи олон нийтийн санал бодлын судалгааны тойм юм. <p>Засаглалын талаархи өнөө үеийн анхаарал татсан асуудлууд болох чадавхи бэхжүүлэх үр бүтээлд илүү анхаарал тавих, олон түмний оролцоог дээшлүүлэх үндэсний шударга ёсны тогтолцоог хөхүүлэн дэмжих зэрэг бүх асуудлууд нь цогцолбор хүрээнд нэгэн зэрэг тавигдаж шийдэгдэх нь зүйтэй гэсэн байр суурин дээр өнөөгийн шударга ёсны тогтолцооны хандлага тулгуурладаг. Иймээс нийт зорилтын хүрээнд дараахь арга хэмжээ авах ёстой: Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төр засгийн байгууллагын үйлчилгээнд үр ашигтай байх ёстой ба тухайн нийгэм эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд нэмэр хандив оруулдаг байх • Төрийн байгууллага нь хуулийн хүрээнд ажиллах, ингэснээрээ иргэддээ дураар авирлах явдал /хүний эрх зөрчих явдлаас/ хамгаалдаг байх <p>Улс орныг хөгжүүлэх стратеги нь улс үндэстний хувьд ашиг тустай байх ёстой. Өөрөөр хэлбэл зөвхөн түүний хэлхээ холбоо багатай, танил талтай элит хүрээнд ашигтай байх бус хамгийн ядуу эмзэг бүлгийнхэнд ч бас адил ашигтай байх ёстой гэж үзсэн байна.</p>
--	--



	<p>Судалгаа юун тухай өгүүлж байна вэ?²</p> <ul style="list-style-type: none"> • 2003 он 	<p>Уг судалгааг анкет, сурвалжлагын аргаар хийсэн байна.</p> <p>Судалгаанд оролцогчдын дунд явуулсан судалгааны асуултын заримаас тоймлон үзэж, хууль тогтоох засаглалд хамаарах асуултад:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуультай болсноор хэдэн жил болсон ч түүний хэрэгжилт ямар байна вэ? гэсэн асуултад, • хууль батлагдаад 3 жил болж байгаа ч уг хуулийн талаархи олон нийтийн мэдлэг, төсөөлөл нэн хангалтгүй буюу 56.2 хувь нь мэдэхгүй гэсэн байгаа нь авлига газар авахад нөлөөлсөн нэг хүчин зүйл болж болох юм. Харин ерөөсөө хэрэгжээгүй гэж 54.4 хувь нь буюу 820 хүн хариулжээ. <p>Энэ нь манай улсад эрх зүйн сургалт сурталчилгаа хоцрогдонгуй байгааг харуулж байна гэж үзжээ. Харин гүйцэтгэх засаглалын хүрээнд дээрх асуудлыг мөн анкет, сурвалжлагын аргаар авсан байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Далд шахалт үзүүлэх, томоохон төсөл дээр ажиллах, хориотой бараа борлуулах, үйлчилгээ эрхлэх, үлэмж ашигтай улс төрийн шийдвэрийг УИХ, ЗГ-аар гаргуулах, үйлчилгээний маягаар шан харамж авах зэрэг багтаж эдгээрт тодорхой ханш байдаг тухай тоон үзүүлэлтийг гаргасан байна. <p>Жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> • албан тушаал ахихад 200 мянгаас доошгүй, • томоохон албан тушаал 10-20 сая г.м
--	--	---

* * *



**Монгол дахь авлигын асуудалд холбогдох ном зүй
эмхтгэлд орсон бүтээлийн тойм – 1Хавсралт 2**

№	Судалгааны сэдэв	Үр дүн, зорилго
	<p>“Хүний эрхийн төлөв байдал”-ын судалгаа</p> <ul style="list-style-type: none"> • 2001 • Уг номыг Монголын ХЭҮК бэлтгэн, НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөр, Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар (ХЭДКГ)-ын хамтарсан МОН/01/103 төслийн хүрээнд, 2003 онд “Хаан Принтинг” ХХК-д хэвлүүлжээ. • Санхүүжүүлэгч НҮБ-ын санхүүжилтээр хийгдсэн “Хүний эрхийн үндэсний хөтөлбөр боловсруулах” төсөл 	<p>НҮБ-ын санхүүжилтээр “Хүний эрхийн үндэсний хөтөлбөр боловсруулах” төслийн хүрээнд 2001 оны 5-аас 8-р сард хийгдсэн “Хүний эрхийн төлөв байдал”-ын судалгаа нь уг илтгэлийн суурь болсон ажээ. Энэхүү судалгааг нийслэл болон бүх аймагт, 127 сум, 8822 өрх, 579 аж ахуйн нэгж байгууллага, 60 шахам мянган иргэдийг хамруулан хийжээ. Уг судалгааны дүнг 2001 онд Олон Улсын Хүний эрхийн өдрөөр олон нийтэд зориулан хэвлүүлэн тараажээ.</p>
	<p>“Авлигын эсрэг сурвалж бичиг” /монгол, орчуулга 450 хуудас/</p> <ul style="list-style-type: none"> • 2000 он • Транспаренси Интернейшнл (ТИ) олон улсын ТББ-аас эрхлэн гаргасан (TI Source Book 2000, “Confronting Corruption: The Elements of a National Integrity System”) хэмээх номыг бичиж боловсруулах ажлыг ТИ-г үндэслэгч бөгөөд авлигын талаархи мэдээлэл, мэдлэгийн менежментийг хариуцагч Жереми Поуп /Jeremy Pope/ хариуцан гүйцэтгэсэн аж. • Санхүүжүүлэгч Энэ номыг 2003 онд Монголын Засгийн газрын Хүний Аюулгүй байдлыг Хангах Сайн Засаглал Хөтөлбөр (ХАБХСЗ) - ийг дэмжих төслийн хүрээнд Монголын судлаач, шинжээчдийн оролцоотойгоор, НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилтээр, монгол хэлнээ хөрвүүлэн хэвлэжээ. 	<p>Энэхүү номоос, дэлхий даяар өрнөж буй Авлигын эсрэг тэмцэлд оруулж ирсэн “Үндэсний шударга ёсны тогтолцоо” хэмээх цоо шинэ үзэл баримтлалтай танилцах, мөн дэлхийн олон улсад хэрэгжүүлж байгаа шинэ санаачлага, шинэ туршлагаудын талаар мэдээлэл авах боломжтой. Номын эхийг ТИ-гийн http://www.transparency.org вэб сайтад байрлуулсан. Тус ном нь авлигын эсрэг сэдвийг бүх талаас нь бүрэн дүүрэн тусгасан байна.</p>



	<p>Хүний Аюулгүй байдлыг Хангах Сайн Засаглал Хөтөлбөр (ХАБХСЗ),</p> <ul style="list-style-type: none"> • 2003. • “Үндэсний шударга ёсны тогтолцоо, түүний үзүүлэлтүүд” • Монголын Засгийн газрын ХАБХСЗ хөтөлбөрийг дэмжих төсөл хариуцан Номын “Үндэсний шударга ёсны тогтолцоо” (ҮШЁТ) хэмээх эхний бүлэг, “Үндэсний шударга ёсны тогтолцооны үзүүлэлтүүд” хэмээх эцсийн бүлэг хоёроос бусдыг НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөрийн гэрээлсэн Монголын 15 мэргэжилтэн боловсруулсан байна. • Санхүүжүүлэгч НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилтээр 	<p>Уг судалгааг Шударга ёсны тогтолцооны нийтлэг шалгуур үзүүлэлтүүд болох дараахь шалгууруудыг иш үндэс болгон боловсруулжээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хууль тогтоох байгууллага • Гүйцэтгэх засаглал • Шүүх засаглал • Чөлөөт шударга сонгууль • Ерөнхий аудит • Төрийн алба • Омбудсман • Хэвлэл мэдээлэл • Иргэний нийгэм • Хувийн хэвшил • Нутгийн удирдлага • Авлигын эсрэг хууль, тогтоомжууд • Авлигын талаархи олон нийтийн санал бодлын судалгааны тойм.
--	---	---

* * *

**Монгол дахь авлигын асуудалд холбогдох ном зүй
эмхтгэлд орсон бүтээлийн тойм - 2**

Хавсралт 3

№	Судалгааны сэдэв	Огноо	Зохиогч
	Ардчиллыг танилцуулахуй: 80 асуулт, хариулт	2005 он	Дэвид Бийтхам, Кевин Бойел товхимол
	Иргэн түншлэгч болох нь: Бодлого боловсруулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг оролцуулах	2003 он	Марк Грамбергер Ш.Ганболд, Г.Наран нарын орчуулга
	Европын холбоонд элсэх үйл явцыг хянах нь: Европын холбоонд шинээр элсэн орсон Зүүн Европын гурван улсын авлига ба авлигатай тэмцэх бодлого	2004 он	Орчуулгын ном
	Монгол дахь ядуурлын асуудалтай холбогдох ном зүй	2004 он	Б.Сувд ахлагчтай МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн баг

“Иргэний нийгмийн байгууллагад холбогдох хууль тогтоомж, УДИРДАМЖ”	2004 он	Леон Е.Айриш., Роберт Кушен, Карла В.Саймон орчуулгын товхимол
Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхтгэл	2005 он	Орчуулгын эмхтгэл
“Нийгмийн хариуцлага: Үзэл баримтлал, шинээр гарч буй практик”	2004 он	Кармен Малена, Райнер Форстер, Жанмежэй Сингх
Хяналт-шинжилгээ, үнэлгээ: Шалгуур үзүүлэлт, явц, үр дүн	2002 он	Эмхтгэл
“Ардчилалд үнэлгээ өгөх гарын авлага”		Дэвид Бийтхэм, Сара Брекин, Лейэн Кейртон, Стюарт Вейр
Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхтгэл	2003 он	Орчуулгын ном
Үр нөлөө бүхий бодлогын баримт бичиг боловсруулах нь	2003 он	Еоин Янг, Лиза Квин орчуулгын ном
Авлига түүний тухай ойлголт, тэмцэх арга зам	2000 он	Зориг сангаас гаргасан семинарын эмхтгэл
Mongolian National Program for Combating Corruption		Монгол, англи хэл дээр
Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт мониторингийн судалгаа	2004 он	Д.Ганхуяг ахлагчтай судлаачдын баг Монгол, англи хэл дээр
Төрийн албаны талаархи хууль, эрх зүйн актын эмхтгэл	2002 он	Ванчингийн Удвал
Human Rights and Freedoms in Mongolia, Status Report	2003 он	www.oecd.org/dat/asiacom/stocktaking.htm англи хэл дээр
Report on Human Rights and Freedoms in Mongolia 2004	2003 он	Англи хэл дээр
Report on Human Rights and Freedoms in Mongolia 2005; Ulaanbaatar, 2005, NHRC of Mongolia	2005 он	Англи хэл дээр
Авлигын эсрэг цуврал уулзалт, ярилцлагын товч тэмдэглэл, эмхтгэл	2003 он	Засгийн газрын ХАБХСЗ хөтөлбөр
Авлигын эсрэг Үндэсний Бага Хурал	2003 он	Засгийн газрын ХАБХСЗ хөтөлбөр



Монгол Улсын Засгийн газрын “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”-ийн бодлогын баримт бичиг	2001 он	Эмхтгэл
Засаглалын нэр томъёоны тайлбар	2003 он	Засгийн газрын ХАБХСЗ хөтөлбөр
Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль-2004	2004 он	Р.Бурмаа, С.Оюунтуяа
Эйн Рэнд, Зөвшилцлийн засаг бол шинэ фашизм мөн	2005 он	Д. Энхзаяа
Төрөө завхруулж, түмнээ хуурсан шаштир- 1, шаштир-2	2003 он	Ж.Нэргүй
Авлигын эсрэг хуулийн төслүүд	1996-2001	Монгол, англи хэл дээр
Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр	2002 он	УИХ-ын тогтоол
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл	1999-2000	УИХ-ын архивын хавтаст материал
Авлигын эсрэг тэмцэх Монгол Улсын үндэсний төлөвлөгөөний баримт бичиг”	1998-2000	УИХ-ын архивын хавтаст материал
“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн баримт бичиг”	1998-2000	УИХ-ын архивын хавтаст материал
Олон улсын Бизнесийн үйл ажиллагаанд гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдах явдалтай тэмцэх тухай Конвенци (товчоор, OECD-гийн конвенци	1997.5.23	НҮБ-ын Конвенцийн орчуулга
Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр	2005 он	Эмхтгэл 1, 2
Монгол дахь авлига, түүнтэй тэмцэх арга зам	2000 он	Б.Наранбаатар Эрдэм шинжилгээний өгүүлэл
Монголд авлига хар тахал болтлоо хүчирхэгжсэний шалтгаан, түүний хор уршиг	2002 он	В.Алтантүлхүүр Эрдэм шинжилгээний илтгэл
Албан тушаал, хээл хахуулийн гэмт хэргийн байдал, цаашид анхаарах асуудал	2000 он	С.Болдбаатар Эрдэм шинжилгээний илтгэл
Авлигатай тэмцэх эрүүгийн эрх зүйн асуудал	2004 он	Р.Ганболд Магистрийн ажил, монгол, хураангуй англи хэлээр

	Коррупцийн ойлголт, мөн чанар	1995 он	О.Баттулга Эрдэм шинжилгээний нийтлэл
	Авлигын мөн чанар, түүний үр дагаврын асуудал	2003 он	Б.Алтансүх Эрдэм шинжилгээний нийтлэл
	Бизнесийн салбар дахь авилгал	2000 он	МҮХАҮТ Судалгааны тайлан
	Авлигын индекс	2002 он	МҮХАҮТ Судалгааны тайлан
	Улс төрийн хүрээний авлигын индекс	2002 он	МҮХАҮТ Судалгааны тайлан
	Авлигын эсрэг тэмцэлд хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоог эрчимжүүлэх нь	2003 он	МҮХАҮТ Төслийн эцсийн тайлан
	Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх нь	-	Хүний эрхийн боловсролын төвөөс гаргасан зөвлөмж
	Авлига ба төрийн албан хаагчид	2001 он	Зориг сан Төслийн тайлан монгол, англи хэл дээр
	Эрэн сурвалжлах сэтгүүл зүй	2001 он	Зориг сан Төслийн тайлан монгол, англи хэл дээр
	Өнөөдөр эсвэл хэзээ ч...	2002 он	Зориг сан Төслийн тайлан монгол, англи хэл дээр
	Авлигын эсрэг тэмцэх Монгол Улсын үндэсний төлөвлөгөө		Жон Куа Тайлангийн орчуулга
	Авлигын эсрэг тэмцэх үндэсний хөтөлбөр		Де.Спевилли Тайлангийн орчуулга
	Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа хөтөлбөрийн үр дүн, цаашдын хандлага; Outcomes of community policing program and future tendencies,	2005 он	Тайланг М.Хоролсүрэн, Л.Янжмаа нар боловсруулсан. Монгол, англи хэл дээр
	Сайн засаглал	2003 он	Судалгааны баг: Ш.Батсүх, Б.Батхүү, С.Ганболд, Ч.Тунгалаг, Ц.Даваадорж, Д.Цолмон - Судалгааны тайлан
	2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг	2004 он	Сонгогчдын боловсрол төв, Глоб Интернетшл, Нээлттэй нийгэм форум ТББ-ууд Судалгааны тайлан

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нээлттэй байдал-иргэдийн оролцоо	2001 он	“Нийгмийн дэвшил-Эмэгтэйчүүд” хөдөлгөөн Судалгааны тайлан
Монгол улс дахь авилгалын байдалд хийсэн үнэлгээний тайлан	2005 он	АНУ-ын ОУХА Үнэлгээний тайлан англи (хураангуйг монгол) хэлээр
Улсын Их Хурлын сонгууль-2004	2004 он	Р.Бурмаа, С.Оюунтуяа Гарын авлага
Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл	2002 он	ХЭҮК-ийн илтгэл

* * *

Хүнд суртлын асуудлаар хийгдсэн судалгааны бүтээлийн тойм

Энэ асуудлын хүрээнд 2000 оноос хойш хийгдсэн 4 судалгааг сонгон авч судалж үзэв. Эдгээр судалгаа нь төрийн эрх мэдлийг урвуулан ашиглах, ил тод байдлыг хангах асуудлыг голлож хөндсөн байна. Судалгааны ажлыг тоймлон дүгнэвэл:

Нэг. Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг авах арга хэмжээ

Уг судалгааг Нээлттэй нийгэм форумын санхүүжилттэй судлаач С.Баяраа 2005 онд хийж гүйцэтгэсэн байна. Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг арга хэмжээг илүү боловсронгуй болгосноор төрийн эрх мэдлийг урвуулан ашиглах явдал багасч улмаар иргэдийн төрд итгэх итгэл сэргэнэ” гэсэн таамаглалыг судалгааны үндсэн таамаглал болгосон байна.

Судалгааны ажлын бүтээл нь:

1. Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглах зарим төрлүүд
2. Одоо үйлчилж байгаа хэм хэмжээ
3. Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглах боломжийг бүрдүүлж буй шалтгаанууд
4. Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахад авах арга хэмжээ
5. Хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх талаар
6. Бодлогын зөвлөмж гэсэн үндсэн бүтэцтэй бөгөөд үндсэн хөндсөн сэдэв нь дотроо дэд сэдвүүдэд хуваагдсан байна.

Уг судалгааны хүрээнд судлаач төрийн эрх мэдлийн урвуулан ашиглаж буй байдлыг хууль тогтоомж, олон нийтийн санал асуулга, төрийн байгууллагуудын төлөв байдлаар харьцуулсан судалгаа зэргийг нэлээд өргөн ашиглаж үндсэн 10 бодлогын зөвлөмж гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг дор бүр нь дэд зөвлөмжид тусгаж асуудлыг олон талаас нь судалж шинжилсэн байна. Мөн зөвлөмжүүд нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг үндэслэлтэй, дэлгэрэнгүй, хэрэгжүүлэх субьекттэй гаргасан нь оновчтой болжээ.

Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглах зарим төрөлд судлаач төрийн албанд томилох, авч ажиллуулахад улс төрийн ивээл үзүүлэх, төрийн албанд төрөл садан, танил талаа татах зэргийг хамааруулсан байна. Үнэхээр үүний хүрээнд Монгол Улсад болж өнгөрсөн сонгууль бүхний дараа төрийн албан хаагчдыг улс төрийн шалтгаанаар хоморголон халж, бий болсон орон тоонд нь мөн л улс төрийн үндэслэлээр /тухайн намд үнэнчээр зүтгэгч

гишүүн, дэмжигч/ ажилд авдаг уламжлал тогтсон бөгөөд уг асуудалд нам бусууд элбэг өртдөг тухай судалгаанд тусгасан байна. Судалгаанд Монголын нийгэмд улс төрийн ивээл үзүүлэх, төрөл садан, танил талаа татах гэсэн үзэгдлүүд өөр хоорондоо холилдсон болохыг мөн Монгол Улс хүн ам цөөтэй, тархай бутархай, засаг захиргааны олон нэгжтэй байгаа нь ялангуяа хөдөөгийн сумын түвшинд төрийн албанд төрөл садны хүмүүс нэг дор ажиллах явдлыг эрхгүй бий болгодгийг тодорхой харуулсан байна.

Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглах боломжийг бүрдүүлж буй шалтгаануудад ерөнхийд нь хууль тогтоомж тодорхой бус, уялдаа муутай, зөрчилдөөнтэй, хууль хэрэгждэггүй, төр засгийн ил тод байдал хангалтгүй, түүхэн соёл, уламжлал болон олон нийтэд үйлчлэх төрийн албаны туршлага бага, иргэд, иргэний нийгмийн байгууллага, захиргааны эрх мэдлийг урвуулан ашигласан албан тушаалтан, актыг шүүхэд өгөх туршлага бага, ийм соёл бий болоогүй зэргийг хамааруулсан байна. Судалгааны хүрээнд судлаач нийт 10 чиглэлийн хүрээнд бодлогын зөвлөмж гаргасан байна.

Нэгдүгээрт, Төрийн удирдлагад шинэлэг бодлого, хэм хэмжээг оруулж ирэх асуудлын хүрээнд:

- Төрийн албаны шинэчлэлийг эрчимтэй хэрэгжүүлж ард түмэнд жинхэнэ ёсоор үйлчилдэг болгохын тулд сэтгэлгээний шинэ хандлагыг төлөвшүүлэх.
- Төрийн эрх мэдлийг хэрэглэхтэй холбогдсон эрх, үүрэг, хариуцлага, дэг журмыг ойлгомжтой, тодорхой, нарийвчлан заасан зохицуулалтууд /хууль, хуулийн үйлчлэл бүхий журам/ бий болгох. Аль нэг албан тушаалтан бусдын бүрэн эрхэд хамаарах асуудлаар чиглэл өгдөг явдлыг болиулах. Сонгууль болгоны дараа Засгийн газрын бүтцийн өөрчлөлт хийдгийг бүх түвшинд хуулиар хориглох /хийсэн ч тэр нь бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа үйлчлэхээр хуульчлах/.
- Ашиг сонирхлын зөрчлийг нарийвчлан тодорхойлсон заалтуудыг хуулинд бий болгох, түүнээс урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох.
- Төрийн албанд сонгон шалгаруулах үйл явцыг ил тод болгож түүнд хөндлөнгийн /иргэний нийгмийн/ хяналт бий болгох.
- Ёс зүй болон авлигатай тэмцэх талаар мэдлэг олгох сургалтыг төр засгийн бүх түвшинд тогтмол явуулах.
- Төрийн үйлчилгээний стандартыг бий болгох, төрийн үйлчилгээ үзүүлэгчдийн дунд өрсөлдөөн бий болгох, үнэлгээг нь үйлчлүүлэгчдийн санал асуулгаар тодорхойлох.
- Иргэдийг төр засагтай харьцах тал дээр боловсруулах /захиргааны болон шүүхийн гомдол гаргах гэх мэт/. Төрийн болон төрийн бус байгууллагын дэргэд “Иргэдэд Үйлчлэх төв”-үүдийг олноор байгуулж өргөдөл, гомдол гаргах, шүүхэд хандахад нь туслах.
- Төрийн албан хаагчдыг шударгаар ажиллуулах хөшүүргүүдийг /үүнийг уламжлал томъёоллоор “нийгмийн хамгаалалт” гэж нэрлэдэг/ бодитой бий болгох. Төрийн албан хаагчийг авлигаас хөндийрүүлэхэд тэдний нийгмийн асуудлыг шат дараатай шийдвэрлэхдээ төрөөс үзүүлж буй хөнгөлөлт, урамшуулал нь тэдний шударга үйл ажиллагаатай шууд хамааралтай байхаар зохицуулах /орон сууцны зээл, хүүхдийн сургалтын төлбөр гэх мэт/ тухай зөвлөмж.

Хоёрдугаарт, Хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, хэрэгжих механизмыг сайжруулах хүрээнд:

- Төрийн эрх мэдэлтэй холбоотой хууль эрх зүйн заалтуудыг ойлгомжтой, нарийвчлан боловсруулж эрх мэдлээ урвуулан ашиглах боломж олгосон хуулийн цоорхойг арилгах. Үүний тулд эхний ээлжинд засаж өөрчлөх, шинэчлэх, цуцлах, хүчингүй болгох хууль, хуулийн заалтын “тооллого” явуулж, жагсаалт гаргах.
- Төрийн эрх мэдлийг урвуулан ашигласан тохиолдолд хуульд заасан шийтгэлийг

бодитоор оногдуулдаг болох /торгууль оногдуулах, ажлаас халах/, шаардлагатай зарим тохиолдолд чангатгах /ялангуяа торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх/.

- Хууль тогтоомжийг хэрэглэгчдэд хэрэглэхэд дөхөм, ойлгомжтой, тодорхой болгохын тулд стандартыг шинэчлэх.
- Авлигын эсрэг Хараат бус комиссын тухай хуулийг батлах.

Гуравдугаарт, Төрийн үүргийг шилжүүлэх хүрээнд шударга өрсөлдөөний зарчимд тулгуурлан хувийн болон төрийн бус байгууллагад төрийн зарим үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх. Энэ талаар хууль гаргах асуудлыг дэвшүүлэн тавьжээ.

Дөрөвдүгээрт, Ил тод байдлыг нэмэгдүүлэх хүрээнд:

- Иргэдэд шууд үйлчилдэг төрийн байгууллага бүрт тухайн үйлчилгээтэй холбоотой хууль, дүрэм, журам, зааврыг ил тод байрлуулах заавал биелүүлэх хуульчилсан журмыг бий болгож мөрдүүлэх. Энэхүү журмыг зөрчсөн байгууллагад хуулийн дагуу шийтгэл оногдуулдаг болгох. Мөн энэ тухай мэдээллийг байгууллага бүрт байрлуулах.
- Орлогын мэдүүлгийг төрийн бүх дээд, дунд шатны албан хаагчдын хувьд заавал гаргадаг, тэр нь нийтэд нээлттэй байх. Улс төрийн нам, сонгуульд хандивласан байдлыг мөн мэдүүлж байх
- Төрийн бүх үйл ажиллагааг илүү ил тод болгох, үүнд: төрийн албанд томилох, ажиллуулах, лиценз зөвшөөрөл олгох, бараа үйлчилгээ худалдан авах, албан татварын багц хууль гэх мэт.
- Төрийн албатай холбоотой бүх дүрэм журмыг нээлттэй байлгах
- Төрийн нууцын жагсаалтыг хамгийн ноцтой, зайлшгүй нууцлах зүйлээр хязгаарлаж хүрээг нь хумих
- Электрон засаглалтай болох, иргэдийн өргөдлийг /үүнд төрөл бүрийн зөвшөөрөл, лиценз багтана/ онлайн хүлээн авч боловсруулдаг дэг журам бий болгох,
- Төрийн бүх мэдээллийг интернетэд байрлуулах.

Тавдугаарт, Бодлого боловсруулах, шийдвэр гаргахад иргэдийг оролцуулах хүрээнд:

- Мэдээлэл бүрэн, бодитой, итгэж болох, олоход хялбар, ойлгоход хялбар байх.
- Төрийн албан тушаалтан болон байгууллагатай харьцах, тэдний зүгээс иргэдийн эрх ашгийг хохироосон тохиолдолд хэрхэх талаар иргэдэд мэдлэг боловсрол олгох. Үүний тулд иргэдэд зөвлөгөө өгөх төвүүдийг төрөөс болон ТББ-аас олноор ажиллуулах
- Иргэдтэй зөвлөлдөх үйл явц нь төр засгаас иргэдийн оруулж байгаа саналуудыг ажил хэрэг болгохуйцаар зохион байгуулагдсан, зорилго нь тодорхой, хугацаа нь хязгаартай байх.
- Иргэдийн оролцоог хангахын тулд тэдэнд саналаа гаргах хангалттай хугацаа өгөх, уян хатан байх, төр засгийн бодлого боловсруулахад саналуудыг хамруулан тусгах механизм байх.

Зургаадугаарт, Мэдээлэл олж авах, мэдээлэх боломжийг нэмэгдүүлэх хүрээнд:

- Төрийн албаны тухай мэдээллийг олж мэдэхэд шаардагдах техникийн, зохион байгуулалтын болон хуулийн нөхцлийг бүрдүүлэх.
- Олон улсын стандартад нийцсэн Мэдээллийн эрх чөлөний тухай хуулийг батлах
- Олон нийтийн эрх ашгийн үүднээс илчлэн мэдээлэх явдлыг хуулиар хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх

Долоодугаарт, Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх хүрээнд:



- Төр засгийг хариуцлагатай байлгах төвшинд ажиллаж хоточ нохойн үүрэг гүйцэтгэх хэмжээнд хүртэл эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх
- Хуульд эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх хөшүүргийг бий болгох шаардлагатай байна. 1) Төрийн албан тушаалтны нэр төр хөндөгдөх асуудал нь жирийн иргэдийнхтэй адил байх ёсгүй. 2) Нэр төр, алдар хүндийг доромжлох, гүтгэхийг эрүүгийн хуулиар шийдвэрлэдэг болсон, 3) төрийн албан тушаалтны эрх мэдлээ урвуулсан тухай мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээг зохих журмын дагуу шалгах өмнө байсан хуулийн заалтыг шинэ хуулиар авч хаясан, 4) төрийн албан хаагч нэр төрөө сэргээлгэхээр шүүхэд гомдол гаргасан тохиолдолд нотлох үүргийг зөвхөн сэтгүүлчийн нуруун дээр тохсон байна. Иймээс дээрх заалтуудыг буцаан сэргээх чиглэлд зохих хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах.
- Төрийн албан хаагч нэр төрөө сэргээлгэхээр шүүхэд хандахын өмнө тухайн мэдээллийн хэрэгслээр үнэмшилтэй тайлбар хийх, нотлох, хөрөнгө орлогын мэдүүлгийг нь эрх бүхий байгууллага нийтэд ил тод болгох зэрэг заалтыг зохих хуулиудад тусгах замаар эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хамгаалах механизмыг бүрдүүлэх шаардлагатай. / УИХ/

Наймдугаарт, Парламентаас гүйцэтгэх засаглалыг хянах хяналтыг сайжруулахын тулд төрийн албаны хяналтыг тогтмол, тасралтгүй хэрэгжүүлэх зөвлөмжийг гаргасан байна

Есдүгээрт, Мониторингийг дэмжих үүднээс иргэний нийгмээс төр засгийн үйл ажиллагааг хянах явдлыг хөхүүлэн дэмжиж, Засгийн газрын үйл ажиллагаа, Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаанд мониторинг хийх асуудлыг дэвшүүлэн тавьжээ.

Аравдугаарт, Сэтгэх хүчний төвүүдийг бий болгон хөгжүүлэхийн тул иргэний нийгмийн сэтгэх хүчний төвүүдийг бий болгон төр засгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж төрийн эрх мэдлийг урвуулан ашиглаж байгаа тохиолдлуудад шүүмж, тайлбар хийж засаж залруулах талаар тодорхой арга хэмжээний зөвлөмж гаргах талаар санал зөвлөмж гаргажээ.

Хоёр. Төрийн ил тод байдлын эрх зүйн орчин: Нийгмийн баялгийн хуваарилалт

Уг судалгааг Г.Эрдэнэбат, М.Батсуурь нарын судлаачид 2007 онд хийж гүйцэтгэсэн байна. Ил тод байдлын зарчим төрийн үйл ажиллагааг зохицуулсан болон нийгмийн баялгийг хуваарилахтай холбоотой хууль тогтоомжид тусгагдсан байдал, ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг судлах нь судалгааны үндсэн зорилго байсан бөгөөд уг зорилгын хүрээнд энэхүү судалгааг төрийн ил тод байдлыг хангах нийтлэг эрх зүйн үндсийг тодорхойлсон хууль тогтоомж болон төрөөс нийгмийн баялгийг хуваарилахтай холбоотой буюу улсын төсвийн зарцуулалт; төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах үйл явц; газар олголт; ашигт малтмалын лиценз олголттой холбоотой хууль тогтоомж дахь ил тод байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг судалснаар хязгаарласан байна. Түүнчлэн эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи судалгаа нь тусдаа арга зүй, судалгааны үзэл баримтлал шаардагдана гэж үзсэн тул ил тод байдлыг хангасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлаагүй.

Судалгааны ажил нь:

1. Төрийн ил тод байдлын эрх зүйн үндсийг тодорхойлсон нийтлэг зохицуулалт
2. Улсын төсвийн зарцуулалтын ил тод байдал
3. Улсын төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах үйл явцын ил тод байдал
4. Газар олголтын ил тод байдал
5. Ашигт малтмалын лиценз олголтын ил тод байдал болон дүгнэлт гэсэн бүтэцтэй байна.

Уг судалгаа нь нэрийн хувьд нэлээд өргөн утгатай боловч судлаачид судалгааны хүрээг Төрийн ил тод байдлын эрх зүйн үндсийг тодорхойлсон нийтлэг зохицуулалт, Улсын төсвийн зарцуулалтын ил тод байдал, Улсын төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах үйл явцын ил тод байдал, Газар олголтын ил тод байдал, Ашигт малтмалын лиценз олголтын ил тод байдал гэсэн таван зүйлээр хязгаарлаж тухайн үеийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг судалсан байна. Судалгааг олон талаас нь авч үзээгүй бөгөөд гаргасан дүгнэлт нь хууль тогтоомжийн хэрэгжилт, хийдэл, давхардалтай талаас нь гаргажээ. Судалгааны хүрээнд үндсэн 3 хүрээнд дүгнэлт гаргасан байна. Эдгээр нь:

Нэгдүгээрт, Нийтлэг зохицуулалтын хүрээнд төрийн ил тод байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн үндэс ерөнхий байдлаар бүрдсэн гэж болох ч эрх зүйн орчинг бүрдүүлэх хувьдаа нарийвчилсан зохицуулалт хийж төрийн үйлчилгээний анхдагч нэгж дээр эл мэдээллийн хүртээмжийг хэрхэн хүргэх арга, журам баталгаа нь хангалтгүй байна. УИХ, Засгийн газар, яам, агентлаг, аймаг, нийслэлийн засаг даргын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан тушаал шийдвэрийг нийтэд ил тод болгох талаар эрх зүйн орчин бүрдсэн боловч иргэд мэдээллийг хайх, олж авах үндсэн нэгжүүд дүрэм, журмыг иргэдэд мэдээлэх талаар зохицуулалтгүйгээс иргэний мэдэх эрх хангагдахгүйд хүрэхээр байна.

Хэм хэмжээ тогтоосон дүрэм журам, шийдвэрүүдийг мэдээлэх эрх зүйн орчин бүрдсэн атлаа төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудлаар гаргасан нэгбүрчилсэн актыг мэдээлэх талаар ямар нэг эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэв. Мөн нөгөө талаар мэдээллийг ил тод болгоогүйгээс хуулийн ямар хариуцлага хүлээх талаар зохицуулалт дутмаг байгаа нь ил тод байдлыг хангах хуулийн механизмын хэрэгжилтийг бүрхэг болгож болзошгүй байна.

Хэдийгээр хууль тогтоомжоор мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэвшилттэй зохицуулалтуудыг хийсээр байгаа ч төрийн нууцын тухай, байгууллагын нууцын тухай хуулиудын үзэл баримтлалын алдаатай томъёолол, зөрчилдөөнтэй зохицуулалтаас үүдэн байгууллага, албан тушаалтан өөрийн дур зоргоор мэдээллийг нууцлах боломж байгаа нь дээрх ололт амжилтуудыг үгүйсгэж магадгүй байна гэж тус тус дүгнэжээ.

Хоёрдугаарт, Үйл ажиллагааны нээлттэй байдлын хүрээнд төрийн үйлчилгээний тодорхой салбарын харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах талаар зарим нэг зохицуулалт байгаа боловч ил тод байдлын энэ түвшин хэрэгжих баталгаагаар бараг хангагдаагүй байна. Хууль, дүрэм, журамд заагдсан “үйл ажиллагаанд иргэдийг оролцуулж болно, хяналт тавих нөхцлийг бүрдүүлнэ, төрийн байгууллага албан тушаалтаны үйл ажиллагаа, шийдвэрийг иргэдэд танилцуулж болно” гэх мэт салаа утгатай, албан тушаалтаныг шууд үүрэгжүүлээгүй заалтууд нь төрийн үйл ажиллагааг нээлттэй болгохтой холбоотой зохицуулалтын үр нөлөөг бууруулж байна.

Үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангахтай холбоотой зохицуулалт төрийн үйлчилгээний салбаруудад харилцан адилгүй бүрджээ. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны салбарт нээлттэй байдлыг хангах талаар харьцангуй амжилттай зохицуулалтууд хийгдсэн байхад улсын төсвийн зарцуулалт, газар олголт, ашигт малтмалын лиценз олголттой холбоотой зохицуулалтад үйл ажиллагааны нээлттэй байдал хангалтгүй байна гэж дүгнэжээ.

Гуравдугаарт, Нийтлэг зохицуулалтын хүрээнд төдийгүй тодорхой салбарын харилцааг зохицуулсан эрх зүйн орчны хүрээнд оролцоог хангах замаар төрийг ил тод болгох шийдэл хамгийн бага хуульчилагдсан байна. Үүнийг нэг талаас ил тод байдлын эл түвшинг хангах, хэрэгжүүлэх нь төвөгтэй байж болох ч нөгөө талаас энэ нь эрх баригчдын хүсэл зоригоос шалтгаалсан гэж үзэх үндэстэй. Оролцооны аргаар ил тод байдлыг хангах боломжтой,



шаардлагатай асуудалд хуулиар “олон нийтийн зөвлөл, хяналтын зөвлөл зэргийг ажиллуулах, иргэний байгууллагын төлөөллийг оролцуулах” тухай заалтууд тусгагдсан боловч тэрхүү оролцоог зохицуулсан журам байхгүй учир хэрэг дээрээ хэрэгжих механизм хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Гурав. Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал

Уг мониторинг 2007 оны долдугаар сараас 6 сарын хугацаатай Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр, Авлигатай тэмцэх газрын /цаашид “АТГ” гэх/ захиалгаар “Глоб интернэшнл” төрийн бус байгууллага хэрэгжүүлсэн байна.

Авлигатай тэмцэх газраас гаргасан зөвлөмжийн дагуу төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлээр төрийн байгууллагууд хэрхэн ажиллаж байгаа талаар бодитой мэдээлэлтэй болох, уг мэдээлэлдээ тулгуурлан зөвлөмжийн хэрэгжилтийн түвшин, хэрэгжүүлэхгүй байгаа шалтгаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлж төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн ерөнхий зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны гол зорилго байсан бөгөөд судалгаанд Улаанбаатар хот, дүүргийн төрийн 200 байгууллага, 200 ажилтан, 200 албан тушаалтан, 780 үйлчлүүлэгч иргэн оролцсон.

Энэ нь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх байгууллагуудыг чиг үүрэг, тогтолцоогоор нь системтэй авч үзэх, түүнчлэн дээд, дунд, анхан шатны байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо болон иргэдэд үйлчлэх үйлчилгээний хүртээмжийг цогц байдлаар судлахад илүү үр дүнтэй гэж үзсэн байна.

Судалгааны ажил нь:

1. Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилтийн хураангуйлсан үр дүн
2. Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилт, орчин нөхцөл байдал
3. Иргэдээс санал, гомдол хүлээн авах 19-77 утасны мэдээлэл
4. Дүгнэлт, зөвлөмж гэсэн нэлээд өргөн, нарийвчилсан бүтэцтэй байна.

Уг мониторинг нь өргөн хүрээтэй, асуудалд олон талаас нь олон аргачлалаар хандсан бөгөөд судалгаа нь оновчтой аргачлалтай, баримттай, үндэслэлтэй болсон бөгөөд дүгнэлт, зөвлөмжүүд нь оновчтой болсон байна.

Нэгдүгээрт, Судалгааны хүрээнд дараахь дүгнэлтүүд гарсан байна. Үүнд:

- Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 41 хувь нь л АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Харин 12 хувь нь зөвлөмжийг судлах шатандаа байгаа бол 34 хувь нь зөвхөн тойм мэдээлэл авсан төдий, 13 хувь нь энэ тухай мэдээлэлгүй байв. Энэ нь нэг талаар АТГ-аас 4-р сард төрийн байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмжийнхөө хэрэгжилтэнд тавьсан хяналт сул байсан, нөгөөтэйгүүр байгууллагын үйл ажиллагааныхаа талаархи танилцуулгыг хангалттай хийгээгүй зэргээс шалтгаалсан гэж үзэж байна.
- АТГ нь сүүлийн саруудад үйл ажиллагаагаа эрчимжүүлж, хяналтаа сайжруулсантай холбоотойгоор төрийн байгууллагуудад зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл явцын идэвх сайжрах хандлага ажиглагдсан нь нааштай үзүүлэлт юм.
- Төрийн байгууллагууд 8 дугаар сараас хойш АТГ-ын зөвлөмжийн талаар мэдээлэл авч, судалж эхэлсэн, мөн хэрэгжүүлэх шатандаа орсон нь мониторингийн судалгаа хийсэн болон 1977 утасны сурталчилгааг эрчимжүүлсэнтэй холбоотой.
- АТГ нь шинээр байгуулагдаад удаагүй байгаа байгууллага тул иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үйл ажиллагаагаа олон нийтэд танилцуулж

байх зайлшгүй шаардлагатай байна. Үүний нэг жишээ нь 11 дүгээр сард 1977 утасны сурталчилгааг зогсоосон нь иргэдээс ирж байсан санал, гомдлын тоо цөөрөхөд шууд нөлөөлсөн явдал юм гэсэн ерөнхий дүгнэлтүүд гаргажээ.

Мөн мэдээлэл хүртээмжтэй байх талаар дараахь дүгнэлтийг гаргасан байна. Эдгээр нь:

- Мэдээллийг хүртээмжтэй байлгах хэлбэрүүд, түүний ашиглалт төрийн байгууллагад харилцан адилгүй байна. Олонх байгууллагад иргэдэд мэдээлэл түгээх самбар, мэдээлэл өгөх үүрэгтэй ажилтан байгаа бол, харин вэб сайт, тараах материал хангалтгүй байлаа. Үүний шалтгааныг төсөв санхүүгийн хүндрэл болон иргэд мэдээлэл түгээх дээрх хэлбэрүүдийг тэр бүр ашигладаггүйтэй холбон тайлбарлаж байв. Вэб сайттай байгууллагууд сайт дахь мэдээллийн агуулгаа шинэчлэх тал дээр муу үзүүлэлттэй байна.
- Судалгаанд хамрагдсан 90 байгууллагын талаас илүү хувьд нь иргэдийн гомдол, саналын мөрөөр холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизм байдаг ч гаргасан зөрчлийг арилгах тал дээр тун сул ажиллаж байна. Мониторингийн судалгаа хийх явцад үйлчлүүлж байсан нийт 430 иргэний 33 хувь нь гомдол гаргаж, тэднээс дөнгөж 13 хувь нь асуудлаа шуурхай шийдвэрлүүлж чадсан бол 35 хувь нь шийдвэрлүүлэх явцдаа хүнд сурталтай тулгарсан, 52 хувь нь шийдвэрлүүлж чадаагүй байна.
- Төрийн зарим байгууллагууд үндэслэлгүйгээр төлбөр хураамж авч байна хэмээн үйлчлүүлэгч иргэд үзэж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, судалгаанд оролцсон иргэдийн 18 хувь нь дунджаар хорь гаруй мянган төгрөгийн хураамж төлсөн байв. Төрийн байгууллагуудын, иргэдээс авч буй төлбөр хураамжийн хувь хэмжээ, авч буй үндэслэл нь эргэлзээтэй байна.
- Төрийн байгууллагууд нь дотооддоо төсвийн зарцуулалт болон албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг нээлттэй байлгах тал дээр сул ажиллаж байна. Үүний шалтгааныг гол төлөв хууль, дүрэм журмаар хязгаарласан байдагтай холбон тайлбарлаж байлаа. Гэтэл тухайн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хуулиудыг судалж үзэхэд ийм заалт байхгүй байв. Байгууллагууд дотоод дүрэм, журмаа Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшлахгүйгээр боловсруулан, үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор өөрчилж болох атал энэ тал дээр дэвшилттэй алхам хийсэн нь тун цөөн байгаа бөгөөд эндээс төрийн байгууллагууд бүхэлдээ хүнд сурталд автжээ гэсэн дүгнэлтийг хийж байна.
- Байгууллагууд иргэдийн хэрэгцээт мэдээллийг вэб сайтдаа тавьж, тавьсан мэдээллээ байнга шинэчилж байх тал дээр хангалтгүй ажиллаж байна. Мэдээлэл түгээх самбар, мэдээлэл өгөх үүрэгтэй ажилтан зэрэг бусад мэдээллийн хэлбэрүүд түгээмэл байдаг нь үйлчлүүлэгч иргэдээс авсан сурвалжлага, ажиглалт, бичиг баримтын судалгаануудаас тодорхой харагдаж байна.

Үйл ажиллагаагаа нээлттэй байлгах талаар дараахь дүгнэлтийг гаргасан байна. Эдгээр нь:

- Хүнд суртал, чирэгдэл ихтэй, иргэдийн шийдвэрлүүлэхээр хандсан асуудлыг хуульд заасан хугацаанаас нь сунжруулах явдал түгээмэл байна. Ийм зөрчилтэй байгууллагуудыг Газрын албад, Засаг даргын тамгын газар, Замын цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, албад тэргүүлж байв.
- Судалгаанд оролцсон төрийн байгууллагуудын албан хаагчид тухайн байгууллагын шийдвэр гаргах үйл явц нь дотооддоо нээлттэй байдаг гэсэн боловч харин судалгаанд оролцсон иргэдийн өгсөн мэдээллээс үзэхэд зөвлөмжид заасанчлан түүний үндэслэлийн талаархи мэдээлэл иргэд, хуулийн этгээдэд нээлттэй байж чадахгүй

байна. Үүний гол шалтгаан нь энэ чиглэлийн ажил төрийн байгууллагуудад хэвшил болоогүйтэй холбоотой гэж дүгнэж болох юм.

Үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжийг бүрдүүлэх талаар дараахь дүгнэлтийг гаргасан байна. Эдгээр нь:

- Хэдийгээр төрийн байгууллагуудад иргэдээс санал, гомдол хүлээн авах утас, санал хүсэлтийн хайрцаг, дэвтэр, тусгай ажилтан ажиллуулах зэрэг боломж байгаа ч санал гомдлыг хүлээн авах, барагдуулах механизм хангалтгүй ажиллаж байна. Үүнд, нэг талаас санал, гомдлыг хүлээн авах арга хэлбэрээ иргэдэд танилцуулдаггүйгээс тэд мэддэггүй, үүнээс шалтгаалж байгууллагуудад хандаж санал гомдол гаргахгүй байх нь элбэг, нөгөөтэйгүүр төрийн байгууллагуудад итгэх итгэл үлэмж алдарсан нь нөлөөлж байна.
- Тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн саналыг авах, талаар төрийн байгууллагууд хангалтгүй ажиллаж байна.
- Байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг олон нийтэд мэдээлэх ажиллагаа төрийн байгууллагуудад сул байна.

Хоёрдугаарт, судалгааны хүрээнд дараахь зөвлөмжүүдийг гаргажээ. Үүнд:

- АТГ нь үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд сайтар танилцуулж, зорилтот бүлгээ зөв сонгон, агуулга хэлбэрийг сайтар бодож боловсруулан, оновчтой хэрэгслээр дамжуулан цаашид тогтмол явуулах нь зүйтэй.
- АТГ нь төрийн байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмжийнхөө хэрэгжилтэд тавих хяналтаа сайжруулах шаардлагатай байна.
- Төрийн байгууллагуудад урьд өмнө нь огт байгаагүй болон чиг үүргээс нь гадуурхи үйл ажиллагаа явуулахыг шаардсан зүйл заалтууд АТГ-ын зөвлөмжид байхгүй бөгөөд уг зөвлөмжийн хэрэгжилтийг хангах суурь нөөц, боломж хангалттай бүрдсэн байна гэж үзэж байна. Зөвлөмж хэрэгжихгүй байгаад анхаарлаа түлхүү хандуулж, хариуцлагад тооцох механизмыг ажиллуулдаг болгоход нөлөөлөх нь зүйтэй.
- АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхийг төрийн байгууллагуудад хянан хариуцах үүрэгтэй тусгай ажилтан, эсвэл ажил үүрэг нь ижил бүтцэд албан ёсоор даалган хариуцуулах шаардлагатай байна.
- АТГ нь 3 бүлэг 18 заалт бүхий зөвлөмжөө цаашид үйл ажиллагаатайгаа уялдуулж, боловсронгуй болгон сайжруулж байх нь зүйтэй. Тухайлбал, зөвлөмжийн заалтуудын хоорондын утга санааны давхардал, бүлэг хоорондын шилжсэн утга санааг цэгцэлж, зааг ялгааг нь тодорхой гаргах. Мөн зөвлөмжийн хэрэгжилтийн үр дүнг одоогийн шалгуур үзүүлэлтүүдээр хангах боломжтой эсэх, шаардлагагүйг хасах, шинэ зүйл заалт нэмж оруулах, уг зөвлөмжийг хэрэгжүүлэхийн ач холбогдлыг олон нийт, төрийн байгууллагуудад тайлбарлан таниулах хэрэгтэй.
- Нэг чиг үүрэг бүхий анхан, дунд, дээд шатны байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайтар хангаж өгвөл зөвлөмжийн зарим заалтууд богино хугацаанд хэрэгжих боломжтой юм. Тухайлбал, вэб сайтын асуудлыг ийм замаар шийдэж болно
- Байгууллагуудын үйл ажиллагааны чиг үүргийн онцлогоос хамааран чиглэл чиглэлээр ил тод байдлыг хангаж, хүнд суртлыг багасгахад чиглэсэн менежментийн өөрчлөлт хийж болохуйц тусгай зөвлөмжүүдийг боловсруулан хүргүүлбэл зохино.
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж хүнд суртлыг халахад олон

нийтийн зүгээс тавих хяналтыг бий болгож түүний дагуу арга хэмжээ авдаг тогтолцоо бий болгох нь нэн чухал. Энэ нь 19-77 утсанд иргэд хэрхэн идэвхтэй хандаж байснаас харагдаж байна. Ялангуяа үйл ажиллагаандаа хөдөө орон нутгийн иргэдийн оролцох боломжийг бүрдүүлбэл илүү үр дүнд хүрэх болно.

- АТГ нь иргэдийн санал, гомдлыг хүлээн авахаас гадна, цаашид үйл ажиллагаандаа тэдний оролцох боломжийг бүрдүүлж өгөх нь АТГ-т итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулж, улмаар хамрах хүрээг нь өргөжүүлэхэд хувь нэмэр оруулах юм.
- АТГ нь дээрхээс гадна бусад олон хэлбэрээр олон нийт болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах нь зүйтэй гэсэн санал зөвлөмжийг тус тус дэвшүүлэн тавьжээ

Дөрөв. Хүнд суртлын индекс - 2007

Уг судалгааны ажилд тусгагдсан төрийн байгууллагуудын хүнд суртлын индексийг Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын Эдийн засаг, бизнесийн шинжилгээний, үнэлгээний төв 2004-2007 он хүртэл жил бүр судлан гаргасан байна.

Бизнес эрхлэхэд төрийн байгууллагуудаас хүндрэл бэрхшээл учруулж буй хүнд суртлуудыг гаргаж ирэх, ялангуяа төрийн ямар байгууллага их хүнд суртал гаргаж байгааг гаргах, төрийн байгууллагууд дахь хүнд суртлыг багасгах нь хүнд суртлын индексийг гаргах зорилго юм.

Хүнд суртлын индекс-2007 оны судалгааны онцлог нь зөвхөн төрийн үйлчилгээний байгууллагуудыг бус, мөн яамдыг хамруулсан явдал болов. Судалгаанд хот, хөдөөгийн 1300 гаруй иргэд, бизнес эрхлэгчид хамрагдан өөрсдийн санал бодлоо илэрхийлсэн байна.

Төрийн байгууллагуудын хүнд суртлын индекс -2007

Төрийн байгууллагууд	Үзүүлэлтүүд							2007	
	Авлига, хээл хахууль	Журам, дүрэм бичиг цаас	Ажлын уялдаа холбоо, з/б	Хуулийн гажуудал	Дарамт шахалт, хандив нэхэлт	Үйлчилгээний чанар	Ажилчдын зан харьцаа, ёс зүй	Оноо	Байр
Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн алба	4.32	3.85	3.38	3.48	3.83	3.96	3.94	26.76	I
Хотын газрын алба	3.72	4.0	3.52	3.85	3.76	3.47	3.58	25.90	II
Шүүхийн байгууллагууд	3.96	3.43	3.46	3.91	3.89	3.66	3.84	25.44	III
Дүүргүүдийн газрын алба	3.93	3.72	3.72	3.26	3.69	3.30	3.57	25.20	IV
Прокурорын байгууллагууд	3.53	3.55	3.49	3.49	3.48	3.51	3.68	24.73	V
Замын цагдаа	3.83	3.36	3.27	3.68	3.28	3.32	3.82	24.66	VI
Хотын захиргаа /НЗАА/	3.42	3.47	3.71	3.75	3.69	3.16	3.42	24.62	VII

Цагдаагийн байгууллагууд	3.81	3.44	3.32	3.39	3.43	3.42	3.74	24.56	VIII
УМХГазар	3.73	3.64	3.35	3.55	3.72	3.27	3.25	24.51	IX
Гаалийн байгууллагууд	3.24	3.71	3.23	3.46	3.58	3.36	3.81	24.39	X
ИБМУТ	3.60	3.52	3.44	3.39	3.31	3.47	3.55	24.28	XI
Татварын байгууллагууд	3.75	3.83	3.36	3.31	3.24	3.24	3.25	24.24	XII
Халамж үйлчилгээний байгууллагууд	3.59	3.51	3.45	3.35	3.33	3.48	3.43	24.14	XIII
АМГТХЭГ	3.51	3.34	3.32	3.57	3.39	3.23	3.51	23.87	XIV
ШБӨХЗГазар	3.46	3.59	3.25	3.16	3.25	3.21	3.15	23.07	XV
УНДЕГазар	2.97	3.42	3.23	3.33	3.31	3.35	3.21	22.82	XVI
Дүүргийн захиргаад	3.11	3.31	3.4	2.96	3.08	3.13	3.42	22.41	XVII
ГХОГХА	3.31	3.23	3.11	2.98	3.04	3.09	3.10	21.89	XVIII
Оюуны өмчийн газар	3.20	3.16	3.10	3.10	3.06	3.03	3.07	21.72	XIV
СХЗҮТ	3.01	3.02	3.01	3.12	2.87	2.95	2.96	20.94	XX

* * *

Яамдын хүнд суртлын индекс - 2007

Яамдууд	Үзүүлэлтүүд							2007	
	Авилгал, хээл хахууль	Журам, дүрэм бичиг цаас	Ажлын уялдаа холбоо, з/б	Хуулийн гажуудал	Дарамт шахалт, хандив нэхэлт	Үйлчилгээний чанар	Ажилчдын зан харьцаа, ёс зүй	Оноо	Байр
ХЗДХЯам	3.61	3.46	3.63	3.47	3.36	3.30	3.63	24.46	I
Эрүүл мэндийн яам	3.75	3.55	3.39	3.43	3.35	3.38	3.49	24.34	II
БСШУЯам	3.76	3.46	3.34	3.36	3.30	3.35	3.66	24.23	III
Үйлдвэр, худалдааны яам	3.71	3.47	3.36	3.32	3.26	3.24	3.46	23.82	IV
Сангийн яам	3.49	3.44	3.18	3.40	3.38	3.41	3.44	23.74	V
БХБЯам	3.48	3.43	3.37	3.29	3.34	3.33	3.37	23.61	VI
НХХЯам	3.49	3.49	3.28	3.27	3.24	3.33	3.41	23.51	VII
Байгаль орчны яам	3.51	3.48	3.34	3.41	2.91	3.9	3.41	23.45	VIII
ТЭХЯам	3.48	3.43	3.37	3.26	3.20	3.26	3.35	23.35	IX

ХХААЯам	3.43	3.41	3.34	3.28	3.23	3.13	3.34	23.16	X
ЗТАЖЯам	3.49	2.85	3.32	3.32	3.23	3.30	3.38	22.89	XI
Гадаад хэргийн яам	3.43	3.44	2.68	3.20	3.19	3.11	3.32	22.37	XII

* * *

Хүнд суртлын төсөөллийн индекс 2004 - 2007

Байгууллагууд	Эзэлсэн байр			
	2004	2005	2006	2007
Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн алба	VI	IX	II	I
Хотын газрын алба	I	III	VI	II
Шүүхийн байгууллагууд	IV	IV	I	III
Дүүргүүдийн газрын алба	I	III	VI	IV
Прокурорын байгууллагууд	IV	IV	VIII	V
Замын цагдаа	IV	IV	III	VI
Хотын захиргаа /НЗАА/	III	VI	V	VII
Цагдаагийн байгууллагууд	IV	IV	VII	VIII
УМХГазар	V	V	IX	IX
Гаалийн байгууллагууд	II	I	XI	X
ИБМУТ	IX	VII	IV	XI
Татварын байгууллагууд	VII	VIII	X	XII
Халамж үйлчилгээний байгууллагууд	-	-	-	XIII
АМГТХЭГ	X	X	XV	XIV
ШБӨХЗГазар	-	-	-	XV
УНДЕГазар	-	-	-	XVI
Дүүргийн захиргаад	III	VI	V	XVII
ГХОГХА	XII	XII	XVI	XVIII
Оюуны өмчийн газар	-	-	-	XIX
СХЗҮТ	VIII	II	XIII	XX
МИАТ	-	-	XII	-
ТЗХЭГ	XI	XI	XIV	-

* * *

МҮХАҮТ-ын 2004-2007 оны төрийн байгууллагын “Хүнд суртлын индекс” нь нэлээд ач холбогдолтой судалгаа байсан бөгөөд судалгааг иргэд, бизнес эрхлэгчид хамааруулж гаргасан байна. Судалгааны хүрээнд гарсан үр дүн нь төрийн байгууллагын нэр хүнд болон цаашдын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлж тухайн жил хүнд сурталтай байсан байгууллага дараа дараагийн жилүүдэд хүнд суртал нь багассан байх жишээтэй байна. Тухайлбал 2004-2007 онд гаалийн байгууллагуудын хүнд суртал нэлээд буурсан үзүүлэлттэй байна. Харин МҮХАҮТ-аас 2008 оны Хүнд суртлын индексийг хараахан гаргаагүй байна.

Хүнд суртал

Хүнд суртал гэдэг ойлголт нь улс төр гэдэгтэй адил олон утга, агуулгатай ойлголт юм. Хүнд суртал хэмээх ойлголт нь яг юуг агуулдаг талаар нийтлэг, нэг мөр тогтсон ойлголт байдаггүй бөгөөд харин иргэдийн дунд хүнд суртал гэж ерөнхийдөө төрийн үйл ажиллагаатай холбон ойлгодог нь нийтлэг юм.

Я. Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д хүнд суртлыг албан хэрэгт түшмэлийн арга барилаар хандах хандлага, хүнд сурталтанг хүнд суртлыг баримтлагчид гэж тайлбарласан байдаг. Англи хэлний “bureaucrasy” гэдгийг монгол хэлээр орчуулбал хүнд суртал гэж хөврүүлэгддэг¹⁵. Хүнд суртал гэдэг үг нь Латин хэлний “burra” болон Грек хэлний “kratos” гэсэн үгнүүдээс бүрдсэн үг гэж үздэг. “Burra” нь ширээг бүтээхэд хэрэглэдэг бараан өнгөтэй даавуу, “kratos” нь эрх мэдэл, удирдах гэсэн утгатай. Иймд хүнд суртал гэдэг нь ширээний буюу бюроны эрх мэдэл гэсэн утгыг агуулдаг байна. Энэхүү хүнд суртал буюу бюрокраси гэсэн ойлголт анх гарч ирж байх үед төрийн албан хаагчийн албаны ширээний бүтээлэг нь бараан өнгөтэй даавуу байсан бөгөөд энэхүү адилтгалаар нийгэмд төрийн албан хаагчийн эрх мэдэл нэмэгдэж байгааг илэрхийлж байжээ.

Хүнд суртал нь төрийн удирлага, улс төртэй холбоотой ойлголт юм. Хүнд суртлыг олон утгаар авч үзсэн байдаг. Нэгдүгээрт хүнд суртал нь сөрөг болон аливааг муулсан утгыг илэрхийлдэг. Хүнд суртал нь зохион байгуулалтын сөрөг зүйл бөгөөд төрийн эрх мэдлийг буруугаар ашиглахыг илэрхийлсэн ойлголт гэж үздэг бөгөөд энэ утгаараа хүнд суртал нь “үр өгөөжгүй байх”, “ажлыг удаашруулах”, “дүрэмд баригдах”, “хариуцлагаас зугтах”, “удирдлагын нууцлаг байдал”, “эрх мэдэл шилжүүлэхийг хүсэхгүй байх”, “удирдлагадаа хэт холбогдох” зэрэг сөрөг харилцаа үйлдэл юм. Хүнд сурталтай холбоотой сөрөг талууд нь төрийн албан хаагчаас бус, хүнд суртлын бүтцээс үндэслэлтэй. Үйл ажиллагааны удааширал, хүнд суртлын шалтгаанаас иргэдэд учруулж буй хохирол нь хүнд суртлын журам болон процедурын нэг үр дүн юм.

Өөр нэг утгаараа хүнд суртал гэдэг нь тодорхой онцлог бүхий байгууллагын хэлбэр гэж үзсэн байдаг. Уг тодорхойлолтыг Вебер (Weber) гаргасан бөгөөд түүнийхээр хүнд суртал гэдэг нь ажил үүргийн хуваарилалт, удирдлагын дэслэн захирах, дүрэм, журам, албан бичиг болон үйл ажиллагаагаа цэгцлэх, хувь хүний бус, дэг журам бүхий бүтэцтэй, албан ёсны байдалтай нэг байгууллагын хэлбэр юм. Энэ утгаараа хүнд суртал рациональ байгууллагын хэлбэр юм. Хүнд суртал нь тогтвортой хэлтэс (газар) болон хуулиар олгогдсон эрх мэдлээс бүрдэнэ. Бүх л хэлтсийн чиг үүрэг, эрх мэдэл дүрмээр зохицуулагдах тул тогтвортой, зохион байгуулалттай ажиллагааны тогтолцоог бүрдүүлдэг. Үр өгөөжийг дээшлүүлэхтэй холбоотой арга зам нь уг зохион байгуулалтын онцлогт чухалчилдаг байна. Хүнд сурталтан нь хүнд суртлын дүрмээр ажиллахыг хүсдэг. Дүрмээ хэрэгжүүлэхдээ хувь

¹⁵ Э.Чинбат. “Англи-Монгол толь”, Улаанбаатар хот 2001 он. 150 дахь талд:

Bureaucrasy; 1. хүнд суртал, 2. төрийн хүнд сурталт ажилтнууд.

Bureaucrat; хүнд сурталтан, төрийн ажилтан.

Bureaucratic; хүнд суртлын.

Bureaucratism; хүнд суртал.

Bureaucratize; хүнд суртал гаргах, чирэгдүүлэх.

хүний шинжийг анхаардаггүй. Вебер зохион байгуулалтын хэлбэр нь зөвхөн төрд байдаг онцлог биш бөгөөд хувийн секторт ч зохион байгуулалт түгээмэл байдаг гэж үздэг.

Нөгөө талаас хүнд суртлыг “олон нийтийн удирдлага-public administration”-тай адилтгадаг. Ерөнхийдөө хүнд суртлыг улс төрийн тогтолцооны олон нийтийн удирдлагын нэг мөч гэж тодорхойлдог. Энэ утгаараа хүнд суртал гэдэг нь төрийн удирдлагад олон төрлийн захиргааны чиг үүрэг - ажлыг хэрэгжүүлэхийн тулд орчин үеийн эрх баригчдын зүгээс удирдаж байгаа болон төрийн байгууллагуудаас бүрдсэн зохион байгуулалтыг бүхэлд нь хэлдэг байна. Хүнд суртал нь хувийн сектороос илүү төрийн байгууллага дахь аргыг илэрхийлдэг байна. Түүнчлэн хүнд суртал нь олон төрлийн улс төрийн бүлэглүүдийн (эрх зүйт төр, аймаг, дүүрэг, сум гэх зэрэг) удирдлагыг болон олон нийтийн бодлогыг зохицуулсан хуулийн хэрэгжилтийг мөн агуулдаг. Үүнтэй холбоотойгоор хүнд сурталтан нь улс төрийн шийдвэрийн зохицуулалт болон хэрэгжилттэй холбоотой этгээд юм.

Францын эрдэмтэн Мишэл Крозер (Michel Crozier) хүнд суртлын ойлголтыг 3 хэсэгт авч үзсэн байдаг байна. Үүнд: 1-рт Хэлтэсээс удирдах. Өөрөөр хэлбэл, дэс дарааллын хэлбэрээр зохион байгуулагдаж, томилогдох замаар ажиллаж буй төрийн албан хаагчдаас бүрдсэн төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй захиргааны үйл ажиллагаа юм. 2-рт хүнд суртал хамтын үйл ажиллагааны зохион байгуулалттай хэлбэрт оруулсан байдал. 3-рт ажил хэргийг удаан хэрэгжүүлэх, нэг хэвийн, үйл ажиллагааны эмх цэгцгүй байдал болон хэрэгцээг хангалттай хэмжээнд хангаагүй байх.

Хүнд суртлын сөрөг талууд

Хүнд суртлын сөрөг тал түүний бүтэц, үйл ажиллагааны онцлогоос үндэслэлтэй гэж үздэг бөгөөд эдгээр сөрөг талыг жагсаавал:

1. Хүнд сурталтанг үр өгөөжтэй, идэвхитэй ажиллуулахын тулд хууль дүрмийг чанд сахиулах шаардлагатай бөгөөд энэ байдал нь эргээд ажилтанг өөрчлөгдөж буй нөхцөл байдал, хэрэгцээнд тохируулан ажиллах боломж, хүчийг хязгаарладаг.
2. Хүнд сурталд албан хаагч моторын арааны шүдтэй адил. Өөрөөр хэлбэл, албан хаагч зохион байгуулалтын нэг хэсэг болох бөгөөд зорилгоо хэрэгжүүлэх стандарт нь хувь хүний онцлогт хамаарахгүй. Иймд албан хаагч хүнд суртлын тогтолцоонд нөлөөлөн ганцаарчилсан зохицуулалт хийх боломжгүй талтай.
3. Хүнд суртал рациональ зохион байгуулалтаар хэрэгжүүлж буй механизм биш юм. Хүнд сурталд дураараа болон аль нэг талыг баримталсан дүрэм байдаг бөгөөд доод албан тушаалтантай дээд албан тушаалтан нь харьцах харьцаа нь хууль бус байдаг бөгөөд зарим тохиолдолд хүнлэг бус, дураараа шинжтэй байдаг.
4. Хүнд суртал бүхэн албан ёс-хэлбэрийн бүтцийг илэрхийлдэггүй. Практикт албан хаагчид өөрсдийн хөгжүүлсэн харилцаа, ойлголт, зан үйлийнх нь бий болгосон албан бус бүтэц нь албан ёсны бүтцийг бусинуулдаг байна.
5. Вебер хамтын ажил үүргийн хуваарилалтад тулгуурласан мэргэшсэн байдал хууль ёсны дэс дарааллын удирдлагыг нөлөөгүй болгох боломжийг тооцоогүй бөгөөд хууль ёсны дэс дарааллын удирдлага хүнд сурталд техникийн талаар мэргэшсэн доод албан тушаалтандаа холбогдох байдлыг бий болгодог. Өнөөгийн удирдлагын хамгийн чухал асуудал бол мэргэшсэн байх явдал юм.
6. Хүнд суртлын зохион байгуулалтын бүтэц нь удирдлагыг дээд шатандаа төвлөрөх боломжийг бий болгодог бөгөөд түүнчлэн дунд, доод шатны удирдлагын шийдвэр гаргах боломж олгодоггүй. Энэхүү байдал нь бичиг шидэлцэхийг нэмэгдүүлж, ажиллагааг удааширах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгодог.



7. Хүнд суртал хэвшмэл байдалд орсон чиг үүрэг болон ажлын тогтолцоонд тулгуурладаг. Хүнд суртал ерөнхийдөө тогтвортой бүтэцтэй бөгөөд хүнд суртлын үр өгөөжгүй байдлыг үндэс нь уг тогтолцоо өөрчлөгдөж буй нөхцөл байдалд нийцдэггүй, өөрөө өөрийгөө шинэчилдэггүйд оршдог.
8. Албан хаагчдын хариуцлагаас зугтах боломжийг албан хаагчдыг үр бүтээлтэй, нөлөө бүхий ажиллах зорилгоор бий болгосон дүрэм, журам бүрдүүлэх талтай байдаг. Удирдлага хариуцлагаас зугтахын тулд өмнө ирсэн асуудлыг шийдвэрлэхээсээ илүү холбогдох хууль дүрэмд зөвхөн үгийн утгаар хандах талтай байдаг. Иймд өөрсдийн дүрмийг явцуу утгаар бий болгодог. Удирдлага өмнө нь ирсэн асуудалд хууль дүрмээ хараад шийдвэрлэхийг оролддог бөгөөд хууль дүрэм байхгүй тохиолдолд өмнө асуудлыг хэрхэн шийдвэрлэж байсныг хардаг тийм тохиолдол байхгүй бол асуудлыг хариултгүй орхих, эсхүл “үгүй” гэсэн хариулт өгдөг байна.
9. Хүнд суртлын зохион байгуулалтын бүтэц нь цаг хугацаанд хаалттай байдлыг бий болгодог бөгөөд үр бүтээлгүй болдог. Хүнд суртал нь шинэчлэлд хаалттай хандах талтай. Чадваргүй удирдлага хүнд суртлын зохион байгуулалтад дээд шатанд богино хугацаанд дээшлэх нь олон байдаг.

Хүнд суртлын сөрөг талыг саармагжуулах боломж

Хүнд суртлын сөрөг талыг хамгийн бага түвшинд хүргэх зарим аргууд:

1. Нөлөө бүхий улс төрийн хяналт
2. Боломжийн уян хатан зохион байгуулалтыг бий болгох
3. Сайн удирдагч болон удирдлага
4. Байгууллагын дотор эрх шилжүүлэх замаар дунд болон дээд шатны удирдлагын хариуцлагыг нэмэгдүүлэх болон бичиг цаасны ажлыг багасгах
5. Шударга хүний нөөцийн удирдлага
6. Захиргааны хамтын ажиллагааг хөгжүүлэх
7. Байгууллагын зорилго, удирдлага, ажиллагаа, дүрэм, үр дүнг байнга эргэн харах, энгийн болгох
8. Хэт дүрэмд захирагдах байдлаас сэргийлэхийн тул ажлын суртахууныг сайжруулах
9. Нөлөө бүхий олон нийтийн харилцааг бий болгох.

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНД СУРТЛЫН АСУУДЛААР ХИЙГДСЭН СУДАЛГАА

Д/д	Сэдэв	Тайлбар
1.	Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал <ul style="list-style-type: none"> • 2007 он • Глоб Интернэшнл” ТББ • Санхүүжүүлэгч Нээлттэй Нийгэм Форум 	Мониторинг нь өргөн хүрээтэй, асуудалд олон талаас нь олон аргачлалаар хандсан бөгөөд судалгаа нь оновчтой аргачлалтай, баримттай, үндэслэлтэй болсон бөгөөд дүгнэлт, зөвлөмжүүд нь оновчтой болсон байна



2.	<p>Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг авах арга хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> • 2005 он С.Баяраа • Санхүүжүүлэгч Нээлттэй Нийгэм Форум 	<p>Судалгааны хүрээнд судлаач төрийн эрх мэдлийг урвуулан ашиглаж буй байдлыг хууль тогтоомж, олон нийтийн санал асуулга, төрийн байгууллагуудын төлөв байдлаар харьцуулсан судалгаа зэргийг нэлээд өргөн ашиглаж үндсэн 10 бодлогын зөвлөмж гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг дор бүр нь дэд зөвлөмжид тусгаж асуудлыг олон талаас нь судалж шинжилсэн байна. Мөн зөвлөмжүүд нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг үндэслэлтэй, дэлгэрэнгүй, хэрэгжүүлэх субъекттэй нь гаргасан оновчтой болжээ</p>
3.	<p>Хүнд суртлын индекс-2007</p> <ul style="list-style-type: none"> • 2007 он • МҮХАҮТ-ын Эдийн засаг, бизнесийн шинжилгээ, үнэлгээний төв • Санхүүжүүлэгч: Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим 	<p>2004 оноос эхлэн МҮХАҮТ -аас төрийн байгууллагуудын хүнд суртлын индексийг гаргаж байна</p>
4.	<p>Төрийн ил тод байдлын эрх зүйн орчин: Нийгмийн баялгийн хуваарилалт</p> <ul style="list-style-type: none"> • 2007 он Г.Эрдэнэбат, М.Батсуурь • Санхүүжүүлэгч Нээлттэй Нийгэм Форум 	<p>Судалгаа нь нэрийн хувьд нэлээд өргөн утгатай боловч судлаачид судалгааны хүрээг Төрийн ил тод байдлын эрх зүйн үндсийг тодорхойлсон нийтлэг зохицуулалт, Улсын төсвийн зарцуулалтын ил тод байдал, Улсын төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах үйл явцын ил тод байдал, Газар олголтын ил тод байдал, Ашигт малтмалын лиценз олголтын ил тод байдал гэсэн таван зүйлээр хязгаарлаж тухайн үеийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг судалсан байна</p>
5.	<p>Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх нь</p> <ul style="list-style-type: none"> • 2006 он • Хүний эрхийн боловсролын төв • Санхүүжүүлэгч Нээлттэй Нийгэм Форум 	<p>Хуулийн байгууллагын үйл ажиллагаа тэр бүр ил тод нээлттэй явагддаггүйгээс ажилтнууд нь хээл хахууль авилгад өртдөг гэж олон нийтийн зүгээс үздэг талаар зөвлөмждөө дурдсан</p>
6.	<p>Шүүх үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал</p> <ul style="list-style-type: none"> • ТАНАБЭ МАСАНОРИ • Санхүүжүүлэгч "ЖАЙКА"-ийн "Эрх зүйн шинэтгэл, туслалцаа" төсөл 	<p>Монгол дахь нөхцөл байдал, шүүх ил тод байхын зорилго, шүүх үйл ажиллагааг үзэхэд зөвшөөрөл хэрэгтэй эсэх, шүүх хаалттай байх тухай, шүүхийн аюулгүй байдал, дүрс бичлэг, гэрэл зураг авах тухай зэрэг асуудлыг хөндсөн</p>

7.	Шүүхийн нийгмийн өмнө хүлээх хариуцлага ба ил тод байдал <ul style="list-style-type: none"> • Ч.Өнөрбаяр Санхүүжүүлэгч • Нээлттэй Нийгэм Форум 	Шүүхийн нийгмийн өмнө хүлээх хариуцлага – Үндсэн хуульт ёсны бүрдэл, Шүүхийн хараат бус байдал ба нийгмийн өмнө хүлээх хариуцлага, Шүүхийн менежмент ба олон нийттэй харилцах асуудал, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ба шүүх эрх мэдэл, шүүхээс олон нийттэй харилцах бусад арга хэлбэрүүд
8.	Захиргааны ажлыг боловсронгуй болгох асуудал <ul style="list-style-type: none"> • 2004 он С.Баяраа • Санхүүжүүлэгч Нээлттэй Нийгэм Форум 	
9.	Төв, орон нутгийн засаг захиргааны зохистой тэнцвэр <ul style="list-style-type: none"> • 2004 он • Л.Лувсанжамц • Санхүүжүүлэгч Нээлттэй Нийгэм Форум 	
10.	Засаг захиргааны нэгжийн шинэтгэлээр гарч болох сөрөг үр дагавар: Төрийн хийгээд нийгмийн үйлчилгээний чанар, түүний өртөг <ul style="list-style-type: none"> • 2005 • Д.Дэлгэрцогт • Санхүүжүүлэгч Нээлттэй Нийгэм Форум 	

* * *

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ ТОЙМ

Энэхүү тоймыг бэлтгэхдээ www.google.com вэб сайтаас хайлт хийснээс гадна Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим, Төрийн албаны зөвлөл, Нээлттэй нийгэм форум, Ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн, “Сант марал” судалгааны байгууллагаас утсаар болон биечлэн лавлаж, зарим мэдээлэл авсан болно.

Мэдээлэл цуглуулах явцад ашиг сонирхлын зөрчил, ялангуяа төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой материал /ном, товхимол, гарын авлага, өгүүлэл, нийтлэл гэх мэт/ ховор, тухайн асуудал манай улсын хувьд бага судлагдсан бөгөөд шинэхэн сэдэв болох нь ажиглагдсан. Нийт олдсон, цуглуулсан материалын хүрээнд авч үзвэл төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг үүнээс өөр сэдвээр хийсэн судалгааны зарим хэсэгт нь өнгөц, товч дурдсан байх буюу дээрх асуудлыг судалгааныхаа гол объект болгон аваагүй тохиолдол зонхилж байна. Эдгээрээс зарим нэгийг нь дурдвал:



Нэг. Төрийн албан хаагчийн ёс зүй

ШУА -ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгээс “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр УИХ -ын Төрийн байгуулалтын байнгын хорооны захиалгаар 2003 онд судалгаа¹⁶ хийсэн байх бөгөөд үүний үр дүнд тайлангийн 3.2 дахь хэсэгт төрийн албан хаагчийн ашиг сонирхлын талаар үнэлгээ хийжээ.

Энэхүү судалгааны гол К. зорилго нь төрийн албан хаагчийн ёс зүйн талаар олон нийт ямар ойлголт, дүгнэлттэй байдаг, төрийн албаны нэр хүнд, үүрэг, хариуцлагыг өндөржүүлэхэд төрийн албан хаагчдад олон нийтийн зүгээс ямар шаардлага тавьж буйг тодорхойлохын зэрэгцээ төрийн албан хаагчийн ёс зүйн харилцааны эрх зүйн зохицуулалттай холбоотой асуудлыг судлах явдал байв. Судалгааг Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Төв, Ховд, Өвөрхангай, Завхан, Говь-Алтай, Сүхбаатар, Дорнод аймгийн 1120 иргэнээс анкетын аргаар, мөн төрийн алба, ёс зүйн харилцааны зохицуулалтын асуудалтай холбогдсон гүнгийрүүлсэн сурвалжлагыг фокус-группын аргаар хийсэн байна. Уг судалгааны нэг чиглэл нь төрийн албан хаагчийн ашиг сонирхлын талаархи үнэлгээ байснаас судлаачдын зүгээс дараахь дүгнэлтийг өгсөн байна:

Манай улсын Төрийн албаны тухай хууль нь олон улсын жишгээр боловсруулагдсан бөгөөд “төрийн алба нь нийтийн итгэл даах алба юм” гэсэн зарчмаар үйлчилдэг байх ёстой. Гэтэл санал асуулгад хамрагдсан нийт хүмүүсийн үзэж байгаагаар, төрийн албан хаагчид үйл ажиллагаандаа хувийн ашиг сонирхлоо төрийнхөөс урьдал болгон тавьж байгаа явдал нь Төрийн албаны тухай хуульд заасан үүргээ өөрт ашигтайгаар ашиглаж байгаа юм биш үү гэсэн эргэлзээг төрүүлж байна гэжээ.

Төрийн албан хаагчид ашиг сонирхлын асуудалд хандах хандлага ямар байна вэ гэсэн асуултын хариултаас харахад иргэдийн 73.5 хувь нь хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа ч, албан хаагчид /48.2 хувь/ буюу тал шахам хувь нь өөрсдөө энэ байдлыг хүлээн зөвшөөрсөн нь төрийн албан хаагч хувийн эрх ашгаа төрийнхөөс дээгүүр тавьж байна гэдэг нь харагдаж байна.


Төрийн албан хаагчдын хувийн болон нийтийн ашиг сонирхлын зөрчлийн байдлын талаархи хүмүүсийн санал бодлыг индексийн арга /дор графикаар үзүүлэлт/-р хураангуйлж үзвэл иргэд ч, албан хаагчид ч хувийн эрх ашгаа төрийнхөөс илүүд тавьдаг явдлыг таслан зогсоох шийдвэртэй алхам хийх цаг болсон нь эргэлзээгүй гэжээ. Энэ бүхнээс үзэхэд төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчлийн асуудал нэлээд ноцтой асуудал болж байгаа тул түүний шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.



¹⁶ ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгээс хийсэн “Төрийн албан хаагчийн ёс зүй” судалгааны тайлан /2003 он/-аас холбогдох мэдээллийг авсан болно.



График. Төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчлийн индекс



АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын санхүүжилтээр “Монгол Улс дахь авлигын байдалд хийсэн үнэлгээ¹⁷”-г 2005 оны 6, 7 дугаар сард Casals & Associates, Inc (C&A) байгууллагаас Вашингтон дахь Олон улсын хөгжлийн агентлаг, Азийн сантай хамтран хийсэн байна. Уг тайлангийн гол дүгнэлт нь урьд өмнө хийгдэж байсан тоон болон чанарын бусад судалгааны нэгэн адил Монгол улсад “жижиг сажиг” буюу захиргааны түвшинд ч, “их хэмжээний” буюу элит түвшинд ч авлигын боломж улам өссөөр байна гэж үзжээ.

Ийнхүү Монголд авлига улам бүр өсөн томорч байгаа нь хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалж байгаагаас нилээд чухлыг нь дор дурдсан байна:

- Бараг бүх шатанд ашиг сонирхлын зөрчилдөөн тодорхой салбар болон системийг бүхэлд нь хамарсан шинжтэй болсноор улсын ба хувийн хэвшлийн хоорондох зааг хязгаар нилээд бүдгэрсэн.
- Төр засгийн ихэнх үйл ажиллагаа ил тод бус, энэ талаар мэдээлэл авах боломжгүй байгаа нь хариуцлагыг бүхий л талаар сулруулж, энэ нь улмаар хэвлэл мэдээллийн үр ашиггүй байдалд нэрмээс болж, бодлого хэлэлцэх, төр засагт хяналт тавих үйл явцад иргэд оролцох боломжийг хязгаарлаж байна.
- Иргэдэд үзүүлэх үйлчилгээ хүрэлцээ муутай байгаа нь хэт улс төржсөн төр захиргааны байгууллагуудыг нэмэгдүүлж, “бялуу хуваах систем” оршин тогтнох нөхцөлийг бүрдүүлж байна.
- Шаардлагатай шинэчлэлийг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх улс төрийн зориг, удирдлагын арга барил хязгаарлагдмал байгаагаас гадна хоорондоо зөрчилдсөн, нэг нь нөгөөгөө давтсан хуулиуд нь бодлогыг цааш нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад болж байна.
- Монголбанк, Үндэсний аудитын газар, УИХ-ын байнгын хороод, Ерөнхий прокурорын

¹⁷ <http://www.usaid.gov/mn/documents/CorruptionAssessment-ExecutiveSummary-Mongol.pdf>. /2009.4.15/

газар, Улсын мэргэжлийн хяналтын газар, Төрийн өмчийн хороо болон Сангийн яамны хэлтэс, газрууд зэрэг төр засгийн хяналтын институцууд сул байна.

- Үнэлгээний үр дүнг тодорхойлж, тайландаа хэд хэдэн стратегийн зөвлөмж гаргасан бөгөөд үүний нэг нь “Сонирхлын зөрчилдөөн, ил тод байдал, мэдээлэл олж авах боломж, иргэдэд үзүүлэх үйлчилгээнд хийх шинэчлэл, авилгалтай тэмцэх бие даасан байгууллага зэрэг асуудлуудыг хөндөх, ингэхдээ иргэний нийгмийг оролцуулах, НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийг хэрэгжүүлэх үйл явцад олон нийтийн оролцоог дэмжих” тухай байлаа.


Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний албанаас “Авлигын ерөнхий төлөв байдлын судалгаа”-г 2008 оны 9 дүгээр сараас 11 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд хийсэн¹⁸ байх бөгөөд иргэд, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчдийн авлигын талаархи санаа бодлыг тодруулах, авлигатай холбоотой тэдэнд тохиолдож байсан асуудлууд, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэж байсан зэрэг мэдээллийг цуглуулан, нэгтгэн дүгнэж олон нийтэд тараах, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийн суурь мэдээлэл болгон ашиглах, нөгөө талаас авлигын индексийн аргачлалыг боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, энэ чиглэлээр судалгаа явуулах туршлага хуримтлуулах зорилгыг агуулсан байна.

Энэхүү судалгаанд нийслэл, 21 аймгийн 2990 /үүнээс 1333 иргэн, 360 бизнес эрхлэгч, 1297 төрийн албан хаагч/ хувь хүн хамрагджээ. Судалгааны дүгнэлтээс ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой байж болох хэсгийг дор түүвэрлэвэл:

- Авлига, хүнд суртал, төрийн албан тушаалтнуудын ашиг хонжоо хайсан байдал нь иргэдийн сэтгэлийг зовоож буй асуудлын нэг болж байна.
- Иргэдийн зүгээс төрийн албан хаагчдад хээл хахууль өгөх санаачилга, шалтгаан нь ерөнхийдөө тухайн асуудлыг хээл хахууль өгөхгүйгээр шийдвэрлэх боломжгүй гэсэн тогтсон үзэл баримтлал байдаг, иргэд өөрсдөө хээл хахуулийг санал болгож өгдөг, төрийн албан хаагчид шаарддаг, эсвэл тийм байдалд оруулдаг гэсэн 3 эх үүсвэртэй байдаг байна. Судалгааны дүнгээр иргэд дунджаар 520.9 мянган төгрөгийн хэмжээтэй хээл хахуулийг дунджаар 210 хоногийн хугацааны дотор төрийн албан хаагчдад өгсөн байна гэжээ.
- Иргэд, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчдын төсөөллөөр авлигад хамгийн их өртсөн институциудээр газрын алба, УИХ-ын гишүүд, гаалийн байгууллага, эмнэлэг, улс төрийн намууд зэргийг нэрлэсэн байна.
- Судалгаанд оролцогчид улс төрчид, төрийн албан тушаалтнуудын ёс зүйгүй байдал болон төрийн хяналтын систем сул байгаа нь авлигыг бий болгож байгаа гол шалтгаан нөхцөл гэж үзэж байна. Харин бусад шалтгаан нөхцөлүүдийн хувьд иргэд, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчид бүр ялгаатай байдлаар тодорхойлж байна гэжээ. Тухайлбал, авлига үүсэх шалтгаан нөхцөл болж болох 26 асуудлаас иргэд төрийн хяналтын систем сул байгааг, төрийн албан хаагчид төрийн албан хаагчдын цалин амьдралд нь хүрэлцэхгүй байдлыг, бизнес эрхлэгчид төрийн үйл ажиллагаа бизнесийн үйл ажиллагаатай холилдож байгаа зэргийг авлига үүсэхэд чухал нөлөөтэй хүчин зүйл гэж үзсэн байна.


Энэхүү судалгаанд төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой буюу тийм шинжийг агуулсан 3 асуултыг 1297 төрийн албан хаагчаас асуусан ба түүнд хариулсан байдлыг дор графикаар үзүүлбэл:

¹⁸ Авлигын ерөнхий төлөв байдлын судалгааны дүнгээс холбогдох мэдээллийг авсан болно.



Эндээс хэн нэгийг ажилд ороход нь тусалдаг гол шалтгаанууд нь судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар гэр бүл, хамаатан садангийн холбоотой учир /23.9 хувь/, улс төрийн буюу нэг нам, бүлгийн гэсэн утгаар /21.9 хувь/, танил тал, найз нөхдийн гуйлтаар /20.3 хувь/, нэг нутаг, анги, найз нөхдийн холбоотой /15.7 хувь/, өөрт нь ашигтай байсан учир /9.1 хувь/ зэрэг шалтгаанууд орж байна гэжээ. /Тайлангийн 46-47 дахь тал/

Харин төрийн албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэх явцад нь иргэд үйлчлүүлэгчдийн зүгээс хамгийн их буюу 38.5 хувь нь хууль бус санал тавьдаг бол судалгаанд оролцогчдын 30.4 хувь нь найз нөхдөөс, 22.5 хувь нь дээд албан тушаалтнаас, 15.8 хувь нь улс төрийн нам, бүлгийн гишүүдээс, 15.6 хувь нь хамт ажиллагчдаас, 14.7 хувь нь харилцагч байгууллагынхнаас хууль бус санал тавьдаг гэж хариулсныг дараахь графикаар харууллаа. /Тайлангийн 50 дахь тал/



Хоёр. Төрийн албан хаагчийн сонирхлын зөрчил, түүнийг шийдвэрлэх арга зам

Тухайн асуудлыг судалгааныхаа гол объект болгосон дараахь 2 судалгаа байгаа боловч Нээлттэй нийгэм форумас зарласан хөтөлбөрийн хүрээнд хийж буй судалгаа нь тодорхой шалтгааны улмаас дуусаагүй, түр хугацаагаар зогссон байна:

Удирдлагын академийн судалгааны багаас “Төрийн албан хаагчийн сонирхлын зөрчил, түүнийг шийдвэрлэх арга зам” сэдэвт судалгааг Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлийн захиалгаар хийж, 2008 оны 4 дүгээр сард тайлан, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлжээ.¹⁹ Энэхүү тоймыг бэлтгэн, цуглуулсан мэдээллийн хүрээнд авч үзвэл уг судалгаа нь төрийн албан хаагчийн сонирхлын зөрчлийн сэдвээр дагнан хийгдсэн буюу судалгааны зорилго, зорилт, тодорхой арга, аргачлал бүхий бүтээл байсан.

Төрийн жинхэнэ албан хаагчид сонирхлын зөрчилд үл өртөн, төрийн буюу нийтийн ашиг сонирхлын үүднээс ажил үүргээ гүйцэтгэдэг байх улс төр, эдийн засаг, нийгэм соёлын болон эрх зүйн үндсийг бүрдүүлэх арга замын асуудлыг судлан боловсруулахад энэ судалгааны зорилго оршиж байна. Тайлан 6 бүлэг, 9 зүйлтэй, 7 хавсралтаас бүрдсэн бөгөөд судалгааны арга зүйг 2 дугаар бүлэгт, 3 дугаар бүлэгт сонирхлын зөрчлийн ойлголт, түүний илрэх хэлбэр, зохицуулалтын талаар, 4 дүгээр бүлэгт сонирхлын зөрчлийг амжилттай зохицуулж байгаа улсуудын туршлагыг судлан тодорхойлсон /Үүнд: Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн улсуудын, мөн Төв болон Зүүн Европын улсуудын туршлагыг судалсан байна./ ба 5 дугаар бүлэгт Монгол Улс дахь сонирхлын зөрчлийн өнөөгийн байдлыг бодлого, хуулийн зохицуулалт, дүрэм, журмын зохицуулалт, институцийн орчны хүрээнд тодорхойлохын зэрэгцээ төрийн албан хаагчид, иргэдийн ойлголт, тэдний санаа бодлыг тусгах зэргээр судлан тодорхойлсон байна.

Харин 6 дугаар бүлэгтээ судалгааны ажлын дүгнэлт, сонирхлын зөрчлийн зохицуулалтыг сайжруулах санал, зөвлөмжийг тусгаснаас гадна хавсралт болгож ном зүй, судалгааны анкетын асуулга, ярилцлагын асуулт болон хууль, эрх зүйн баримт бичгийн ашиг сонирхлын зөрчилд холбогдох заалтын түүвэр, байгууллага /албан хаагчийн/-ын ёс зүйн ба сахилгын дүрмийн харьцуулалтыг хүснэгтээр оруулжээ.

Судалгааг харьцуулалтын, баримт бичгийн, санал асуулгын болон ярилцлагын аргаар хийхдээ Улаанбаатар хот, Баян-Өлгий, Говь-Алтай, Хэнтий, Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгч, төрийн байгууллагын албан хаагчийг хамруулсан төдийгүй зарим яам, Татварын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, шүүх, прокурор, мэргэжлийн хяналтын гэх мэт нэлээд олон байгууллагыг хамруулжээ. Ингээд судалгааны тайлангаас хэсэгчлэн дурдвал:

- Нэгдүгээрт, харьцуулсан судалгаанаас үзвэл Төв болон Зүүн Европын улсуудын төрийн албан хаагчдын хувьд одоо үйлчилж буй болон шинээр боловсруулж буй ёс зүйн дүрмийн бүтцэд сонирхлын зөрчлийн зохицуулалт орсон байх бөгөөд үүнд Польш, Чех, Македон, Латви, Словак, Румын, Албани, Литва зэрэг улс багтсныг хүснэгтээр үзүүлсэн байна.
- Сонирхлын зөрчлийг зохицуулах талаархи бусад орны туршлагаас харахад асуудалд олон талаас нь, системтэйгээр хандаж, цогц бодлого боловсруулан хэрэгжүүлж, иж бүрэн арга хэмжээ авдаг нь амжилтад хүрэх нөхцөл болдог байна хэмээн дүгнээд сонирхлын зөрчлийг зохицуулах бодлогын 2 үндсэн хандлага байгааг тодорхойлжээ. Эхнийх нь илүү өргөн хүрээний бодлогын түвшинд авч үзэн, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, дараагийнх нь тусгайлан бодлого боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд энэ

¹⁹ Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн хувийг авч үзсэн болно.

зохицуулалтад сонирхлын зөрчлийн талаар хууль гаргаж, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх институцийг бий болгон ажиллах явдал юм гэсэн байна.

- Хоёрдугаарт, санал асуулгын судалгааны хүрээнд сонирхлын зөрчилд албаны нэр нөлөөгөө хувийн эрх ашгийн үүднээс ашиглаж өөртөө давуу байдал бий болгож байгаа үйлдлийг онцлон сонирхлын зөрчил гэж үзсэн байна. Танил тал найз нөхөддөө давуу эрх олгох, албан үүргээ гүйцэтгэсний төлөө бэлэг сэлт авах, ажлын цагаар хувийн ажил хөөцөлдөх, ах дүү хамаатан садандаа давуу эрх олгох зэрэг нь бүхэлдээ өөртөө давуу байдал бий болгох, хувийн эрх ашгийг урьтал болгож байгаа үйлдэл бөгөөд энэ нь тухайн этгээдийн албан ажил, эрх үүрэгтэй зөрчилдөж, сонирхлын зөрчил үүсгэж байгаа хэлбэр юм гэж уг судалгаанд дурджээ.
- Сонирхлын зөрчил хамгийн ихээр илэрч болох тохиолдлын талаар иргэдээс судалгаа авахад ажилд авах 63.1%, албан тушаал дэвшүүлэхэд 61.9%, ашиг орлого хуваах 43.1%, гадаад, дотоодын сургалтад хамруулахад 54%, тендер шалгаруулах, гэрээгээр ажил гүйцэтгэхэд 69%, тусгай эрхийн зөвшөөрөл олгоход 65.4% сонирхлын зөрчил хамгийн их илэрч байна гэж уг судалгаанд бичсэн байна.
- Мөн төрийн албан хаагчдын дунд ажилд анх ороход нь сонирхлын зөрчилд автахгүй байх талаар судалгаа хийхэд улс төрийн албан тушаалтай төрийн албан хаагчдын дунд сонирхлын зөрчил илүү гардаг байж болох нь ажиглагдсан байна.
- Нийгмийн бүхий л хүрээнд сонирхлын зөрчил байна гэсэн хариултыг судалгаанд хамрагдсан хүмүүсийн ихэнх нь өгсөн ба 81.4% нь сонирхлын зөрчлийг зохицуулах зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бол ердөө 4.8% нь огт шаардлагагүй гэж хариулжээ. Сонирхлын зөрчлийг зохицуулахын тулд юу хийвэл зохистой вэ гэхэд 48.7% нь төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, 21.5% нь ёс зүйн дүрэм боловсруулах, 16.8% нь хууль гаргах хэрэгтэй гэж үзжээ.
- Салбарын болон байгууллагын дотоод журам, ёс зүйн дүрэмд “гэрээ хэлэлцээр байгуулах үед хувийн сонирхлоор хандах”, “төрийн албанаас гарснаас хойш ашиг сонирхлын зөрчилтэй бизнесийн байгууллагад ажиллахыг хориглох” санаа тусгагдаагүй байх нь нийтлэг байна. Ёс зүйн зөрчилд хамаарах заалтууд нь бүхэлдээ тунхаглалын шинжтэй, процедурыг тодорхой зааж өгөөгүй, хяналтын болон хариуцлагын тогтолцоог нарийвчлан тодорхойлоогүй байна. Судалгааны дүнгээс үзэхэд УИХ, Газрын алба, гааль, Засгийн газрын танхим, яам, шүүх, татвар зэрэг байгууллагад сонирхлын зөрчил их байна гэжээ.
- Санал асуулгын болон дүнгээс харахад сонирхлын зөрчлийн мөн чанарын талаар төрийн албан хаагчдын талаар ойлголт, төсөөлөл харьцангуй жигд байна. Сонирхлын зөрчилтэй “хатуу бодлогын” аргаар буюу хууль дүрмийг чангатгаж хариуцлага тооцох хэрэгтэй гэж бараг нийтээрээ үзэж байна. Байгууллагуудад сонирхлын зөрчлийг зохицуулсан дүрэм, журам байдаг ч тэр бүр хэрэгждэггүй, дүрэм журмын тухай албан хаагчдын мэдлэг хангалтгүй, зохицуулалт нь оновчтой биш байгааг харуулж байна гэж дурдсан судалгаанд тусгажээ.

Нээлттэй нийгэм форумас 2006 оны 11 дүгээр сард явуулсан “Ашиг сонирхлын зөрчил” сэдэвт бодлогын судалгаа²⁰. Уг судалгаа нь бүрэн дуусаагүй байгаа²¹ бөгөөд судлаач эхний ээлжинд ашиг сонирхлын зөрчлийн судлагдсан байдлын тоймыг гадаадын судлаачдын болон Монгол дахь судалгаа, шинжилгээ гэсэн 2 хэсэгтэйгээр гаргажээ. Судлагдсан байдлын талаар:

²⁰ http://www.openforum.mn/forum_topics/fellows/Oyuntuya-Second.pdf /2009.4.13/

²¹ Ийм мэдээллийг Нээлттэй нийгэм форумын ажилтнаас авсан.

- Ашиг сонирхлын зөрчил гэсэн ойлголт нь нэг талаас ёс зүйн шаардлага, нөгөө талаас авилгын сүүдэр, шалтгаан болж яригдсаар иржээ. Энэ ойлголтыг зарим судлаачид авилга гэж үзсэн байхад зарим судлаачдын судалгааны бүтээл, эх сурвалжид хараахан авилга биш харин авилга бий болох эрсдэл, авилга биш гэж үзсэн байна
- Сонирхлын зөрчлийн хамгийн өргөн тархсан хэлбэрүүд нь эрх мэдлийг ашиглах, албан тушаалыг ашиглах, төрийн мэдээллийг ашиглах, дайллага, цэнгээн, бэлэг, хөрөнгө орлогын мэдүүлэг зэрэг юм гээд үүний адил ашиг сонирхлын зөрчлийн олон хэлбэрүүд бий ч товчоолбол дараахь хэлбэрүүд гадаадын судалгааны эх сурважуудын хүрээнд нийтлэг байна гэжээ. Үүнд:
 - Төрийн албан хаагч ямар нэг байдлаар хувийн ашиг сонирхолд нөлөөлж болзошгүй шийдвэр гаргахад оролцох, нөлөөлөх;
 - Тодорхой асуудлаар шийдвэр гаргахад эрх мэдэл, ажил, албан тушаалын байдал, танил талын хүрээгээ ашиглан шууд буюу шууд бусаар нөлөөлөх;
 - Ах дүү, хамаатан садан, найз нөхөддөө ивээл үзүүлж, давуу эрх олгох;
 - Төрийн албан хаагч нь ажил үүрэгт нь нөлөөлөхүйц болон хяналт тавих үүрэгт нь багтдаг өөр бусад ажил, албан тушаал эрхлэх, хавсран гүйцэтгэх;
 - Аливаа компанийн ТУЗ-ийн гишүүн болон бусад хуулийн этгээдийн удирдах байгууллагын гишүүн байх;
 - Шууд удирдлага буюу хяналт тавьдаг албан тушаалтан нь гэр бүлийн гишүүн, садан төрлийн холбоотой байх;
 - Төрийн албанаас гарснаас хойш тодорхой хугацаанд хяналтын үүрэг функцийг хувьд холбоотой байсан байгууллагад ажиллах буюу төрийн албанаас гарсны дараахь ашиг сонирхлын зөрчлийн хэлбэрүүд;
 - Төрийн албан тушаал эрхэлж байх явцдаа олж авсан мэдээллээ ашиглах буюу ашиглахыг зөвшөөрөх;
 - Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийн ил тод байдал зэрэг.

Манай улсын хувьд ашиг сонирхлын зөрчлийн асуудал харьцангуй шинэ ойлголт учраас энэ талаархи ойлголт олон нийтийн дунд болон бодлого боловсруулагчдын түвшинд ч хангалтгүй байна. Жишээлбэл, хууль санаачлагчдаас хувьцаа эзэмшдэг компанийхаа эрх ашгийг хамгаалсан хуулийн төслийг санаачлан өргөн барих, өөрийн шууд болон шууд бус хувийн ба санхүүгийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр гаргах үйл явцад оролцох, шийдвэр гаргахад нөлөөлөх явдал түгээмэл байна. Ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар манай улсад их хожуу ярьж эхэлсэнтэй холбоотойгоор энэ чиглэлээр дагнасан болон нарийвчилсан судалгаа хийгдэж байгаагүй юм гэж судлаач дүгнэсэн байна.

Гурав. Бусад

Нэгдүгээрт, “Төрийн албан дахь сонирхлын зөрчлийн менежмент” гарын авлагыг 2007 онд Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөнөөс орчуулан гаргасан байна. Нийт 154 тал бүхий энэ гарын авлагад сонирхлын зөрчлийн үндсэн ойлголтууд, түүний төрөл, сонирхлын зөрчлийн тодорхойлох тест, сонирхлын зөрчилд холбогдох ёс зүйн загвар хуулийн заалтууд, өөрийгөө шалгах тест, бэлэг болон урамшууллын талаар шалгах асуулт, шударга ёсыг шалгах бодлого гэх мэт сонирхолтой мэдээлэл агуулагджээ. Үүнээс



гадна хавсралт болгож УИХ-ын 2007 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 9 дүгээр тогтоол, сонирхлын зөрчилтэй холбоотой олон улсын гэрээ, конвенц, бусад эрх зүйн актыг хэсэгчлэн оруулсан байна.

Хоёрдугаарт, УИХ-ын Тамгын газрын шинжээч Ю.Эрдэнэтуяа 2001, 2009 онд тус тус хийсэн “Гадаадын зарим орны парламентын гишүүний ёс зүйн талаархи зохицуулалт” сэдэвт харьцуулсан судалгаандаа сонирхлын зөрчлийн асуудлыг тусгайлан оруулсан байна. Ингэхдээ Австрали, Их Британи, ХБНГУ, Энэтхэг, Умард Ирланд, Канад, АНУ, Өмнөд Солонгос, Польш, Молдав, Бельги, Дани болон бусад улс энэ асуудлыг хэрхэн /тусгайлан эрх зүйн акт гаргасан эсэх, бусад эрх зүйн актын зохицуулалтад орсон эсэх/ зохицуулсан, ямар хязгаарлалт, хориг байдаг эсэх, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотойгоор парламентын гишүүний үүрэг, баримтлах журам зэргийг тодорхой хэмжээнд судлан түүний үндсэн дээр Монголын нөхцөлд хэрэгжүүлж болохуйцаар зарим санал, зөвлөмж гаргажээ. Тухайлбал, “УИХ-ын гишүүн нь аливаа бизнесийн үйл ажиллагаа болон бусад ашиг сонирхлын зөрчилтэй асуудлаар УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан эхлэхэд энэ тухайгаа албан ёсоор мэдэгдэж, тухайн асуудлаархи хэлэлцүүлэг болон санал хураалтад оролцохгүй байх тухай зааж өгөх нь гишүүний нэр хүнд, эрх мэдлийг хувийн болон улс төрийн ашиг хонжоо олох зорилгоор ашиглахаас сэргийлэх ач холбогдолтой төдийгүй нийгэмд шударга ёс, ил тод байдал тогтооход зохих нөлөөтэй болно” гэсэн байна

Гуравдугаарт, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, Азийн санаачилга хүрээлэнгийн судлаач Г.Эрдэнэбатын “Сонирхлын зөрчлийн эрх зүйн зохицуулалт” сэдэвтэй нийтлэлдээ “Манайд төрийн албан хаагч нь нийтийн ашиг тусын төлөө бус амин хувийн ашиг тусын төлөө ажилладаг болоод удлаа. Албан тушаалтан хуулиар олгогдсон эрх мэдэл, боломж, давуу талаа өөрийнхөө, гэр бүл, ах дүү, найз нөхөр, нутаг нэгтнийхээ төлөө ашиглах боллоо. Сүүлдээ бүр нийтэд үйлчлэх ёстой төрийн албыг (public service) хувийн хэрэгцээг хангах арга хэрэгсэл мэтээр бодож, үүнийгээ зүй ёсны, байдаг л зүйл гэж итгэдэг болжээ. Ингэж нийтийн тусын төлөө ажиллах үүрэгтэй албан тушаалтаны шударга бус, авлигач байдлыг гааруулсаны нэг шалтгаан нь хувийн болон албаны сонирхлыг системтэй эрх зүйн зохицуулалтаар хязгаарлалгүй өнөөг хүрсэн явдал билээ.

Иймд бид нэн даруй сонирхлын зөрчлийг хязгаарлах үр нөлөөтэй эрх зүйн орчин бүрдүүлэхийн төлөө ажиллах шаардлагатай болоод байна.” гээд бусад улс гүрнүүдийн асуудлыг шийдвэрлэх хандлага, хэрэгжүүлж буй туршлагаас үзвэл сонирхолын зөрчлийг амжилттай хязгаарлахын тулд:

- Сонирхолын зөрчлийг хязгаарлах эрх зүйн зохицуулалтын хүрээ, арга замыг хуулиар тогтоох;
- Төрийн албаны менежментэд сонирхлын зөрчлийг хязгаарлах стандарттай болгох;
- Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэмд сонирхлын зөрчлийн хязгаарласан хэм хэмжээ суулгаж өгөх;
- Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн хангамжийг сонирхолын зөрчлийг хязгаарлах хөшүүрэг болгон ашиглах;
- Төрийн албаны ил тод байдлыг хангаж сонирхлын зөрчлийг хянах иргэний нийгмийн институттэй болох зэрэг багц асуудлыг шийдвэрлэх ёстой хэмээжээ.

Эцэст нь тэрээр “сонирхлын зөрчлийн” асуудлыг ганц хууль гаргаснаар шийдэх асуудал биш болох нь харагдаж байна гэжээ. Асуудлыг үр нөлөөтэй шийдвэрлэхийн тулд төрийн албан хаагчийн ёс зүйг хэм хэмжээнд ачаалах, үйл ажиллагааг нь ил тод болгох, менежментийг хөгжүүлэх, цалин хөлс, урамшлын тогтолцоог шинэчлэх зэрэг олон асуудлыг цогцоор нь шийдвэрлэх бодлого боловсруулж ажиллах ёстой болох нь харагдаж байна.” гэсэн

саналыг дэвшүүлснийг түүний зөвшөөрлөөр ишлэлээ.

Дөрөвдүгээрт, Нээлттэй нийгэм форумын менежер Ж.Баярцэцэгийн “Авлигын эсрэг хууль хийгээд ашиг сонирхлын зөрчил” сэдэвт нийтлэл²². Авлигаас урьдчилан сэргийлэх нэг гол нөхцөл нь сонирхлын зөрчлийг хуулиар сайн тодорхойлж зохицуулах явдал бөгөөд хуулийн төсөлд сонирхлын зөрчлийн талаархи тодорхойлолт байхгүйн зэрэгцээ төслийн долдугаар зүйлд авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой албан тушаалтнуудын тодорхой үйлдэл хийхийг хориглохоор заасан нь хангалтгүй юм гэсэн байна.

Энэхүү нийтлэл нь Авлигын эсрэг хуулийн төсөлтэй холбогдуулан ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар тодорхой саналууд өгөхөд чиглэгдсэн байна. Тухайлбал: хэлэлцэгдэж буй Авлигын эсрэг хуулийн төсөлд сонирхлын зөрчлийг зохицуулсан тодорхой зохицуулалтыг оруулахыг санал болгож байна. Үүнд дараахь зүйлийг төрийн албан хаагчдад хориглох нь зүйтэй гэжээ:

- Төрийн албан хаагч нь ашиг сонирхлын зөрчилдөөн үүсгэж болзошгүй шийдвэр гаргахад оролцох, нөлөөлөх. Ийм тохиодолд ашиг сонирхлын зөрчилдөөн бүхий уг нөхцөл байдлын талаар удирдлагадаа урьдчилан мэдэгдэж, шийдвэрт оролцохгүй байна.
- Шийдвэр гаргахад эрх мэдэл, ажил албан тушаалаа ашиглан шууд буюу шууд бусаар нөлөөлөх,
- Төрийн албан хаагч нь ажил үүрэгт нь нөлөөлөхүйц болон хяналт тавих үүрэгт нь багтдаг өөр бусад ажил албан тушаал эрхлэх, хавсрах;
- Аливаа компанийн ТУЗ-ын гишүүн болон бусад хуулийн этгээдийн удирдах байгууллагын гишүүн байх;
- Шууд удирдлага буюу хяналт тавьдаг албан тушаалтан нь гэр бүлийн гишүүн, садан төрөл байх;
- Төрийн албанаас гарснаас хойш тодорхой хугацаанд хяналтын үүрэг функцийн хувьд холбоотой байсан байгууллагад ажиллах,
- Албан үүргээ гүйцэтгэх явцад олж авсан мэдээллээ ашиглах буюу ашиглахыг зөвшөөрөх.

Жич:

Энэхүү тоймыг бэлтгэхдээ дээрх судалгааны тайлан, түүний үр дүн /дүгнэлт, санал, зөвлөмж гэх мэт/ болон бусад судлаачдын бичсэн нийтлэл, өгүүллийн агуулга, дэвшүүлсэн санал, зөвлөмжид өөрийн зүгээс дүгнэлт хийгээгүй болно.



²² www.openforum.mn; мөн судлаачтай уулзаж, зарим мэдээлэл авсан. /2009.4.16/

ТӨРИЙН АЛБАН ТУШААЛД ТАВИХ ШААРДЛАГА, БОЛЗОЛЫН ТУХАЙ (СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ)

У. Мөнхбат

Сэдвийн хүрээнд:

- Төрийн албан тушаалд тавих шаардлагын хуульд тусгагдсан байдал, зарим дүгнэлт, санал;
- Төрийн албан тушаалд тавих болзолын хуульд тусгагдсан байдал, зарим дүгнэлт, санал;
- Төрийн албан тушаалд тавих шаардлага, болзол холбогдох хуульд хэрхэн зохицуулагдсан байдлыг хүснэгтээр тус тус гаргалаа.

* * *

Төрийн албан тушаалд тавих шаардлага, болзол холбогдох хуульд хэрхэн зохицуулагдсан байдлыг шинжилж боловсронгуй болгох арга замыг тодорхойлох

Монгол Улс ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжих үйл явцын үр дүнд нийгэм, эдийн эдийн засгийн харилцааны өөрчлөлттэй холбоотойгоор төрийн байгууллага, төрийн албаны тогтолцоо, үйл ажиллагааны зарчмыг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн шинэчлэх шаардлагын үүднээс 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Төрийн албаны тухай хуулийг баталсан байна. Улмаар бусад хуулийн зарим зүйл, заалт нь ерөнхий хуультайгаа зөрчилддөг, хууль тогтоомжийн давхардлыг арилгах, төрийн албыг улс төр, бизнесийн нөлөөнөөс ангид байж мэргэжлийн үндсэн дээр хаших боломжоор хангах, төрийн захиргааны ба улс төрийн албан хаагчийн ялгаа заагийг тодорхой болгох зэрэг²³ хэд хэдэн шаардлагаар түүнийг 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр шинэчлэн найруулсан. Батлагдсанаас нь хойш энэ хуульд 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл 12 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байгаа нь тус хууль амьдралд хэр нийцсэн, хэрэгжилт нь ямар байгааг “өнгөцхөн” ч гэсэн харуулж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчинзургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно.” гэж заажээ. Энэ үндэслэлээр харвал Төрийн албаны тухай хууль тухайн харилцааг зохицуулах гол хууль байх бөгөөд түүнтэй бусад хууль нь буюу албан тушаалд томилоход баримтлах зарчим, тавигдах болзол²³, шаардлага²⁴ нь уялдсан, нийцсэн байх ёстой юм. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчид тавигдах шаардлага, болзол, ерөнхий зарчмын талаар суурь хэм хэмжээ нь Төрийн албаны тухай хуульд тусгагдсан гэсэн үг.

Гэхдээ судалгаанаас үзэхэд төрийн албан тушаал /улс төрийн, захиргааны, тусгай, үйлчилгээний/ -д томилоход баримтлах суурь зарчим, тавих шаардлага, болзлыг дээрх хуулиас гадна дараахь эрх зүйн актаар зохицуулжээ:

- 2003 оны Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль;
- 2002 оны Хөдөлмөрийн хууль.

²³ Төрийн албаны тухай хуулийн хувийн хэрэг – I боть. УИХ-ын архив. ХН № 788, 89-90 дэх тал

²⁴ Я.Цэвэлийн тайлбар толиос харвал энэ үг нь “болзоо”, “шаардлага” гэсэн утгатай дүйцэхээр байгаа бөгөөд “болзоо”-г урьдаас тогтоосон хугацаа, газар хэмээн тайлбарлажээ. Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”, УБ., 1966 он, 89 дэх тал

Энэхүү товч судалгааг хийхдээ www.legalinfo.mn; www.intra.paliament.mn; УИХ-ын Тамгын газрын хууль тогтоомжийн сан зэрэг мэдээллийн эх сурвалжийг ашигласан бөгөөд нийт 125 хууль үзэж шүүхэд нийт 56-д нь төрийн албан тушаалд тавих болзол, шаардлагын талаархи зохицуулалтыг тусгажээ. Мөн Төрийн албаны зөвлөлөөс гаргасан холбогдох акт, 250 гаруй хуулиас бусад эрх зүйн актыг шүүсэн болно.

Төрийн албан тушаалд тавих шаардлага

Төрийн албаны тухай хуулийн 10.1-д зааснаар төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага нь хуульд өөрөөр заагаагүй бол:

- тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол;
- туршлага;
- ур чадвартай;
- мэргэшсэн байх явдал мөн.

Энэ нь бүх төрийн албан хаагчид нийтлэг байдлаар тавигдах шаардлага бөгөөд агуулгаас нь харвал Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд ерөнхий шаардлагын хэлбэрүүдийг зохицуулахаар боломжтой байгаа юм. Хэрэв холбогдох хууль бүрээр ерөнхий шаардлагын хэлбэрүүдийг оруулж өгөх юм бол нэг талаар “ерөнхий шаардлага” гэдэг утгаа алдах ба нөгөө талаар хэм хэмжээний давхардал үүсгэх шинжтэй болгожээ. Дор гаргасан хүснэгтээс энэ байдал илүү тодорхой харагдана.

Дээрх ерөнхий шаардлагаас гадна Төрийн албаны тухай хуулийн 5.5-д төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах албан тушаалтны зэрэглэлд хамаарах төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал; 33.4-д төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг Улсын Их Хурал; 33.5-д төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх, туслах албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг Төрийн албаны зөвлөл тус тус тогтоохоор заасан байдаг бол харин үйлчилгээний албан тушаалд тавигдах тусгай шаардлагын талаар хуульд 11.5, 11.6²⁵ дахь хэсгийг эс тооцвол зохицуулаагүй гэж хэлж болно.

Гэхдээ хүснэгтээр гаргасан зохицуулалтаас үзвэл зарим албан тушаалд тавих тусгай шаардлагыг хуулиар тухайлан тогтоосон байгаа боловч зарим албан тушаалтныг томилоход ингэж тусгай шаардлага хуулиар тогтоогоогүй байна. Тухайлбал: Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5.5 дахь хэсэг, Чөлөөт бүсийн тухай хуулийн 6.2, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 12.2, Шүүхийн тухай хуулийн 35.1.7, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 9.2, Эрчим хүчний тухай хуулийн 8.3 дахь хэсэг гэх мэт.

Эндээс харвал Улсын Их Хурал улс төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагыг зөвхөн хуулиар, төрийн өндөр болон төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавих тусгай шаардлагыг хууль болон тогтоолоор тогтоохоор байгаа нь хоорондоо зөрчилдсөн шинжтэй болсон байна. Мөн зарим албан тушаалд тавих шаардлагыг хуулиар тухайлан зохицуулсан байхад УИХ, Төрийн албаны зөвлөлөөс дахин шаардлага тогтоох зохистой эсэх? Төрийн үйлчилгээний албан тушаалд тавих шаардлагыг хэн тогтоох вэ? Тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан үзэмжээрээ тогтоогоод байх уу? гэсэн асуултын хариу хоосон үлдэж байгаа юм. Ийнхүү өөр өөрөөр зохицуулж буй нь энэ талаархи харилцааг зохицуулсан Төрийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж хоорондын уялдаа холбоо алдагдагдахаас гадна тэдгээрийн хэрэгжилтэд муугаар нөлөөлнө.

²⁵ Мөн тус бүтээлд “шаардлага” гэдгийг шаардахын үйлт нэр гээд тэр нь үйл ажлыг гүйцэтгэх бүтээхэд зайлшгүй холбогдох нөхцөл бололцоог нээх; ажлыг гүйцэтгүүлэхээр шаардлага тавих утгатайг тайлбарлажээ. Мөн тэнд, 826 дахь тал

Төрийн албан тушаалд тавих болзол

Төрийн албаны тухай хуулийн 16.2-т төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзолын талаар тусгасан бөгөөд тодруулбал төрийн жинхэнэ албан тушаалд дараахь тохиолдолд авч ажиллуулахыг хориглоно:

- хуульд өөрөөр заагаагүй бол Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн, эсхүл бусад төрлийн гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлээд ялгүйд тооцох буюу ялгүй болох хугацаа нь дуусаагүй,
- төрийн жинхэнэ албан тушаалаас сахилгын шийтгэлээр халагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй,
- хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан тушаалтантай гэр бүл, төрөл, садангийн хүн нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол,
- хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн төрийн албаны онцлог төрөл болох энэ үүргээ биелүүлээгүй бол,
- гадаадын иргэн, харъяалалгүй хүн,
- хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.

Энэ бол төрийн захиргааны болон тусгай албан тушаалд тавих нийтлэг болзол. Харин Төрийн албаны тухай хуульд улс төрийн албан тушаалд тавих болзолыг хуулиар тогтоохоор заасан ба үйлчилгээний албан тушаалд тавих болзолын талаар дурдаагүй боловч бусад хуульд зарим албан тушаалд тавих болзолыг тусгажээ.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад албан тушаалд тавих болзол, шаардлагын талаар зохицуулагдсан байдлыг судалж үзвэл Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд тэдгээрийг нэг ойлголтын дор тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, Төрийн албаны тухай хуулиар 2 өөр ойлголт, нэр томъёогоор илэрхийлсэн нь алдагдсан /болзол, эсхүл шаардлага гэдэгт нөгөөгөө багтаасан/, хольж хутган томъёолсон буюу цэгцгүй болсон гэж дүгнэхээр байна. Тэгэхээр дээрх нэр томъёонуудыг нэг мөр болгох үүднээс хуулиар тодорхойлох, эсхүл Монгол Улсын Дээд шүүхээс тайлбарлах нь зүйтэй болов уу.

Мөн Төрийн албаны тухай хууль, бусад хуульд “хуульд өөрөөр заагаагүй бол”, “хууль тогтоомжид заасан бусад тохиолдол” гэх мэт хэм хэмжээний уялдуулах техникийг багагүй хэрэглэсэн буюу ерөнхий, тусгай зохицуулалтад аль алинд нь оруулсан нь хийдэл, давхардал, зөрчил үүсэх нөхцөл болохыг үгүйсгэхгүй. Жишээ нь, Төрийн албаны тухай хуулийн 4.2.4-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албанд иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх зарчмыг баримтална.”, 6.1, 10.1, 11.4. 16.2.1, 16.2.6 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 18.2. Тиймээс энэ талаархи зохицуулалтыг цэгцлэх үүднээс “..хуульд өөрөөр заагаагүй бол..” гэсэн томъёоллуудыг хасах саналтай байгаа бөгөөд харин аль хэм хэмжээнээс нь хасах, хэрхэн өөрчлөхийг нарийвчилсан судалгаанд үндэслэн хийх хэрэгтэй юм.

Цаашид Төрийн албаны тухай хуулиар тодорхойлсон ерөнхий болон бусад хууль тогтоомжоор тодорхойлсон шаардлага, болзолыг нэг мөр болгох шаардлагатай бөгөөд тухайн төрийн албан хаагчийг томилох бүрт түүнд зориулсан шалгуур гаргаад байвал нөгөө л хэм хэмжээний хоорондын зөрчил, давхардал үүсэх нь дамжиггүй. Иймээс тусгай шаардлага, болзолыг хууль тус бүрээр биш, албан тушаал тус бүрт нь биш, нэгдмэл байдлаар зохицуулах боломжтой.

Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд төрийн албанд баримтлах зарчмыг тодорхойлсон явдал нь тухайн харилцааны ач холбогдолтой болсон төдийгүй эдгээрийг гуйвалтгүй дагаж биелүүлэх, хэрэгжүүлэхдээ Төрийн албаны тухай хууль, бусад хуулиар

дэлгэрэнгүй зохицуулах зүй ёсны шаардлага байдаг. Энэ ч үүднээс төрийн албан тушаалд тавих болзол, шаардлага нь:

- хууль дээдлэх,
- иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх,
- төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчимд үндэслэн, шууд уялдаж гарч ирсэн.

Төрийн албыг хууль дээдэлдэг болгох, тогтвортой байлгах, улс төрийн болон эдийн засгийн ашиг сонирхолын нөлөөнөөс ангид байлгахын тулд тавигдах болзол, шаардлага нь тодорхой, эрх бүхий этгээд үзэмжээр шийдэх боломжгүй байх нь зохистой. Эрх бүхий албан тушаалтан субъектив хандлагаар, хүнд нь зориулж, тааруулж шаардлага, болзол тогтоон төрийн албан тушаалд томилдог байдлыг өөрчилж, тухайн ажлын үндсэн чиг үүрэгтэй нь уялдуулж тусгай шаардлага, болзолыг тавьж, тогтоох тийм л эрх зүйн зохицуулалтыг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар боловсронгуй болгох шаардлагатай байна. Үүнд:

1. захирах, захирагдах хэм хэмжээг тодорхой болгох,
2. болзол, шаардлагыг нэг хуульд заасан бол бусад хуулиар давхардуулан зохицуулахгүй байх,
3. болзол, шаардлагыг ямар эрх зүйн актаар тогтоох, түүнийг тогтоох субъектыг тодорхой болгох. ОХУ-ын Төрийн албаны тогтолцооны тухай хууль, ОХУ-ын төрийн иргэний албаны тухай хуулиар энэ тухай тодорхой зохицуулсан байна.
4. Улс төрийнхөөс бусад төрийн албан тушаалд тодорхой этгээдийг сонгон шалгаруулж, томилох процедурт тухайн байгууллагын удирдлага, эрх бүхий албан тушаалтны саналыг авдаг “буруу” практикийг таслан зогсоох үүднээс Төрийн албаны тухай хуулийн 17.4 дэх хэсгийг өөрчлөн найруулах шаардлагатай.
5. 2008 оны байдлаар Монгол Улсад төрийн албан хаагчийн тоо нийт 116547 байх бөгөөд үүнээс үйлчилгээний албан хаагч 83 хувь буюу 96130-аар тоологджээ.²⁶ Энэ тоон үзүүлэлт нь үйлчилгээний албан тушаалд тавих нэгдмэл шаардлага, болзол бүхий зохицуулалт бий болгох, тэдгээр нь үйлчилгээний чиг үүрэг, онцлогт тохирсон байх / заавал дээд боловсролтой байх албагүй, заавал туршлагатай байх албагүй, заавал нарийн мэргэшсэн байх албагүй гэх мэт/-ыг шаардаж байгаа юм. Өөрөөр хэлбэл, төрийн жинхэнэ албан тушаал, үйлчилгээний албан тушаалд тавих шаардлага, болзолыг тусад нь зохицуулах гэсэн санаа.

Албан тушаалд тавих шаардлага, болзол холбогдох хуульд хэрхэн зохицуулагдсан байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

№	Хуулийн нэр (зүйл, хэсэг, заалт)	Болзол, шаардлага	Тайлбар/санал



²⁶ Тус хэсэгт үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдал болон Төрийн албаны хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулахыг тодорхойлсон байна.

Авлигын эсрэг хууль, 19.1.	Авлигатай тэмцэх газрын албан хаагч нь: 1. ял шийтгүүлж байгаагүй, 2. төрийн байгууллагад ажиллаж байхдаа ёс зүйн дүрэм зөрчиж, сахилгын шийтгэл хүлээж байгаагүй, 3. дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй, 4. тухайн ажлын талаар мэдлэг, ур чадварын шаардлага хангасан 5. Монгол Улсын иргэн байна.	
Авлигын эсрэг хууль, 21.2.1	Авлигатай тэмцэх газрын даргад нэр дэвшигч нь: 1. Төрийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, 2. 55 нас хүрсэн, 3. Эрх зүйч мэргэжилтэй, 4. Удирдах болон мэргэжлийн ажлын мэдлэг туршлагатай, 5. Сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй.	
Авлигын эсрэг хууль, 21.2.2.	Авлигатай тэмцэх газрын дэд даргад нэр дэвшигч нь: 1. Төрийн албанд 10-аас доошгүй жил ажилласан, 2. Эрх зүйч мэргэжилтэй, 3. Гүйцэтгэх болон мөрдөн байцаах ажлын мэдлэг туршлагатай, 4. Сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй.	
Авлигын эсрэг хууль, 25.2	Авлигатай тэмцэх газрын албан хаагчид нь хоорондоо нэг гэр бүлийн буюу төрөл садангийн холбоотой байхыг хориглоно.	
Авто замын тухай хууль, 6.3	Нийслэлийн авто замын газрын даргыг 1. Авто зам, тээврийн болон эдийн засгийн салбарын мэргэжилтэй, 2. Тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа, Төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
Архивын тухай хууль, 16.4	Аймаг, нийслэлийн архивын эрхлэгчийг 1. Архив, түүх, нийгмийн салбарын мэргэжилтэй, 2. Архивын байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж байгаа, Төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 16.3	Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг 1. Байгаль орчны мэргэжилтэй, 2. Тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа, Төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 26.5	Байгаль орчны хяналтын улсын байцаагчаар 1. Экологи, байгаль хамгаалал, байгаль орчны хяналт, үнэлгээний чиглэлийн мэргэжилтэй, 2. Эсхүл энэ чиглэлээр мэргэшиж дадлагажсан дээд боловсролын зэрэгтэй иргэнийг томилно.	



Газрын тухай хууль, 20.3	Аймаг, нийслэл, дүүргийн газрын албаны даргыг 1. Газрын харилцааны зохих мэргэжилтэй, 2. Тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа 3. Төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
Галын аюулгүй байдлын тухай хууль, 7.1	Гал түймэртэй тэмцэх асуудал эрхэлсэн байгууллагад 1. 18 нас хүрсэн, 2. Монгол Улсын иргэнийг өөрийнх нь хүсэлтээр авч ажиллуулна.	
Гамшгаас хамгаалах тухай хууль, 29.1	Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний харъяа салбар, нэгж болон аймаг, нийслэл, дүүргийн онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчаар 1. Төрийн албаны тухай хуульд заасан шаардлага, гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоосон журам, 2. эрүүл мэнд, бие бялдар, 3. мэргэжил, боловсролын болон 4. ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан иргэнийг авч ажиллуулна.	
Дипломат албаны тухай хууль, 15.1, 15.2	Дипломат албан тушаалд томилогдох иргэн нь 1. Олон улсын эрх зүй, эдийн засаг, улс төр харилцааны онолын зохих бэлтгэлтэй, 2. Дадлага туршлагатай, 3. Дээд боловсролтой, 4. 2 буюу түүнээс дээш гадаад хэлийг шаардлагын түвшинд эзэмшсэн байх бөгөөд нэг нь түгээмэл гадаад хэл байна. 5. Ажлын зайлшгүй шаардлага, 6. Онцгой мэргэшил, 7. Дадлага туршлагыг харгалзан 8. Түгээмэл нэг гадаад хэл эзэмшсэн хүнийг дипломат ажилд томилон ажиллуулж болно.	
Дипломат албаны тухай хууль, 15.4	Дипломат албанд орох иргэнийг сонгон авах болзлыг гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	“Болзол” гэхээр Төрийн албаны тухай хуулийн зөвхөн 16 дугаар зүйл ойлгогдохоор байна.
Дипломат албаны тухай хууль, 16.9	Дипломат төлөөлөгчийн газарт дипломат ажилтан, үйлчилгээ, техникийн ажилтныг томилон ажиллуулахдаа Мэргэжлийн бэлтгэл, 1. Мэргэшил, 2. Боловсрол, 3. Ажилласан хугацааг нь харгалзана.	
Дээд боловсролын тухай хууль, 13.1	Их сургууль, дээд сургууль, коллежид үндсэн мэргэжлийн хичээлийг 1. Магистр, 2. Түүнээс дээш зэрэгтэй багш заана.	Энэ тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйл мөрдөгдөнө.

13.5	Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн албан тушаал, дэд профессор, профессор цолын тодорхойлолт, нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.	
Иргэний бүртгэлийн тухай хууль, 6.8	Аймаг, нийслэл, дүүргийн Иргэний бүртгэл, мэдээллийн албаны даргыг 1. Хууль, хүн ам зүй, эдийн засгийн мэргэжилтэй, 2. Иргэний бүртгэлийн байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж байгаа 3. төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
Иргэний бүртгэлийн тухай хууль, 8.1	Иргэний бүртгэлийн ажилтнаар 1. хууль, хүн ам зүйн болон эдийн засгийн зохих боловсролтой, 2. бүртгэлийн ажлын дадлагатай иргэнийг ажиллуулна.	
Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, 9.4	Улсын байцаагч нь 1. дээд боловсролтой, 2. малын эмч буюу мал зүйч мэргэжилтэй байна.	
Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, 16.3	Хамтарсан болон дагнасан хувийн үйлдвэр, аж ахуйн бусад нэгжийн үйл ажиллагаа эрхэлдэг бол бүрэн эрхийнхээ хугацаанд уул нэгжийн ажлыг эрхлэн удирдаж болохгүй.	
Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 26.2	Баг, хорооны Засаг даргад тухайн нэгжийн нийтийн хуралд оролцож байгаа иргэд 1. төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг, 2. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тухайн хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл хурлын төлөөлөгч, тус тус нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд ... томилуулахаар санал болгоно.	
26.5	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад нэр дэвшигч нь дараахь шаардлагыг хангасан байна. 1. Дээд боловсролтой, 2. Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан, 3. Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх, 4. Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх, 5. Ялгүй байх	Болзол, шаардлагыг хамтад нь “шаардлага” гэсэн ойлголтод багтаасныг харж болно.
26.6	Баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь дараахь шаардлагыг хангасан байна. 1. Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх, 2. Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх, 3. Ялгүй байх	Дээрхтэй мөн адил.

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 18.8	Яамны төрийн нарийн бичгийн даргыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар, томилж, чөлөөлнө.	Төсвийн санхүүжилтийн тухай хуульд тодорхой зохицуулалттай давхардсан байгаа тул хасах.
18 ³ .2	<u>Хуульд өөрөөр заагаагүй бол</u> агентлагийн даргыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонгож, эрхлэх асуудлын хүрээнд нь тухайн агентлаг хамаарч байгаа Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар томилж, чөлөөлнө.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд тодорхой зохицуулалттай давхардсан байгаа тул хасах.
Монгол Улсын Их Хурлын тухай хууль, 40.1	Тамгын газрыг хуульч мэргэжил бүхий Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах бөгөөд түүнийг УИХ-ын даргын санал болгосны дагуу УИХ томилж, чөлөөлнө.	
Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль, 4.1	Комиссын гишүүнд нэр дэвшигч нь 1. Хууль зүйн, улс төрийн өндөр мэргэжилтэй, 2. Хүний эрхийн талаар зохих мэдлэг, туршлагатай, 3. Ял шийтгэлгүй, 4. Монгол Улсын 35 насанд хүрсэн иргэн байна.	
Монгол Улсын Үндсэн хууль, 21.3	УИХ-ын гишүүнээр 1. Монгол Улсын 25 нас хүрсэн, 2. Сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.	
Монгол Улсын Үндсэн хууль, 30.2	Ерөнхийлөгчөөр 1. 45 нас хүрсэн, 2. Сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, 3. Монгол Улсын уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно.	
Монгол Улсын Үндсэн хууль, 51.2	1. Хууль зүйн дээд боловсролтой, 2. Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, 3. Монгол Улсын 35 нас хүрсэн иргэнийг УДШ-ийн шүүгчээр, 1. Хууль зүйн дээд боловсролтой, 2. Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, 3. Монгол Улсын 25 нас хүрсэн иргэнийг Бусад шүүхийн шүүгчээр томилж болно.	
Монгол Улсын Үндсэн хууль, 65.2	Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр 1. Хууль зүй, улс төрийн өндөр мэргэжилтэй, 2. Монгол Улсын 40 нас хүрсэн иргэнийг томилно.	
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, 4.1	Цэцийн гишүүн 1. хууль зүй, улс төрийн өндөр мэргэжилтэй, 2. эрүүгийн ял шийтгэлгүй, 3. Монгол Улсын 40 нас хүрсэн иргэн байна.	



	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 16.4	Санхүүгийн мэдээллийн албаны дарга, хянан шалгагч дараахь шалгуурыг хангасан байна. 1. Банк, санхүү, хууль зүйн салбарт 3-аас доошгүй жил ажилласан, 2. Зээлийн болон баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй, 3. Ял шийтгэлгүй.	
	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль, 6.5	Зөвлөлийн шинжээчээр өндөр мэргэшлийн эрдэмтэн, мэргэжилтнийг орон тооны ба орон тооны бус журмаар томилон ажиллуулна.	
	Нийгмийн даатгалын тухай хууль, 22.3	Нийгмийн даатгалын төв байгууллагын даргыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хуулийн 45.1-д заасны дагуу нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонгож, нийгмийн даатгалын үндэсний зөвлөлтэй зөвшилцөж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд тодорхой зохицуулалттай давхардсан байгаа тул хасах.
	22.4	Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, хэлтсийн даргыг 1. нийгмийн даатгалын байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж байгаа, 2. төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
	26.1	Нийгмийн даатгалын байгууллагад 1. 2-оос доошгүй жил ажиллаж мэргэшсэн, 2. Мэргэжлийн өндөр зэрэгтэй, 3. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтанд нийгмийн даатгалын байцаагчийн эрх олгоно.	
	Нийгмийн халамжийн тухай хууль, 6.3	Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хуулийн 45.1-д заасны дагуу нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонгож нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар томилж, чөлөөлнө.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд тодорхой зохицуулалттай давхардсан байгаа тул хасах.
	10.1	1. Нийгмийн ажилтны боловсрол эзэмшсэн, 2. Нийгмийн хамгааллын ажлын дадлага, туршлагатай, 3. Тухайн ажлыг мэргэжлийн түвшинд эрхлэх чадвартай, 4. Эрх бүхий байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн, 5. Мэргэшсэн нийгмийн ажилтан нийгмийн ажлыг гүйцэтгэнэ.	
	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 21.2	Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий, ахлах болон улсын байцаагч нь мэргэшсэн нягтлан бодогч байна.	

	Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, 8.5	Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн талаар зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг олон нийтийн радио, телевизийн үндсэний Зөвлөл байгуулж болох бөгөөд уг зөвлөлийн бүрэлдэхүүнд сэтгүүл зүй, улс төр, эрх зүй, хэрэглэгчдийн эрх ашиг, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, урлаг, шашин, байгаль орчин, спорт зэрэг чиглэлээр мэргэшсэн хүмүүсийг оруулна.	
	21.3	Үндэсний зөвлөлийн гишүүнд дараахь этгээдийг нэр дэвшүүлэхгүй: 1. Төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч, 2. Улс төрийн намын удирдах албан тушаалтан, 3. Бусад радио, телевизэд ажиллаж байгаа, түүнчлэн ажилладаггүй боловч хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход нь оролцдог этгээд, 4. Бусад радио, телевизэд хөрөнгө оруулалт хийсэн этгээд, эсхүл олон нийтийн радио, телевизийн санхүүгийн хараат бус байдалд нөлөөлж болох этгээд.	
	21.4	Үндэсний зөвлөлийн гишүүнээр 1. Ял шийтгэлгүй, 2. иргэний нийгмийн төлөөллөөс санал болгосон Монгол Улсын иргэнийг томилно.	
	21.6	Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид, эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Улсын Их Хуралд, эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно.	
	30.2	өргөдлийг шалгах хороо нь Үндэсний зөвлөлийн гишүүд болон хүний эрх, сэтгүүл зүй, эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хүмүүсээс бүрдэнэ.	
	31.3	Ерөнхий захирлаар 1. дээд боловсролтой, 2. ял шийтгэлгүй, 3. улс төрийн намын гишүүн бус хүнийг томилно.	
	Орон нутгийн сонгуулийн тухай хууль, 4.3	Тухайн аймаг, нийслэл, суманд байнга оршин суугч, сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн орон нутгийн хурлын төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй.	

	Орон нутгийн сонгуулийн тухай хууль, 20.4	Орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвшигч нь энэ хуулийн 4.3-т зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан байна 1. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх, 2. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх, 3. ял шийтгэлгүй байх, 4. хууль тогтоомжид заасны дагуу намын гишүүнээс түдгэлзсэн төрийн албан хаагч орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвшиж байгаа бол уг ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн байх.	
	Прокурорын байгууллагын тухай хууль, 39.1	1. Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан, 2. Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвараар шаардлага хангасан, хуульчийн мэргэжлээр 3-аас доошгүй, эсхүл прокурорын туслах ажилтнаар 2-оос доошгүй жил ажилласан, 3. Ял шийтгүүлж байгаагүй, 4. 23 нас хүрсэн Монгол Улсын иргэнийг прокуророор томилно.	
39.2		Аймаг, нийслэлийн болон дагнасан прокуророор хуульчийн мэргэжлээр 5-аас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг томилно.	
39.3		Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоор 35 нас хүрсэн, хуульчийн мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг томилно.	
45.1		Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан Монгол Улсын иргэнийг мөрдөн байцаагчаар томилно.	
45.2		Мөрдөн байцаах албаны даргаар хуульчийн мэргэжлээр 5-аас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг томилно.	
	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 11.5	Хорооны гишүүнд дараахь этгээдийг нэр дэвшүүлэхгүй: 1. Төрийн улс төрийн албан хаагч, 2. Улс төрийн намын удирдах албан тушаалтан, 3. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, 4. Санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдэд ажиллаж байгаа этгээд, 5. Санхүүгийн үйлчилгээ явуулж байгаа хуулийн этгээдийн энгийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч.	
11.6		Хорооны дарга, гишүүн нь 1. Эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, 2. Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, 3. Ял шийтгүүлж байгаагүй, 4. монгол Улсын иргэн байна.	

29.4	Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр 1. эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, 2. ажлын дадлага туршлагатай, 3. ёс зүйн хувьд төлөвшсөн, 4. Монгол Улсын иргэнийг томилно.	
29.5	Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр 1. Төрийн улс төрийн албан хаагч, 2. Улс төрийн намын удирдах албан тушаалтан, 3. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, 4. Хорооны дарга, гишүүн болон ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтныг томилохыг хориглоно.	
Соёлын тухай хууль, 15.4	Улсын болон бүс нутгийн, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн соёлын байгууллагын дарга, захирлыг 1. Тухайн салбарын мэргэжилтэй, 2. Соёл, урлагийн байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж байгаа Төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, 4.6	Хорооны гишүүн нь Монгол Улсын ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, прокурор, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчид нэр дэвшигч байхыг хориглоно.	
Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, 23.4	Аймаг, нийслэлийн стандартчиллын даргыг 1. Инженер, техник, технологийн мэргэжилтэй, 2. Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажиллаж байгаа, 3. Төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 12.1	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 1. Сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр дипломын болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй багш ажиллана.	
Статистикийн тухай хууль, 13.4	Үндэсний статистикийн хорооны дарга, Тэргүүн дэд болон Дэд даргыг томилохдоо тэдний 1. Эдийн засаг, статистик, удирдлагын мэдлэг, 2. Ур чадвар, 3. Мэргэжлийн ёс зүй, 4. Ажлын туршлагыг харгалзана.	
16.1	1. Мэргэжлийн ур чадвар, 2. Ажлын дадлага, туршлагыг харгалзан Статистикийн байгууллагын ажилтанг статистикийн улсын байцаагчаар Үндэсний статистикийн хорооны дарга томилж, чөлөөлнө.	



	Тагнуулын байгууллагын тухай хууль, 17.3	Тагнуулын ажилтанд тавигдах ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг тагнуулын байгууллагын дарга тогтооно.	
	Тагнуулын байгууллагын тухай хууль, 17.8	Тагнуулын байгууллагын захиргаа, үйлчилгээний ажилтны эрх зүйн байдлыг Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн хууль, хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна.	
	Таримал ургамлын үр, сортын тухай хууль, 9.3	Үрийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 6 дахь хэсэгт заасны дагуу томилж, чөлөөлнө.	
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 27.10/	Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь зохих шатны Засаг даргатай зөвшилцөн тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газарт хамгаалалтын захиргаа байгуулах асуудлыг шийдвэрлэж, даргыг нь 1. Байгаль орчны мэргэжилтэй, 2. Тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа Төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
	Төв / Монголбанк/ банкны тухай хууль, 26.3	Монголбанкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг томилохдоо түүний 1. Эдийн засаг, банк, санхүү, удирдлагын мэдлэг, 2. Мэргэшлийн үр чадвар, 3. Мэргэжлийн ёс зүй, 4. Ажлын туршлагыг харгалзана.	
	27 ^{1.4}	Хяналтын зөвлөлийн дарга гишүүн нь 1. Банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн чиглэлээр мэргэшсэн, 2. Эдгээр салбарын ажлын дадлага туршлагатай, 3. Ёс зүйн хувьд төлөвшсөн, 4. Монгол Улсын 30-аас дээш насны иргэн, 5. Ял шийтгэлгүй, 6. банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн мэргэжлээр магистрын болон түүнээс дээш зэрэг, цолтой,	
	27 ^{1.5}	Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр банк, санхүү, эдийн засгийн салбарын асуудал хариуцсан төрийн байгууллагад өмнө нь ажиллаж байсан хүнийг томилж болно.	
	27 ^{1.6}	Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр УИХ-ын болон Засгийн газрын гишүүн, төрийн улс төрийн бусад албан тушаалтан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, төрийн захиргааны албан тушаалтан, Монголбанкны удирдах албан тушаалтныг томилж үл болно.	
	28.5	Монгобанкны ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар хариуцуулсан үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаалыг хавсран эрхэлж болохгүй.	



	Төрийн албаны тухай хууль, 34.4	Зөвлөлийн орон тооны 2 гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр нэг хүний нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь 1. төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, 2. мэргэшсэн, 3. ял шийтгэлгүй, 4. 40 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна.	
34.7		Зөвлөлийн даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд нэр дэвшигч нь 1. Төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, 2. Удирдах ажлын дадлага, туршлагатай, 3. Ял шийтгэлгүй, 4. 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна.	
34.9		Зөвлөлийн орон тооны 3 гишүүний дотор нэг нутгийн болон нэг анги хамт төгссөн хоёр хүн байж болохгүй.	
	Төрийн аудитын тухай хууль, 9.3	Энэ хуулийн 13.2, 13.3, 13.6-д заасан шаардлага аймаг, нийслэлийн Ерөнхий аудиторт нэгэн адил хамаарах..	
13.2		Монгол Улсын Ерөнхий аудиторор томилогдох хүн нь дараахь шаардлагыг хангасан байна. 1. Монгол Улсын иргэн байх, 2. 40-өөс дээш настай байх, 3. Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх, 4. Ял шийтгүүлж байгаагүй, 5. эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль, төрийн захиргаа болон холбогдох бусад чиглэлээр боловсролын зэрэгтэй байх, 6. төрийн албанд 10-аас дээш жил ажилласан байх, 7. Монгол Улсын Ерөнхий аудиторын бүрэн эрхэд харшлах аливаа ажил, албан тушаал давхар эрхэлдэггүй, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, мэргэжлийн болон төрийн бус байгууллагад санхүүгийн сонирхолгүй байх.	
13.7		Ерөнхий аудиторын орлогчид нэр дэвшигч нь энэ хуулийн 13.2-т заасан Монгол Улсын Ерөнхий аудиторт тавигдах шаардлагуудыг нэгэн адил хангасан байна.	
14.5		Төрийн аудитын байгууллагын ажилтан үүрэгт ажлаа үр нөлөөтэй гүйцэтгэх мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна.	
		Монгол Улсын Ерөнхий аудитор өөрийн болон бусад ажилтны гэр бүл, төрөл садны хүнийг Үндэсний аудиторын газарт ажилтнаар авч ажиллуулахыг хориглоно.	
Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 18.2		Захирлаар томилогдох этгээд дор дурдсан шаардлага хангасан байвал зохино: 1. дээд боловсролтой, 2. аль нэг хуулийн этгээд буюу түүний салбар нэгжийн удирдах ажлыг 2-оос доошгүй жил хийсэн, удирдлагын зохих дадлагатай, 3. удирдлагын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг.	

18.3	Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хассан, эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн, удирдаж байсан хуулийн этгээдээ дампууруулсан, эсхүл удирдах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс өөрчлөгдсөн этгээдийг таван жилийн дотор захирлаар томилохыг хориглоно.	
21.5	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 21.2-т заасан болзлыг хангасан нэр дэвшигчдээс томилно.	
50.2	Шинжээч нь дараахь шаардлага хангасан байвал зохино: 1. сонгон шалгаруулах төслийн үндсэн мэргэжлийн дээд боловсролтой, уг мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх, 2. багд орох бусад шинжээчдийн хувьд нягтлан бодох бүртгэл, санхүү-эдийн засаг, эрх зүйн болон шинжлэх ухаан, техникийн талаар тухайн төслийн агуулгатай холбогдох дээд боловсролтой, зохих дадлагатай байх, 3. ял шийтгэлгүй, 4. төсөл буюу хувьчлах эд хөрөнгийн талаар ямар нэгэн хувийн сонирхолгүй байх	
69.3	Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд түүнийг Сангийн яамны зөвшөөрөлтэйгээр захирал томилно.	
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 47.3	Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орсон албан тушаалтан дараахь шаардлагыг хангасан байвал зохино: 1. худалдан авах ажиллагааны чиглэлээр, эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн байх, 2. тендерт оролцогч болон түүнийг төлөөлөх этгээдийн эцэг, эх, хадам эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд биш байх, 3. сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчтой хөдөлмөрийн гэрээний харилцаанд ороогүй байх, 4. энэ хуулийн 50.1-д заасан төрийн албан хаагчийн үүргийг сүүлийн 1 жилийн хугацаанд зөрчөөгүй.	
Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, 13.2	Төрийн тусгай хамгаалалтын албанд 1. 20 нас хүрсэн, 2. Эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, 3. Зохих боловсрол, ажлын туршлагатай, 4. Ял шийтгэлгүй, 5. Монгол Улсын иргэнийг ажиллуулна.	
Төрийн хяналтын тухай хууль, 10.2	Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллагын даргыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1-д заасны дагуу нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонгож Монгол Улсын ерөнхий сайд томилж, чөлөөлнө.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд тодорхой зохицуулалттай давхардсан байгаа тул хасах.

10.11	Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын даргыг 1. Төрийн хяналт, шалгалтын байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас 2. Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, 5.1.3	Албан хаагчийг зөвхөн 1. Мэдлэг, боловсрол, 2. Мэргэжил, туршлага, 3. Мэргэшлийн үр чадварын үндсэн дээр нээлттэй өрсөлдөөний зарчмаар томилох,	Төрийн албаны тухай хуулийн 17.4 дэх хэсэгтэй зөрчилдсөн шинжтэй.
17.1.12	Ерөнхий менежер ажилтныг ажилд томилохдоо .. энэ хуулийн 5.1.3-т заасан зарчмыг баримтлах	
21.2	Төрийн өмчийн хороо төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилохдоо төрийн албаны төв байгууллагаас энэ хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж санал болгосон, дараахь болзлыг хангасан нэр дэвшигчдээс томилно: 1. Тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвартай, 2. Тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхад ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй.	
43.1	Төрийн албаны төв байгууллага нь төсвийн байгууллагын удирдах албан тушаалтныг энэ хуулийн 5.1.3 -т заасан зарчмыг баримтлан сонгоно.	
48.1	Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын ерөнхий менежер албан хаагчийг томилохдоо тухайн ажлын байранд тавигдах шаардлагын дагуу 1. Мэдлэг, боловсрол, 2. Мэргэжил, туршлага, 3. Мэргэшлийн үр чадварыг нь үндэслэх зарчмыг баримтална.	
51.1.6	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ерөнхий менежерийг улсын төсвийн байгууллага, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ерөнхий менежерийг томилдог зарчимтай ижил зарчмаар шалгаруулан томилох, үр дүнгийн гэрээ байгуулах.	
Харилцаа холбооны тухай хууль, 8.6	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, дараахь шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Зохицуулах хорооны дарга, гишүүнээр томилно: 1. Эдийн засаг, мэдээлэл холбоо, техник, хууль зүй, удирдлагын дээд боловсролтой, 2. өндөр мэргэжил, ажлын туршлагатай, 3. удирдан зохион байгуулах чадвартай, 4. зохицуулах хорооны дарга, гишүүн нь үйлчлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй.	

	Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, 17.5	Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллагын даргыг 1. инженер техник, технологийн мэргэжилтэй, 2. мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
	Хүнсний тухай хууль, 9.5	Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний технологич нь мэргэжлийн байна.	
	12.2	Хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагчийг Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 2, 3, 4, 6 дахь хэсэгт заасны дагуу томилж, чөлөөлнө.	
	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, 17.4	Аймаг, нийслэлийн хүүхдийн байгууллагын даргыг 1. нийгмийн салбарын болон хүүхдийн байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж байгаа, төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, 20.5	Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга, ажилтнуудыг үндэсний зөвлөлийн гишүүнээр батлахыг хориглоно.	
	21.2	Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1-д заасны дагуу нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонгож, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албаны даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд тодорхой зохицуулалттай давхардсан байгаа тул хасах.
	Хөдөлмөрийн тухай хууль, 7.2	Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах	
	7.4	Иргэнийг ажилд авахад эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд хувийн амьдрал, үзэл бодолтой холбоотой, гэрлэлтийн байдал, намын харъяалал, шүтдэг шашных нь тухай болон жирэмсэн эсэх талаар асуулт тавьж болохгүй.	
	27.1	Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой /51 буюу түүнээс дээш хувьтай/ хуулийн этгээдэд нэг гэр бүлийн буюу төрөл садангийн хүмүүс хөрөнгө мөнгө захиран зарцуулах ажил, албан тушаалд хамт ажиллахыг хориглоно.	
	28.1	Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно.	
	28.2	Энэ хуулийн 28.1 нь хавсран ажиллахад нэгэн адил хамаарна.	

	Цагдаагийн байгууллагын тухай хууль, 29.2	Цагдаагийн албанд 1. 18 нас хүрсэн, 2. Ял шийтгэлгүй, Монгол Улсын иргэнийг хүсэлтээр нь авч ажиллуулна.	
	29.3	Цагдаагийн байгууллагад ажиллах иргэний эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, боловсролын болон ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг цагдаагийн төв байгууллага тогтооно.	
	Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль, 7.2	Цацрагийн хяналтын байцаагч нь 1. Цацрагийн хяналтын чиглэлээр мэргэшсэн, 2. Зохих шалгалт өгч тэнцсэн байна.	
	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, 8.1.12	Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын захирал /дарга/-ын ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.	
	19.3	Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн тодорхойлолт, нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	
	Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль, 13.1	Хянан зохицуулах албаны улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлж, мөн хуулийн 23 дугаар зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаагаар хангагдана.	
	Шүүхийн тухай хууль, 28.1	Шүүгчид дараахь шаардлага хангасан Монгол Улсын иргэн нэрээ дэвшүүлэх эрхтэй: 1. Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзлыг хангасан, 2. Ял шийтгүүлж байгаагүй, Хуульдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан	
	28.3	Анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчид 3-аас доошгүй жил ажилласан шүүгч нэрээ дэвшүүлэх эрхтэй.	
	28.4	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид Улсын дээд шүүхийн шүүгч нэрээ дэвшүүлэх эрхтэй.	
	30.3	Мэргэшлийн хороо нь 1. Хууль зүйн өндөр мэргэшилтэй, 2. Хуулийн болон шүүн таслах ажлын дадлагатай шүүгч, хуульч, эрдэмтдээс бүрдэнэ.	
	30.5	Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны гишүүн орохгүй.	



31.1	Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн 1. Эрх зүйн мэдлэг, ажил хэргийн чадварын талаар гаргасан Мэргэшлийн хорооны дүгнэлт, 2. Хувийн зан суртахуун, 3. биеийн эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан нэр дэвшигч нэг бүрээр хэлэлцэн нууцаар санал хурааж, олонхийн санал авсан нэр дэвшигчийг шүүгчээр томилуулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.	
34.3	Шүүгч багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.	
66.2	Гүйцэтгэх нарийн бичгийн дарга 1. хууль зүйн дээд боловсролтой, 2. мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан 3. шүүхийн ажлын дадлага туршлагатай, 4. ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэн байна.	
72.2	Судалгааны төвийн судлаачид мэргэшсэн байна.	
73.3	Шүүгчийн туслах нь 1. хууль зүйн дээд боловсролтой, 2. ял шийтгэлгүй Монгол Улсын иргэн байна.	
74.2	Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь 1. хууль зүйн дээд боловсролтой, 2. ял шийтгэлгүй Монгол Улсын иргэн байна.	
79.2	Шүүгчид хуулиар хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.	
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 132.4	Шийдвэр гүйцэтгэгч 1. ял шийтгэлгүй, 2. шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтаар тэнцсэн Монгол Улсын иргэн байна.	
132.6	Хорих байгууллагын албан хаагч нь 1. 18 насанд хүрсэн, 2. Ял шийтгэлгүй, Зохих мэргэжлийн сургалтад хамрагдсан Монгол Улсын иргэн байна.	
132.7	Хорих байгууллагад ажиллах иргэний эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар тогтооно.	“Ёс зүйн шаардлага” гэж заасан нь Төрийн албаны тухай хуулийн 10.2 дахь заалттай зөрчилдөнө.
Эрчим хүчний тухай хууль, 11.2	Зохицуулах зөвлөлийн гишүүнийг томилох, ажиллах журмыг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	
Эрүүл мэндийн тухай хууль, 3.1.7	“Эмнэлгийн мэргэжилтэн” гэж анагаах ухааны дээд, дунд боловсролтой хүний их, бага эмч, сувилагч, эм зүйч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, шүдний эмч, эмнэлгийн бусад мэргэжилтнийг хэлнэ.	

	Эрүүл мэндийн тухай хууль, 11.6	Аймаг, нийслэл, дүүргийн эрүүл мэндийн газрын даргыг 1. Эрүүл мэндийн салбарын мэргэжилтэй, 2. Тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.	Нэг хэм хэмжээ болгох
УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоол, Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам, 1.5	Төрийн жинхэнэ албан тушаалд тавих ерөнхий болон тусгай шаардлага, ёс зүйн хэм хэмжээ, Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол хангасан Монгол Улсын иргэн сонгон шалгаруулалтад орно.		
	Засгийн газрын 2001 оны 131 дүгээр тогтоол, Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн, шууд захирагч нарын төсвийн ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх журам, 2.2	Төсвийн ерөнхий нягтлан бодогчоор дараахь шаардлага хангасан хүнийг ажиллуулна: 1. төсвийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэжлийн магадлан итгэмжлэгдсэн дээд сургуулийг төгссөн, бакалавраас доошгүй зэрэгтэй, нягтлан бодогч эсвэл эдийн засагч-нягтлан бодогч мэргэжил эзэмшсэн байх, 2. шууд захирагч нарын ерөнхий нягтлан бодогч нь төсвийн байгууллагын бүртгэл тооцооны ажил дээр 2-оос доошгүй жил ажилласан байх, 3. төвлөрүүлэн захирагч нарын ерөнхий нягтлан бодогч нь төсөвт байгууллагын ерөнхий нягтлан бодогч, эсхүл төвлөрүүлэн захирагчийн тооцооны нягтлан бодогчийн ажлыг 3-аас доошгүй жил гүйцэтгэсэн, туршлагатай мэргэшсэн нягтлан бодогч байх, 4. ерөнхийлөн захирагчийн төсвийн ерөнхий нягтлан бодогч нь төсөвт байгууллагын ерөнхий нягтлан бодогч, эсвэл санхүүгийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн нягтлан бодогч байх, 5. төрийн албаны тухай хуульд заасны дагуу туршилтын хугацаатай ажиллуулсан тохиолдолд туршилтын нэг жил хүртэлх хугацаанд ажлын шаардлага бүрэн хангаж байгаа нь нотлогдсон, 6. ял шийтгэлгүй, татварын болон банкны зээлийн өр төлбөргүй, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 36, 43.2, 43 ¹ дүгээр зүйлийн дагуу захиргааны шийтгэлгүй байх, 7. тухайн төсвийн эрх захирагчийн гэр бүлийн буюу төрөл садангийн хүмүүс ерөнхий нягтлан бодогчоор ажиллахыг хориглоно.	
Засгийн газрын 2002 оны 40 дүгээр тогтоол, Усан замын тээврийн хэрэгсэлд хяналт тавьж, бүртгэх журам, 1.5	Техникийн комиссын гишүүд болон улсын байцаагч нь 1. авто буюу усан замын тээврийн инженер, эсхүл эдийн засагч мэргэжилтэй, 2. энэ чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, 3. мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, 4. дадлага туршлагатай, 5. хууль зүйн зохих мэдлэгтэй байна.		



**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН
ТОО БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ (2005-2008)***К. Пүрэвсүрэн*

Төрийн албан хаагчдын талаарх тоо бүртгэл, төрийн албанд шинээр нэмэгдсэн орон тоо, тэдгээрт зарцуулагдах төсвийн зардлын хэмжээг холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл, судалгаанд тулгуурлан нэгтгэн гаргах боломжгүй байна. Учир нь улсын хэмжээнд нийт 4000 орчим төрийн байгууллага байдаг ба тооллогыг явуулах аргачлал нь төрийн албан хаагчийн ангилал зэрэглэл болон яам, агентлагийн гэх мэт салбар чиглэлээр нь бүртгэлийг багцалж гаргадаг тухай Төрийн албаны зөвлөлөөс тайлбар өгсөн болно

Төрийн албан хаагчийн тоо бүртгэлийн явцад зарим байгууллагыг толгой байгууллагынх нь нэгжид хамааруулан тоолсон ба энэ нь ТЕГ-ын харьяа Улсын бүртгэлийн албанаас олгосон Улсын бүртгэлийн дугаар бүхий гэрчилгээтэй, бие даасан хуулийн этгээдүүдийг төрийн байгууллага хэмээн үзсэн ба харин зарим яамны нэгж байгууллага нь бие даасан хуулийн этгээд гэх боловч Улсын бүртгэлийн өөрийн дугааргүй учир Төрийн байгууллага гэж үзээгүй дээд байгууллагынх нь нэгэн нэгж гэж үзсэн байна. Мөн зарим нууцын зэрэглэлтэй байгууллага тоон бүртгэлд хамрагдаагүй тул нийт төрийн байгууллагын тоог ойролцоогоор 4000 гэсэн болно.

Мөн төрийн албан хаагчдын дунд өөр албан ажлыг хавсран гүйцэтгэх явдал багагүй байдаг нь бодит тоог хүн нэг бүрээр гаргахад хүндрэлтэй байдаг байна. Цалингийн сангийн талаарх мэдээллийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийн дагуу төсөв ерөнхийлөн захирагчийн багцанд тусгасан төсвөөс авч нэгтгэсэн болно Дашрамд дурдахад Өдрийн сонинд нийтлэгдсэн Төрийн албан хаагчдын тоо 10.0 мянгаар зөрсөн тухайд тодруулга хийсэн ба энэ нь дээр дурдсан давхар ажил эрхлэлт болон хүчний байгууллагын албан хаагчдын тоотой холбоотой бөгөөд Сангийн яамнаас албан хаагчийн тоог гаргахдаа цалинждаг тоогоор гаргасан байдаг нь дээрх хоёр байгууллагын тоон үзүүлэлт зөрүүтэй болоход хүргэсэн байна.

Төрийн албан хаагчдын орон тооны өөрчлөлтийн талаар Төрийн албаны зөвлөлөөс санал авах тухай Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8-т “төрийн байгууллагын өөрчлөлт, хөгжлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийн төлөвлөлтийн арга зүй, удирдлагаар хангах, ...” мөн зүйлийн 35.1.11-т “төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг боловсруулан батлахад санал өгөх, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийхэд мэргэшил арга зүйн зөвлөгөөгөөр хангах” гэж заасан боловч төрийн захиргааны байгууллагын бүтэц зохион байгуулалт, орон тооны өөрчлөлтийн шийдвэрийг Засгийн газар, Улсын Их Хурал хуулийн дагуу Төрийн албаны зөвлөлөөс санал авахгүйгээр гаргадаг байна.

Үүнтэй холбоотой төрийн албан хаагчдын шилжилт хөдөлгөөн гарах үед тухай бүрт нь мэдээллийг авч чаддаггүйгээс төрийн албан хаагчдийн орон тооны өөрчлөлтийн нарийвчилсан тоон мэдээлэл тэр бүр гардаггүй ба зөрүүтэй байдаг тухай Төрийн албаны зөвлөлийн мэргэжилтэн тайлбарлав. Дараах багцаар гаргасан мэдээллийг Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн газраас авсан мэдээ, материалд тулгуурлан гаргасан болно. Иймд олдсон мэдээлэл болон Монгол Улсын 2006 – 2008 оны төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайланд тулгуурлан төрийн албан хаагчдын тоо, цалингийн сангийн өсөлтийн талаар зарим үзүүлэлтийг хавсралт хүснэгтээр нэгтгэн гаргав.

* * *

ЯАМД, АГЕНТЛАГИЙН 2006-2008 ОНЫ ОРОН ТООНЫ ТОЙМ ҮЗҮҮЛЭЛТ

Хавсралт 1

Төрийн байгууллага		2006 он		2007 он		2008 он	
		Орон тоо	Өсөлт, бууралт	Орон тоо	Өсөлт, бууралт	Орон тоо	Өсөлт, бууралт
Яамд	Гадаад хэрийн яам	397		540	+ 143	540	0
	Санхүү, гааль татвар	2389		2697	+ 308	2697	0
	ХЗДХЯ	15743		2727	-13016	18625	+15898
	Байгаль орчны яам	2246		2564	+318	2564	0
	Батлан хамгаалах яам	7290		674	-6616	9606	+8932
	БСШУЯам	50078		58074	+7996	58329	+255
	Барилга, хот байгуулалтын яам	440		939	+499	939	0
	ЗТАЖЯам	88		194	+106	194	0
	Түлш, эрчим хүчний яам	56		95	+39	113	+18
	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	2384		103	-2281	2023	+1920
	Үйлдвэр худалдааны яам	268		325	+57	325	0
	ХХААЯам	549		570	+21	570	0
Эрүүл мэндийн яам	20466		24653	+4187	24635	0	
Агентлаг	Улсын мэргэжлийн хяналтын газар	1437		1661	+224	1661	0
	Онцгой байдлын Ерөнхий газар	2537		3135	+598	3135	0

Тайлбар: 2005 онд яамдын харьяаллаар нарийвчлан гаргасан бүртгэлийг ТА3-өөс ирүүлээгүй ба ҮСГ-аас болон бусад эх сурвалжаас хайхад уг мэдээлэл олдоогүй тул тухайн онд бүртгэгдсэн нийт төрийн албан хаагчийн тоог оруулав. 2005 оны тайлан мэдээ байхгүйгээс 2006 оны өсөлт, бууралтыг тооцоогүй болно.

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН 2005-2008 ОНЫ
ЦАЛИНГИЙН САНГИЙН ТОЙМ ҮЗҮҮЛЭЛТ**

Хавсралт 2

Төрийн байгууллага		2005 он	2006 он	2007 он	2008 он
		Цалингийн сан /мян.төг/ ¹	цалингийн сан /сая. төг/ ²	цалингийн сан /сая. төг/ ²	цалингийн сан /сая. төг/ ³
МУ-ын Ерөнхийлөгчийн ТГ-ын даргын төсөвийн багц			126.0 /үндсэн цалин/	1,611.0	1,840.9
УИХ-ын ТГ-ын ЕНБДарга		466,899.3	649.4	1,002.8	2,390.5
Ерөнхий сайд		3,319,204.4	3,120.1	4,373.7	8,381.3
ЗГХЭГ-ын дарга		804,679.5	884.2	1,600.1	2,832.2
Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч		114,053.7	174.36	228.05	507.5
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга		1,444,990.7	2,019.2	2,639.5	6,381.9
Улсын ерөнхий прокурор		1,019,981.6	1,388.2	1,880.6	4,160.5
Яамд	Гадаад хэргийн сайд	3,787,703.1	4,054.8	5,093.4	7,446.5
	Сангийн сайд	3,700,160.0	5,052.1	6,800.5	14,260.8
	ХЗДХэргийн сайд	18,684,854.0	26,863.3	34,908.5	68,823.5
	Байгаль орчны сайд	1,970,477.3	2723.9	3901.9	9198.7
	Батлан хамгаалахын сайд	9,791,183.3	13,930.5	18,205.5	34,609.7
	БСШУ-ны сайд	52,950,586.3	53,267.40	Байхгүй	Байхгүй
	Барилга, хот байгуулалтын сайд	465,463.9	687.3	1448.9	3272.1
	ЗТАЖ-ын сайд	110,433.5	174.6	253.1	2,953.8
	Түлш, эрчим хүчний сайд	157,490.3	237.1	288.8	1,369.1
	НХХөдөлмөрийн сайд	872,822.7	871.7*	Байхгүй	Байхгүй
	Үйлдвэр, худалдааны яам	480,987.6	956.6	1119.9	2288.1
	ХХАА-н сайд	606,456.6	835.0	1,048.1	3,098.6
	Эрүүл мэндийн сайд	24,194,619.2	33437.27	42152.35	96836.06

Агентлаг	Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд	1,991,838.5	2,932.3	3,944.2	7082.7
	Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд	3,969,964.5	5,664.50	7,948.90	14,976.04

* * *

Тайлбар: УИХ-д ажлаа тайлагнадаг зарим байгууллагууд болон агентлагуудын талаарх хүснэгт дэх мэдээлэл ашигласан материалд бүрэн тусгагдаагүй байх тул яамд, УИХ-д ажлаа тайлагнадаг зарим байгууллагын түвшинд мэдээллийг гаргав.



(Footnotes)

¹ Монгол Улсын 2005 оны төсвийн гүйцэтгэлийн хураангуй тайлан 2006 он

² Монгол Улсын 2008 оны төсвийн төсөл

³ Монгол Улсын 2008 оны төсвийн төсөл

⁴ Монгол Улсын Төрийн албан хаагчийн 2007 оны тоо бүртгэл



ТӨРИЙН САНГИЙН ЗЭЭЛЭЭР ӨНДӨР ХӨГЖИЛТЭЙ ОРНУУДАД СУРАЛЦАГЧДЫН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

Ц. Төвүүсүрэн, П. Тогоо

Монгол Улсын “Дээд боловсролын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 3 дах хэсэгт зааснаар төрийн сангийн хөрөнгөөр дээд боловсрол эзэмшүүлэх журмыг Засгийн газар тогтоохоор заасны дагуу 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 тоот тогтоол гаргаж “Сургалтын төрийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам”-ыг 1 дүгээр, Монгол улсын болон гадаадын дээд боловсролын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг 3 дугаар, “Гадаадын дээд боловсролын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг 5 дугаар хавсралтаар батлан мөрдүүлж байна.

Монгол Улсын БСШУЯ-ны сайд, СЭЗЯ-ны сайдын хамтарсан 2001 оны 310\290 тоот тушаалаар “Өндөр хөгжилтэй орнуудад магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ыг батлагдан гаргаснаас хойш 2001-2008 оны хооронд өндөр хөгжилтэй орнуудад давхардсан тоогоор 2125 суралцагчдыг сургасан байна. Ингэхдээ жилд 208-285 суралцагч явуулсан бөгөөд нэг суралцагчид зарцуулсан жишиг төлбөр жилд 2500-16000 сая төгрөг, нийт 21,3 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Үүнээс 199,0 сая төгрөгийн зээлийг эргэн төлжээ. \Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт - 1-ээс үзнэ үү\

БСШУЯ-ны Сургалтын төрийн сангаас ирүүлсэн мэдээллээс суралцагчдыг орон орноор нь авч үзвэл: ОХУ-44, АНУ-27, Англи-15, ХБНГУ-10, Япон-4, Австралид-3, Казакстанд-3, Франц-2, Украин-2, Нидерландад-2, Норвегид-1, Швецарид-1, Шинэ Зеландад-1, Чехд-1, Шведэд-1 оюутан тус тус суралцсан байна. \Хүснэгт-1\

ХЗДХЯ-ны захиалгаар 31, БСШУЯ-ны захиалгаар-21, ЭМЯ-ны захиалгаар-22, ХААХҮЯ-ны захиалгаар-3, Удирдлагын академийн захиалгаар 1, УИХТГ-ын захиалгаар 4, ГХЯ-ны захиалгаар 8, Сангийн яамны захиалгаар 13, БОЯ-ны захиалгаар 2, БХЯ-ны захиалгаар 4, ЗГХЭГ-ын захиалгаар 1, БХБЯ-ны захиалгаар 1, Монгол банкны захиалгаар 2, ЗТАЖЯ-ны захиалгаар 1, ММ агентлагийн захиалгаар 1, ЭБЭХЯ-ны захиалгаар 1, ҮСХ захиалгаар 1 хүн тус тус суралцсан байна.

Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журмаар Сургалтын төрийн сан, суралцагч хоёрын хооронд байгуулдаг гэрээгээр энэ харилцааг зохицуулж иржээ. Жич: Энэхүү мэдээллийг БСШУЯ-ны харьяа Сургалтын төрийн сангаас албан тоотоор ирүүлсэн мэдээллийг үндэслэн бэлтгэв. Өндөр хөгжилтэй оронд төрийн сангийн зээлээр суралцуулах асуудлыг дараах байдлаар эрх зүйн хувьд зохицуулж байна. \Хавсралт-2\



2001 - 2008 онуудад сургалтын төрийн сангийн зээлээр өндөр хөгжилтэй орнуудад магистрантурт, аспирантурт, докторантурт суралцагчдын судалгаа

Хавсралт-1

№	Улс	Сургууль	Оюутны тоо	Захиалагч байгууллага	Төгсөөд байгууллагадаа ажиллаж байгаа
1	ХБНГУ	Бремений их сургууль	10	ХЗДХЯ-3 БСШУЯ-2 ЭМШУИС-3 ХҮХААЯ-1 УА-1	1
2	ОХУ	- ДЯА академи хуулийн ДС - Дипломатын академи -ЭЗ академи эмч нарын МД - Ивановын нэхмэлийн академи - барилга архитектур - Москвагийн цэргийн сургууль - Москва НУ - Боловсролын ИС - Эрхүү ЭЗ академи	44	ХЗДХЯ-21 УИХТГ-1 ГХЯ-6 Сангийн яам-2 БСШУЯ-3 ТТХ-1 ЭМШУИС-4 БОЯ- ОБЕГ-3 БХЯ-1 ЗГХЭГ-1	44
3	Англи	-Вестмистерийн ИС - Дипломатын академи - Рийдийн ИС - Холборон коллеж - Худалдааны сургууль -Бирмингхамын ИС	15	УИХТГ-1 ГХЯ-1 САНГИЙН ЯАМ-2 БСШУЯ-4 ХХААЯ-1 ХЗДХЯ-3 ЭМШУИС-2 БХБЯ-1	15
4	АНУ	-Колорадогийн ИС - Ютагийн ИС - Домникан коллеж - Орегоы ИС - Брижпортын ИС - Вашингтоны ИС - Westwind-ийн академи Texas АДЖ -Олон улсын харилцааны сургууль -Пенсальванийн ИС	27	Сангийн яам-7 Монгол банк-2 ММАгентлаг-1 ЭМШУИС-6 УИХТГ-2 ХЗДХЯ-3 БОЯ-1	27

5	Франц	-Сорбоны ИС - Электре ИС	2	БСШУЯ-1 ГХЯ-1	2
6	Япон	Хирошима ИС -Токиогийн ИС	4	БСШУЯ-2 ЭМШУИС-1 Сангийн яам-1	4
7	Норвеги	Бергений ИС	1	БСШУЯ-1	1
8	Швецари	Женевийн ИС	1	БСШУЯ-1	1
9	Украин	Харьковийн ИС	2	БСШУЯ-2	1
10	Нидерланд	Нийгмийн судалгаа Агаар зураг	2	БСШУЯ-1 ЭХЭБЯ-1	2
11	Шинэ Зеланд	Окландын ИС	1	Сангийн яам-1	1
12	Казакстан	-Мэдрэлийн мэс засал -Элгэний эмгэг -Микробиологи	3	ЭМШУИС-3	3
13	Чех	Вилончелийн ИС	1	БСШУЯ-1	1
14	Швед	Нийгмийн эрүүл мэнд	1	БСШУЯ-1	1
15	Австрали	-Свинбурн ТИС - Өмнөд Уэльсийн ИС - Куртин ИС	3	ҮСХ-1 ЭМШУИС-2	3
Нийт			117		117

Тайлбар:

- Орон, сургуулийн нэр, оюутны тоо, захиалагч байгууллагыг нэгтгэж гаргасан болно.

* * *

**СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН ЗЭЭЛЭЭР ӨНДӨР ХӨГЖИЛТЭЙ ОРНУУДАД
СУРАЛЦАГЧДЫН САНХҮҮГИЙН СУДАЛГАА**

№	Онууд	Суралцагчын тоо	Нэг суралцагчид зарцуулсан жишиг төлбөр	Нийт суралцагчид зарцуулсан санхүүжилт /сая,төг/	Сургалтын төрийн сангийн зээлийн эргэн төлөлт /сая төг/
1	2001 он	279	2500-16000	2381,8	0

2	2002 он	280	2500-16000	2427,6	0,6
3	2003 он	281	2500-16000	2844,0	0
4	2004 он	270	2500-16000	3426,3	11,7
5	2005 он	275	2500-16000	2924,4	14,2
6	2006 он	247	2500-16000	2604,2	83,0
7	2007 он	208	2500-16000	2065,1	80,5
8	2008 он	285	2500-16000	2701,1	9,0
	Дүн	2125	0,0	21374,5	199,0

Жич: 1. Суралцагчдын тоо давхардсан тоогоор болно. 2. МУЗГ-ын 2008 оны 178 дугаар тогтоолоор нийт 50 суралцагчдад хамааралтай 930168 ам.долларын зээлийг чөлөөлсөн болно.

* * *

Хавсралт-2

№	Хууль, эрх зүйн актуудын нэр	Шийдвэрийн хэлбэр, огноо	Зохицуулж буй харилцаа
1	Дээд боловсролын тухай хууль	7.3 дах хэсгийн заалт	7.3 “сургалтын төрийн сангийн хөрөнгөөр дээд боловсрол эзэмшүүлэх журам”-ыг Засгийн газар батална.
2	МУ -ын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох журам	ЗГ-ын 2008 оны 177-р тогтоолын 3 дугаар хавсралт	МУ-ын магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролы сураглтын байгууллага /цаашид “сургууль” гэнэ/ баклавр, магистр, докторын өдрийн сургалтанд зохих журмын дагуу элсэн суралцаж байгаа МУ-ын иргэнд сургалтын төлбөрийн төрийн буцалтгүй тусламж олгох, хоёр улсын ЗГ хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүйгээр суралцаж байгаа МУ-ын иргэнд амьжиргааны тэтгэлэгийн буцалтгүй тусламж олгох болон хоёр улсын ЗГ хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэнд суралтын төлбөр, амьжиргааны тэтгэлгийн буцалтгүй тусламж олгох нөхцөл бүрдүүлэх матераил, төрийн буцалтгүй тусламжийн санхүүжилтийн асуудлыг зохицуулсан.

3	Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам	БСШУЯ-ны сайд, СЭЗ-ийн сайдын 2001 оны 310/290 дугаар тушаалын хавсралт	Өндөр хөгжилтэй /АНУ, ОХУ, Австрали, Герман, Франц, Канад зэрэг/ орны нэр хүндтэй сургуулиудад магистр, аспирантур, докторантурын сургалтанд хамрагсдын сургалтын болон тэтгэлэгийн зардлыг санхүүжүүлэх суралцагчдыг сонгон шалгаруулах, суралцагч болон сургалтын төрийн сангийн хооронд байгуулах гэрээний нөхцөл, бололц, тэтгэлгийн зээлийг эргэн төлөх, эргэн төлөгдсөнд тооцож шийдвэр гаргах, маргааныг шийдвэрлэх асуудлыг зохицуулсан.
4	Сургалтын төрийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам	ЗГ-ын 2008 оны 177 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт	Сургалтын төрийн сангаас дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зохих журмын дагуу төрийн буцалтгүй тусламж, зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулах, сангийн удирдах зөвлөлийг байгуулах, зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр, чиг үүрэг, сангийн захиргааг байгуулах, захиргааны чиг үүрэг, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, захиран зарцуулах, сангийн бүрэн эрхийн асуудлыг зохицуулсан
5	Гадаадын дээд боловсролын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам	ЗГ-ын 2008 оны 177 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт	ОУ-д нэр хүндтэй, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад зохих журмын дагуу элссэн оюутан, магистрант, докторант /цаашид суралцагч гэнэ/-ын сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг, эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг сургалтын төрийн сангаас зээлийн хэлбэрээр санхүүжүүлэх, суралцагчыг шалгаруулах, суралцагчтай гэрээ байгуулах, суралцагчийн бүрдүүлэх материал, санхүүжилт олгох асуудлыг зохицуулсан
6	Гадаадын дээд боловсролын байгууллагад суралцагчдад буцалтгүй тусламж олгох тухай гэрээ	БСШУ-ы сайд, Сангийн сайдын 2008 оны 70/369 дүгээр хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт	Хоёр улсын ЗГ хоорондын хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүйгээр суралцаж байгаа Сургалтын төрийн сантай гэрээ байгуулсан МУ-ын иргэнд амьжиргааны тэтгэлэг олгох, гэрээний талууд болон сургалтын төрийн сан, суралцагчын эрх, үүрэг, гэрээг сунгах зэрэг асуудлыг зохицуулсан
7	Зарим хүмүүсийг сургалтын сангийн зээл, түүний хүүгийн төлбөрөөс чөлөөлөх тухай	ЗГ-ын 2008 оны 5 сарын 14-ний өдрийн 178 дугаар тогтоолын хавсралт	Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадын боловсролын сургалтын байгууллагад суралцан төгсч, эзэмшсэн мэргэжлээрээ 5 болон түүнээс дээш жил үр бүтээлтэй ажиллаж байгаа нэр бүхий 50 хүнийг сургалтын төлбөр болон амьжиргааны тэтгэлэгийн зээл, түүний төлбөрөөс чөлөөлсөн байна.



4

БҮЛЭГ

ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБА, СУДАЛГААНЫ ТӨВҮҮДИЙН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ,
БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

УИХ-ЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГЖИЙН ТҮҮХЧИЛСЭН ТАНИЛЦУУЛГА

Ц. Норовдондог (Ph.D), О. Нарантуяа

1990 - 1994 он. Төр, нийгэм судлалын академи

1990 оны 6 дугаар сард явагдсан бүх ард түмний анхны чөлөөт ардчилсан сонгуулийн үр дүнд байгуулагдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын 1991 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Улс төрийн дээд сургуулийг татан буулгаж, нийгэм-улс төрийн шинэ нөхцөл байдал үүссэнтэй уялдуулан Улсын Бага Хурлын дэргэд Төр, нийгэм судлалын академи байгуулсан.

Энэхүү Төр, нийгэм судлалын академийн гүйцэтгэх чиг үүрэг нь Төрийн байгуулалт, эрх зүй, улс төр судлал, социологи, төрийн эдийн засаг, нийгмийн бодлогын асуудлаар судалгаа явуулах, батлагдсан хуулийг таниулах, дэлхийн улс орнуудын парламентад ёсыг судалж, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэдтэй хамтын ажиллагаа явуулах, Ардын Их Хурал, Улсын Бага Хурал, Улсын Ерөнхийлөгч болон өөрийн үйл ажиллагаанд шаардагдах мэдээллийн сан бий болгож, өөрийн номын сан байгуулах...зэрэг тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байжээ.

1994 - 1996 он. УИХ-ын дэргэдэх Судалгааны төв

1994 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн УИХ-ын 15 тоот тогтоолоор Төрийн бодлого, нийгмийн асуудал судлах академийг УИХ-ын харъяанд шилжүүлэн ажиллуулах болсон байна. Төр, нийгмийн судлалын академийг БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор тус улсын улс төрийн тогтолцоо, зах зээлийн харилцааны шинэ нөхцөлд төрт ёсны монгол уламжлалыг судлан эзэмших, төрийн бодлого, үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэл, үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагад нийцүүлэх ... зорилго бүхий эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага байв.

Судалгааны төв нь захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, секторын эрхлэгч 2, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан 2, ахлах ажилтан 2, ажилтан 3, туслах ажилтан 2, нягтлан бодогч нийт 16 орон тоотой үйл ажиллагаа явуулж байсан. 1996 оны УИХ-ын хоёрдахь удаагийн сонгуулийн дүнд байгуулагдсан УИХ-ын 1996.08.30-ны өдрийн 37 дугаар тогтоолоор татан буулгасан бөгөөд чиг үүргийг нь хэрэгжүүлэх нэгжийг УИХ-ын Тамгын Газрын бүтцэд ажиллуулахаар шийдвэрлэжээ.

1996 - 2000 он. УИХ-ын Тамгын газрын нэгдүгээр нарийн бичгийн дарга болон Хуулийн хэлтсийн даргын харьяанд Судалгаа, мэдээлэл, лавламжийн алба

УИХ -ын Тамгын Газрын Ерөнхий нарийн бичгийн дарга 1996 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 175 дугаар захирамжаараа Тамгын Газрын бүтэц, орон тоог өөрчлөхдөө УИХ-ын Тамгын Газрын Ерөнхий нарийн бичгийн даргын нэгдүгээр орлогч бөгөөд Хуулийн хэлтсийн даргын эрхлэх асуудлын хүрээнд Судалгаа, мэдээлэл, лавламжийн алба байгуулсан. Тус алба шинжилгээ, судалгааны хэсэг, номын сан, архив, сүлжээ, программын хэсэгтэй нэлээд том нэгж байжээ.

2000 - 2003 он. УИХ-ын Тамгын Газрын Захиргаа, олон нийттэй харилцах хэлтсийн харьяа лавлагаа, мэдээллийн алба

Харин УИХ-ын Тамгын Газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2001 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 198 дугаар захирамжаар Тамгын Газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн дээрх албыг Мэдээлэл, судалгааны хэлтэс болгосон байна. Ингэхдээ архив, сүлжээ, программын хэсгийг хасч, хэлтсийн дарга 1, судлаач 5, ахлах ном зүйч 1, ном



зүйч 1, номын санч 2, нийт 10 орон тоотойгоор ажиллуулсан боловч мөн оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 355 дугаар захирамжаараа тус хэлтсийг татан буулгаж, номын сангийн хэсгийг Тамгын газрын Захиргаа, олон нийттэй харилцах хэлтэст харъяалуулсан байна. УИХ-ын Байнгын хороодоос ирүүлсэн саналаар 2002-2005 онд нийт 7 судалгааны ажлыг БСШУЯ-ны Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжүүлэн ШУА-ын харъяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдээр хийлгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг 2-3 жилийн хугацаанд гүйцэтгэн, ихэнх судалгааны тайланг холбогдох Байнгын хороонд хүлээлгэн өгчээ.

2003 - 2008 он. УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв

УИХ-ын 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 37 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв байгуулсан. Төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, сурталчилах үйл ажиллагаанд шинжлэх ухааны мэдээллээр үйлчлэх чиг үүрэг бүхий уг төв захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, судлаач гэх мэт 17 хүний орон тоотой ажиллаж, 2004-2008 онд нийт 16 судлагааны ажил Байнгын хорооны болон бусад байгууллагын захиалгаар гүйцэтгэсэн ба дунджаар нэг судалгааны ажлыг 6-12 сар, бүр 4 жилийн хугацаанд ч хийдэг байжээ.

УИХ -ЫН ТАМГЫН ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ТӨВ

УИХ-ын Тамгын газрын бүтцэд СШОНХТ-ийг байгуулсан эрх зүйн үндэслэл

- “Улсын Их Хурал өөрийн гишүүд, байнгын болон бусад хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх болон ажиллах нөхцөлөөр хангах үүрэг бүхий Тамгын газартай байна. (Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 31-р зүйлийн 31.4/
- Тамгын Газар нь УИХ-ын хууль тогтоох, хянан шалгах, төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэшлийн зөвлөгөө өгөх, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий мэргэшсэн алба байна. (Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 32-р зүйл)
- “Парламентын ажлын мэргэшсэн алба болох УИХ-ын Тамгын Газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйчилгээний арга хэлбэрийг сайжруулах, ардчилсан засаглалтай орнуудын парламентын ажлын албаны түвшинд хүргэх (УИХ-ын 22-р тогтоол, “ Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө”)
- Хууль тогтоох ажиллагааны нэг дутагдал бол шинээр гарах хуулийн төсөлд холбогдох судалгаа, дүн шинжилгээ хийх чадавхи сул, ялангуяа тухайн хуулиас үүдэн гарах эдийн засаг, нийгмийн үр дагаварыг судланшинжлэх явдал муу байна. Иймд Монголын Парламентаас хууль тогтоох буюу бодлого тодорхойлох чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа бодлогын шинжилгээ, эрсдэлийн менежментийг өргөн ашиглаж, гаргах гэж буй хууль, тухайн хуульд оруулах гэж буй нэмэлт өөрчлөлтийн эерэг, сөрөг тал, гарч болох эрсдэл, түүнийг даван туулах арга замыг тодорхойлж, чухамхүү “Долоо хэмжиж нэг огтол” гэсэн зарчмыг барьж ажиллах шаардлагатай.
- (НҮБХХ-ийн шугамаар “ Ардчилсан засаглалын парламентыг бэхжүүлэх” төслийн хүрээнд УИХ-ын Тамгын газрын чадавхийг бэхжүүлэх талаар хийсэн судалгааны дүгнэлт, зөвлөмж)
- Судалгаа хийх, санал дүгнэлт боловсруулахтай холбогдсон нийтлэг эрх, үүрэг:
- УИХ, Байнгын болон бусад хорооноос өгсөн үүрэг, ажлын хэсэг, УИХ-ын гишүүдээс тавьсан саналын дагуу тодорхой асуудлаар судалгаа хийх, санал дүгнэлт боловсруулах
- УИХ-ын үйл ажиллагаанд шаардагдах мэдээ, материал, улс орны нийгэм, эдийн засаг, хөгжлийн хөтөлбөрт холбогдох танилцуулга, судалгаа тооцоо, мэргэжлийн

албаны дүгнэлтийг бусад байгууллага, албан тушаалтанаас гаргуулан авах /УИХ-ын 2002 оны 5-р тогтоол, “Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэм, Нийтлэг чиг үүргийн матрицийн “Б”-д заасан эрх, үүрэг/

- Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв нь Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын хүрээнд ирүүлсэн захиалга, чиглэлийн дагуу болон Төвийн санаачлагаар цаг үеийн тулгамдсан асуудлууд, бодлогын чанартай асуудлуудаар судалгаа хийх, бодлогын шинжилгээний дүгнэлт, зөвлөмж гаргах, цаг үеийн шуурхай мэдээлэл, судалгааны мэдээллээр хангах, судалгааны мэдээллийн бааз бүрдүүлэх, хууль, тогтоолын төсөл болон бодлого боловсруулах шатанд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, салбарын мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, экспертүүдийн саналыг авах, хэлэлцүүлэг хийхтэй холбоотой үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. (Монгол Улсын Их Хурлын Тамгын Газрын Ерөнхий нарийн бичгийн даргын “Тамгын газрын алба, хэлтсүүдийн ажлын чиг үүрэг шинэчлэн батлах тухай” захирамж, 2009.02.05, №73)

УИХ-ын даргын 2008 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 147 дугаар захирамж, УИХ-ын 2009 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 3 дугаар тогтоолоор дээрх төвийг Тамгын газрын зохион байгуулалтын бүтцэд шилжүүлэн Ерөнхий нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээнд Судалгаа, шинжилгээ, олон нийттэй харилцах төв болгон нийт 47 ажилтантай байгуулсан. Гэвч эдийн засаг, санхүүгийн хямралтай холбоотойгоор зарим орон тоог цомхтгосон шийдвэр гарч одоогоор нийт 33 ажилтантай ажиллаж байна / Судалгаа, шинжилгээ, олон нийттэй харилцах төвийн хамт олон/ 2009.03.07

Ажлын зохион байгуулалт, чиг үүрэг

Судалгааны төвд одоогоор төвийн дарга-1, ахлах референт-5, референт шинжээч-4, Референт судлаач-19, бүгд 29 хүн ажиллаж байна. СШОНХТ-ийн харьяанд УИХ-ын номын сан-3 хүнтэй ажиллаж байна. Бүтэц зохион байгуулалтын хувьд судалгааны 6 хэсэг, УИХ-ын номын сантай . Макро эдийн засаг, Эдийн засгийн бодит салбар, Нийгмийн бодлогын салбар, Дэд бүтцийн салбар, Бүс нутаг хөдөөгийн хөгжлийн салбар, Эрх зүй, төрийн байгуулалт, гадаад бодлогын судалгааны салбар гэсэн судалгааны 6 чиглэлд холбогдох асуудлуудаар судалгаа хийж байна.

Судалгаа, шинжилгээ, олон нийттэй харилцах төв УИХ-ын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлуудын хүрээнд УИХ-ын гишүүд болон Байнгын хороодоос ирүүлсэн захиалга, чиглэлийн дагуу, мөн төвийн санаачлагаар цаг үеийн тулгамдсан асуудлуудаар бодлогын судалгаа, харьцуулсан судалгаа, тойм судалгаа, мэдээлэл судалгаа, лавлагаануудыг бэлтгэн гаргаж байна.

Судалгааны чиглэлүүд

1. Нийгмийн бодлогын судалгааны баг

- 1.1 Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого
- 1.2 Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого
- 1.3 Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлого
- 1.4 Жендерийн тэгш байдлыг хангах бодлого
- 1.5 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого

2. Макро эдийн засгийн бодлогын судалгааны салбар

- 2.1 Төсвийн бодлого
- 2.2 Татварын бодлого
- 2.3 Мөнгөний бодлого



- 2.4 Санхүүгийн зах зээлийн хөгжлийн бодлого
- 2.5 Засгийн газрын өрийн бодлого
- 2.6 Гадаад худалдааны салбарын бодлого
- 2.7 Өрсөлдөх чадварыг сайжруулах бодлого
- 2.8 Хувийн хэвшлийн салбарыг хөгжүүлэх бодлого

3. Эдийн засгийн бодит салбарын хөгжлийн бодлогын судалгааны хэсэг

- 3.1 Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого
- 3.2 Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого
- 3.3 Боловсруулах аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого
- 3.4 Байгаль орчин, экологийн бодлого
- 3.5 Аялал жуулчлалын салбарын бодлого
- 3.6 Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бодлого
- 3.7 Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого

4. Дэд бүтцийн хөгжлийн бодлогын судалгааны салбар

- 4.1 Зам, тээврийн салбарын хөгжлийн бодлого
- 4.2 Хот байгуулалт, барилгын салбарын хөгжлийн бодлого
- 4.3 Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого
- 4.4 Түлшний салбарын хөгжлийн бодлого
- 4.5 Мэдээлэл, холбооны технологийн салбарын хөгжлийн бодлого

5. Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлогын судалгааны салбар

- 5.1 Бүсчилсэн хөгжлийн бодлого
- 5.2 Эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийн бодлого
- 5.3 Хөдөөгийн хөгжлийн бодлого

6. Төрийн байгуулалт, эрх зүйн шинэтгэл, гадаад бодлогын судалгааны хэсэг

- 6.1 Эрх зүйн шинэтгэлийн бодлого
- 6.2 МУ-ын төрийн байгуулалт, төрийн удирдлагын бодлого
- 6.3 МУ-ын төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэлийн бодлого
- 6.4 Үндэсний аюулгүй байдлын бодлого
- 6.5 Гадаад харилцааны бодлого
- 6.6 Батлан хамгаалах салбарын бодлого
- 6.7 Парламент судлал

Судалгааны дүгнэлт, санал зөвлөмж болон тухайн асуудлыг шийдвэрлэх бодлогын хувилбаруудыг онол, практик, бусад орнуудын туршлагатай харьцуулан бодлогын судалгааны онол арга зүй, өргөн хүрээтэй мэдээллийн бааз дээр тулгуурлан боловсруулж мэдээлэл, судалгаагаар УИХ-ын гишүүдийг жигд хангах асуудалд Тамгын газар болон Судалгааны төв анхаарч байна. Мөн Дэлхийн эдийн засгийн болон Монгол улсын эдийн засаг, нийгмийн байдалын талаархи статистик мэдээллүүдийг сар, улирлаар тоймлон бэлтгэж дотоод сүлжээнд байрлуулахын зэрэгцээ УИХ-ын гишүүд, Тамгын газрын алба хэлтсүүдийг тойм мэдээллээр хангаж байна.

Судалгааны төв хууль, тогтоолын төсөл, бодлогын баримт бичиг боловсруулах шатанд

иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, салбарын мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, судалгааны байгууллагууд, экспертүүдийн саналыг авч судалгааны түвшинд нэгтгэн боловсруулалт хийж байна. Энэ чиглэлээр бусад судалгааны байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож, УИХ-ын номын санг түшиглэн хэвлэл мэдээллийн эх сурвалжуудад анализ хийх, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн саналыг авах, интернетийн эх сурвалжуудыг ашиглах замаар томоохон хэмжээний судалгааны мэдээллийн баазыг бүрдүүлж байна.

Судалгааны ажлын зохион байгуулалтыг байгаа хүн хүч, нөөц боломжиндоо тулгуурлан оновчтой зохион байгуулж судлаачдыг мэргэшүүлэх, хурдан хугацаанд чадваржуулах, судалгааны төвийн үйл ажиллагааг жигдрүүлэх, төлөвшүүлэх тал дээр анхааран ажиллаж байна.



УИХ -ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төвийн хамт олон, 2009. 3. 07

Судлаачдаас Доктор Ph.D - 4, магистр - 16, эдийн засагч - 5, хууль эрх зүйч - 11, Улстөр судлаач -1, багш - 2, маркетингийн менежер - 2, инженер - 4, сэтгүүлч - 2, химич - 1, УИХ-ын гишүүн асан 2 хүн байна. УИХ-ын Судалгааны төв нь цаг үеийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх бодлогын хувилбаруудыг боловсруулахад үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Ийм учраас дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудаас гарч байгаа саналуудыг тэнцвэртэйгээр авч судлах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хууль тогтоомж, бодлого шийдвэрийн онолын үндэслэлийг боловсруулах, эрх зүйн зохицуулалтын олон улсын стандарт болон бусад орнуудын туршлагыг судлах, тухайн асуудлыг шийдвэрлэх бодлогын гарц буюу хувилбар, санал зөвлөмж боловсруулах тал дээр чармайлт гарган ажиллаж байгаа юм. Ялангуяа хууль тогтоомж, бодлого боловсруулах шатанд Ажлын хэсгийн хэрэгцээнд, мөн УИХ-аар тухайн асуудлыг хэлэлцэн батлах үед УИХ-ын гишүүдэд дээрхи судалгаа, мэдээллүүд ихээхэн ач холбогдолтой байдаг.

Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд гүйцэтгэсэн судалгааны ажлын мэдээлэл

Судалгааны төвөөс өнгөрсөн хугацаанд нийт 41 судалгааны ажлыг гүйцэтгэжээ. Үүнээс: Бодлогын судалгаа-8, Харьцуулсан судалгаа- 11, Тойм судалгаа-9, Мэдээлэл судалгаа-11, Контент анализ-1, илтгэл-1-ийг тус тус бэлтгэн гаргасан. Үүнээс: Байнгын хороодын захиалгаар-7, УИХ-ын гишүүдийн захиалгаар-20, Судалгааны төвийн санаачлагаар- 14 судалгааны ажлыг гүйцэтгэв.

Судалгааны төвд хийгдсэн судалгаанаас УИХ-ын бүх гишүүдэд 18 судалгаа, захиалагчид -23 судалгааг тус тус хүргүүлж, дотоод сүлжээнд судалгааны ажлын талаархи мэдээллийг байршуулж байна. Гүйцэтгэсэн судалгааны ажлуудыг төрөл тус бүрээр кодлон хэвлэмэл болон цахим байдлаар мэдээллийн бааз болгон хадгалж байна.

Өнгөрсөн чуулганы хугацаанд Эдийн засаг, санхүүгийн хямрал, Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ, Бүс нутгийн хөгжлийн асуудлууд, Валютын зах зээлийн зохицуулалтын асуудлууд, Малчдын зээлийн асуудал, Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын хуулиудын хэрэгжилт, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал, Уран олборлох, ашиглах асуудлууд, Өрсөлдөөний бодлого, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн асуудал зэрэг олон чухал асуудлуудаар судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Хаврын чуулганаар ашигт малтмалын орд ашиглах гэрээ, ипотекийн үнэт цаасны зах зээл, хадгаламжийн даатгал, хот тосгоны эрх зүйн байдал, таваар түүхий эдийн биржийн асуудал, бичил уурхай, хийн хангамж зэрэг олон чухал асуудлуудыг хэлэлцсэн учраас судалгааны төв цаашид томоохон хэмжээний, чухал ач холбогдолтой бодлогын судалгаан дээр төвлөрч ажиллах болно.

Гадаад харилцаа

УИХ-ын Тамгын газрын ажилтнууд /СШОНХТ-ийн ажилтан Ю.Эрдэнэтуяа, Ц.Мягмарцэрэн, А.Пагма/ 2009 оны 3 дугаар сарын 22-29-ны өдрүүдэд Бүгд найрамдах Франц улсын Парламентын үйл ажиллагаатай танилцах айлчлал хийв. Айлчлалын хүрээнд Бүгд Найрамдах Франц улсын Эдийн засаг, үйлдвэр, хөдөлмөрийн яамны Уул уурхайн агентлаг, Парламентын номын сан, архивын үйл ажиллагааны зохион байгуулалт, хуулийн судалгааны алба, Парламентын дээд танхим болон Сенатын үйл ажиллагааны талаар туршлага судлав.

СШОНХТ-ийн дарга Ц.Норовдондог, референт-судлаач Ц.Болормаа болон УИХТГ-ын ажилтан н.Батмөнх нар 2009 оны 6 дугаар сарын 16-19-нд Австрали Улсын Парламент болон Парламентын Тамгын газрын үйл ажиллагаатай танилцан туршлага судлах айлчлал хийлээ.

Энэхүү туршлага солилцох айлчлалын хүрээнд Австралийн парламентын дээд болон Төлөөлөгчдийн танхимын Тамгын газрын үйл ажиллагаа түүнчлэн парламентад мэдээлэл, судалгааны үйлчилгээ үзүүлдэг номын сангын үйл ажиллагаатай нарийвчлан танилцсан юм.

СШОНХТ-ийн ажилтануудад Бүгд Найрамдахчуудын Олон Улсын хүрээлэнгээс 2009 оны 2 дугаар сарын 10-11-ны хооронд “УИХ-ын Тамгын газрын судалгаа шинжилгээний чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтын зохион байгуулав. Сургалтанд АНУ-ын Конгрессийн судалгааны албаны Мэдээлэл, судалгааны мэргэжилтэн Шэрри Шапиро хүрэлцэн ирж зөвлөгөө өгөв. Мөн 2009 оны 6 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Конгрессын гишүүдийг дагалдан яваа ажлын хэсэг УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төвийн ажилтнуудтай уулзалт хийв. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Конгрессын

Судалгааны албаны хэлтсийн орлогч дарга Клей Вэллборн, Конгрессын Судалгааны албаны Азийн асуудал хариуцсан мэргэжилтэн Брюс Боон, Конгрессын Судалгааны албаны Мэдээлэл судалгааны мэргэжилтэн Шерри Шапиро, Төлөөлөгчдийн танхимын Ардчилалыг Дэмжих Комиссын мэргэжилтэн Маргарита Семинарио нар оролцов.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн УИХ-ын Судалгааны төвийн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх процесстой нарийвчлан танилцаж туршлага солилцов. Төлөөлөгчид болон судалгааны төвийн ажилтнууд асуулт, хариултын журмаар харилцан ярилцаж, бие биенийхээ сонирхсон асуултанд хариулт өгөв. Дэлхийн банк, ННФ, БНОУХ, Азийн сан, АНУ-ын Конгрессийн Ардчилалыг дэмжих комисс зэрэг олон улсын байгууллагууд, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны олон байгууллагууд, эрдэмтэн судлаачид, төрийн болон төрийн бус байгууллагууд тус төвөөр дамжуулан судалгааны үр дүн, санал зөвлөмжөө УИХ-д хүргэх сонирхол, хамтран ажиллах санал, хүсэлтээ илэрхийлж байгааг бид нааштайгаар хүлээн авч, тууштай хамтран ажиллахыг эрмэлзэж байна.



ГАДААДЫН ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ НЭГЖИЙН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Орон	Харьяалал, статус	Товч түүх	Бүтэц зохион байгуулалт	Чиг үүрэг	Ямар бүтээгдэхүүн гаргадаг
1. Бүгд Найрамдах Турк Улс	Туркын Үндэсний Их Хурлын Хууль болон Тогтоолын газар нь харьяандаа 6 хэлтэс, нэг төвтэй бөгөөд төв нь Судалгааны төв юм. Судалгааны төвийг нь Туркын Үндэсний Их Хурлын Судалгааны төв гэж нэрлэдэг.	Судалгааны төвийн үйл ажиллагааг Туркын Үндэсний Их Хурлын даргын 2006 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 107 дугаар шийдвэрээр баталсан Туркын Үндэсний Их Хурлын Судалгааны төв журмаар зохицуулдаг байна.	Судалгааны төвийн нэгж удирлага, хэсгүүд болон захиргааны үйлчилгээны товчооноос бүрддэг. Судалгааны төв гишүүдийн хүссэн мэдээллийг хангах зорилгоор төрөл бүрийн салбараар хэсгүүдэд хуваагдсан. Эдгээр салбарууд нь: <ul style="list-style-type: none"> • Эрх зүйн болон харьцуулсан хууль тогтоомж, • Нийтийн удирдлага болон Улс төрийн шинжлэх ухаан, • Эдийн засаг болон санхүү, • Олон улсын харилцаа, • Нийгмийн бодлого, • Газар тариалан, Байгалын нөөц, Шинжлэх ухаан болон Технологи. /Журмын 5 дугаар зүйл/ 	<ul style="list-style-type: none"> • Парламентын хэлэлцэх асуудлыг судлан хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, мэдээллийг дүгнэх, • Гишүүдийг дүн шинжилгээ хийсэн шаардлагатай мэдээллээр хангах, • Улсын болон олон улсын талбар дахь өдөр тутмын асуудал, бага хурал болон семинарыг ажиглах • Ажиллаж байгаа асуудлаар холбогдох мэдээллийн баазыг бий болгох • Зорилгоор хэвлэмэл болон электрон мэдээллийн эх сурвалжийг тандах, • Их сургууль, төрийн байгууллага, мэргэшсэн хүмүүс, нийгмийн байгууллага гэх зэрэг гадна байгууллагаас эх сурвалжтай мэдээллийг хангахын тулд нөлөө бүхий хамтын ажиллагааны сүлжээг бий болгох, • Судалгааны төвийн интэрнет болон интранет хуудас бий болгох, агуулга болон хэлбэрээр нь удирдах, • ECPDR (Европын парламентын Судалгаа 	<ul style="list-style-type: none"> • Судалгааны тайлан: • Судлаачийн тодорхой сэдвээр төрөл бүрийн эх сурвалжаас олж авсан мэдээллийг нягтлан дүн шинжилгээ хийсэн, агуулга бүхий, нарийвчилсан болон олон чигтэй бэлтгэсэн бичвэр юм • Мэдээллийн нот: • Судлаачийн тодорхой сэдвээр төрөл бүрийн эх сурвалжаас олж авсан мэдээллийг нягтлан богино, үндэстэл бүхий, хэрэглэхэд тохиромжтой хэлбэрээр хандсан, тайлбарласан бичвэр, • Төлөвлөгөөний товчлол: Парламентын хэлэлцэх асуудал эсхүл хэлэлцэх боломжтой чухал, агуулгын өөрчлөлт санал болгосон хуулийн төсөл, өмнө нь гаргасан санал, санал болгож буй өөрчлөлт, олон нийтийн санал, бодолтой холбоотой мэдээллийг агуулсан бичвэр, • Баримт бичгийн эмхтгэл: Төрөл бүрийн сэдвээрхи мэдээллийн хэрэгцээг хангах баримт бичгийг эмхтгэх.

<p>2. Эстони Улс</p>	<p>Парламент буюу Рийгикогуийн Тамгын газрын бүтцэд багтдаг эрх зүй-шинжилгээний хэлтэс нь бие даасан мэдээлэл-судалгааны алба юм.</p>	<p>1992 онд шинэ Үндсэн хуулийн үндсэн дээр явагдсан сонгуулийн үр дүнд зохион байгуулагдсан парламентын тамгын газрын бүтцэд байгуулагдсан.</p>	<p>Тамгын газар нь хэвлэл, мэдээллийн, боловсон хүчний, сонгуулийн, олон улсын харилцааны, захиргаа аж ахуйн, мэдээлэл-судалгааны гэсэн 6 хэлтэстэй.</p>	<p>болон Баримт бичгийн төв), IFLA (Олон улсын номын сангын холбоо), Парламентын хэсэг болон APLAP (Ази-Номхон далайн орнуудын номын сангын холбоо), IPU (Олон улсын Парламент холбоо) зэрэг олон улсын байгууллагуудтай чиг үүрэгтэй холбоотой асуудлаар нөлөө бүхий хамтын ажиллагааг явуулах, үйл ажиллагаанд нь оролцох.</p> <ul style="list-style-type: none"> • Судалгааны төвийн чиг үүргийн агуулгад хамаарагдаагүй зүйлийг Судалгааны төвийн удирдамжаар зохицуулна. /Журмын 7 дугаар зүйл/ 	<ul style="list-style-type: none"> • Аман мэдээлэл: Хүссэн мэдээллийг биеээр болон утсаар хүссэн хүнд нь хүргэх, • Статистикийн мэдээлэл: Төрөл бүрийн салбар дахь статистикийг товчлон хэрэглэхээр бэлтгэсэн, цаг хугацаанд нь шинэчилсэн ажиллагаа юм. /Журмын 8 дугаар зүйл/
				<ul style="list-style-type: none"> • Рийгикогуийн гишүүд болон тамгын газрын эрх зүй, эдийн засаг, нийгмийн бодлого, нийгмийн удирдлагын хэлтэсүүдэд зөвлөгөө өгөх • Үндсэн хуулийн зорилт, тамгын газрын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар зөвлөмж гаргах • Бусад улс орнуудын парламентын судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагаа явуулах • Харьцуулсан судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг. 	<ul style="list-style-type: none"> • Судалгааны тайлан • Зөвлөмж • Харьцуулсан судалгаа, дүгнэлт

3. БНЛитв Улс	<p>Парламентын судалгааны газар нь Литвийн Сеймын тамгын газрын бүтцэд харъяалагддаг.</p>	<p>1990 оны анхны чөлөөт сонгуулийн дүнд байгуулагдсан Сеймийн тамгын газрын бүтцэд анх байгуулагдсан.</p>	<p>Парламентын судалгааны газар нь ерөнхий мэдээллийн хэлтэс, ном зүйн мэдээллийн хэлтэс, эдийн засгийн болон нийгмийн мэдээллийн хэлтэс, эрх зүй ба улс төрийн мэдээллийн хэлтэс гэсэн зохион байгуулалттай.</p>	<ul style="list-style-type: none"> Сеймийн гишүүдийг мэдээлэл- шинжилгээний материалаар хангах Хууль тогтоох байгууллагад өргөн баригдсан хуулийн төсөлд шинжилгээ хийх Янз бүрийн салбарын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулах 	<ul style="list-style-type: none"> Мэдээллийн товхимол Судалгааны тайлан Зөвлөмж Харьцуулсан судалгаа, дүгнэлт
4. Израйль Улс	<p>Бүгд Найрамдах Израйль улсын Парламентын (Knesset) Судалгаа мэдээллийн төв</p>	<p>2000 оны 7 сард 15 дахь Knesset –ийн дарга Абрахам Бүрг өөрийн бүрэн эрхийн хугацаанд анх санаачилсан. Абрахам Бүрг нийгэм, улс төр болон эдийн засаг, парламентын хамгийн чухал зүйл нь мэдээлэл судалгаа гэж үзсэн учраас мэдээлэл судалгааны төвийг үүсгэн байгуулсан байна. 16 дахь Knesset-н дарга Р. Ривлэн 2003 онд мэдээлэл судалгааны төвийн үйл</p>	<p>Мэдээлэл судалгааны хэлтсийн дарга, ажилчдын ахлах - 3, техник технологийн хэлтсийн дарга.</p>	<ul style="list-style-type: none"> Парламентын болон байнгын хороодын гишүүдэд хууль тогтоох үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл, эх сурвалжаар хангах Гүйцэтгэх эрх мэдэлд тавих парламентын хяналтад туслах Үндэсний болон нийтийн ашиг сонирхолтой холбоотой маргааныг шийдвэрлэхэд туслах Тэнцвэртэй, үнэн бодит, чанартай, суурь мэдээллээр хангахыг зорьдог. Мэдээлэл судалгаагаар хангахдаа дэвшилтэт шинэ бүтцийг ашигладаг. 	<p>Soft, hard хэлбэрээр мэдээллээ гаргадаг.</p>

			ажиллагааг өргөжүүлж, хууль эрх зүй, эдийн засгийн зэрэгцээ, төсвийн үнэлгээг нэмж, цар хүрээг нь өргөтгөсөн байна.	
5. Бүгд Найрамдах Унгар Улс	Мэдээллийн төв нь Тамгын газар болон парламентын номын сантай хамтран үйл ажиллагаагаа явуулдаг. Парламентын гишүүдэд бүрэн үйлчилгээ үзүүлж, иргэдэд тодорхой хүрээгээр үйлчилдэг. Мэдээллийн төв нь хууль тогтоох үйл ажиллагаа парламентын хороо, албан хаагчдыг мэргэжлийн болон шаардлагатай ном зүйн мэдээллээр хангадаг. Парламентын гишүүдэд бүх нөхцөлөөр, иргэдэд тодорхой хязгаарлалттай үйлчилдэг.	ажиллагааг өргөжүүлж, хууль эрх зүй, эдийн засгийн зэрэгцээ, төсвийн үнэлгээг нэмж, цар хүрээг нь өргөтгөсөн байна.	Парламентын гишүүдийн хууль тогтоох үйл ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлэх зорилгоор Парламентын мэдээллийн төв 1991.09.01 нд Унгарын парламентын ордонд байгуулагдсан.	Мэдээллийн төв нь дараах төрлийн мэдээлэл өгдөг. <ul style="list-style-type: none"> • Парламентын хороо, тэдгээрийн гишүүд • Парламентын үйл ажиллагааны тухай мэдээ, тоо баримт • Санал хураалтын дүн, гишүүдийн үйл ажиллагаа • Чуулганы үеэрх гишүүдийн хэлсэн үг, маргаан, чуулган хуралдсан хугацаа, дэмжигдсэн болон татгалзсан санал. • Хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай танилцуулга, нэмэлт өөрчлөлт, хуулийн төсөл, түүний явц,
				Билл статус болон парламентын түүх гаргадаг. Статистик мэдээллээр хангадаг. 1997 онд олон нийтэд болон иргэдэд нээлттэй үйлчлэх утастай болсон.

6. Грек Улс	Шинжлэх ухааны алба	Шинжлэх ухааны зөвлөлийн дор ажилладаг. Энэ зөвлөл нь их сургуулийн профессоруудаас бүрдсэн 9 гишүүнтэй. Чуулган юмуу байнгын хороодын хуралдаанд оролцдог. Шинжлэх ухааны алба нь дотроо 4 хэлтэстэй - судалгааны 1-р алба - судалгааны 2-р алба - мэдээлэл болон технологийн алба - парламентын номын сан	Нийт 780 ажилтантай	Шинжлэх ухааны зөвлөлийн дор ажилладаг. Энэ зөвлөл нь их сургуулийн профессоруудаас бүрдсэн 9 гишүүнтэй. Чуулган юмуу байнгын хороодын хуралдаанд оролцдог. Шинжлэх ухааны алба нь дотроо 4 хэлтэстэй - судалгааны 1-р алба - судалгааны 2-р алба - мэдээлэл болон технологийн алба - парламентын номын сан	Хамгийн нийтлэг гаргадаг бүтээгдэхүүн бол судалгааны тайлан юм. Тайлангууд нь олон хэлбэртэй байна. Эдгээрт, бодлогын шинжилгээ, эдийн засгийн судалгаа, статистикийн тойм, хууль эрх зүйн шинжилгээ, товч тайлангууд (Short reports), дэлгэрэнгүй тайлангууд (RL) зэрэг багтаж байна. Жил бүр 700 гаруй судалгааны тайлан хийж гүйцэтгэдэг. 150 орчим тойм мэдээлэл хийсэн байна.
7. АНУ	АНУ-ын Конгрессийн судалгааны төв Зөвхөн АНУ-ын Конгрессийн гишүүд болон Байнгын хороодод үйлчилдэг.	1914 онд Хууль Тогтоомжийн Лавлах Үйлчилгээ нэртэйгээр байгуулагдаж байсан. Вашингтонд төв оффис нь байдаг.	АНУ -ын Конгрессийн гишүүд болон Байнгын хороодод хууль боловсруулахад нь туслах зорилгоор зөвхөн төвийг сахисан, үнэн зөв, найдвартай судалгааны тайлан, мэдээ материалыг гарган өгч үйлчилнэ.	АНУ -ын Конгрессийн гишүүд болон Байнгын хороодод хууль боловсруулахад нь туслах зорилгоор зөвхөн төвийг сахисан, үнэн зөв, найдвартай судалгааны тайлан, мэдээ материалыг гарган өгч үйлчилнэ.	Гол бүтээгдэхүүнүүд нь 3 форматаар гардаг. <ul style="list-style-type: none"> • Судалгааны тайлан • Цаг үеийн асуудлаар тойм мэдээ мэдээллийг агуулсан товч тайлан • Сарын статистик бюллетин • Парламентын гарын авлага
8. Австрали Улс	Австралийн Парламентын Номын сан Викториан Парламентын гишүүдэд үйлчилдэг.	2004 оны 2-р сарын 1нд байгуулагдсан.	Хууль боловсруулахад шаардлагатай мэдээ материалаар Парламентын гишүүдэд үйлчилдэг.	Хууль боловсруулахад шаардлагатай мэдээ материалаар Парламентын гишүүдэд үйлчилдэг.	Гол бүтээгдэхүүнүүд нь 3 форматаар гардаг. <ul style="list-style-type: none"> • Судалгааны тайлан • Цаг үеийн асуудлаар тойм мэдээ мэдээллийг агуулсан товч тайлан • Сарын статистик бюллетин • Парламентын гарын авлага

<p>9. Канад Улс</p>	<p>Парламентын номын сан</p>	<p>Парламентын номын сан нь Дээд, Доод Канадын эрх зүйн номын сангаас эхлэлтэй бөгөөд 1790 онд байгуулагдсан. 1841 онд Дээд, Доод Канад нэгдэхэд хоёр номын сан нэгджээ. Номын сангийн ордон нь 1876 онд ашиглалтанд оржээ.</p>	<p>Эрх зүйчид, эдийн засагчид, эрдэмтэд, захиргааны болон нийгмийн бодлогоор мэргэшсэн боловсон хүчнээс бүрдсэн. Парламентын бусад орднуудад өөрийн салбартай.</p>	<p>Сенат, Нийтийн танхимуудын спикерын зөвшөөрсөн заавар, үүргийн дагуу Сенат, Нийтийн танхимын нэгдсэн байнгын хорооны үйл ажиллагаанд тусалцаа үзүүлдэг. Мөн парламентын гишүүдэд, болон Сенат, Танхимын албаны хүмүүст</p> <ul style="list-style-type: none"> • бүх талын мэдээлэл, баримт бичгээр хангах, • өргөн хүрээний судалгаа, шинжилгээ хийх, • парламентын түүх, үйл ажиллагааг олон нийтэд таниулах • сургалт зохион байгуулах зэргээр үйлчилгээ үзүүлэхээс гадна олон нийтэд хандсан мэдээлэл, танин мэдэхүйн төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулдаг. 	<ul style="list-style-type: none"> • мэдээллийн багц, • брошюр • олон нийтэд зориулсан баримт бичиг
<p>10. Бельгийн Вант Улс</p>	<p>Бельгийн холбооны парламентын номын сан</p>	<p>1831 онд байгуулагдсан. 1905 оноос Телевөгчдийн танхим болон Сенатын танхимд хамтад нь үйлчлэх болсон.</p>	<p>Парламентын гишүүд болон холбогдох албан хаагчдын баримт бичиг боловсруулах төв болсон. Дараах үйлчилгээг үзүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Баримт бичиг судлах, • судалгаа, шинжилгээний баримт бичиг, • номын сангийн үйлчилгээ • баримт хувилах • электрон эх сурвалжийн ашиглалтын талаархи сургалт 	<ul style="list-style-type: none"> • судалгаа, шинжилгээний баримт бичгийн эмхтгэл • Үнэ цэнэтэй, ховор баримт бичгүүдийн эмхтгэл • Хууль, эрх зүйн баримт бичиг, бусад албан баримтуудыг нэгтгэсэн компакт диск 	<ul style="list-style-type: none"> • Судалгааны тайлан • Баримт бичгийн эмхтгэл • Хэвлэмэл материал
<p>11. Албани Улс</p>	<p>Албаний парламентын номын сангийн бүтэцд харьяалагддаг.</p>	<p>Номын сан нь 3 төрлийн үйлчилгээ үзүүлдэг.</p> <ul style="list-style-type: none"> • Лавлагаа өгөх үйлчилгээ-парламентын гишүүд, 	<p>Парламентын гишүүд, туслахуудыг хууль батлах үеийн бүхий л мэдээллээр хангах.</p>	<p>Парламентын гишүүд, туслахуудыг хууль батлах үеийн бүхий л мэдээллээр хангах.</p>	<ul style="list-style-type: none"> • Судалгааны тайлан • Баримт бичгийн эмхтгэл • Хэвлэмэл материал

<p>12. Бүгд Найрамдах Социалсит ВьетнамУлс</p>	<p>Мэдээлэл, Номын сан Судалгааны төв /Center of Information, Library, and Research Service/ Үндэсний Ассемблейн Тамгын Газарт харъяалагддаг</p>	<p>1991 онд байгуулагдсан. 1996-1999 оны хооронд Шведийн олон улсын хөгжлийн агентлагын /SIDA/ 3 жилийн төслөөр судалгааны төвийн чадавхийг бэхжүүлэх төсөл амжилттай хэрэгжсэн</p>	<p>Төв нь 165 ажиллагсадтай</p>	<p>байнгын хороо, туслахуудад шаардлагатай ном, хэвлэмэл материалаар туслах.</p> <ul style="list-style-type: none"> • Судалгаа хийх-хууль гаргагч, байнгын хорооны хүсэлтийн дагуу хууль батлахтай холбогдуулан түргэн шуурхай судалгаа гаргаж өгөх • Индексжүүлэх үйлчилгээ: Парламентаас баталсан хууль эрх зүйн акт, Парламентын баримт бичиг, Сонин хэвлэлд парламентын гишүүдийн өгсөн ярилцлага, хэвлэлийн бага хурал, санал бодлоо илэрхийлсэн хэвлэмэл материалуудыг нэгтгэх 	<p>Бичиг баримт, хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд мэдээлэл-судалгаа шинжилгээгээр үйлчлэх үндсэн чиг үүрэгтэй</p>	<p>Судалгааны тайлан</p> <ul style="list-style-type: none"> • Зөвлөмж • Мэдээлэл • Эмхэтгэл
--	--	---	---------------------------------	--	---	--

<p>13. Тайланд Улс</p>	<p>Судалгааны төв нь харьяанд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд парламентын ордонд байрладаг.</p>	<p>Судалгааны төв нь АНУ-ын ардчиллын тусалцааны комисс, Тим-Лэстэгийн үндэсний парламент болон АНУ-ын конгрессын номын сан, АНУ-ын Хөгжлийн агентлаг (USAID), Азийн сангийн (Asian foundation) хамтын ажиллагааны үндсэн дээр байгуулагдаж байсан. Хөтөлбөрийн эхний жил Азийн сан техникийн тусалцаа үзүүлж байсан. Дараа нь 2009 онд бүрэн хэмжээгээр Үндэсний парламентын бүтцэд хамаарах болсон. Үндэсний парламентын судалгааны төв 2009.01.09</p>	<p>Судалгааны төв нь тусгайлан бэлтгэсэн 4 судлаач, Эрх зүйн мэдээллийн сүлжээний (GLIN) менежер болон ажилтан, 1 мэдээллийн технологийн туслах ажилтантай</p>	<p>Зорилго нь парламентын номын сангийн нөөцийг бүрдүүлэх, мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгох хууль тогтоомжийн судалгааны чиг үүргийг бэхжүүлэх, бичиг баримтыг албан ёсоор хадгалах</p>	<p>Судлаачид нь бодлогод дүн шинжилгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан мэдэх, хууль тогтоогчийн асуулт болон хүсэлтэд амаар болон бичгээр хариу өгөх зэрэг ажлуудыг хийдэг</p>
------------------------	---	--	--	--	--



14. Энэтхэг Улс	Энэтхэгийн парламентын тамгын газрын ерөнхий нарийн бичгийн даргад харъяалагддаг. Номын сангийн бүтэцэд судалгаа лавлагааны хэсэг багтдаг.	-ний өдөр албан ёсоор нээгдсэн Номын сан нь парламентын гишүүдийн номын сан, ажилчин албан хаагчдын номын сан гэж 2 ялгаатай байдаг. 26000 орчим номын фондтой. Түүнчлэн 14 сонин, 20 тогтмол хэвлэмэл бүтээгдэхүүнийг бүртгэдэг байна.	Номын сан нь парламентын гишүүдийн номын сан, ажилчин албан хаагчдын номын сан гэж 2 ялгаатай байдаг. 26000 орчим номын фондтой. Түүнчлэн 14 сонин, 20 тогтмол хэвлэмэл бүтээгдэхүүнийг бүртгэдэг байна.	<ul style="list-style-type: none"> Судалгаа мэдээллийн хэсэг нь парламентын гишүүдийн хүсэлтийн дагуу хэлэлцэхээр болон батлах гэж байгаа хууль эрх зүйн акттай холбоотой шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргаж өгөх, Судалгааны хэсэг нь дараахь чиглэлийн дагуу судалгаа хийнэ: <ul style="list-style-type: none"> - Эдийн засаг санхүүгийн асуудал - Б оловсрол шинжлэх ухаан - Хууль эрх зүйн - Пар ламентын асуудал - Улс төрийн асуудал - Нийг мийн асуудал
15. ХБНГУ	Судалгаа шинжилгээ, гадаад харилцаа Германы Бундестагийн Тамгын газрын бүтэцэд хамаарагддаг.	Үндсэн 4 хэлтэстэй. Үүнд: судалгаа шинжилгээний үйлчилгээний хэлтэс. Уг хэлтэс нь 11 сектортой. 1. Түүх, орчин үеийн түүх, улс төр 2. Гадаад харилцаа, олон улсын хууль, эдийн	<ul style="list-style-type: none"> Судалгааны цуврал тайлан Зөвлөмж Мэдээлэл Эмхтгэл 	<ul style="list-style-type: none"> Судалгааны цуврал тайлан Зөвлөмж Мэдээлэл Эмхтгэл

16. Финланд Улс	Финландын парламентын (Riksdag) Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн даргын харьяанд Мэдээлэл харилцааны хэлтэс /Information and communication department/ байдаг.	1919.10.01-нд анх байгуулагдсан. 1980 онд өнөөгийн хэлбэрээ олсон.	Номын сан Судалгааны алба Мэдээллийн алба	<ul style="list-style-type: none"> • Парламентын гишүүд, бусад парламентын ажиллагсдад мэдээлэл, судалгаа шинжилгээ, баримт бичиг болон бусад материалуудаар үйлчлэх. • Олон нийтэд Парламентын болон Европарламентын талаархи мэдээллийг түгээх. 	<ul style="list-style-type: none"> • Туршлага судлах 	
			<ul style="list-style-type: none"> засгийн хамтын ажиллагаа болон хөгжил, батлан хамгаалах, хүний эрх болон хүмүүнлэгийн тусламж, 3. Үндсэн хуулийн эрх зүй, захиргааны эрх зүй 4. Төсөв, санхүү 5. Эдийн засаг болон технологи, хэрэглэгчийн эрх ашиг, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуучлал, 6. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал 7. Иргэн болон эрүү, процессийн эрх зүй, экологийн эрх зүй, тээвэр, барилга, хот байгуулалт 8. Экологи, байгаль хамгаалал, цөмийн аюулгүй байдал, болосрол болон судалгаа 9. Эрүүл мэнд, гэр бүл, ахмад настан, эмэгтэйчүүд болон хүүхдүүд 10. Соёл, хэвлэл мэдээлэл, спорт 11. Европын хэрэг 	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийг: <ul style="list-style-type: none"> • Видео болон Телевизийн хөтөлбөрүүд • Хэвлэмэл хэлбэрээр • Онлайн хэлбэрээр түгээдэг 2008 оны хавраас судалгаа, шинжилгээний ажил үйлчилгээг он-лайн хэлбэрээр үзүүлж эхлэсэн. 		

17. Исланд Улс	Исландын парламентын (Althingi) Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн даргын харьяанд Мэдээлэл, олон нийтийн хэлтэс /The Information and Publications Department/	1799 онд анх байгуулагдсан. 1991 онд өнөөгийн хэлбэрээ олсон.	Албан ёсны танилцуулгын алба Судалгаа шинжилгээ ба номын сангийн алба Олон нийттэй харилцах алба	<ul style="list-style-type: none"> • Парламентын гишүүдэд мэдээлэл, судалгаагаар үйлчлэх, хуулийг албан ёсоор нийтэд танилцуулах, Олон нийттэй харилцах үндсэн чиг үүрэгтэй. 	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл • Судалгааны тайлан • Олон нийтэд хандсан мэдээлэл
18. Швед Улс	Шведийн парламентын (Riksdag) Нарийн бичгийн дарга нарын танхимд Судалгааны төв харьяалагддаг	1540 онд анх байгуулагдсан. 1974 онд өнөөгийн хэлбэрээ олсон		<ul style="list-style-type: none"> • Парламентын гишүүд • Намын бүлгийн ажлын албадуудад • Байнгын хороодод • Парламентын бусад нэгжүүдэд судалгаа мэдээллээр үйлчилэх. • Байнгын хорооны болон Парламентын шийдвэрт хяналт үнэлгээ /evaluation/ хийж, цаашид хэрхэн сайжруулах, боловсронгуй болгох талаар судалгаа хийх 	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл • Судалгааны тайлан • Бодлогын зөвлөмж
19. Бүгд Найрамдах Чех Улс	Чехийн Үндэсний Хурлын Тамгын газрын харьяанд Судалгааны төвтэй	1990 онд Шинжлэх ухааны үйлчилгээний хэлтэс нэртэй байгуулагдаж, 1991 онд Холбооны Хурлын тэргүүлэгчдийн шийдвэрээр Шинжилгээ ба шинжээчдийн	Зохион байгуулалтын бүтэц нь: <ul style="list-style-type: none"> • Дарга • орлогч дарга • судлаачид • захиргааны ажилтнууд Нийт 16 ажилтантай. Үүнд: <ul style="list-style-type: none"> • хуульч 7 • эдийн засагч 2 • түүхч 1 • улстөр судлаач 2 	Судалгааны хүрээлэн нь эрдэм шинжилгээ судалгаа сургалт гэсэн үндсэн 3 чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл • Судалгаа • Сургалтын материалууд

		<ul style="list-style-type: none"> • техникийн ажилтан 1 • туслах ажилтан 3 	<p>санал дүгнэлтийн хэлтэс болон өөрчлөгдсөн. Одоо Парламентын дэргэд Судалгааны хүрээлэн нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна.</p>	<p>1988 онд Парламентын номын сангийн бүрэлдэхүүнд 5 судлаачтай байгуулагдсан. 1989 оноос номын сангийн дэргэд бие даасан Судалгааны төв болж 13 судлаачтай болсон. 1994 онд 24 судлаачийн орон тоотой ажиллаж байгаад 1997 онд Тамгын газрын бүтцийн өөрчлөлтөөр компьютер-мэдээллийн албатай нэгдэн 15</p>	<ul style="list-style-type: none"> • Хуулийн лавлагаа • Мэдээлэл • Сэдэвчилсэн товхимол • Хэвлэлийн тойм 	<p>Парламент болон гишүүдийг шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангах чиг үүрэгтэй. Улс төр, хууль эрх зүй, гадаад харилцаа, эдийн засаг, хөдөө аж ахуй, үйлдвэр-эрчим хүч, тээвэр - зам харилцаа, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл зэрэг салбарын чиглэлээр дотоод, гадаадын шаардлагатай мэдээллээр шуурхай хангах үүрэгтэй.</p>	<p>Судалгааны төв нь Үндэсний Ассамблей болон Тамгын газрын удирдлагад шууд захирагддаг. Захирал, орлогч захирал, Ерөнхий үйлчилгээний хэсэг, Сургалтын хэлтэс (Сургалт, төлөвлөлийн ба сургалтын хэсэгтэй), Судалгааны хэлтэс гэсэн зохион байгуулалттай ажилладаг.</p>	<p>Үндэсний Ассамблейн дэргэд Парламентын номын сан, Судалгааны төвтэй.</p>	<p>20. Бүгд Найрамдах Солонгос Улс</p>
--	--	---	--	--	--	--	--	---	--

21. Бразил Улс	Парламентын доод танхимын харьяанд Баримтжуулалт ба мэдээллийн төвтэй	судлаач, 5 орчуулагчтай ажиллаж байна.	Тодорхой мэдээлэл алга	Доод танхимын board буюу Удирдлагын зөвлөл, Тамгын газрын Хуулийн хэлтсийн удирдлагад ажилладаг	<ul style="list-style-type: none"> • Хуулийн шинжлэл • Мэдээлэл, судалгаа • Баримтжуулалт, архивын бүрдүүлэлт • Хэвлэн нийтлэх үйл ажиллагаа • Олон нийттэй харилцах • Номын сангийн үйлчилгээ үзүүлэх <p>эрэг үндсэн чиг үүргийн дагуу ажилладаг.</p>	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл • Судалгаа • Ном товхимол • Эмхэтгэл
22. Япон Улс	Японы Парламентын номын сангийн бүтцэд Судалгаа болон хуулийн лавлах хороо ажилладаг.	Судалгаа болон хуулийн лавлах хороог анх Showag-ын 23 дугаар онд байгуулсан бөгөөд уг хорооны судалгааны материалд Японы эртний хаадын үеийн бичиг баримтууд хадгалагдаж байдаг	Тус хороо нь 16 зөвлөх, ахлах ажилтан, 5 туслах ажилтан нийт 153 албан хаагчидтай. Бүтцийн хувьд Захирал, орлогч захирал, 14 албатай. Үүнд: 1.Ерөнхий хэрэг эрхлэх алба 2.Хуулийн лавлах болон зохицуулах алба 3.Судалгааны алба 4.Парламентын бичиг баримтын алба 5.Бодлого болон парламентын хэрэг эрхлэх алба 6.Нийгмийн удирдлага болон шүүхийн хэрэг эрхлэх алба 7.Гадаад хэргийн болон үндэсний батлан хамгаалахын алба 8.Эдийн засаг, санхүүгийн алба 9.Үйлдвэрлэл, худалдаа, технологийн алба	Судалгаа болон Хуулийн Лавлах хорооны үндсэн чиг үүрэг, харууллага нь Япон улсын Төв номын сангийн тухай хуулийн 15-р зүйлээр зохицуулагддаг. Үндсэн гол чиг үүрэг нь: • Парламентаар хэлэлцэх хуулийн төсөл, хуулийн зүйл, ангид задлан, дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт, гаргах • Цуглуулсан материалд дүн шинжилгээ хийж 2 танхимын парламентын гишүүдэд өргөн барих, • Танхимын болон гишүүдэд шаардлагатай бүхий л судалгааны материалыг танхимын гишүүдийн хүсэлтийн дагуу бэлтгэх, • Шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах	<ul style="list-style-type: none"> • Парламентын гишүүдийн санал, хүсэлтийн дагуу бэлтгэсэн материалын, судалгааны тайлан, Урьдчилан бэлтгэсэн судалгааны тайлан, Чуулганаар хэлэлцэх бүхий л асуудалд хийсэн дүн шинжилгээний материал, Хэвлэмэл болон электрон хэлбэрийн мэдээллийн бааз 	

		<p>10.Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон орчны алба</p> <p>11.Газрын хөгжил болон харилцааны алба</p> <p>12.Боловсрол, соёлын алба</p> <p>13.Нийгмийн халамж, хөдөлмөрийн алба</p> <p>14. Гадаад мэдээллийн алба</p>	<p>хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх,</p> <ul style="list-style-type: none"> • Хууль зөрчсөн болон бусад хууль тогтоомжид үл нийцэх хуулийн төсөлд санал, дүгнэлт бэлтгэх, анализ хийх • 2 танхимын гишүүдийн хүсэлтийн дагуу бэлтгэсэн материалд холбогдох мэдээллийн баазыг электрон болон хэвлэмэл байдлаар бий болгох зэрэг үндсэн гол чиг үүргээс гадна нууцлалыг чандлан хадгалах үүргийг давхар хүлээсэн байдаг. 	<p>хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх,</p> <ul style="list-style-type: none"> • Хууль зөрчсөн болон бусад хууль тогтоомжид үл нийцэх хуулийн төсөлд санал, дүгнэлт бэлтгэх, анализ хийх • 2 танхимын гишүүдийн хүсэлтийн дагуу бэлтгэсэн материалд холбогдох мэдээллийн баазыг электрон болон хэвлэмэл байдлаар бий болгох зэрэг үндсэн гол чиг үүргээс гадна нууцлалыг чандлан хадгалах үүргийг давхар хүлээсэн байдаг.
<p>23. Украин Улс</p>	<p>Украины парламент Дээд Радатын нарийн бичгийн дарга нарын газрын харьяанд Эрдэм шинжилгээний удирдах газар ажилладаг</p>	<p>Тодорхой мэдээлэл алга</p>	<p>Тус газар нь 7 хэлтэстэй.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Европын холбооны хүний эрхийн болон олон улсын харилцаа, хүмүүнлэгийн эрх зүйн бодлогын хэлтэс 2.Үндсэн хуулийн эрх зүйн бодлогын хэлтэс 3.Нийгмийн бодлогын хэлтэс 4.Иргэний болон төрийн эрх зүйн бодлогын хэлтэс 5.Хөдөөгийн хөгжил, байгаль орчныг хамгаалах бодлогын хэлтэс 6.Төсөв, банкны үйл ажиллагааны бодлогын хэлтэс 7.Үйлдвэрлэлийн хөгжил, макроэдийн засгийн бодлогын хэлтэс 	<p>Мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> • Судалгааны тайлан • Эрх зүйн шинжлэл • Холбогдох эмхтгэл, товхимол

ХАВСРАЛТ

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ
ТӨВИЙН АЖИЛТНУУДЫН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ**

Хавсралт 1

№	Нэрс	Албан тушаал	Судалгааны чиглэл	E-mail хаяг /parliament.mn/
1.	Ц.Норовдондог	Төвийн дарга	Судалгааны хэсгүүдийг удирдах, эдийн засгийн судалгаа	Tsnorov
2	Ц.Товуусүрэн	Ахлах-референт	Нийгмийн судалгаа	Tovuu3589
3	Б.Буяндэлгэр	Ахлах-референт	Бүс нутгийн судалгаа	Buyan
4	Д.Ариунаа	Ахлах-референт	Эдийн засгийн судалгаа	Ariunaad
5	Г.Алтан-Оч	Ахлах-референт	Дэд бүтцийн судалгаа	Altanoch
6	Ю.Эрдэнэтуяа	Ахлах-референт	Эрх зүй, төрийн байгуулалт, гадаад бодлогын судалгаа	Erdenetuya
7	Ч.Базар	Референт-шинжээч	Эдийн засгийн бодит салбарын судалгаа	C_bazar
8	Н.Түвшинтөгс	Референт-шинжээч	Дэд бүтцийн судалгаа	Tuvshintugs_n
9	С.Дорждагва	Референт-шинжээч	Эдийн засгийн бодит салбарын судалгаа	Dorjdagva
10	Г. Чулуун	Референт-шинжээч	Бүс нутгийн судалгаа	Chuluun_g
11	Ц.Түвшинзаяа	Референт-судлаач	Бүс нутгийн судалгаа	Ts.Tuvshinzaya
12	Ш.Хишигсүрэн	Референт-судлаач	Эрх зүй, төрийн байгуулалтын судалгаа	khishig
13	У.Мөнхбат	Референт-судлаач	Эрх зүй, төрийн байгуулалтын судалгаа	Munkhbat
14	Г.Билгээ	Референт-судлаач	Эдийн засгийн судалгаа	Bilgee_9
15	Б.Ариунжаргал	Референт-судлаач	Дэд бүтцийн судалгаа	Ariunjargal_b
16	Ц.Батдорж	Референт-судлаач	Эдийн засгийн судалгаа	Ts_batdorj
17	Ө.Мөнхтунгалаг	Референт-судлаач	Эдийн засгийн судалгаа	
18	Д.Мягмарцэрэн	Референт-судлаач	Эдийн засгийн судалгаа	Myagmartseren

19	А.Пагма	Референт-судлаач	Эдийн засгийн судалгаа	A_pagma
20	Ц.Болормаа	Референт-судлаач	Эдийн засгийн судалгаа	Tsbolor
21	О.Нарантуяа	Референт-судлаач	Эрх зүй, төрийн байгуулалтын судалгаа	Narantuya_O
22	Ц.Элбэгзаяа	Референт-судлаач	Эдийн засгийн судалгаа	Elbegzaya_ts
23	Б.Мөнхцэцэг	Референт-судлаач	Олон нийт, дотоод ажил	Bmunkhtsetseg
24	К.Пүрэвсүрэн	Референт-судлаач	Эрх зүй, төрийн байгуулалтын судалгаа	Purevsuren_k
25	Т.Мягмаржав	Референт-судлаач	Нийгмийн судалгаа	myagmarjav
26	Ч.Онончимэг	Референт-судлаач	Эдийн засгийн судалгаа	Ononchimeg_ch
27	Ц.Батбаяр	Референт-судлаач	Эдийн засгийн судалгаа	Tsbatbayar
28	Д.Золбоо	Референт-судлаач	Бүс нутаггийн судалгаа	Zolboo
29	Р.Батсүх	Референт-судлаач	Бүс нутгийн судалгаа	Rbatsukh
30	Д.Жигваагүнсэл	Референт-судлаач	Бүс нутгийн судалгаа	jigvaa
31	Ц.Янжинцэрэн	Референт	Номын сан	Tsyanjin9@yahoo.com
32	Оюунтулга	Шинжээч	Номын сан	
33	Ж.Алтанцэцэг	Шинжээч	Номын сан	Jamts_a317@yahoo.com

* * *

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ТӨВИЙН 2009 ОНЫ ХАВРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН БҮРТГЭЛ

Хавсралт 2.

№	Судалгааны ажлын сэдэв	Захиалагч
1.	МУ-ын эдийн засаг, санхүүгийн өнөөгийн байдал, хямралын шалтгаан, нөлөөллийг тогтоох, хямралаас гарах арга замыг тодорхойлох нь	СШОНХТ

2.	МУ-ын бүс нутгийн хөгжлийн өнөөгийн байдал, бүсийн нэмэгдэлд хамаарагдах “бичил бүс” тогтоох судалгаа, бусад орнуудын туршлага	УИХ-ын гишүүн Р.Амаржаргал
3.	МУ-ын валютын зах зээлийн зохицуулалтын тулгамдсан асуудлууд: эрх зүй, эдийн засгийн орчны өнөөгийн байдал, бусад орнуудын туршлага	СШОНХТ
4.	Ашигт малтмалын салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалт / тогтвортой байдлын/-ын гэрээний талаар	БХАА Д.Одсүрэн
5.	Гадаадын зарим орнуудын мэргэжлийн боловсролын сургалтын талаархи зарим хуулийн зохицуулалт	БХАА
6.	Ашигт малтмалын орд ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний талаархи харьцуулсан судалгаа. Бусад орнуудын туршлага, Оюу толгой орд ашиглах гэрээний төслийн харьцуулалт	СШОНХТ
7.	Гадаадын зарим орнуудын парламентын гишүүдийн ёс зүйн асуудлын зохицуулалт	ТББХ
8.	2009 оны төсөв болон төсвийн тодотголын төслийн зүйл ангиудын харьцуулалт, Төсвийн тодотголын хэлбэр, баримтлах стандарт туршлага, зарим саналууд /АНУ-ын жишээ/	УИХ-ын гишүүн Г.Занданшатар
9.	“Атрын 3 дах аян” хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд хийсэн судалгаа	СШОНХТ
10.	Оюу толгойн ордыг ашиглах гэрээний төслийн талаархи судлаачдын шүүмж, зарим харьцуулалт	Эдийн засгийн байнгын хороо
11.	Төрийн албан тушаалд тавих шаардлага, болзолын тухай	УИХТГ
12.	МУ-ын Их Хурлын хуралдааны дэгийн эрх зүйн зохицуулалтын асуудалд	УИХТГ
13.	Засгийн газраас УИХ-д өргөн барьсан Оюу толгойн ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын болон Хувь нийлүүлэгчдийн гэрээний төсөлд хийсэн шинжилгээ, санал зөвлөмж	Эдийн засгийн байнгын хороо
14.	Гадаадын зарим орны төрөөс олгодог одон, медаль, цолны талаархи тойм судалгаа	УИХ-ын гишүүн Ш.Сайхансамбуу
15.	Дэлхийн зарим орнуудын төв банкны хүү	УИХ-ын гишүүн Н.Батбаяр
16.	УИХ-ын судалгаа, шинжилгээний нэгжийн түүхчилсэн танилцуулга	СШОНХТ
17.	Гадаадын Парламентын судалгааны нэгжүүдийн талаархи мэдээлэл	СШОНХТ

18.	Төрийн сангийн зээлээр өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын талаархи мэдээлэл судалгаа	УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин
19.	Эдийн засаг, санхүүгийн хямралтай холбогдуулан төсвийн талаар зарим орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, засгийн газраас УИХ-д өргөн барьсан төсвийн тодотгол, түүнтэй холбогдуулан зарим ТББ-ын гаргасан санал, зөвлөмжийн талархи мэдээлэл	СШОНХТ
20.	МУ-ын хэмжээнд хайгуулын болон ашиглалтын Тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа дотоодын болон гадаадын ААН-ийн талаархи мэдээлэл	УИХ-ын гишүүн З.Алтай
21.	Зүүн хойд Азийн чуулга уулзалтанд УИХ-ын дэд дарга Н.Энхболдын хэлэх үг	УИХ-ын дэд дарга Н.Энхболд
22.	Авилга, төрийн албаны хүнд суртал, төрийн албан хаагчийн ашиг сонирхолын зөрчлийн асуудлаар хийгдсэн судалгааны тойм	УИХ-ын дарга Д.Дэмбэрэл
23.	Төрийн албан хаагчын ёс зүйн асуудлаархи хэвлэлийн нийтлэлийн контент-анализ /2004-2008 он/	УИХ-ын дарга Д.Дэмбэрэл
24.	Төрийн байгууллагад 2005-2009 оны хооронд шинээр буй болгосон орон тоо, тэдгээрийн чиг үүргийн талаар	УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин
25.	МУ-ын эдийн засаг, нийгмийн байдлын талаархи тойм мэдээлэл /2009 оны 1 сар, 2 сар, 1 дүгээр улирлын байдлаар	СШОНХТ
26.	Дэлхийн эдийн засаг, Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнийн мэдээлэл /1,2 дугаар сар/	СШОНХТ
27.	Төрийн бэлгэдлийн агуулга, ач холбогдолын зарим асуудал	СШОНХТ
28.	Дэлхийн Ураны зах зээл, цөмийн аюулгүй ажиллагааны зохицуулалтын ОУ-ын стандарт, бусад орнуудын эрх зүйн зохицуулалтын орчны талаархи судалгаа мэдээлэл	УИХ-ын гишүүн П.Алтангэрэл
29.	“Нийгмийн даатгалын тухай” болон “иргэний эрүүл мэндийн даатгалын тухай” хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээ, тулгамдсан асуудлууд	УИХ-ын гишүүн С.Бямбацогт
30.	Тусгай хамгаалалттай газар нутгийн өнөөгийн байдал, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	УИХ-ын гишүүн Ц.Сэдванчиг
31.	МУ-ын нутаг дэвсгэрт борлуулж буй нефть бүтээгдэхүүний импорт, хилийн болон зах зээлийн, жижиглэнгийн үнийн талаархи харьцуулалт \шударга бус өрсөлдөөний аспект\	СШОНХТ
32.	Стратегийн ач холбогдолтой салбаруудад гадаадын хөрөнгө оруулагчдад хувьцаа эзэмшүүлэхэд тавих хязгаарлалт, холбогдох эрх зүйн зохицуулалт \бусад орны туршлага\	УИХ-ын гишүүн Н.Батбаяр

33.	Зарим улс орнуудын Өрсөлдөөний бодлого, хууль тогтоомжийн өнөөгийн байдал, шинэчлэлийн явц \бусад орны туршлага\	СШОНХТ
34.	Малын хулгайн зөрчилд оногдуулах захиргааны шийтгэлийн хэм хэмжээний хэрэгжилтийн байдал, өөрчлөх арга, боломж	УИХ-ын гишүүн Ц.Сэдванчиг
35.	МУ-д ипотекаар баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх асуудал, бусад орнуудын туршлага сэдэвт бодлогын судалгааны дүгнэлт, зөвлөмж /хураангуй/	СШОНХТ санаачлагаар
36.	Туул гол ба Богд уулын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт гарч буй зөрчлүүд, хамгаалах талаар авч байгаа арга хэмжээ, Засгийн газрын “Алт” хөтөлбөрийн хэрэгжилт, сөрөг үр дагавар, залруулах талаар авсан арга хэмжээ	УИХ-ын гишүүн Д.Энхбат
37.	Монгол, Франц хоёр улсын ашигт малтмалын хуулийн талаархи харьцуулсан судалгаа	УИХТГ-ын ЕНБ-ийн дарга Ц.Шаравдорж
38.	Шатахууны зах зээлийн өнөөгийн байдал, үнийн харьцуулсан судалгаа	УИХ-ын гишүүн С.Бямбацогт
39.	Зарим орны хувь хүний албан татварын тогтолцоо, бүртгэлийн систем, хариуцлагын механизм	
40.	Жижиг дунд үйлдвэрлэл ба төрийн дэмжлэг	УИХ-ын гишүүн Г.Занданшатар
41.	Бүгд Найрамдах Франц улсын парламентын үйл ажиллагааны туршлага	СШОНХТ-ийн санаачлагаар
42.	Австрали улсын Парламентын Тамгын газрын үйл ажиллагааны туршлага	СШОНХТ-ийн санаачлагаар

* * *

**УИХ -ЫН 2009 ОНЫ ХАВРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭСЭН
БУСАД СУДАЛГААНЫ ЖАГСААЛТ (i ботид орсон)**


Хавсралт 3

Бодлогын судалгаа, шинжилгээ		Гүйцэтгэсэн судлаачид
1.	Хууль тогтоох, бодлого боловсруулах шатанд бодлогын судалгаа шинжилгээний үүрэг, ач холбогдол	Ц. Норовдондог (Ph.D)
2.	Бодлогын судалгаа шинжилгээний онол, арга зүйн асуудлууд	Ч. Базар (Ph.D), Д. Ариунаа (MSc)
Эдийн засаг, санхүүгийн салбарын бодлогын асуудлаар		
3.	Монгол Улсад ипотекаар баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх асуудал, бусад орнуудын туршлага, өргөн барьсан хуулийн төслийн шинжилгээ	Ц. Норовдондог (Ph.D), Д. Ариунаа (MSc), Ж. Элбэгзаяа, Ц. Батбаяр, Ч. Онончимэг, Ш. Хишигсүрэн

4.	Өрсөлдөөний бодлого: Зарим орнуудын өрсөл-өөний бодлого, хууль тогтоомж, өнөөгийн байдал, шинэчлэлийн явц (Харьцуулсан судалгаа)	<i>Д. Ариунаа (MSc), Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа</i>
5.	Монгол Улсын валютын зах зээлийн тулгамдсан асуудлууд: Эрх зүй, эдийн засгийн орчны өнөөгийн байдал, бусад орнуудын туршлага	<i>Д. Ариунаа (MSc), Ц. Батбаяр, Ч. Онончимэг, Г. Билгээ, Б. Цолмонбаяр</i>
6.	Жижиг дунд үйлдвэрлэл ба төрийн дэмжлэг	<i>Д. Ариунаа (MSc), А. Пагма, Г. Билгээ, Ц. Болормаа, Ц. Түвшинзаяа, Ц. Батдорж</i>
7.	Зарим орны хувь хүний албан татварын тогтолцоо, бүртгэлийн систем, хариуцлагын механизм (Харьцуулсан судалгаа)	<i>Ц. Батдорж, Ц. Түвшинзаяа, Г. Билгээ</i>
Уул уурхай ашигт малтмалын салбарын бодлогын асуудлаар		
8.	Ашигт малтмалын салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалт (тогтвортой байдал) -ын гэрээний талаар	<i>Д. Мягмарцэрэн, Ц. Батбаяр</i>
9.	Засгийн газраас УИХ -д өргөн барьсан Оюутолгой ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын болон Хувь нийлүүлэгчдийн гэрээний төсөлд хийсэн шинжилгээ, санал зөвлөмж	<i>Ц. Норовдондог (Ph.D), Г. Алтан-Оч (Ph.D), Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа</i>
10.	Оюутолгой ордыг ашиглах хөрөнгө оруулалалтын гэрээний төслийн талаархи судлаачдын шүүмж, зарим харьцуулалт	<i>Н. Түвшинтөгс, Г. Чулуун</i>
11.	Ашигт малтмалын орд ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний талаархи харьцуулсан судалгаа, бусад орнуудын туршлага	<i>Ч. Базар (Ph.D), С. Дорждагва</i>
12.	Дэлхийн ураны зах зээл, цөмийн аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, бусад орны эрх зүйн орчны харьцуулсан судалгаа	<i>Ц. Норовдондог (Ph.D), Н. Түвшинтөгс, Б. Мөнхцэцэг, Б. Ариунжаргал, Г. Алтан-Оч (Ph.D), Ц. Болормаа, С. Дорждагва, Д. Мягмарцэрэн</i>
13.	Монгол Франц хоёр улсын Ашигт малтмалын тухай хуулийн харьцуулалт	<i>Д. Мягмарцэрэн</i>
Эрх зүй, төрийн байгуулалт гадаад бодлогын асуудлаар		
14.	Улсын Их Хурлын хуралдааны дэгийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудалд	<i>Ш. Хишигсүрэн</i>
15.	Малын хулгайн зөрчилд оногдуулах захиргааны шийтгэлийн хэм хэмжээний хэрэгжилтийн байдал, өөрчлөх арга, боломж	<i>У. Мөнхбат</i>
16.	Төрийн бэлгэдлийн агуулга, ач холбогдлын зарим асуудал (Төрийн далбааны өдөр бий болгох тухай хуулийн төсөлд)	<i>Ю. Эрдэнэтуяа (Ph.D), Г. Чулуун,</i>


17.	Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаархи хэвлэлийн нийтлэлийн контент анализ	<i>Ц. Норовдондог (Ph.D), Ю. Эрдэнэтуяа (Ph.D), К. Пүрэвсүрэн, Б. Мөнхцэцэг, О. Алтансүх, Б. Ариунжаргал, З. Бауыржан, Д. Золбоо, У. Мөнхбат, Т. Мягмаржав, О. Нарантуяа, Ч. Онончимэг, Б. Цолмонбаяр, Ш. Хишигсүрэн, Ц. Түвшинзаяа, Д. Жигваагүнсэл</i>
18.	Гадаадын зарим орны парламентын гишүүдийн ёс зүйн талаархи зохицуулалт	<i>Ю. Эрдэнэтуяа (Ph.D)</i>
Нийгмийн бодлогын асуудлаар		
19.	Нийгмийн даатгалын тухай болон иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудын хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээ, тулгамдсан асуудлууд	<i>Ц. Норовдондог (Ph.D), Ц. Товуусүрэн, А. Пагма, Т. Мягмаржав</i>
20.	Гадаадын зарим орны мэргэжлийн боловсролын сургалтын талаархи хууль эрх зүйн зохицуулалт	<i>Ю. Эрдэнэтуяа (Ph.D), Ц. Товуусүрэн, Б. Мөнхцэцэг, П. Тогоо, Ц. Болормаа, Ц. Түвшинзаяа</i>
Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын асуудлаар		
21.	«Атрын 3 дахь аян» хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд хийсэн судалгаа	<i>Р. Батсүх (Ph.D), Д. Золбоо, Д. Жигваагүнсэл</i>
22.	Малчдын зээлийн талаархи судалгаа	<i>Р. Батсүх (Ph.D), Д. Жигваагүнсэл</i>
23.	Монгол Улсын бүс нутгийн хөгжлийн өнөөгийн байдал, бүсийн нэмэгдэлд хамаарах «бичил бүс» тогтоох судалгаа, бусад орны туршлага (Бодлогын шинжилгээ)	<i>Ц. Норовдондог (Ph.D), Р. Батсүх (Ph.D), Д. Золбоо, Б. Буяндэлгэр, Ц. Түвшинзаяа, Д. Жигваагүнсэл</i>
24.	Тусгай хамгаалалттай газар нутгийн өнөөгийн байдал, эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь	<i>Ч. Базар (Ph.D)</i>
25.	Хавсралт	





Уншигчийн тэмдэглэл

A series of 25 horizontal dotted lines for writing.



ISBN 978-999-9--56-70-8

УИХ -ын Тамгын газар ©
«СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА»
(Судалгааны эмхтгэл - 2)

«Мөнхийн үсэг» хэвлэх үйлдвэр
Хэвлэлтэд шилжүүлсэн 2009.10.05
Тираж 300, Хэвлэлийн хуудас 20
Цаасны хэмжээ 176 * 250 $\frac{1}{10}$
(Анхны хэвлэл)
УБ, 2009